ХАЙРТ МОНГОЛ ОРНОО МАНДУУЛЪЯ

ХИЛ СУДЛАЛ

МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИ, ДХИС-ИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ, ДХИС ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭНГИЙН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ОНОЛ - МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

23 ДАХЬ ЖИЛДЭЭ **УЛИРАЛД НЭГ УДАА ГАРНА**

№ 1
2021 он

АГУУЛГА

СУЛИНХЭЭРИЙН ОТРЯДЫН ТҮҮХТ 80 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭСЭН ТОРГОН АГШИН.

Т.Жаргалсайхан. Түүх өртөөлсөн 80 жил хил судлал-онол практик

Ц.Ганболд. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоо, түүний агуулга, мөн чанар

Л.Лхагвасүрэн. Усчин-хилчдийн энерги зарцуулалтад хийсэн судалгааны үр дүн

Ц.Ганболд. БНХАУ-ын хилийн болон хилийн дэглэмийн зөрчилтэй тэмцэж буй асуудлыг судалсан нь

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ИННОВАЦИ

Ц.Ганболд. Улсын хил хамгаалалтад нисэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ыг ашиглах нь

Ж.Болормаа. Улсын хил хамгаалалтанд шинэ техник, технологийг нэвтрүүлье.

Т.Баяр-Эрдэнэ. Улсын хил хамгаалалтын инженер техникийн хангалтын түүхэн уламжлал

ХИЛИЙН ТҮҮХ

Ч.Сайнтөр. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн хөгжлийн түүхийн үечлэлийн асуудал

Ц.Ганболд., М.Ганбаатар. Монгол Улсын хилийн болон хил хамгаалалтын түүхийг баяжуулъя

Ө.Бавуу. Орос-Манжийн хилийн "Буурын гэрээ", түүний үр дагавар

Ц.Ганболд. Байтгийн хилчин баатруудын байлдааны хүлэг Тэгшээгийн хүрэн халзан морийг алдаршуулъя.

С.Билэгсайхан. Нийслэлийг чөлөөлсний 100 жилийн ойд. Ардын хувьсгалын партизан Лувсанцэрэнгийн Цэвээновын тухай

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

Б.Буд. Эх оронч үзлийн онол, практикийн тулгамдсан асуудлууд

Б.Эрдэнэ-Очир. Танин мэдэхүйн сэтгэл зүй ба оюун ухааны тухай

ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

С.Уганбаяр. Хил дээр бүтээсэн газрын зураг

Ц.Ганболд. Холын хүний үгийг сонсохуй... Доктор, профессор М.Лхагвасүрэнтэй хийсэн ярилцлага

Х.Энхсайхан. Жасрай гуайн шадар хамгаалагчийн дурсамж...

М.Жавзансүрэн. Төрд орхигдсон ч Эх Орныхоо төлөө зүтгэсээр

ХИЛЧИН-УРАН БҮТЭЭЛ

Ө.Бавуу. Эв мод (дууны шүлэг)

ХИЛЧНИЙ ШИРЭЭНИЙ НОМ

Ш.Арвай. Дурдатгал ба Хүүрнэл

Хилийн албаны сургуулиас шинээр гаргасан сурах бичиг, гарын авлага

Шалгагчийн гарын авлага

Хилийн шалган нэвтрүүлэх албанд холбогдолтой хууль тогтоомжууд

Нягтлан бодох бүртгэл

Галт зэвсэгтэй адилтгах үхэлд үл хүргэх зэвсэг

Цэргийн байр зүй

Бие хүний сэтгэл зүйн онцлогийг судлах судалгааны арга, аргачлал

Өөрийгөө таниад бусдыг шинжихүй

Ц.Ганболд. Хаант Орос-Манж Чин улсын хилийн харилцааны түүхэн тойм (1689-1911)

Хилийн хамааралтын ухаан

ТҮҮХ ӨРТӨӨЛСӨН 80 ЖИЛ

(Домогт Сулинхээрийн отрядын 80 жилийн ойн баярыг тэмдэглэх үеийн сэтгэгдэл)

Сул хээр мориор овоглосон Сулинхээрийн отряд 2020 оны 09 дүгээр сарын 17-ны нар ээсэн намрын налгар өдөр Чөлөөлөх дайнд оролцсоны 75 жилийн ой, анги байгуулагдсаны яруу алдарт 80 жилийн ойн тэмдэглэлт өдөр, давхар баярыг ёслол төгөлдөр тэмдэглэлээ.

Цар тахлын үед мөрдөх дэглэм журам суларч Монголчууд бид дэлхий нийтэд аливаа аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч зохион байгуулалтад орж чаддагийг баталж байсан зуны урин цаг үед хийхээр төлөвлөж байсан боловч намар болтол 80 жилийн ойг түр хойшлуулж, таатай билэгт сайн өдрийг хүлээн энэ өдрийг товложээ.

Хуанли харвал хилчдийн өдөр, намрын тэргүүн сарын шинийн 30-ны өдөр. Говийн тэнгэр хур бороо тэгш хайрлан газар дэлхий ногоорон дүнхийж хүн малын нуруу тэнийсэн намрын налгар сайхан цаг.

Уул толгод, булаг шанд бүр нь түүх хэлхэх хийморлог хилчдийн өлгий нутаг Сулинхээрийн хязгаарт түүхэн баяраа тэмдэглэхээр зочид гийчид айлчлан ирж өргөө гэртээ саатан тухлажээ. Өглөө эртлэн боссон тэд баярын өмсгөлөө өмсөж, бэлэн болсон харагдана.



Тэртээх 80 жилийн өмнөх эх орныхоо торгон хил, халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах ариун үүрэг хүлээж Улсын маршал, өрлөг жанжин Х.Чойбалсангийн тушаалаар тулгын гурван чулуут тулж үүсэн байгуулагдсан домогт отряд маань ийнхүү 80 жилийн түүхэн намтар, баялаг түүхт өдөртөө, үе үеийн амьдралыг цогцлоосон ахмад хилчдээ урин залж орчин үеийн хил хамгаалах ариун бөгөөд хүндтэй үүргээ нэр төртэй биелүүлж буй хамт олон минь цэргийн гавьяаны одонт байлдааны тугаа хүндэтгэн залахаар хуран цуглаж, жигдрэн жагсжээ.

Эгнэн ярайсан цэрэг эрс, эгнэгт баатрын албыг дааж явсан эрхэм хүндэт ахмад хилчид болон түүний гэр бүл, үр

хүүхэд, ажилчид, анги байгууллагатай мөнхийн холбоотой аймаг, сумдын удирдлагуудын төлөөлөл зорилго нэгт хилийн отрядуудын хүндэт зочид нээлтийн ажиллагаанд хүрэлцэн иржээ.

Штабын дарга, хошууч Г.Эрдэнэбатын "Байлдааны тугийн дор зэргээц, баруун тийш" хэмээх сүрлэг сайхан командаар анги байгууллагын оройн дээд шүтээн аранзал улаан тугаа заллаа.

Ойн арга хэмжээнд уригдан ирсэн хүндэт зочид, ангийн захирагч, хурандаа П.Батбилэгийн дэргэд байраа эзлэн зогсжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын цэргийн асуудал хариуцсан ахлах референт, доктор, бригадын генерал Ч.Сайнтөр, Дорноговь аймгийн засаг дарга Г.Эрдэнэцэцэг, ХХЕГ-ын хүний нөөцийн хэлтэсийн дарга, хурандаа Б.Батмөнх, Хилийн 0288 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Батбаяр, Хилийн 0129 дүгээр ангийн захирагч, хурандаа Ц.Батбаяр, Хилийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Нямбат, ДХИС-ийн Удирдлагын академийн хилийн албаны удирдлага, стратегийн профессорийн багийн профессор, хурандаа П.Баттогтох, тус ангийн захирагчаар ажиллаж байсан Ш.Алтангэрэл, Д.Энхбаатар, Ш.Бат-Эрдэнэ, Б.Батболд нар хүрэлцэн ирсэн байлаа.

Сэтгэл нь хөөрч баясч, зүрх цээжинд багтахаа больж, хоёр нүдийг нь баярын нулимс бүрхэж, омогшилийн бахархалд бахардсан ахмад хилчид зогсож харагдлаа.

Ангийн захирагч, хурандаа П.Батбилэг түүхт 80 жилийн ойн баярын арга хэмжээг нээж үг хэлснээр баярын арга хэмжээ эхэллээ.

ХХЕГ-ын даргын тушаалыг хурандаа Б.Батмөнх танилцуулж, Дорноговь аймгийн засаг дарга Г.Эрдэнэцэцэг үг хэлж тус тус шагнал гардуулан, ахмад хилчдийг төлөөлж, хурандаа Ш.Алтангэрэл үг хэллээ.

Ангийн бие бүрэлдэхүүн офицер, ахлагч нар, гэрээт болон ХЦАХ-чид ёслолын жагсаалаар алхахад хүрэлцэн ирсэн зочид бахархан алга ташиж, баяр хүргэв. Ёслолын жагсаалаас эмэгтэй алба хаагчид болон ХЦАХ-дын хайрцаг олны анхаарлыг татаж байв. Жигдрэн алхах албан хаагчдийн алхаа бүрт бэлтгэлээ бүрэн хангасан итгэлтэй байдал ажиглагдан, царайнд нь баярын мишээл тодорч харагдана.

Энэ онд Чөлөөлөх дайны 75 жилийн ой тохиож байгаа.

Домогт отряд маань 1945 онд хилийн 0168 дугаар ангийн дарга, хурандаа Э.Халтар цэргээ удирдан фронтын баруун жигүүр болж, бие даан үүрэг гүйцэтгэж Өвөрмонголын Батхаалга хот, Улаанцав чуулганы долоон хошууг чөлөөлж, японы тагнуулын болоод орон нутгийн дээрэмчдийн зэвсэгт бүлгийг устгаж түүхэн гавьяаг байгуулсан.

Хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, улсын хилийнхээ халдашгүй дархан байдлыг батлан хамгаалж, эрэлхэг хилчдийнхээ эгнээнээс хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн 10, генерал, хурандаа цолтон 60 гаруйг төрүүлж гаргасан бахархам үйлстэй анги билээ.

2017 онд Дорноговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 85 дугаар

тогтоолоор Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, эрэлхэг хилчин, хурандаа Э.Халтарын нэрэмжит болгон мөнхжүүлсэн.

Ангийн удирдлага, зочид төлөөлөгчидийнхөө хамтаар хурандаа Э.Халтарын хөшөөнд цэцэг өргөн, хүндэтгэл үзүүлснээр баярын үйл ажиллагаа үргэлжиллээ.

Э.Халтар нь тус ангийг удирдан чөлөөлөх дайнд оролцсоноос гадна НАХЯ-ны хилийн асуудал хариуцсан нэгдүгээр хэлтсийн дарга хүртэл чухал хариуцлагатай албан тушаалыг хашиж байсан юм. Цаг төрийн байдлаас шалтгаалан хилийн цэргийн анги салбаруудыг татан буулгасан тухайн үед хилийн цэргийг удирдах хамгийн өндөр албыг хашиж байсан.

Цэцэг өргөх ёслолын ажиллагаанд Э.Халтарын хүү Х.Баатар хүрэлцэн ирсэн нь онцлог байлаа.





ЭРЭЛХЭГ ДАЙЧДЫН ГАВЬЯАГ МӨНХЛӨВ.



Манай отряд 1945 оны Чөлөөлөх дайны баруун жигүүрт бие даан оролцож ялалт байгуулсан баатарлаг түүхтэй. Тэдний алдар гавъяагаар бид бүхэн бахархаж, хойч үедээ энэхүү түүхэн үйл явдлын сурталчлан таниулах ариун үүрэгтэй.

Ангийн түүхт 80, Чөлөөлөх дайнд оролцож ялалт байгуулсаны 75 жилийн ойг угтаж хийсэн бүтээлч ажлуудын нэг нь энэхүү дурсгалын цогцолбор хөшөө юм. Ангийн нийт бие бүрэлдхүүний дунд "Чөлөөлөх дайнд оролцсон баатарлаг дайчдад зориулсан дурсгалын хөшөө"-ний загвар, дизайн гаргах уралдаан зохион байгуулжээ. Уралдаанд ангийн төв, хилийн заставаас 17 загваруудыг ирүүлснээс хөшөө бүтээн босгох санаачлагыг анх гаргасан ангийн захирагч, хурандаа П.Батбилэгийн загвар, утга агуулга, хэлбэр дизайны хувьд шалгарчээ. Энэ загварыг үндэслэн "168 студи"-д эхийг гаргаж, хийж бүтээсэн болой.



Дайнд оролцож гарамгай амжилт байгуулсан дурсгалт он болох 1945 гэсэн бичиглэлийг гантиг суурин дээр 7 м х 2 м харьцаатай хийж Эх орныхоо төлөө амь биеэ үл хайрлан, сэлмээ хурцлан давшиж буй морьтой баатрыг дүрсэлсэн байна. Тус хөшөө нь нийт 5 метр өндөртэй бөгөөд цэцгийн мандал бүхий суурийг 14 м х 7 м х 0,6 м харьцаатай гантиг чулуун шалтайгаар хийж, 20 м х 40 м талбайг зүлэгжүүлэн, хашлага, зам зэргийг цементлэн хийсэн. Уг бүтээн байгуулалтын ажлыг тус ангийн Сэтгэлзүй, мэдээлэл, соёл сурталчилгааны албаны хамт олон 2020 оны 5 дугаар сараас эхлэн, зураач, ахлах ахлагч Д.Гантулгатай хамтран хийж 9 дүгээр сарын 17 буюу анги байгуулагдсаны 75 жилийн ойгоор хүлээлгэн өгсөн байна.



Нээлтийн арга хэмжээ баярын өдөр морин цагт буюу 11.40 минутад эхэллээ. Ойд оролцсон зочид төлөөлөгчид талбайд хүрэлцэн ирж тэднийг төлөөлөн хөшөөний нээлтийн туузыг ангийн захирагч, хурандаа П.Батбилэг, Чөлөөлөх дайнд тус отрядыг удирдан оролцож, ялалт авчирсан хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, эрэлхэг хилчин, хурандаа Э.Халтарын хүү бэлтгэл дэд хурандаа Х.Баатар, Монгол Улсын 168 дахь генерал Ч.Сайнтөр, Дорноговь аймгийн засаг дарга хатагтай Г.Эрдэнэцогт нар хайчлав. Үлээвэр хөгжмийн цоглог маршийн аялгуу дор Хайрт Эх орон бид бүхнийхээ төлөө халуун амиараа сөрөн зогсож, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэсэн эрэлхэг дайчдынхаа гэгээн дурсгалд зориулсан энэхүү хөшөө дурсгал эгнэгт мандан сүндэрлэв ээ.

ДОМОГТ ОТРЯДЫН ТҮҮХТ 80 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ



Баярын хурлын үйл ажиллагаа товлосон цагтаа эхэллээ. Хүрэлцэн ирсэн хүндэт зочид байраа эзэлж, ангийн захирагч, хурандаа П.Батбилэг, бригадын генерал Ч.Сайнтөр нар орж ирлээ. Цаг яг 16:00 болж байв. Энэ үйл ажиллагаанд сайтар бэлтгэсэн нь мэдрэгдэж байв.

Сулинхээрийн отрядын соёлыг төв жишиг тохижилтоороо алдаршсан гэдгийг би дуулсан, мөн харсан. Энд олон том арга хэмжээ зохион байгуулагдаж байсан гэдгийг сонссон. Жил хүрэхгүй хугацааны өмнө ХХБ-ын удирдах ажилтны цугларалт хилийн ангид анх удаа энэ л танхимд зохион байгуулагдсан.

Мөн ХХБ болон говь цөлийн бүсийн хилийн ангиудын олон сургалтууд явагдаж байсан. Тэр ч утгаараа сайхан тохижуулсан байна. Багагүй хөдөлмөр хүч шингэсэн харагдана. Тохижилтоос гадна 80 жилийн ойн гангараагаа өмсжээ. Хаашаа ч харсан Домогт Сулинхээрийн отрядын ойн баяр болж байгааг илтгэх зурагт хуудас, самбарууд... Тайзыг ч гэсэн маш сайхан байдлаар засч гоёжээ. Миний урд суух ахмад хилчний сандалын ар түшлэг дээр "Танд түүхт 80 жилийн ойн баярын мэнд хүргэе" бичээс бүхий бүтээлэг ганцхан надад зориулсан мэт харагдана. Мөн надад зориулан "Сулхээрийн төвөргөөн" эмхтгэлийн тусгай дугаарыг тавьсан байсныг авч уншиж байтал хурлын ажиллагаа эхлэх цаг болжээ.

Хүндэт зочдыг харвал ангийн захирагч, хурандаа П.Батбилэг, бригадын генерал Ч.Сайнтөр, хурандаа Б.Батмөнх хурлын тэргүүлэгчийн ширээнд суужээ.

Тэдний ард Хилийн 0129, 0108 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Нямбат, Ц.Батбаяр, тус ангийн захирагчаар ажиллаж байсан хурандаа П.Баттогтох, Ш.Алтангэрэл, Д.Энхбаатар, Ш.Бат-Эрдэнэ, Батболд нар цэргийн хувцас болон дээлээр гангаран суужээ.

Баярын ажиллагааг нээж тотрядын дарга, хурандаа П.Батбилэг илтгэл тавьлаа. Домогт отряд маань ХХБ-ын жишиг отряд болон хөгжиж эндээс л хөгжлийн чиг хандлагыг мэдэж авч болохоор болжээ. Захирагчийн хэлсэн

үг бүрт хүмүүс алга ташин талархан хүлээн авч байсан.



Хурандаа П.Баттогтох ДХИС-ийн Удирдлагын академийн хилийн стратеги, тактикийн профессорын багийн профессор гэсэн чухал үүргийг хүлээж яваа хүндтэй нэгэн, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгийн газрын цэргийн асуудал хариуцсан ахлах референт, бригадын генерал Ч. Сайнтөр үг хэлэв. Хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэнгийн ойн баярын мэндчилгээг ХХЕГ-ын хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Батмөнх уншиж танилцууллаа.Үүний дараагаар яамны болон ХХЕГ-ын шагналаар олон хүн шагнагдав. Ахмад хилчид болон зочид төлөөлөгөчид заал дүүрэн суусан танхимд алга ташилт, баяр баясал дүүрэн байв. Шагналын ая тасралтгүй хангинаж шагнагдаж байгаа хүмүүсийн нэрс ар араасаа хөврөнө. Яг энэ үед тог тасрав. Энэ үед тус ангийн бүрэлдэхүүний бэлтгэлээ хэрхэн хангасныг шалгах мэт болов. Зохион байгуулж буй алба хаагч нар юу болоогүй мэт үйл ажиллагаагаа цааш нь үргэлжлүүлэв. Соёлын төвийн харанхуй орчинг цонхны хөшгөө нээж гэрэлтэй болгож, хөтлөгч чанга дуугаар нэрсийг зарлан, шагналын аяыг үлээвэр хөгжим тоглож байлаа. Тог тасрана гэдгийг мэдэж байсан юм шиг л үргэлжлэн явагдлаа. Зааланд суусан хүмүүсийн уур амьсгал үнэхээр бахдам сайхан мэдрэгдэж байв.

Хүрэлцэн ирсэн хүндэт зочдоос ангийн 80 жилийн ойд талархалын үгээ хэлж эхэллээ. Энд зарим онцлог хүмүүсийг дурдвал:

Дорноговь аймаг дахь Гаалийн газрын дарга Цэенрэгзэн, Шүүхийн тамгын газрын дарга Д.Даваадорж, Прокурорын газрын ахмад прокурор Н.Чулуун, хурандаа Ж.Жалбуу, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа Э.Халтарын хүү, бэлтгэл дэд хурандаа Х.Баатар, Болор цомын эзэн, яруу найрагч Ж.Баяржаргал, хурандаа Ц.Сангарагчаагийн охин С.Учрал, Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын удирдлага, тус ангид алба хаасан ХЦАХ-дын төлөөлөл улаан туузтай харагдана.

Хурлын ажиллагаа өндөрлөж, концерт эхэллээ.

ХҮНДЭТГЭЛИЙН КОНЦЕРТ

Ойд ирсэн зочид төлөөлөгчдөд барих дараагийн бэлэг хүндэтгэлийн концертоор үргэлжилж, ангийн уран сайханчид 80 жилийн ойдоо зориулан утга агуулга төгөлдөр байдлаар бэлтгэжээ. Тус концерт ангид ажиллаж амьдарч байхдаа туурвиж байсан болон сум, орон нутгийн уран бүтээлчдийн хөг

аялгуугаар бүтсэн уран бүтээлүүдээс бүрдсэн нь онцлог байлаа.

Ахмад хилчин, бэлтгэл дэд хурандаа М.Очирсүхийн шүлэг, ахмад И.Октябрийн хөгжим "Одонт отряд" дуугаар эхэлж, олон жилийн уртад хилчид бидэнтэйгээ уянгалж, мөнхийн хамт байдаг УГЗ Т.Мөнгөн-Өлзийгийн аялгуу "Сулинхээрийн уул", СТА Б.Тэрбишийн аялгуу "Сулинхээрийн бүсгүйчүүд" зэрэг хуучний сайхан дуунуудаар эгшиглэсэн нь ахмад хилчдийнхээ торгон мэдрэмжийг хөглөсөн дуун цэнгүүн болжээ. "Сулинхээрийн уул" дууны ард дэлгэцэн дээр дууны клипийг тавьж өгсөн нь тухайн үед ажиллаж байсан ахмад хилчдийн сэтгэлийн хөдөлгөж, босож даган дуулахад хүргэв.

Бусад уран бүтээлийн ард ч ахмад хилчдийн зураг нэг нэгээрээ хөврөх нь өөрсдөө клипэнд тоглож байгаа мэт орчин нөхцөлийг төрүүлж байв. Хилчдийн дуу бүжигт уяран тэртээ сайхан цаг үе залуу наснаа очсон мэт санагдаж өөрийн эрхгүй босож, баярын нулимс унагаасан байв.

Орчин цагийн уран бүтээлчид цэргийн үлээвэр хөгжим, ардын үндэсний хөгжим, эстрад хөгжмийн төрлүүд мөн багтсан байна.



ХҮНДЭТГЭЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТ ХҮНДЭТГЭЛТЭЙ БОЛЛОО.



Энэ өдөр ойн баярт уригдан ирсэн 400 гаруй зочид төлөөлөгчдөд зориулан хүндэтгэлийн босоо хүлээн авалт зохион байгууллаа.

Уг үйл ажиллагааг спорт зааланд зохион байгуулсан ч тэнд орчныг бүрэн өөрчилж классик загварын хэв маягийг бүрдүүлжээ. Орчин үеийн шийдэл бүхий өнгө зургийг хослуулан засан нь үнэхээр хүндэтгэлийн арга хэмжээг илэрхийлнэ.

Энэ үдэш халуун дарс, амтат зоог хамар цоргиулсан үдшийн танхимд ирсэн зочдыг морилон саатахад дэлхийн сонгодог аяс намуухан эгшиглэн угтаж, ангийн захирагч, хурандаа П.Батбилэг "Түүх өртөөлсөн 80 жил" ойн хүндэтгэлийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн зочдод хандан үг хэлэхийн ялдамд, баярлаж талархсанаа илэрхийлснээр баярын босоо хүлээн авалт эхэллээ.

Тус хүлээн авалтын соёлын арга хэмжээг Сэтгэлзүй мэдээлэл соёл сурталчилгааны албаны хамт олон дэлхийн сонгодог уран бүтээлүүд болоод олны хүртээл болсон аав ээж, нутаг усны тухай уран бүтээлүүдээр зочдын мэлмийг баясгаж, сонорыг мялаасан бол 2020 оны 1 дүгээр ээлжээр Өмнөговь аймгаас татагдан ирсэн байлдагч Б.Уганбаяр циркын үзүүлбэр үзүүллээ.

Өнгө өнгөөр алагласан баярын ширээний засалт, амттан тэргүүтнийг зохион байгуулахад Хүнсний албаны дарга, ахлах дэслэгч Н.Ариунтунгалаг, ахлах тогооч, дэд ахлагч Л.Банзрагч, зочид буудлын эрхлэгч Т.Азжаргал нараар ахлуулсан ажилсаг 15 бүсгүй өөрсдийн авъяас ур чадвар, эмэгтэй хүний торгон мэдрэмжээ ашиглан засан илт мэдрэгдэнэ.



Нийт 124 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, ангийн ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хугацаат цэргийн алба хаагчдад худалдааны бус өөрсдөө тарьж ургуулсан эрүүл хоол хүнсийг олгох зорилгоор говь нутагт хүнсний ногоо тариалах арга технологийг судлан нэвтрүүлж ургуулсан хүнсний ногоо, өргөст хэмх, тарвас, бэлтгэсэн сүү, цагаан идээ зэргийг ашиглан бүсгүйчүүд сэтгэлээ шингээж 52 нэр төрлийн хоол, 44 нэр төрлийн зууш, салат, 16 нэр төрлийн талх нарийн боов, 12 нэр төрлийн хачир, 32 нэр төрлийн ундаа, 9 нэр төрлийн сүү цагаан идээ

зэргийг бэлтгэн тавьсан байлаа.

Энэ үдшийн үйл ажиллагаанд оролцож буй зочид төлөөлөгчид, ахмад хилчдээс сэтгэлийнхээ үгийг дайж, хил хамгаалах байгууллагын жишиг анги юу хийж, ямар үйл ажиллагаа зохион байгуулж, яаж амьдарч байна гэдгийг харлаа, жишиг ойн арга хэмжээг нүдээрээ үзэж, биеэрээ оролцлоо. "Улаанбаатар хотын хамгийн өндөр зэрэглэлийн ресторанд ороод ирсэн мэт сэтгэгдэл төрүүлж тансаг орчин, зоогийг бэлтгэсэн байна", бидний залгамж халаа болсон залуучууд маань хөгжин дэвшиж ихийг хийж бүтээн, орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхаж байна хэмээн бахархан ярьж байсан юм.

ХАТАНБУЛАГИЙН ҮДЭШ

Ойн баярын үйл ажиллагаа ар араасаа нэгдсэн зохион байгуулалт дор ёслол төгөлдөр зохион байгуулагдсаар сумын "Залуус" талбайд үргэлжиллээ.

Орон нутгийн ард иргэдийг хамруулж зохион байгуулсан "Хатанбулагийн үдэш" шоу цэнгүүнд оролцохоор ойд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид, намрын налгар үдэш эстрад хөгжмийн аялгуу дор дуулж, бүжиж алжаалаа тайлахаар олон залуус хүрэлцэн иржээ.

Шоу үдэшлэгийг ангийн соёлын төвийн дэргэдэх эстрад хөгжмийн "Аранзал" хамтлаг оройлон зохион байгуулж хил, үе үеийн хилчдийн тухай болон 70-90-ээд оны сэтгэлд хоногшсон дуунууд, орчин үеийн хөг аялгуунд нийцсэн уран бүтээлүүдээр үзэгч түмэндээ бэлэг барьсан юм.

Мөн ирсэн зочид төлөөлөгчдийг төлөөлж ахмад уран бүтээлчид, Хатанбулаг сумын Соёлын төвийн авъяастнууд 80 жилийн түүхтэй Сулинхээрийн отрядын хилчдэд баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлж байлаа. Баярын салют өнгө өнгөөр буудаж, Дорнын говийн намуухан үдшийг хүүхдийн инээд хөөр, залуусын дуу хуур, настнуудын халуун яриагаар өрнүүлсэн энэ үдэш түүхийн хугацаанд түмэндээ Сулинхээр хэмээн нэрийдсэн Домог түүхийг улбаа отряд зуун жаран хоёрын дунд настайгаа ийнхүү золголоо.

Баярлалаа хилчид ээ. Баярлалаа төрөлх домогт отрядын хамт олон минь. Өглөөнөөс үдэш болтол баярын ажиллагааг алдаа мадаггүй сайхан зохион байгуулсан та бүхэндээ талархалын үгээ харамгүй хэлж байна.



САЯХАН МЭТ САНАГДАНА.

Түүх өртөөлсөн 80 жилийн ой, Сүүжийн тал, Сулин хээрийн отряд минь гэж ярилцах ахмад хилчдын яриа өрнөх тэр өдрийг санахад өчигдөр мэт санагдана.

Өнөөдөр өвлийн эхэн сар гарсан гэхэд говь нутагт налгар намрын өдөр мэт наран авхай тунгалгаар ээсэн тийм нэгэн сайхан өдөр.

2020 оны 09 дүгээр сарын 17-н буюу хилчдын баярын өдөр алдар түүхээр арвин домогт Сулинхээрийн отрядын түүхт 80 жилийн ойн баяр өндөрлөөд удаагүй байна. Энэ үед ажиглагдсан нэгэн сайхан үйл явдлыг уншигч олондоо сонирхуулмаар санагдсан юм. 80 жил гэдэг хүнээр төлөөлүүлэн бодоход хүний орчлонд 80 насыг зооглосон настан. Мөн өнөөдрийн залуучууд, ирээдүй хойч бидний төлөө ихийг хийж бүтээж бүтээсэн буурал тэргүүнтэй эмээ, өвөө юм.

Хил хамгаалах байгууллагын жишиг отряд болтлоо хөгжиж чадсан анги маань эх орныхоо торгон хилийг сахин хамгаалаад 80 хавар, 80 өвлийг үдсэн түүхийн буурал харгуй. Сулинхээрийн домогт отряд гэх нэр алдрыг Монгол Улсынхаа говь нутгийн эмжээр болсон газар тамгалж чадсан их түүхтэй.

Эдүгээ 1940 онд анхны шаваа тавьж байсан анги өнөөдөр хайртай бүсгүйгээ болзоонд хүлээх ганган залуу шиг өнгө гэрлээ гялалзуулан сүрлэг харагдана.

Энэ л отрядын 80 жилийн түүхээс бичилцэж, амьдрал ахуй, эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө залуу нас, халуун сэтгэлээ зориулсан үе үеийн хилчин дайчид, зочид төлөөлөгчид, ажилтан албан хаагчид маань баяртаа оролцоод, орсон бороо арилж, ирсэн зочид буцдагын адилаар буцах эхэлжээ.

Төрөлх отрядын хилчид уригдан ирсэн зочид биднийг гуулин хөгжмийн сүр жавхлант ая дор үдэн гаргаж өглөө.



Ойн баярын хоёр өдөр Монгол орныхоо өнцөг булан бүрээс зорин ирсэн зочид маань баяр баясгалан цацруулан бие биетэйгээ уулзан учирч ангийнхаа өнөө цагийн дүр төрхийг магтан, сайшааж биднийг залуу байхад, намайг ажиллаж байхад ийм анги, отряд байдаггүй байлаа. Орчин үеийн хил хамгаалах байгууллагын отрядын өнгө төрх их сайхан болсон байна гэж ам булаалдан ярих ахмадуудын бахархах яриа чих дэлсэнэ.

Сонсоход улс эх орны аюулгүй байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлын төлөө цаг наргүй зүтгэх хилчин хэмээх нэр алдраар овоглосноороо бахархах, омогших сэтгэгдэл мэдрэгдэнэ. Баяртаа оролцсон бид анхны ажлын гараагаа эхэлж, төрөлх нутаг ус болсон хуучин отрядын байрлалаа санагалзан зорьлоо.


Энэ зүг яаран явах машины цувааг би лав тоолоод 20 гаргаад алдсан юм. Замд говь нутгийн үзэсгэлэнт хулан хуйлран давхихыг харж, Толийн булгын тунгалаг рашаанаас амсаад, сайн явж ирэв үү? самбартай хөтөл даван зорьсон газраа очлоо.

Тэнд очсон хүмүүс ямар нэгэн юм ирээд хайгаад байгаа ч юм шиг, зарим эмэгтэйчүүд нь уулга алдан гайхаж байсан.

Мөхөс миний бодлоор хуучин ажиллаж байсан анги, амьдарч байсан гэр орон нь байхгүй болохоор ингэж байна гэж бодож байлаа. Гэтэл ахмад буурлуудынхаа яриаг сонсоход тийм биш болохыг нь сонсоод өөрөөсөө ичих шиг болж билээ.

Ахмад хилчид маань хуучин ангийн туурь гэж бодохоор төсөөлөлд нь барилгын балгас, энэ тэнд хөглөрсөн мод, тоосго, тэрч бүү хэл уул уурхай ажиллаад, ухаж түнхсэн газар шороо угтах байх даа гэж битүүхэндээ бодож, зарим нөхөд нь ярилцаж явсан юм билээ.

Харин үрсээ угтах ээж шиг намрын шар нар дулаанаар ээсэн Замын шанд нутаг дуниартан угтаж, **“Энд Сулинхээрийн отряд 1973-2016 онд байрлаж байв”** гэсэн хаягтай хөшөө сүндэрлэн харагдаж, онгон дагшин байгаль эх сайхан хэвээр угтсан юм.



Очсон хүмүүсийн ирж хайсан зүйл нь олон нийтийн сүлжээгээр энэ газрыг минь мөнгөтэй хүмүүс худалдан авч, алт гаргаж байна гэх сургаар сэтгэл нь өмөрч суусан хүмүүсийн зарим нь уулга алдан яанаа гэхэд би хүртэл тэр мэдээлэл дээр сэтгэгдэл хүртэл бичиж байсан гэж нөхдөө инээлгэлээ. Ахмадууд маань сүү цагаа идээгээ өргөн, манайх хаана байлаа, цэргийн байр хаана байлаа энд байсан, үгүй тэнд байсан гэж ярилцан хөхрөлдөх ахмадуудын царайнд амар амгалангийн гэрэл гэрэлтэж байлаа.

Хуучин анги байрлаж байсан Замын шандийн хөрс энд урьд нь юу ч баригдаж байгаагүй мэт эрүүл, дагшинаараа байх бөгөөд хуучин соёлын төв, жагсаалын талбай тойрон байсан модод ногоонооров. Мөн соёмботой хөшөө, цэргийн хөшөөгөөр хаана юу байсныг төсөөлнө. Залуу нас, өнгөрсөн дурсамж тодорч, хэлэхэд тун ч амаргүй гэгэлгэн сэтгэгдэл төрж байлаа.

Зарим ахмадууд маань уул усныхаа баримжаагаар л бид энд тийм юм байсан гэж багцаалдаж байна, нэг ширхэг хаягдал тоосгоны ч үлдэгдэлгүй хөрсийг цэвэрлэн нөхөн сэргээлт хийж зүлэг, ургамал ургасан байгаль байлгаж байгаад ангийн захирагчид талархал илэрхийлж байсан юм.

Энд бид албаа сайхан хааж байжээ. Болоод л байсан гэхдээ өнөөгийн хилчдийн орчин нөхцөл бууриа сэлгэсэн нь цаг хугацааны асуудал. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ нүүдэл энэ хөгжил ирэх л байсан.

Тийм ээ Монгол хүн тэр дундаа хилчин хүн дорнын их говийн шаргал нарыг тольдон байдаг газар шороо, уул ус, ургамал, амьтан газар нутгаа бүрэн бүтэн байлгах тэр сэтгэлээ хэзээ ч гээхгүй юм даа гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байсан юм.

ЧИН СЭТГЭЛИЙН ЦЭГЦТЭЙ ЯРИЛЦЛАГА

Бэлэг дурсгалын зүйлийг хэрхэн бэлтгэсэн талаар тус ангийн захирагчийн орлогч, СМСС-ны албаны дарга, хэвлэлийн төлөөлөгч, дэд хурандаа Г.Даваатогтохтой ярилцлаа.



А. -Түүхт 80 жилийн ойд зориулан гаргасан дурсгалын зүйлийн талаар мэдээлэл өгнө үү?

Х. -Түүхт 80 жилийн ойн баярт 250 хүн хүрэлцэн ирсэн тооцоо гарсан. Хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд дурсгал болгож дараах зүйлсийг гардуулан өгсөн. Үүнд: “Сударлан орших Сулинхээр мину” 300 хуудас бүхий зургийн цомог, “Эх орны манаа” сонины тусгай дугаар, сулхээр морины дүрс бүхий сувинер, ангийн архив болон ахмад хилчдээс авсан зургийн цуглуулга бүхий дискыг гардуулан өгсөн. Мөн отрядын бүсгүйчүүдийн сэтгэлээ шингээн бэлтгэсэн ааруул, хөмүүл зэрэг зүйлсийг нэмж нэг багц бэлэг болгон өгсөн.

А. -Бэлэг дурсгалын хувьд ахмад хилчид ам сайтай байгаа сонсогдож байсан. Хэрхэн бүтээсэн талаар...?

Х. -Хамгийн их хөдөлмөр шингэсэн бүтээл бол “Сударлан орших Сулинхээр мину” 300 хуудас бүхий зургийн цомог юм. Ангийн удирдлагын хэмжээнд 80 жилийн ойд зориулан ном гаргахаар 2019 онд төлөвлөж байсан боловч тухайн үед ХХБ-ын хэмжээнд мөрдөж байсан тушаал журмаар ном бүтээхийг хориглосон байсан. Тийм болохоор зургийн цомог бүтээх шийдвэр гарсан. Зургийн цомгийн бэлтгэл ажлыг 2019 оноос хангаж эхэлсэн. Цомгийн хамгийн анхны загвар санааг ахмад хилчин, бэлтгэл дэд хурандаа Ё.Нацагдорж хэмээх эрхэм ах маань гаргасан. Ингээд түүний санаан дээр ажиллаж эхэлсэн. Улаанбаатар хотод ажлын багийг ангийн захирагчийн шийдвэрээр гаргаж ажиллуулсан. Энэ багт манай Нууц, мэдээллийн аюулгүй байдлын офицер, ахмад Ч.Гончигдорж, бэлтгэл дэд хурандаа Ё.Нацагдорж нар

14 хоног ажиллаж ирсэн. Үндэсний архив, Хилийн цэрэг, Тагнуул, Батлан хамгаалах яамны архивуудаас тус ангитай холбоотой олон хэрэгтэй зураг, материалуудыг олж авчирсан.

Миний хувьд бол урьд өмнө ийм өргөн агуулгатай зүйл дээр ажиллаж үзээгүй. Яг хаанаас эхлэх вэ? гээд олон асуудал дээр туршлага дутагдаж байсныг хэлэх үү? үнэхээр тулгамдах асуудал тохиолдож байсан шүү. Хамгийн их санаа тавьж гол зохион байгуулалтыг хийж өгсөн хүн бол манай ангийн захирагч юм. Маш олон зүйл дээр зөвлөж, гаргалгаа хийж өгсөн.

Мөн ангийн захирагч, хурандаа П.Батбилэг МУ-ын зохиолчдын эвлэлийн яруу найргийн төвийн дарга, Болор цомын эзэн, зохиолч Ж.Баяржаргалыг урьж авчирч, ангийн төв хилийн застават ажиллуулсан. Ингээд ангийн захирагч болон Ж.Баяржаргал ахын ажиллагааны дүнд цомог маань үндсэн дүр төрхөө олж эхэлсэн. Үндсэн дүр төрхөө 2020 оны 05-06 дугаар сард бий болгож авсан гэсэн үг юм. Зохиолч хүн бол уран бүтээл дээр үнэхээр билэг оюунтай байдгийг эндээс харж бахархаж байсан. Ж.Баяржаргал ахдаа үнэхээр баярлаж, бахархаж явдаг.

Зургийн цомог дээрээ оруулах баяжилт, өөрчлөлтүүдээ хийгээд ангийн захирагч болон бусад даргын зөвлөлийн гишүүдээр 3 удаа хянуулж, нэмэлт засваруудыг хийгээд эхээ бэлэн болгосон. Цомгоо "Соёмбо принтинг" компани дээр хэвлүүлсэн. Хэвлүүлэхэд ямар ч бэрхшээл үүсээгүй. Хавтасны зураг, үсгийн товгор байдал /кише/ ерөнхий бүтцийг ангийн захирагч 7 хоног шахам хянаж баталсан. Ер нь маш их олон хүний хөдөлмөр зүтгэл орсон ажил болсон. Ангийн бие бүрэлдэхүүнээс энэ ажилд оролцоогүй хүн гэж байхгүй. Мөн ахмад хилчдийн оролцоо их байсныг дурдах нь зүйтэй болов уу. Зургийн фонд бий болгох, эх бэлтгэхэд ахмад И.Октябрь хамтарч ажилласан. Даргын зөвлөлийн гишүүд, тасаг албаны дарга нар, мөн штабын даргын оролцоо их байсан. Хамтын ажиллагааны үр дүнд бий болдог ажил юм байна гэдгийг маш сайн ойлгож авсан.

Ер нь бол маш өргөн агуулгатай түүхэн цомог болсон гэж үзэж байгаа. Цомог авсан ахмад хилчид маань ч талархан сайшааж байсан. "Сударлан орших Сулинхээр мину" цомог маань одоо ажиллаж байгаа ангийн бие бүрэлдэхүүний бүгдийнх нь зураг багтсан, мөн ангийн түүх, Дорноговь аймгийн хил орчмын нутаг дэвсгэрийн газар нутгийн онцлог, түүх гээд олон зүйлийг агуулсанаараа онцлог болсон.

А. -Бусад дурсгалын зүйлийн тухайд?

"Эх орны манаа" сонины тусгай дугаарыг ахмад И.Октябрь бид 2 ХХЕГ-ын олон нийттэй харилцах албаны бүрэлдэхүүнтэй хамтарч гаргасан. Тэд маш их сэтгэл гаргаж, хамтарч ажилласанд талархаж байна.

Бэлэг дурсгалын хувьд Улаанбаатар хотод загварыг нь Л.Түвшинбат гэдэг урлаачаар хийлгэсэн. Маш их зүтгэл гаргаж хийж өгсөн. Энэ бол ангийн захирагч, хурандаа П.Батбилэг бид хоёрын ярилцаж байгаад гаргаж авсан загвар. Их сайхан дурсгалын

зүйл болсон. Сэтгэл хангалуун байгаа шүү. Тэгээд ойд хүрэлцэн ирсэн ахмад хилчид, тэдний гэр бүл, хүндэт зочиддоо гардуулан өгсөн дөө. Зочид төлөөлөгчид маань маш талархалтай хүлээн авсан.

-Танд ажлын амжилт хүсье.

-Баярлалаа. Бидний хийж бүтээснийг бодитойгоор үнэлж талархал илэрхийлсэн ахмад хилчид тэдний гэр бүлд аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хилийн 0168 дугаар ангийн ахмад хилчин, дэд хурандаа Т.Жаргалсайхан

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЭГДСЭН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ АГУУЛГА, МӨН ЧАНАР

Доктор, профессор Ц.Ганболд

Хилийн аюулгүй байдлыг хангах субъектууд, тэдгээрийн үүрэг оролцоо

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, нэгдмэл тогтолцооны бүрдэл хэсэг болох субъектүүдийн харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах нь хилийн аюулгүй байдлыг хангахад гол үүрэгтэй, шийдлээ хүлээж буй чухал асуудлуудын нэг юм.

Доор дурдагдсан субъектууд хилийн аюулгүй байдлыг хангах талаар өөрсдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тусгайлан заасан эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Монгол Улсын аюулгүй байдлын тухай хууль (2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан. Төрийн мэдээлэл сэтгүүл. 2002 он, №3), Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр. Дугаар 48)-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж МУ-ын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

МУ-ын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

"Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа" гэж МУ-ын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ.

МУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд: Байгаль орчныг хамгаалах алба, Гаалийн алба, Дипломат алба, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн хяналтын алба, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, Татварын алба, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, Цагдаагийн алба, Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй.

Хурдтай хувиран өөрчлөгдөж байгаа аюулгүй байдлын орчинд үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататгахын тулд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож хөгжүүлэх

шаардлага тулгарч байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох зорилт:

-Төрийн бүх шатны үйл ажиллагаанд үндэсний ашиг сонирхлыг дээдэлж, төрийн анхдагч үүрэг болсон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг чухалчилна;

-Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ;

-Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно;

-Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ;

-Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа бүхэлдээ мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан байх нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлаа төр-ард түмний нэгдмэл хүчээр хангана;

- Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, төрийн холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид болон иргэдийг шаардлагатай мэдээллээр цаг тухайд нь хангах, үндэсний аюулгүй байлын мэдээллийн сан байгуулах ажлыг чухалчилж, түүний бүрдүүлэлт, хамгаалалт, ашиглалтын горимыг шинэчилж хэрэгжүүлнэ;

- Аюулгүй байдал, гадаад бодлогын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлнэ;

-Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ;

-Гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхийг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бусад байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшинг шинэ шатанд гаргана.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг МУ-ын Их Хурал, МУ-ын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, МУ-ын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ гэж заасан нь МУ-ын хэмжээнд аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, удирдлагын болон зохион байгуулалтын үйл ажиллагааг явуулах, хэрэгжүүлэх үндэс болсон.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий хуульчлан заасан олон байгууллагууд байдаг, тэдгээрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг ч тодорхой. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,

харилцан, хамтран ажиллуулах үндсэн чиг үүрэгтэй Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын алба хэмээх орон тооны ажлын аппарат байдаг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг Улсын Их Хурал 1992 оны 5 дугаар сард батлан гаргасан (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УБ хот, "T&U" Хэвлэх үйлдвэр, 2002 он. тал-45) гаргасан бөгөөд энэ хуулийн дагуу эрх, үүргээ хэрэгжүүлдэг.

Судалгааны ажлын хүрээнд хилийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа, энэ үйл ажиллагаанд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд хэрхэн харилцан, хамтран ажиллаж байгаа болон бодит байдал, үр дүнгийн талаар доор тодорхой авч үзэх бөгөөд хил дамнасан малын хулгайн асуудал дээр гэхэд олон жилийн турш энэ үйлдэл таслан зогсоогдохгүй, улам бүр зохион байгуулалтанд орсон, олон улсын, хил дамнасан шинжийг агуулах болсон төдийгүй түүнтэй тэмцэх ажил нь зөвхөн Хил хамгаалах байгууллагын үүрэг мэтээр ханддаг болсонд, үндэсний аюулгүй байдлыг хангах систем бүрэн ажиллаж чадахгүй, энэ бүхэл бүтэн системийг бүрдүүлэгч аль нэг элементийн хамгийн багаар тооцоход аль нэг нь ажиллахгүй, ажилласан ч дутуу ажиллаж байгаатай холбоотой.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохицуулалт тааруу, чиг чигээ харсан байдалтай, харилцан, хамтран ажиллах төлөвлөгөө байдагч гэсэн тодотгодоггүй, хамтарсан дадлага, сургуульлалт хийдэггүй, хамтын үйл ажиллагааны амьд механизм бүрдээгүй, цаасан дээр л байдаг гэсэн шүүмжлэл нилээд байдаг.

Доктор, профессор Ш.Лхачинжав "...хил хамгаалалт нь зөвхөн ХХБ-ын үүрэг болон хувирсан бөгөөд хуулиар хүлээсэн төр захиргаа, аж ахуй, орон нутгийн байгууллага, иргэдийн оролцоо хаягдсан гэж үзэх үндэстэй" гэж дүгнэсэнтэй санал, үзэл нэг байгаа болно.

Мөн судалгаагаар, Үзэл баримтлал, хуулийн дагуу төв, орон нутгийн байгууллагууд үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зардлыг жил бүр төсөвт суулган хэрэгжүүлэх ёстой ч бодит байдал дээр Засгийн газрын нөөц хөрөнгөөс авч хэрэглэсээр байгаа болон гол хүчин зүйл нь үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй субъектуудын албан тушаалтнуудын мэдлэг, чадвартай шууд холбоотойг тогтоосон. Бидний анхаарах гол асуудлууд эдгээр болно.

Энэ талаар ҮАБЗ-ийн Стратегийн судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан дугуй ширээний ярилцлага дээр мэргэжилтэн, судлаачид үзэл бодлоо илэрхийлж байсан байдаг. / Стратеги судлал сэтгүүл. 2007 он. №3 (39)/

Энэ байдал хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоон дээр илүү тод харагддаг.

МУ-ын хилийн аюулгүй байдал нь / цаашид "хилийн аюулгүй байдал" гэх/ МУ-ын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн. Хилийн аюулгүй

байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.

Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхолыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.

Хилийн тухай хууль нь 8 бүлэг, 58 зүйлээс бүрдэх бөгөөд үүнээс 17 зүйлд үндэсний аюулгүй байлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий МУ-ын байгууллагуудын харилцан ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна.

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого (МУ-ын Их Хурлын тогтоол. 2002 оны 05 дугаар сарын 16-ны өдөр. Дугаар 20) нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг юм.

МУ-ын хилийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэх нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх талаар эрх зүйн бичиг баримтууд дээр дурдсанчлан цогц байдлаар хуульчлагдан батлагдсан боловч амьдрал, практикт хэрэгжих тал дээр хангалтгүй, уялдуулан зангидах зохицуулах үүрэгтэй төрийн институци огт ажиллахгүй, чиг чигээ харсан байдалтай бөгөөд хамтран ажиллаж үр дүнд хүрэх байтугай хуульд заасан үндсэн үүргээ ч биелүүлж чадахгүй байнгын шүүмжлэлд өртөж, иргэдийн зүгээс тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх итгэл алдагдсаар байгаа нь нууц биш билээ.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо, түүний агуулга, мөн чанар

Дотоод, гадаадын аюул заналаас улс орны үндэсний ашиг сонирхлыг хилийн орчинд хангах нь төр, нийгмийн зүгээс анхаарах амин чухал асуудлуудын нэг бөгөөд хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн субьектүүдийн чиглэсэн зорилготой, өргөн хүрээтэй, олон талтай үйл ажиллагааны үр дүнд хэрэгжих зүй тогтолтой.

Энэхүү зайлшгүй шаардлагыг хэрэгжүүлэх нь субьектүүдийн хүч боломжийг нэгтгэн тэдний үүрэг, харилцааг тодотгож, хувиран өөрчлөгдөж байгаа амьдрал үйл ажиллагааны өнөөгийн нөхцөлд учирч болзошгүй аюул заналыг арилгах, саармагжуулах, зайлуулах зорилго, чиглэлтэй, зохион байгуулалттай, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх журмыг ашиглах нөхцөлийг хангах шаардлагатай.

1. Хилийн аюулгүй байдал нь манай улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрч "хилийн аюулгүй байдлыг хангах" гэдэг ухагдахууныг "энэ нь төрийн байгууллагууд, нийгмийн институцүүд, иргэдийн ашиг сонирхолд учирч болзошгүй гадаад, дотоод аюул заналаас найдвартай хамгаалах, аюул заналыг арилгах, саармагжуулах, зайлуулахад чиглэсэн үр дүнтэй нэгдмэл үйл ажиллагаа" / Дмитриев В.А и другие. Проблема сбалансирования системы охраны защиты государственной границы. М.2001/ гэсэн үндэсний аюулгүй байдлыг хангах тухай томъёоллыг иш үндэс болгож болох юм.

"Хилийн аюулгүй байдлыг хангах" гэдэг нь улс орны үндэсний ашиг сонирхлыг улсын хил, хилийн орчинд үүссэн гадаад, дотоод аюул заналаас найдвартай хамгаалах, тэдгээрийг үр дүнтэй сөрөн зогсоход чиглэсэн төрийн байгууллагууд, нийгмийн институцүүдийн болон иргэдийн нэгдмэл үйл ажиллагаа гэж томъёолж болно.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь улс орны тусгаар тогтнолд аюул учруулах, олон улсын эрх зүйн субьектынх нь хувьд түүний үүрэг, ач холбогдлыг бууруулах, аюул, заналыг арилган хилийн орчинд нийгэм, төр, иргэдийг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, эдгээрийн язгуур эрх ашгийг хангахад шаардлагатай хамгаалалтын төвшинг буй болгоход оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилтуудыг тодорхойлох шаардлагатай. Энэ нь нэгдүгээрт, хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул занал буй болохоос урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, хоёрдугаарт, тэдгээрийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилтуудын зэрэгцээ, тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох, туслах чанарын зарим үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээрийг тодотгож өгдөг тулгуур нь аливаа өөрчлөн хувиргах үйл ажиллагаа хоёр төрөлд хуваагддаг гэсэн философи үндэслэл мөн. Энэ нь:

1. Үр дүн нь бодит байдлыг тухайн шатанд эцэслэн өөрчлөх үндсэн зорилтууд (Энэ тохиолдолд аюул, заналыг нэг бол таатай, эсвэл саармаг ажиллагаа болгох, үгүй бол сүйтгэх хүчийг сулруулан өөрчлөх).

2. Үр дүн нь эцсийн зорилгод хүрэх таатай нөхцөл байдлыг бүрдүүлдэг туслах зорилтууд юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх туслах чанарын үйл ажиллагаанд дараах арга хэмжээнүүд орно. / Дмитриев В.А и другие. Проблема сбалансирования системы охраны защиты государственной границы. М.2001/.

а. Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг удирдах үед:

- Цагийн байдлыг үнэлэн шинжлэх, түүний цаашдын өрнөлтийг урьдчилан мэдээлэх;
- Хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа бүх субъект, хүч

хэрэгслүүдийн үйл ажиллагааны мэдээлэл-шинжилгээний хангалтыг тасралтгүй явуулах;
- Хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа субъектүүдийн харилцан ажиллагааг зохицуулах;
- Хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;
- Хилийн аюулгүй байдлыг хангах зорилтуудыг шийдвэрлэх явцад цагийн байдлын өөрчлөлтийг тогтмол хянаж, шаардлагатай тодотголуудыг хийж байх.

б. Хилийн аюулгүй байдлыг хангах хүч хэрэгслүүдийг сонгон бэлтгэж байршуулах үед:
- Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн болон туслах зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудыг байгуулж эрх мэдлийг хуваарилах;
- Төрийн бүтцүүдийн эрх мэдэлд багтах үүргүүдийг биелүүлэх чадвартай хүмүүсийг олж, үүссэн заналыг ердийн нөхцөлд илрүүлэн, сөрөн зогсох зорилтыг шийдвэрлэх аргын талаарх мэдлэгээр хангах, тавигдсан зорилтыг амжилттай биелүүлэхэд шаардлагатай газарт зөв байршуулах талаар хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд байнгын эрэл хийж байх;
- Тактик, техникийн үзүүлэлтээр цагийн байдлын тодорхой нөхцөлд үүссэн аюул, заналыг илрүүлэн эсэргүүцэх зорилтыг шийдвэрлэх боломжтой, орчин үеийн техник хэрэгслүүдийг ашиглах.

в. Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны материал техник, санхүүгийн хангалтын чиглэлээр:
- Учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэн арилгах, хилийн аюулгүй байдлыг хангах бусад зорилтуудыг шийдвэрлэхэд шаардлагатай материал техникийн хэрэгслүүдийг цаг тухайд нь бэлэн байлгах;
- Хилийн аюулгүй байдлыг хангах зорилтуудыг шийдвэрлэхэд шаардлагатай техник хэрэгслүүдийг шинээр бүтээх, үйлдвэрлэх, нэвтрүүлэх;
- Хилийн орчны цагийн байдлыг задлан шинжилж үнэлэн, урьдчилсан дүгнэлт гаргасны үндсэн дээр ойрын ирээдүйд хилийн аюулгүй байдлыг хангах зорилтыг шийдвэрлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг жил, жилийн төсөвт тусгах.

г. Хилийн аюулгүй байдлыг хангах туслах зорилтын хүрээнд түүний эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд:
- Үүсэж болзошгүй аюул заналыг үр дүнтэй сөрөн зогсож, улмаар арилгахад чиглэгдсэн хилийн орчин дахь үндэсний ашиг сонирхолд учруулж болохуйц бодит болон болзошгүй аюул заналыг задлан шинжилж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бий болгох;
- Хилийн аюулгүй байдлыг хангах хүрээний харилцааг зохицуулах, эрх зүйн хэм хэмжээ тогтоох баримт бичгүүдийн заалтуудыг хэрэгжүүлэх тодорхой механизм

бүрдүүлэх;

- Хилийн аюулгүй байдлын эрх зүйн үндэс болсон хуулийн заалтуудын биелэлтэд хяналт тавьж, тэдгээрийг хэрэгжүүлээгүй гэм буруутнуудад хариуцлага хүлээлгэх.

Хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлэх нь бусад зорилтуудаас тэргүүлэх ач холбогдолтойг онцлон тэмдэглэе. Эндээс улсын хилийн аюулгүй байдлыг зохицуулах механизм, эрх зүйн орчинг сайн бүрдүүлэхгүйгээр хилийн аюулгүй байдлыг үр дүнтэй хангах боломжгүй.

"Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-д "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцах"-аар заажээ.

Орчин үеийн шинжлэх ухаан «тогтолцоо» гэдэг ухагдахууныг олон янзаар тодорхойлжээ. Жишээлбэл: тогтолцооны ерөнхий онолыг үндэслэгчдийн нэг Л. Берталанфийн томьёолсноор «Тогтолцоо гэдэг нь үйл ажиллагааны харилцан үйлчлэлд орших элементүүдийн нэгдмэл цогц» / Bertalanfy L. Problems of life-№ 4.1960 p.148/юм.

"Нэгдмэл" гэдэг нь тогтолцооны хүрээнд харилцан уялдаа бүхий элементүүдийн гаднах орчин нь бусад тогтолцоонуудтайгаа цогц болох, нэгдэн нэгэн цул болно гэсэн ойлголт юм.

Тогтолцоо гэдэг нь: Нэгдүгээрт, ажиллах тодорхой хүрээлэл өөрийн элементүүдийн үйл ажиллагааны ерөнхий орчинтой.

Хоёрдугаарт, тогтолцоо нь өөрийнхөө дотоод зохион байгуулалт, бүтэц, бүрдүүлэгч элментүүдээс бүрдэнэ.

Гуравдугаарт, тогтолцооны нэгэн чухал шинж нь бүх элементүүдийн хувьд нийтлэг үйл ажиллагааны зорилго, түүндээ зохицсон үүрэгтэй байна.

Дөрөвдүгээрт, тогтолцоо нь оршин тогтнох бүтцийн хувьд бусад дэд тогтолцоонуудаас (Афанасьев В.Г.Системность и общество. М.1980 с.107.148) бүрддэг онцлогтой.

Дээрхэд үндэслэн "Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо гэдэг нь хилийн аюулгүй байдлыг хангах орчны харилцааг зохицуулах үзэл баримтлалын үндсүүд, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон актууд, хуулийн дагуу хилийн аюулгүй байдлыг хангахад оролцож байгаа харилцан уялдаа бүхий төрийн захиргааны болон олон нийтийн байгууллага, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн үйл ажиллагааны нэгдмэл цогц" хэмээн тодорхойлсон юм.

Тогтолцооны бүтцийн агуулгыг:

а. Үзэл баримтлалын

б. Байгууллагын /Институцчилсэн/

в. Эрх зүйн гэсэн гурван үндсэн дэд тогтолцоонд хуваах боломжтой.

Хилийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын дэд тогтолцоо нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн энэ ажиллагаанд субьектив нөхцөл байдал үүсгэхгүй байх, цалгардлыг арилгах нөхцлийг

бүрдүүлдэг байна.

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого" зэрэг нь дээрх хэсэгт багтаж дэд тогтолцоог төлөөлж байна.

Эдгээр баримт бичгүүд нь төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхлыг хилийн орчинд хамгаалах албан ёсны үзэл баримтлал, хилийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын үндэс болж байна.

Монгол Улсын үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Улсын хилийн тухай хуулиуд болон эрх зүйн бусад актууд, түүнчлэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсүүдэд суурилсан дэд тогтолцоо бүрджээ.

Хилийн аюулгүй байдлыг хангах байгууллагын /Институцчилсэн/ дэд тогтолцоог хилийн орон зайд улсын эрх ашгийг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэг бүхий субъектүүд болох төрийн захиргааны болон тусгай байгууллагууд, өөрийгөө удирдах орон нутгийн ба олон нийтийн байгууллагууд, ард иргэд бүрдүүлдэг.

Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн хэм хэмжээний дэд тогтолцоонд хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэгч олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжууд орно. Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог улсын, бүс нутгийн, орон нутгийн гэсэн үндсэн гурван төвшинд авч үзнэ. Улсын хэмжээний төвшинд төрийн захиргааны төв байгууллагууд орох бөгөөд тэдгээр нь МУ-ын хилийг манах, хамгаалах хүрээнд МУ-ын үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Улсын төвшний байгууллагууд хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улс орны хэмжээнд уялдуулан зохицуулах, чиглүүлэх үүрэгтэй.


Хилийн аюулгүй байдлыг хангах нь ямагт төрийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь байсаар ирсэн.

Хилийн аюулгүй байдлыг хангахын тулд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн зүгээс МУ-ын язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх бүх талын баталгаа бий болгоход чиглэсэн ажиллагааг явуулдаг.

Хилийн аюулгүй байдлыг хангах субъектүүдийн үйл ажиллагаа нь хоорондоо нягт уялдаа зохицуулалттай, хамтран, харилцан ажиллах механизмтай байх ёстой.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд МУ-ын Үндсэн Хууль болон бусад хуульд нийцүүлэн хилийн аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Монголын улс төрийн нам, холбоо, төрийн бус байгууллага, иргэд хилийн аюулгүй байдлыг хангах асуудлаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцох, туслах хэлбэрээр идэвхтэй оролцдог.

Үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах субъект тус бүрийн тухайн хүрээний эрх үүрэг, оролцооны талаар тодруулъя.



Хүснэгт №2. МУ-ын Үндэсний болон Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоо

Монгол Улсын Их Хурал нь хилийн аюулгүй байдлыг хангах талаар өргөн эрхтэй юм.

Улсынхилийншугамыгтодорхойлох, тогтоох, өөрчлөх асуудлыг МУ-ын Их Хурал шийдвэрлэнэ. /МУ-ын Хилийн тухай хууль. 6 дугаар зүйл. Төрийн мэдээлэл, 2017 он, №6./

Улсын хилийг газар дээр нь тогтоохын тулд хил залгаа улстай хилийн шугамыг тодорхойлж, хилийн гэрээ байгуулах ба түүнийг Улсын Их Хурал соёрхон батална. /Монгол Улсын Хилийн тухай хууль. 7 дугаар зүйл. Төрийн мэдээлэл, 2017 он, №6./

МУ-ын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээг УИХ заавал соёрхон батална. /МУ-ын Олон Улсын гэрээний тухай хууль. 8 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 2017он. №2/

Хилийн талаар баримтлах бодлогод олон улсын харилцааны хөгжил, дэлхий

дахины болон бүс нутаг, хил залгаа улс дахь цэрэг-улс төрийн байдал, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх. / Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 3 дугаар бүлгийн 4 заалт/

УИХ-ын тухай МУ-ын хуульд УИХ нь бүтцийн хувьд байнгын ба түр хороо, дэд хороо, намуудын бүлэг, зөвлөл болон байгууллагуудтай бөгөөд УИХ нь тэдгээрээрээ дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Тухайлбал:

-Аюулгүй байдал, Гадаад бодлогын байнгын хороо нь батлан хамгаалах, зэвсэгт хүчин, төрийн нууц хамгаалах, улсын хил хамгаалах, олон улсын хэлэлцээр, олон улсын байгууллагад нэгдэн орох зэрэг асуудлыг шийдвэрлэдэг.

-Нийгмийн бодлогын байнгын хороо нь хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийтийн биеийн тамир болон спорт, хөдөлмөрийн харилцааны хамгаалал зэрэг асуудлыг шийдвэрлэнэ. Төрийн байгууллагын байнгын хороо нь УИХ, Ерөнхийлөгчийн болон аймаг, сум, дүүргийн төлөөлөгчдийн хурлын сонгууль, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжүүдийн зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлыг шийдвэрлэдэг.

-Хууль зүйн байнгын хороо нь улсын хил хамгаалалтын бодлогыг хэрэгжүүлнэ.

-Тусгай хяналтын дэд хороо нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаархи хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг эрхлэн хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг, төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, хүч хэрэгслүүдийг ерөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дээрх байгууллагуудыг хууль тогтоомжийн дагуу татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой илгээлт, удирдамж, уриалга гаргах, үндэсний аюулгүй байдлын эрх зүйн актуудын зарим заалтад тодотгол хийх, дотоод, гадаад бодлогын чиглэлийг тодорхойлох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч хилийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, зохион байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

МУ-ын Үндсэн Хууль болон Ерөнхийлөгчийн тухай хуулиар МУ-ын Ерөнхийлөгчид үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах асуудлаар олгосон бүрэн эрхийг хэд хэдэн бүлэг, багц болгож болох юм.

-Улс орноо болон төрийн байгууллагуудыг удирдах салбар дахь бүрэн эрх. Тухайлбал: УИХ-ын хуралдаанд оролцож, улс орны гадаад, дотоод байдлын нэн чухал асуудлаар илтгэл тавих, Үндсэн Хуулийн дагуу үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах асуудлаар чиглэл өгөх, /Ерөнхийлөгчийн тухай МУ-ын хууль.

12-р зүйл/

-Улс орныг батлан хамгаалах салбар дахь бүрэн эрх. Тэрбээр ҮАБЗ-ийг тэргүүлж, батлан хамгаалах, хил хамгаалах, эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын илтгэл, мэдээллийг сонсож, Зэвсэгт Хүчний Ерөнхий Командлагч байх бүрэн эрх / Ерөнхийлөгчийн тухай МУ-ын хууль. 13-р зүйл/, МУ-ын Ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд улсын хил, онц чухал объектын хамгаалалтад зэвсэгт хүчнээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх, /МУ-ын Зэвсэгт хүчний тухай хууль.2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр.11.1.1/ ба мөн Хил хамгаалалтын дүрмүүд,Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам зэргийг батламжлах зэрэг болно.

-Гадаад харилцааны салбар дахь бүрэн эрх. Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн эрхтэй төлөөлөх бөгөөд Монгол Улсын Их Хуралтай зөвшилцсөнөөр МУ-ын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна.

Ерөнхийлөгчийн тэргүүлсэн ҮАБЗ нь үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл улс төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх төрийн зөвлөлдөх байгууллага юм.

Шийдвэр гаргахдаа нэгдмэл саналын зарчмыг удирдлага болгодог ҮАБЗ нь МУ-ын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд зэрэг гишүүд болон нарийн бичгийн дарга, зөвлөхүүд, илтгэгч, шинжээчдээс бүрддэг. /ҮАБЗ-ийн тухай МУ-ын хууль. 6 дугаар зүйлийн 1/.

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлж, өдөр тутмын удирдлагаар хангадаг ажлын аппарат нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах Ерөнхийлөгчийн шийдвэрийн саналын төслийг бэлтгэж, уг шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүрэгтэй.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээгээр хангах журам"-ыг баталж, ҮАБ-ыг хангах нэгдмэл бодлого боловсруулах, дүгнэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, шийдвэрлэх чиглэл, даалгавар өгөх, шаардлага тавих, хэрэгжилтэд хяналт тавихад шаардлагатай мэдээллээр төрийн холбогдох байгууллагууд зөвлөлийг хангахтай холбогдох харилцааг зохицуулсныг хэрэгжүүлэн ажиллана.

Монгол Улсын Засгийн газар нь Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана, Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг: Сангийн сайд, хилийн боомтын хөгжлийн асуудал, Хууль зүй дотоод хэргийн сайд, улсын хил хамгааллын асуудлыг эрхэлнэ. /МУ-ын Засгийн газрын тухай хууль.13 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 1993. №3./

Улсын хилийг хамтран шалгах явцад байгалийн нөлөөллөөс шалтгаалан газрын гадаргуу, усны гольдрол өөрчлөгдсөнөөс хилийн шугамын

байршлыг тодотгох шаардлага гарсан тохиолдолд хил залгаа улстай хилийн дэглэмийн асуудлаар байгуулсан МУ-ын олон улсын гэрээний дагуу тогтоосон хилийн шугамыг уул шугамаас аль нэг тийш, 200 метр хүртэл зайд өөрчилж тухайн өөрчилсөн газар нутгийг адил чанарын газар нутгаар сольж зохицуулах асуудлыг МУ-ын Засгийн газар тухай бүрд нь шийдвэрлэж, хил шалгах ажлын төгсгөлөөр нэгтгэн Улсын Их Хуралд өргөн мэдэж шийдвэрлүүлнэ./МУ-ын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай хууль. 1 дүгээр зүйл. Төрийн мэдээлэл, 1993. №4/

МУ-ын Засгийн газар нь гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасанчлан, өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулан, улсын болон хилийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг улсын төсөвт тусгана.

МУ-ын Засгийн газар нь "Үндэсний аюулгүй байдал, улсыг батлан хамгаалах зорилтыг хангахад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх; цэргийн бодлого боловсруулах; Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх; Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдах; Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх; Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авах; Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, сэргээн босгох, онцгой ажиллагааг удирдан чиглүүлэх" /Монгол улсын засгийн газрын тухай хууль.УБ.1993/ зэрэг бүрэн эрхээр хангагджээ.


МУ-ын Засгийн газар нь "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт, материал техникийн хангамжийн норм, хэмжээг тогтоох, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах /МУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлого.УБ.2002/ зэрэг асуудлыг хариуцна.

МУ-ын төрийн захиргааны төв байгууллагууд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд зааснаар, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар гарсан хууль тогтоомжууд, МУ-ын Ерөнхийлөгч болон Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд энэ салбарт холбогдолтой эрх зүйн актуудыг боловсруулж МУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барина.

Монгол Улсын хил хамгаалах алба нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны хуульчилсан цөм, хил хамгаалах байгууллагуудыг удирдах төв байгууллага болохынхоо хувьд МУ-ын хууль тогтоомжийн дагуу хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналын талаар мэдээлэл цуглуулж боловсруулан МУ-ын Ерөнхийлөгчид танилцуулах, МУ-ын гүйцэтгэх засаглал, тэдгээрийн харьяа орон нутгийн байгууллагуудад хилийн цагийн байдлын талаар

мэдээлэх, улсын хилийг манах, хамгаалах үед гүйцэтгэх засаглалын болон орон нутгийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг удирдан уялдуулах шуурхай штабуудыг байгуулах, хүч хэрэгслийг зохицуулах, улс төр, эдийн засаг, цэргийн болон бусад ашиг сонирхлыг хилийн орон зайд дээрх байгууллагуудын хүч хэрэгслийг ашиглан хамгаалах, хамтарсан арга хэмжээнүүдийг /хилийн операци, хилийн эрэл/ төлөвлөж хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалалтыг зохион байгуулах, МУ-ын олон улсын гэрээгээр хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу нэвтрүүлэх зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлнэ.

ХХБ нь Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, биелүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад гол үүрэг хүлээнэ.



Хүснэгт №2. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэгч, хилийн аюулгүй байдлыг хангагч субъектүүд

МУ-ын төрийн захиргааны төв байгууллагууд хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлыг хилийн орчинд хангах зорилтыг шийдвэрлэх, зохицуулах, МУ-ын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Тэдгээрийн хилийн аюулгүй байдлыг хангах талаар хүлээх үүрэг, эдлэх бүрэн эрхийг МУ-ын Хилийн тухай хуульд тусгасан.

Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хуурай замын цэргийн командлал, түүний салбаруудтай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

"Батлан хамгаалах эрх ашиг" гэж МУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдал хангагдсан байхыг, /Батлан хамгаалах тухай хууль.3.1.5 дугаар зүйл.Төрийн мэдээлэл. 2016 он, №36/.

Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь МУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино. /Батлан хамгаалах тухай хууль.5.2 дугаар зүйл.Төрийн мэдээлэл. 2016 он, №36/.

Зэвсэгт хүчин нь улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ. /МУ-ын Зэвсэгт хүчний тухай хууль. 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр. 6.2.3./

"Хил халхлах ерөнхий төлөвлөгөө" дагуу улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх анги, салбаруудын томилгоожуулан, хамтарсан дадлага сургуульлалт хийж байна.

-Улсын хил дээр цэрэг-улс төрийн нөхцөл байдал хурцадсан болон улсын хилийг халхлах үед: гүйцэтгэх үүрэг, хариуц ах хэсэг, хил халхлах журам,удирдах байрууын байрлал, харилцан ажиллах журам, удирдах нэгдсэн дохио, холбоог зохион байгуулах журам, урьдчилан бэлтгэх инженерийн төхөөрөмж, ар тал, техникийн хангалт хийх журам;

- Зэвсэгт халдлагыг няцаах үед: улсын хил дээр үүссэн зэвсэгт халдлага, хорлон сүйтгэх тагнуул, алан хядагчдын бүлгийг устгах;

-Хилийн эрэл, операци явуулах үед: дэмжих бүлгийн үүрэг гүйцэтгэх бөгөөд бүрэлдэхүүн, үүрэг, уулзах газар, хүрэлцэн очих хугацаа, дуудах журам, үүрэг гүйцэтгэх зааг, зурвас, район, үүрэг гүйцэтгэх журам, холбоо зохион байгуулах журам, удирдах дохио, ар тал, техникийн хангалтын асуудал;

-Улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалж буй болон зэвсэггүй бөөн иргэдийн цөмрөлтийг няцааж буй үед: хүч нэмэгдүүлэх салбарын үүрэг гүйцэтгэх бөгөөд бүрэлдэхүүн, үүрэг, уулзах газар, хүрэлцэн очих хугацаа, үүрэг гүйцэтгэх жрам, бүрэлдэхүүнийг хилийн застав, харуулуудад хүч нэмэгдүүлэх болон дангаар үүрэг гүйцэтгүүлэх журам, удирдах дохио, ХХБ-ын ашиг сонирхолд цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх үүрэг, мэдээ дамжуулах, солилцох журам, түр ба хөдөлгөөнт харуул байгуулах боломж, түүний үүрэг, хариуцах хэсэг зэрэг болно.

Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Агаарын цэргийн командлал, түүний анги, салбаруудтай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

-Улс орны агаарын хилийг зөрчсөн тохиолдолд харилцан ажиллах журам, бага өндөрт илэрсэн целийн талаар мэдээ солилцох журам;

-Хариуцлагын бүс дэх нислэгийн хөлгийн хаалга, түүгээр нисч өнгөрөх журам;

-Зөвшөөрөлгүй цель илэрсэн үед харилцан ажиллах журам;

-Хил орчимд агаарын цэргийн анги, салбаруудын хээрийн сургууль явагдах үед хилийн анги, салбаруудыг оролцуулах журам;

-Хилийн анги салбаруудын болон агаарын цэргийн анги, салбаруудын нислэгийн талбай, буудлыг харилцан ашиглах журам;

-Цаг агаар, цаг уурын талаарх мэдээлэл солилцох журам зэрэг болно.

Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн штаб, түүний анги, салбаруудтай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

ЦЕГ, ХЦУГ-ын дарга нарын 1998 оны 26/114 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Цагдаагийн болон Хил хамгаалах байгууллагын хамтран ажиллах журам", ХЗДХ-ийн сайд, Санхүү, эдийн засгийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын 2000 оны 149/114/343 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хилийн боомтын асуудлаар харилцан ажиллах журам"-д тодорхой тусгасан.

Харилцан ажиллах төлөвлөгөөний дагуу улсын хилийн бүс, зурваст байрлаж буй Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги, салбаруудыг ШНБ-д болон хилийн дэглэм, журам сахиулах ажиллагаанд оролцоход гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүн, байрлал, ажиллах журам, уулзах район, хүрэлцэн ирэх хугацаа, харилцан ажиллах дохио болон ар тал, техникийн хангалтын журмыг хэлэлцэж тохирно.

Мөн түүнчлэн Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги салбаруудтай харилцан ажилладаг хилийн анги салбарууд нь дараах журмууд, зарчмыг баримтлана. Үүнд:

-Хилийн зарим хэсэгт хилийн операци, эрэл, хээрийн сургууль, зэвсэгт өдөөн хатгалга, зэвсэггүй бөөн иргэдийн цөмрөлтийг няцаах зэрэг ажиллагаа явуулах үед иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох, хязгаарлах ажиллагааны журам;

-Улсын хил хамгаалалтын болон хил орчмын нутаг дэвсгэрт хэв журам сахиулах эрх ашгийн үүднээс мэдээ, мэдээлэл солилцох;

-Хил орчмын нутаг дэвсгэрт онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах журам;

-Улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалж буй үед хамтран ажиллах журам, хамтарсан эргүүл, харуул, манааны үүрэг гүйцэтгэх журам;

-Хилийн шалган нэвтрүүлэх албыг цагдаагийн байгууллагаас улсын хил нэвтрэхэд олгож буй бичигбаримт, тамга, эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсгийн загвараар хангах;

-Цагдаагийн байгууллагаас улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хүмүүсийг саатуулах зэрэг болно.

Тагнуулын байгууллагатай харилцан ажиллахдаа тохиролцох үндсэн асуудлууд:

-Улсын хилийг гүйцэтгэх ба тагнуулын хүч хэрэгслээр хамтран хамгаалах журам;

-Зэргэлдээ улсуудын тагнуулын байгууллага, тэдний тагнуул туршуулуудыг илрүүлэх болон тэдний үйлдлийг таслан зогсоох ажиллагаа;

-Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт улс орны аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалах үүднээс харилцан мэдээ, мэдээлэл солилцох, түүнийг хэрэгжүүлэх арга зам;

-Өөрийн иргэдийг гадаадад нэвтрэх, гадаадын иргэдийг манайд нэвтрэх үеийн тагнуулын хангалт;

-Хилийн операци, эрэл, боомт ажиллах үе болон зэвсэгт халдлага, алан хядах ажиллагаа, дүрвэгсдийн хөдөлгөөнийг саатуулах үеийн тагнуулын байгууллагын оролцоо, ажиллагаа зэрэг болно.

Гаалийн байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

-Улсын хилээр болон хилийн боомтоор хууль бус ачаа, бараа нэвтрүүлэхтэй хамтран тэмцэх;

-Улсын хилийн боомтод дэглэм сахиулах, тогтоох асуудлаар хамтран ажиллах;

-Зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг шалган нэвтрүүлэхэд хамтран ажиллах;

-ШНБ-д онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцан ажиллах;

-"Үндэсний цахим нэг цонх"-ны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах зэрэг болно.

Гадаадын иргэн ба харъяатын асуудал эрхэлсэн байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

Хөрш орнууд болон гуравдагч орноос улсын хилээр нэвтрэх хууль бус цагаачид, дүрвэгсэд, нэрвэгдэгсэд, иргэдийн хөдөлгөөнийг хянах, таслан зогсоох хамтарсан арга хэмжээ;

-Улсын хил дээр гадаад иргэд, харъяат цагаачдад тавих хяналт, тэдгээрийн талаар харилцан мэдээлэл солилцох журам, түүнийг хэрэгжүүлэх арга зам;

-Улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн, захиргааны журмаар албадан гаргах гадаадын иргэдтэй холбоотой асуудал, түүнийг хамтран хэрэгжүүлэх журам;

-ШНБ дээр хилийн хяналтын бусад байгууллагуудтай харилцан ажиллах журам зэрэг болно.

Эрүүл мэндийн байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

-Улсын хилээр хорио цээрт гоц халдварт өвчтэй хүмүүс, хүн амын эрүүл мэндэд аюултай барааг нэвтрэхээс хамгаалах хамтарсан арга хэмжээ;

-Хөрш улсуудын эрүүл мэнд, халдварт өвчлөлийн талаарх мэдээ мэдээлэл солилцох;

-Улсын хил дээр гарсан халдварт өвчний үед, хорио цээр тогтоох үеийн ажиллага, журам;

-Улсын хилээр халдварт өвчтэй хүмүүс бөөнөөр хил нэвтрэх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх хамтарсан арга хэмжээ зэрэг болно.

Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

-Улсын хилээр мал амьтан, ургамлын хортой өвчин, шавьж нэвтрэхээс сэргийлж хамтран ажиллах, холбогдох мэдээ мэдээлэл солилцох;

-ШНБ дээр мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт хийх журам, түүнийг сайжруулах хамтарсан арга хэмжээ;

-Хил орчмын нутаг дэвсгэрт мал амьтны халдварт өвчин гарсан үед хорио цээр тогтоох, хамтран ажиллах журам;

-Улсын хилээр нэвтэрч буй мал амьтныг тусгаарлан хянах зэрэг болно.

Онцгой байдлын байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

МУ-д жилд дунджаар 3500 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 200 гаруй хүн амь насаа алдаж, 700 орчим хүн гэмтэж бэртэн, 950000 толгой мал хорогдож, ойролцоогоор 70 гаруй тэрбум төгрөгийн шууд хохирол учирдаг.

ОББ нь "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого" /МУ-ын Их хурлын тогтоол. УБ. 2011, 22 дугаар тогтоол/, Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр"/Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд. 2016, х. 7/, Онц байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд, ОХУ-тай 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан Хил орчмын нутаг дэвсгэрт үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах гэрээ, 2014 оны 09 дүгээр сард байгуулсан "Ойн түймрээс хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр", МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1999 оны 07 дугаар сарын 15-ны өдөр баталсан "Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай" хэлэлцээрүүдийн үндсэн дээр хамтран, харилцан ажиллагааг зохион байгуулдаг.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт байгалийн гамшиг, онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах журам, үүрэг, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гамшгийн хор хөнөөлийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд хамтран оролцох, болзошгүй аюулын талаар харилцан мэдээ мэдээлэл солилцох зэрэг болно.

Байгаль орчныг хамгаалах байгууллагатай хамтран, харилцан ажиллах үндсэн асуудлууд:

МУ-ын хилд улсын хил дамнасан болон хил орчмын нутаг дэвсгэрт 11 Дархан цаазтай газар нутаг, 8 Байгалийн цогцолборт газар, 2 Байгалийн нөөц газар оршдог.

Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн байгалийн унаган төрхийг хадгалах, амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулах асуудлыг хууль тогтоомж, МУ-ын олон улсын гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ. / МУ-ын Хилийн тухай хууль.21.1 дүгээр заалт.Төрийн мэдээлэл,2017 он, №6/

Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно. /МУ-ын хууль. Байгаль орчныг хамгаалах тухай. 26 дугаар зүйл. Төрийн мэдээлэл, 1995 он. №5-6/.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогын 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн нөхөрлөл, төрийн бус байгууллага, цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтанд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байгаль орчин, уур амьсгалын сангаас олгоно. /МУ-ын хууль. Байгаль орчныг хамгаалах тухай. 54 дугаар зүйл. Төрийн мэдээлэл, 1995 он. №5-6/.

Улсын хил орчмын тодорхой нутаг дэвсгэрийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулж болно.

Улсын хил орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэхдээ Улсын хил хамгаалах байгууллагатай урьдчилан зөвшилцсөн байна.

Улсын хил хамгаалах байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу улсын хилийн болон хил орчмын дэглэмд нийцүүлэн улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг хамгаалалтын захиргаа буюу зохих шатны Засаг даргатай тохиролцон тогтооно.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалуулах зорилгоор хилийн төлөөлөгч, орлогч, туслагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож болно. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг зөвхөн хилийн бүсэд хэрэгжүүлнэ. / Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль.5 дугаар зүйл. Төрийн мэдээлэл.1995 он.№2/.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ХХЕГ-ын байгаль орчныг хамгаалах болон хил хамгаалах талаар хамтран ажиллах журам /Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, ХХЕГ-ын даргын 2010 оны 02 дугар сарын 24-ний өдрийн А-25/03 дугаар тушаалаар батлсан./

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, хилийн халдашгүй дарахн байлыг хангах үүднээс тухайн хилийн хэсгийг хариуцдаг хилийн отряд, Байгаль орчны асууал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, хамгаалалтын захиргаадын дарга нар энэхүү журмыг удирдлага болгон харилцан ажиллах тухай тусгай төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ба жил бүр тодотгон хамтран ажиллана.Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны хүлээх үүрэг:

-Хил орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах зорилгоор Байгаль орчны сайдын 2006 оны 24 тоот тушаалаар батлсан “Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах тухай” журмыг үндэслэн хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нарт идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх олгох;

-Хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа, байгаль, цаг

уурын гамшигт үзэгдлийн талаар хил хамгаалах байгууллагад шуурхай мэдэлж, цагийн байдлыг үнэлж, харилцан ажиллах, зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Хил орчмын нутаг дэвсгэрт хамтарсан хяналт шалгалтын ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа дүгнэж, тоорхой амжилт гаогасан буюу байгаль хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж хилчдийг шагнаж урамшуулж байх;

-ХХБ-аас (байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч) идэвхтэн байгаль хамгаалагчаар томилогдон ажиллаж байгаа хүмүүсийг байгаль орчны хамгаалах талаар зохион байгуулагдаж буй сургалт семинарт оролцуулж, холбогдох хууль тогтоомж, ажлын аргачлал болон бусад шаардлагатай материал, хэрэгслээр хангах;

-Хил орчмын нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээ, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг хүссэн хүмүүст холбогдох хууль тогтоомж, журам зааврыг үндэслэн зөвшөөрөл олгож байх;

-ХХБ-ын анги салбаруудтай хамтран хуулиар зөвшөөрөгдсөн бүс нутагт зохих зөвшөөрлийн дагуу байгалийн дагалт баялаг ашиглах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Хил орчмын нутаг дэвсгэрт хяналт шалгалт явуулах зорилгоор байр сууц барьж ашиглах, хилийн бүс, зурвасс болон тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн заагийг тэмдэгжүүлэхэд хамтран ажиллах;

-Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хилчдийг хамруулж, нийгмийн асуудлыг шиидвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хил хамгаалах ерөнхий газрын хүлээх үүрэг:

-ХХБ нь хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхээс гадна хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчмын нутаг эвсгэрийн байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ахуйн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, байгаль орчны эсрэг аливаа зөрчил гаргаж байгаа болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;

-Хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа, байгаль, цаг уурын гамшигт үзэгдлийн талаар байгаль орчин, аялал жуулчлалын газар, ахмгаалалтын захиргаанд шуурхай мэдээлж, цагийн байдлыг үнэлж, харилцан ажиллах, зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах;

-Байгаль орчин, аялал жуулчлалын газар, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаатай байгалийн дагалт баялгийг ахуйн хэрэгцээндээ ашиглах талаар гэрээ байгуулах;

-Хилийн бүс, зурвас дахь тусгай хамгаалалттай газар нутагт судхлгаа шинжилгээ, аялал жуулчлалын үйл ажиллага явуулах хүмүүст Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нэвтрэх

зөвшөөрөл олгох;

-Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон түүний харъяа байгууллагын ажилтнууд, улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг хяналт шлгалтын ажлаар албан томилолтоо хилийн зурваст явах үед нь боломжтой, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

-Хил орчмын нутаг дэвсгэр, хилийн зурваст байгаль орчны хууль тогтомж ноцтой зөрчигдсөн тохиолдолд ХХБ-ын анги салбарууд холбогдох туслалцаа үзүүлж, хамтарсан хяналт шалгалтыгихийж байх;

-Тусгай хамгаалалттай газар болон алслагдсан хилийн хэсгүүдэд хяналт шалгалт явуулах зорилгоор байр сууц барьж ашиглах, хилийн бүс, зурвас, тусгай хамгаалалттай азар нутгийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, хил орчмын ан амьтад ундаалдаг булаг шанд, усны эх үүсвэрийг хашиж хамгаалах, тохижуулахад хамтран ажиллах;

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлигаар баталсан "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам" –ын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтан, байгаль хамгалагч нарыг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байдлаар нь улсын хил хамгаалалтад оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд хил хамгаалахад туслах хүчний гишүүний үнэмлэх олгож, тодорхой амжилт гаргавал шагнаж урамшуулах зэрэг болно.

Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай харилцан ажиллах үндсэн асуудлууд:

МУ-ын засаг захиргааны үндсэн нэгж болсон 14 аймаг, 69 сум, 150 гаруй баг, 300000 орчим хүн ам хил орчмын нутаг дэвсгэрт оршдог.

МУ-ын газар нутгын 25 хувийг хил орчмын нутаг дэвсгэр эзэлдэг бөгөөд хилийн бүс, зурваст хүн амын 12 хувь, малын 30 орчим хувь нь суурьшин амьдарч байна.

Өнөөгийн байдлаар 246 аж ахуйн нэгж байгууллага хил орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулж байгаагаас 51 нь хилийн бүсэд, 195 нь хилийн зурваст байрлаж байна.

Монгол Улсын хилийн 14 аймагт хил хамгаалахад туслах хүчний зөвлөл, 69 суманд салбар зөвлөл ажиллаж байна.

Амьдрах болон ажил үйлдвэр эрхлэх байршлаар МУ-ын хилд 953 (үүнээс:Уулын бүсэд-330, говь-цөлийн бүсэд-216, ой тайгын бүсэд-277, тал хээрийн бүсэд-130) Улсын хил хамгаалалтад туслах хүчний гишүүн үүрэг гүйцэтгэж байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн Эдийн засгийн хөгжлийн бодлогын судалгааны секторын судалгааны үр дүнгээс авч үзвэл, хил орчмын нутаг дэвсгэрт 1х.д.км газарт нэг хүрэхгүй хүн ноогдож байгаа ба боловсрол багатай хүн ам зонхилсон бүтэц бүхий, ядуурал, ажилгүйдэл нүүрэлсэн бүс нутаг болон хувирч байна.

Экологийн хувьд өндөр уулын хээр, цөлийн хээр, цөлийн бүсийн хил орчмын сумдад уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг байгалийн хүчин зүйл илүү нөлөөлж байна. /Улсын хилийн

аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. ОУЭШБХ.УБ.2012.х-303-305/.

Мөн малын тоо толгой жил бүр багасч, билчээрийн доройтол нүүрлэж, хил хязгаар эзэнгүйдэн, хяналтгүй уул уурхайн нөлөөгөөр байгаль экологийн тэнцвэр алдагдаж байгаа зэрэг нь хилийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс болсоор байна.

Улсын хилийн хамгаалалтыг ердийн, хүч нэмэгдүүлсэн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед сайжруулах арга хэмжээ, хилийн бүс, зурвасын зах хязгаар, тэнд мөрдөх журмыг тогтоох, хилийн бүсэд зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, тэнд хөдөлгөөн үйлдэх, орох ба гарах мөн үйлдвэрлэл явуулах, оршин суух, олон нийтийг хамарсан соёл урлаг, улс төрийн арга хэмжээ явуулах журам, хилийн эрэл, операци болон алба-байлдааны бусад ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан хилийн бүсэд нэвтрэхэд авах нэмэгдэл арга хэмжээ,хязгаарлалт, хилийн асуудлаарх харилцан мэдээ, мэдээлэл солилцох, Засгийн газрын шийдвэр, тогтоолын дагуу хил хамгаалалтад туслах хүчин, орон нутгийн иргэдийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад оролцуулах, нөхцөл, журам зэрэг болно.

Шүүх засаглалын байгууллагууд, тэдгээртэй харилцан ажиллах үндсэн асуудлууд:

Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 9,10 дахь хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6.4 дүгээр зүйлийн 2.8 дахь заалт, 7.3 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16.1, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчилд шийтгэл оногдуулна. /Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 6.2 дугаар зүйл. Төрийн мэдээлэл.2017 он, №24/.

Энэхүү журмын зорилго нь эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах зорилгоор зөрчлийн холбогдогчийг саатуулах, үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох, холбогдогчийн бичиг баримтыг хураан авах, МУ-ын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх харилцааг зохицуулахад оршино. /Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журам.1.1 дүгээр зүйл. Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал. 2017-06-30-ны өдөр. Дугаар А/70-А-17/.

Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах нь хилийн дэглэм зөрчигчийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1. дэх хэсэгт зааснаар хүнийг саатуулах үндэслэл тогтоолд хяналт тавих прокурорт мэдэгдэх; /Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журам.2.4.2 дүгээр зүйл. Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал. 2017-06-30-ны өдөр. Дугаар А/70-А-17/.

-Улсын хил зөрчих, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчих зэрэг улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн аюулгүй байдалд халдсан гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх,

-Гадаад улсаас улсын хил зөрчсөний улмаас учирсан хохирол, ХХБ-аас зарцуулсан зардлыг хил залгаа

улсаас шүүхийн шугамаар нэхэмжлэн барагдуулахад хамтран ажиллах,

-Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн дагуу оногдуулсан торгууль, шийтгэврийн оногдуулалт, шийдвэрлэлтэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх,хяналт тавих,

-Улсын хилийн орон зайд хилийн аюулгүй байдал зөрчигдсөн үйлдэлтэй холбоотойгоор иргэд, байгууллагын зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээх чиглэлээр хамтран ажиллах зэрэг болно.

Хилийн аюулгүй байдлыг хангах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, зөвлөмж:

Монгол Улсын Их Хурал:

Хилийн цогцолбор менежментийн үзэл баримтлалыг Европын холбооны улсуудын хүрээнд өргөн ашиглаж байгаагийн зэрэгцээ дэлхийн зарим бүс нутаг, хөрш орнууд, ялангуяа Дундад Азийн Таджик, Киргиз, Казахстан зэрэг улсуудад "Хилийн аюулгүй байдлын үзэл баримтлал (концепц)" нэрээр нэвтрүүлж байна.

"Монгол Улсын хилийн менежментийн тайлан"-г МУ-ын хилийн менежментийн тогтолцооны үндсэн үзүүлэлтүүд болон хэрэгцээг тодорхойлох, хилийн менежментийг ирээдүйн хөгжил, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд МУ-ын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 2013 онд Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүсэлтээр Австри Улсын Вена хот дахь Шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах олон улсын төв (ШХББОУТ, ICMPD) хийсэн байдаг.

Хилийн цогцолбор менежментийн үзэл баримтлал нь "Нээлттэй боловч найдвартай, хяналттай аюулгүй хилийг бий болгох, хилийн аюулгүй байдал, худалдааг дэмжих үүрэг бүхий бүх байгууллагуудын үндэсний болон олон улсын зохицуулалт, хамтын ажиллагааны замаар үр дүнтэй, зохицуулалт сайтай хилийн менежмент байгуулах зарчим юм". Мэргэжлийн хэллэгт ХМҮБ гэсэн томьёог "Нээлттэй боловч аюулгүй хил" утгатайгаар хэрэглэх нь түгээмэл хэдий ч Хилийн зохицуулалттай менежмент (Coordinated Border Management, CBM), Хилийн орчин үеимйн менежмент (Modern Border Management, MBM) зэрэг томьёог ашиглаж хэрэгжүүлдэг. Хилийн цогцлбор менежментийн гол элементүүд нь хууль, эрх зүйн ба зохицуулалтын тогтолцоо, байгууллагын тогтолцоо, менежментийн холбогдол бүхий тухайлбал хилийн шалгалт, хяналт, худалдааг дэмжих, шилжин суурьших хөдөлгөөн, байгууллагын дотоодын, хоорондын болон олон улсын хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны болон техникийн асуудлууд хамрагддаг.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг өргөжүүлэн, шинэчлэн боловсруулж "МУ-ын хилийн аюулгүй байдлын үзэл баримтлал" болгон хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч:

"Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм"-ийг шинэчлэн соёрхон батлах

Монгол Улсын Засгийн Газар:

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь хилийн аюулгүй байдлыг хангах зорилтуудаа Засгийн газрын тэргүүний удирдлагын дор байгуулсан "Улсын

хилийн комисс"-оор дамжуулан шийдвэрлэж байдаг ОХУ-ын тушлагыг хэрэгжүүлэх боломжтой.

Уг комисс нь төрийн захиргааны төв, орон нутгийн өөрөө удирдах болон олон нийтийн байгууллагуудаас улсын хилийн талаар авч хэрэгжүүлэх бодлогыг боловсруулж, зорилго чиглэлтэй хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий байнгын ажиллагаатай тохируулагч байгууллага (агентлаг)-ыг удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.

МУ-ын Засгийн газрын дэргэд төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавьдаг, төрийн захиргааны төв байгууллагууд, хил орчмын орон нутгийн засаг захиргааны болон олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулдаг, улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулдаг байгууллага (зөвлөл) байх шаардлагатай гэж үзэж байна.

МУ-ын улсын хил хамгаалалтын удирдлагыг сайжруулах зорилгоор "Бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлал" дагуу Бүс нутгийн хил хамгаалалтыг удирдах газруудыг байгуулах,

Хил хамгаалалтын нягтралыг сайжруулан, хүрэхэд хүндрэлтэй, алслагдсан, хамгаалалтгүй хэсгийг хамгаалалтад авч шинэ застав салбаруудыг байгуулах,

Хил хамгаалалтад шинэ техник, технологийг нэвтрүүлэх, эхний ээлжинд нисдэг тэргээр хангах асуудлыг шийдвэрлэх,

1.Үндэсний хөгжил, эдийн засаг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага.

Улсын хилийн дагуу хүн амын суурьших нөхцөл бүрдүүлэх. Түүнчлэн улсын хил манах, хамгаалах эрх ашигт нийцүүлэн, нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого боловсруулж, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэн ашиглах замаар хэрэгжүүлэх, хяналт тавих.

2. Батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллага.

Улсын хилийг өдөр шөнөгүй, тасралтгүй хянах, хил дээр гарсан үйлдлийг шуурхай чадварлаг шийдвэрлэхэд зориулан цэргийн нисэх онгоц, нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх аппарат, локатор, прожектор, радиоэлектрон хэрэгсэл, олон зориулалттай, туулах чадвартай техник хэрэгсэл олж нийлүүлэх, улсын хил манах цэргийг сонгомол, шилдэг бүрэлдэхүүн, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, улсын хилийн инженерийн саад бэхлэлт, цэргийн зориулалттай бат бэх хянах байр барих зэрэг хил манах, хамгаалахад зориулан хил хязгаарын газар нутгийг инженерийн хувьд бэлтгэх иж бүрэн арга хэмжээ авах, агаарын хил манах, зэвсэгт халдлага түрэмгийллийг тодорхой чиглэл, хэсэгт шийдвэрлэх.

3. Тагнуулын төв байгууллага.

Улсын хилд учирч болзошгүй гадаад, дотоодын аюул, ялангуяа хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хил давж болзошгүй гэмт үйлдэл, улсын хилээр хээрэ, хаагуур, ямар зорилго, хүч хэрэглээр үйлдэж болзошгүй байдлын тухай бодит мэдээллээр хилийн харуул, салбар, анги, бүс нутгийн болон улсын хил манаж, хамгаалах удирдах газрыг хангах, хуульд заагдсан чиг үүргийг

хэрэгжүүлэх.

4. Хууль зүйн төрийн захиргааны төв байгууллага.

Улсын хил болон хил орчмын нутагт улс, нийгэм, ард иргэдийн язгуур эрх ашгийг хуулиар хамгаалах, түүнд нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйл, улсын хил, хил орчмын нутгийн эрүүгийн нөхцөл байдлын тухай хил манах, хамгаалах байгууллагын холбогдох шатны нэгжүүдийг мэдээллээр хангаж, улсын хил мөн хил орчмын нутаг дэвсгэрт хуулийн болон хэв журам сахиулах явдлыг хэрэгжүүлж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулиар хүлээсэн бусад чиш үүргийг биелүүлэх.

5. Гадаад харилцааны төрийн захиргааны төв байгууллага.

Улсын хилийн дэглэм зөрчигчдийг илрүүлэх саатуулахад хилчдэд туслах, улсын хил дээр сайн хөршийн найрсаг харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлж, улсын хил, хилийн дэглэмтэй холбогдсон гэрээг чанд сахих, боловсронгуй болгох, хилийн ойр орчмын нутаг дэвсгэрээс ерөнхий цэргийн хүчийг гүнд татуулах, улсын хилийн шугамыг өөрчлөх, зөрчих оролдлого гаргуулахгүй байх, хилийн төлөөлөгч нарыг ангийн захирагч нар хавсардаг журмыг болиулж, тэднийг Засгийн газраас томилон үр ашигтай ажилладаг болгох, улсын хилийн зориулалттай зэвсэг, техник хэрэгслийг буцалтгүй тусламжаар, эсвэл тухайн улсын дотоодын үйлдвэрийн үнээр олж нийлүүлэх, тэдгээрийг дагасан боловсон хүчин магистрант, докторантыг тухайн улсын их, дээд сургуульд сургах, хилийн хамтын ажиллагааг хөгжүүлж үр ашигтай хамтран ажиллах, гуравдагч улсуудын техник, технологи, санхүүгийн тусламж дэмжлэг авах, улсын хилээр зорчигч, ачаа бараа, тээврийн хэрэгсэл нэвтрэх ажиллагааг нээлттэй, шуурхай болгож, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шинэ тогтолцоо бий болгох.

6. Зам тээврийн, барилга, хот байгуулалтын төрийн захиргааны төв байгууллага.

Хилчдээс хил манах албанд зориулагдсан инженер-техникийн байгууламж, манаа харуулын бат бэх хянах байр, саад хаалт, мөр шалгах зурвас, гүний худаг, холбоо мэдээлэл, удирдлагын байр, замууд, гүүр, гарам, застав, отрядын байр, орон сууц, сургууль, цэцэрлэгийн байр, дэлгүүр, тавиулан агуулахууд зэрэг иж бүрэн газруудыг хот тосгон барьж байгуулах зарчимд нийцүүлэн хангалт үйлчилгээний хамт барьж байгуулна. Түүнчлэн иргэний зориулалттай нисэх онгоц, нисдэг тэрэг, ачаа ба суудлын, тусгай зориулалтын техник, ахуйн зориулалттай тоног төхөөрөмж зэрэг асуудлыг шийдэж, хил манах, хамгаалах байгууллагад ханган нийлүүлэх.

7. Байгаль орчин, аялал жуулчлалын төрийн захиргааны төв байгууллага

Хилчидтэй хамтарч улсын хил, түүний орчмын байгаль, ан амьтан, экологийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийн багана, тэмдэг, түүх дурсгалтай газрыг сэргээж хамгаалах, аялал жуулчлалын зорилгоор ашиглах, энэ зорилгоор застав, суман, отрядын гэр бүлийн хүмүүсийг мэргэшүүлэн,

орон тоо гаргаж ашиглах, хөрш улсын зохих байгууллагуудтай тохиролцон хил дамнасан байгалийн эко тогтолцоог хадгалах, аюулгүй байдлыг хамтарч хангах, хууль бусаар ашиглагчдын эсрэг тэмцэх хамтын ажиллагааны иж бүрэн арга хэмжээ авах.

8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны төрийн захиргааны төв байгууллага

Улсын хилийг манах, хамгаалах бодлого үйл ажиллагааны зарчим онцлогийг боловсролын бүх шатны сургалтын тогтолцоонд оруулж, улсын хилийн халашгүй дархан байдлын ач холбогдол, хилчдийн баатарлаг үйлс, түүхийг сурталчилах, хил манах, хамгаалах боловсон хүчний бэлтгэлийн чанар бие даасан байдлыг хангаж, түүнд гадаад дотоодын хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэл хийх, улсын хилийн тухай шинжлэх ухааныг салбар шинжлэх ухааны хэмжээнд хөгжүүлж, хил хамгаалах урлаг зохион бүтээх, хилийн түүх судлал сурталгааг багтаасан Шинжлэх ухааны академийн салбарын статустай хүрээлэн байгуулж, бүх ажиллагааг нь дэмжих, улсын хилийн аюулгүй байдлын онол түүх, арга зүйгээр тэргүүний хөгжилтэй улс гүрний хөрөнгө, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор хил болон хил орчмын нутагт судалгаа шинжилгээ явуулах, МУ-ын хил хязгаарын түүхтэй холбогдсон материалуудын талаар гадаадын холбогдох улсуудад судалгаа явуулж Монгол Улсад авч ирэх, олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохиогдох эрдэм шинжилгээний хуралд хилчин эрдэмтдийг оролцуулах, эх орондоо улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн хүрээний асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны хурал, зөвлөгөөн ярилцлага зохион байгуулж үзэх тооцох.

9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар хүлээн зөвшөөрсөн "Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан эрхтэй байх", "Гэр бүл төрөөр хамгаалуулах эрхтэй", "Хүн бүр ямарч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах", "Хүн бүр хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн салшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх хэрэгтэй", "Бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх эрхтэй" гэсэн ёсоор хилчдийн эрх ашгийг хангах бодлого боловсруулахад шаардагдах арга хэмжээг хуульд тусгаж, хэрэгжүүлэх. Улсын хил дээр алба хааж байгаа хилчид, хөдөлмөрчид алба, амьдралын бодит таатай нөхцөл бололцоогоор хангагдахаас гадна алслагдсан нутагт, гадаадын байнгын шахалт, дарамтанд орох, түүгээр үл барам амь эрсэдсэн бэрх нөхцөлд аж төрж, алба хашдаг учраас тэдгээрт тохирсон нийгмийн хамгаалал, нэмэгдэл арга хэмжээг авах шаардлагатайг анхаарлын төвд байлган, зарчим болгон хэрэгжүүлэх.

10. Эрдэс баялаг, эрчим хүчний төрийн захиргааны төв байгууллага.

Хилчид, ямар ч байсан эрчим хүчээр, тэр тусмаа хямдруулсан

үнээр хангагдах нөхцөл бүрдүүлэх, ялангуяа эрдэс баялаг, эрчим хүчний нөөц ашиглаж байгаа улсын ба хувийн түүнчлэн гадаад дотоодын бүх нэгжүүд МУ-ын хил хязгаар ялангуяа шалган нэвтрүүлэх боомтуудын хөгжлийг олон улсын нийтлэг жишигт ойртуулж хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө хандивлан оруулах их ажил өрнүүлэх шаардлагатай. Яагаад гэвэл энэ нь нэг талаас эрчим хүч, эрдэс баялгийн нөөцийг улсын хилээр түргэн шуурхай нэвтрүүлэх чадамж, бололцоо нь шалган нэвтрүүлэх боомтуудад хяналтын орчин үеийн техник, технологи, хэрэгсэл нэвтрүүлснээс шалтгаална.

Нөгөө талаар тухайн чиглэлд хот, тосгон байгуулагдаж хүн амын суурьшил нэмэгдсэнээс үүдэн улсын хилээр зорчигчид, ачаа бараа тээвэрлэлт, нэвтрэх бололцоо нэмэгдэхээс гадна улсын хил дамнасан олон улсын ба үндэсний чанартай гэмт хэрэг өсөх магадлал өндөр болно.

Хятад улс Эрээнийг манай улсын Замын-Үүдээс илүү хөгжүүлсний учир холбогдол нь эцсийн эцэст хилийн хот тосгон байгуулахад орон нутгаас олсон хөрөнгө мөнгийг нутагт нь үлдээж хуримтлуулан ашигласан төрийн бодлогын үр дүн нөлөөлсөн байна. Иймд манай улсын хилийн боомт, застав, отряд, хил орчмын хот тосгоны хөгжил нь төрийн бодлого, тухайлбал тухайн хэсэг чиглэлээс хөрөнгө мөнгө босгож байгаа гадаад дотоодын компаниудын хүчийг хэр зэрэг зөв ашигласнаас ихээхэн шалтгаалах учир энэ чиглэлээр цогц арга хэмжээ авах.

11. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллага.

Хилчид алс нутагт, хил дамнасан гэмт хэрэгтэй тулалдаж тэмцэлдэх үед шархдах, эрүүл мэндээр хохирох явдал цөөнгүй гардгийг хүлээн зөвшөөрч хилийн манаа, харуул застав, отряд, хязгаарт оршин суугчдын эрүүл мэнд Улаанбаатарт хэрхэн анхаарч шийдэгддэгийн нэгэн адил хил хязгаарт хангагдсан байх учиртай. Иймээс хилийн салбарт их эмч, хилийн ангиудад их эмчийн төрөлжсөн салбар, хил хамгаалах газарт их эмчийн төрөлжсөн төв эмнэлэг байх тогтолцоогоор хилчдийн эрүүл мэндийн хамгаалалтыг шийдвэрлэх шаардлагатай. Хил манах, хамгаалах байгууллагийг эмч, эмнэлэгийн тоног хэрэгсэл, түргэн тусламжийн машин, нисдэг тэргээр нэн тэргүүнд хангах асуудлыг шийдвэрлэх шаардлага гарна. Хөрш орнуудынн хилийн эрүүл мэндийн салбар хоорондын үйлчилгээд онцгой анхаарч арга хэмжээ авах.

12. Сангийн төрийн захиргааны төв байгууллага.

Хил хамгаалах байгууллага ялангуяа хилийн анги салбар, хилчдийн алба байлдааны ажиллагаа, хилчдийн амьжиргаанд шаардлагатай бүхэнд хангалттай төсөв хуваарилах, хилийн манаа, харуул, салбар, ангийн төхөөрөмж, дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн хангамжийг хангах асуудлыг стратегийн түвшинд зэрэгт тавьж хөрөнгө мөнгөний хуваарилалтыг шийдвэрлэхээс гадна улсын хил орчим ард иргэд аюулгүй, хангалуун аж төрөх нөхцөлийг бүрдүүлэхэд мөн санхүүгийн бодлогыг чиглүүлэх.

Улсын хил дээр алба хааж байгаа хилчдийн нийгэм ахуй хангалтад

төвлөрсөн төсвөөс тусгайлан дэмжлэг үзүүлж, хилийн шугамыг хяналтанд байлгах, хил орчмын алслагдсан нутагт хүн ам оршин сууж, зах хязгаартаа эзэн болох хэмжээнд мөнгө, санхүүгийн бодлогыг хөшүүрэг болгон ашиглах зэрэг болно.

Бүх яам, тусгай газруудад хил хязгаарын орон зайд хариуцах чиг үүргийг хуулиар тодотгон тодорхойлж өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагууд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд өөрсдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд улсын хилийг хамгаалахад шаардлагатай эдэлбэр газар олгож, хүрээлэн байгаа орчинг хамгаалах талаар Монгол Улсын хууль тогтоомжууд хэрхэн хэрэгжиж, яаж ашиглагдаж байгаад хяналт тавих, хил орчмын нутаг дэвсгэрт хамааралтай асуудлуудаар хил хамгаалах байгууллагуудтай харилцан ярилцах, иргэдийн сайн дурын үндсэн дээр хил хамгаалалтад оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх, хариуцсан хэсэгтээ байгууллага, үйлдвэр, албан газар, албан тушаалтнууд Хилийн тухай хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, хил хамгаалах байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагууд хилийн орчны үндэсний аюулгүй байдалд хамааралтай, орон нутгийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлэх замаар хилийн аюулгүй байдлыг хангахад оролцоно.

Олон нийтийн байгууллага, иргэдийн бүрэн эрх "МУ-ын хилийн тухай" хууль, "Улсын хил хамгаалалтад иргэдийг татан оролцуулах журам"-ын тухай МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, бусад актуудаар тодорхойлогдоно.

Иргэд "Улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцоно" гэж Хилийн тухай хуульд заажээ. Тэд улсын хилийн болон хил орчмын дэглэмийн шаардлагын биелэлтэд хяналт тавих, хилийн бүс, зурваст байнга болон түр оршин суудаг бол ажил, үйлдвэрлэл явуулж байгаа байрлалаараа улсын хил хамгаалалтад оролцох үүрэгтэй.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн бөгөөд хилийн аюулгүй байдлыг хангахад хуулийн дагуу оролцдог төр захиргааны, орон нутгийн ба олон нийтийн байгууллагууд, хувь хүнээс гадна хилийн аюулгүй байдлын хүрээнд харилцааны зохицуулалт хийдэг үзэл баримтлал, эрх зүйн хэм хэмжээний актууд мөн.

Хилийн аюулгүй байдлыг найдвартай хамгаалахын тулд нэгдмэл, хоорондоо холбоо бүхий эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг нэгдмэл бодлогоор чиглүүлэх тогтолцоог бүрдүүлснээр хангагдана.

Хилийн аюулгүй байдлаа дангаараа хангасан нэг ч улс, гүрэн байдаггүй бөгөөд хамтын ажиллагаагаар л хангах боломжтой гэж үздэг. Хилийн аюулгүй байдлыг хангах дотоод тогтолцооноос гадна гадаад тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

УСЧИН-ХИЛЧДИЙН ЭНЕРГИ ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хошууч Л.Лхагвасүрэн.
ДХИС. Хилийн албаны сургуулийн Ар талын тэнхимийн багш

Орчин цагийн ХХБ үүсэн бий болоод түүхт 86 жилийнхээ нүүрийг үзэж байгаа хугацаанд хилчдийн нийгмийн асуудал, ахуй амьдрал олон зүйлсийг МУ-ын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, ХХЕГ-ын удирдлага, Хилийн отряд, ангийн захирагч нараас томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн шинэчилсээр байна. Үүний нэгээхэн хэсэг болох хилчдийн "Хүнсний хангалтын заавар"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоол, Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 дугаар тушаалаар шинэчлэн баталгаажуулсан билээ.

Энэ зааварт, хилчдэд "Хилийн манааны шөнийн нэмэгдэл", "Хилийн манааны хүйтний нэмэгдэл" зэрэг нэмэгдэл хүнсийг тусгаж өгснөөр хилчид шөнийн цагт болон хүйтний үед биеэс ялгаран гарах эрдэс бодис, энерги зарцуулалтыг нөхөн хангахаар тусгаж өгсөн.

Судлаач миний бие тал хээрийн нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа хилчин, усан хил хамгаалалтанд үүрэг гүйцэтгэдэг буюу зуны цагт өдөрт 1-2 цагийн хугацаанд усанд сэлдэг, өдөр тутам устай харьцдаг хилчдийн хоорондын ялгаа, тэдний бие организмд явагдах эрдэс бодис, энерги зарцуулалтын ялгааг авч үзэх болно.

Хоол хүнс нь цэргийн албан хаагчдын хөдөлмөрийн ачааллаар алдагдсан энергийг нөхөж улсын хил хамгаалалтад сонор сэрэмжтэй үүрэг гүйцэтгэх бололцоог бүрэн хангах ёстой. Хүний бие махбод өдөр тутмынхаа үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний энерги /эрч хүч, калор, хэмжих нэгж нь ккал/ зарцуулдаг. Энэ нь биеийн ба оюуны хөдөлмөр хийх, биеийн ердийн дулааныг тогтмол барих, биеийн эрхтэн зүрх, уушги, мэдрэлийн тогтол эсүүд, гэдэс, ходоод зэрэг олон эрхтний ажиллагааг хэвийн байдалтай байлгахад зарцуулагдана. Хүний бие хамгийн тайван байх үедээ ч тодорхой хэмжээний энерги зарцуулдаг. Энэ энергийн хэмжээ нь хүний хөдөлмөр хийх үед хэд дахин нэмэгдэнэ.

Хүн энэхүү алдагдсан энергиэ гадна орчноос нөхөн авдаг. Хүний хэрэгцээт хоол тэжээлийн хэмжээ, түүнийг гаргах энергийг дулааны нэгж килокалороор хэмжинэ. Нэг литр усыг Цельсийн 1 хэмд халаахад зарцуулагдах дулааны хэмжээг нэг ккал гэнэ. 1грамм ууураг хүний бие махбодод шатахдаа 4,1 гр тослог, 9,3 гр нүүрс ус, 4,1 гр килокалорыг өгдөг. Хүний бие махбодод физиологийн үндсэн үүргүүдийг хэвийн байлгахад зөвхөн ажил төрөл гүйцэтгэхэд бус, унтаж амарч байхад ч дулааны хүчний урсгал байнга явагдаж байдаг.

Хоногт хүний энергийн илчлэг чанарын дундаж зарцуулалтыг төрөлд хувааж үзэж болно.

- Оюуны хөдөлмөр хийдэг хүмүүс 3000-3200
- Механик ажил хийдэг хүмүүс

3200-3600
- Хагас механик ажил хийдэг хүмүүс 4000-4200
- Биеийн хөдөлмөр хийдэг хүмүүс 4500-5000
- Усан спортоор хичээллэдэг болон усанд шумбагч нар 5000-5500 илчлэгийг зарцуулдаг байна.

Дээрх судалгаанаас хилчдийг 4-р бүлэгт хамруулан үздэг. Учир нь хилчид 24 цагийн турш сэтгэл зүй, орчны харилцан адилгүй нөхцөлд байгаль цаг уурын ямарч бэрхшээл сорилтыг үл харгалзан явган эсвэл төрөл бүрийн унаа /машин, мотоцикль, морь, тэмээ/ хэрэглэж МУ-ын хилийг халдашгүй дархан байлгах үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Хилийн манаа нь тухайн цагийн байдалд агшин зуурт дүгнэлт хийж, шийдвэр гаргадаг онцлогтой байдаг ба хилчид эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхэд нь нөлөөлөх хүчин зүйлсийн нэг нь тэдний эрхэлж буй алба, нас хүйс, бие махбодын онцлогт нь тохирсон зайлшгүй шаардагдах энергийн хэмжээг байнга нөхөн сэргээж байх явдал байдаг.

Илчлэг гэж юу вэ?

Илчлэг нь энергийг хэмжих нэгж юм. Өдөр тутмын амьдралд бид хоол хүнснээс авч байгаа энерги ба түүнийг бие мах бодийн үйл ажичллагаа, хөдөлгөөнөөр зарцуулж байгаа байдлыг бид илчлэгээр тодорхойлдог. Жишээ нь: Нэг ширхэг алимнаас авч болох 80 ккал энергийг 1 км алхахад бүрэн зарцуулдаг.

"Калор, Ккал, Kj" зэрэг нь хоорондоо ямар ялгаатай вэ?
- Монгол илчлэгийг-Ккал
- Баруунд-Energy value, Energy, Calories, мөн Kj, Kcal эдгээр тэмдэглэгээг хийсэн байдаг.
- Орос-Энергетическая ценность мөн ккал тэмдэглэдэг байна.

Хүний илчлэг шатаах процесс нь үйлдэж байгаа үйл хэрэг хөдөлгөөний хэмнэл, сэтгэл зүй, биеийн жингийн ялгаа эрдэс бодисын задрал, цаг агаарын өөрчлөлт, орчны тав тух гэх мэт олон төрлийн зүйлсээс шалтгаалан харилцан адилгүй энерги зарцуулж байдаг тэгвэл ихэнх судлаачдын үзэж байгаагаар хүний энерги зарцуулалтын дунджийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд: 70 кг жинтэй хүн 1 цаг тутамд хэдэн калор энерги шатаадгийг харуулна. Үүнээс илүү жинтэй хүн харьцангуй их хэмжээний энерги, бага жинтэй хүн бол арай бага хэмжээний энерги шатаана.
- Унтах – 20 ккал;
- Телевиз үзэх – 72 ккал;
- Зүгээр суух – 81 ккал;
- Ном унших – 91 ккал;
- Шээх – 141 ккал;
- Хоол хийх – 176 ккал;
- Машин засах – 200 ккал;
- Бичиг цаасны ажил – 240 ккал;
- Хөнгөн цэвэрлэгээ – 246 ккал;
- Шатаар өгсөх – 300 ккал;
- Будаг, шавар шохойн ажил – 317 ккал;
- Бүжиглэх – 370 ккал;
- Тавилга зөөх, цас ухах – 422 ккал;
- Унадаг дугуй унах – 441 ккал;
- Сагсан бөмбөг тоглох – 450 ккал;
- Хөлбөмбөг тоглох – 468 ккал;
- Алхах – 675 ккал;
- Усанд сэлэх – 740 ккал;
- Цанаар гулгах – 720 ккал зарцуулдаг гэж тодорхойлсон байдаг.



Хүн өдөр тутмын үйл ажиллагаанд өглөөнөөс орой хүртэл бүүр унтахдаа хүртэл илчлэг зарцуулдаг нь харагдаж байна тэгвэл, хилчдийг Хил судлалын шинжлэх ухааны эрдэмтэн, бригадын генерал Д.Ганбаатар, хурандаа Я.Нямдорж нар "Монгол Улсын хилчдийн энерги зарцуулалт" судалгааны ажилдаа дараах байдлаар судалсан байна.

Хилчдийн энерги зарцуулалтын судалгаанд ХХБ-ын офицер, ахлагч, байлдагч түрүүч нарын бүтэн хоногийн энерги зарцуулалтыг ХХБ-ын анги салбаруудаар ангилан өвөл зуны улирлаар нь харуулсан байна.

Судалгаа хийсэн анги, салбарууд	Өвөл			Зун			Бүгд		
	n	x	s	n	x	s	n	x	S
Баян-Өлгий ....-р отряд	23	4576.5	348.2	17	4410.1	280.6	40	4505.8	328.1
Өмнөгвь....-р отряд	17	4256.2	333.2	22	4154.8	343.1	39	4199.0	338.2
Увс...-р отряд	17	3966.2	164.6	20	3898.3	254.5	37	3929.5	217.7
Дорнод....-р отряд	15	4539.0	394.2	14	4736.5	325.4	29	4634.3	346.7
Улаанбаатар....-р отряд	19	4291.4	341.0	7	4085.0	625.4	26	4235.8	431.6
Баян-Өлгий ....-р ХЗ	8	4693.6	195.1	7	4633.1	228.0	15	4665.3	205.3
Өмнөгвь....-р ХЗ	5	4478.4	296.9	3	4339.5	157.8	8	4426.3	250.3
Увс...-р ХЗ	4	4588.5	396.2	3	4280.8	423.5	7	4456.6	405.6
Дорнод....-р ХЗ	2	4422.6	323.7	6	4492.5	363.2	8	4475.0	332.0
Баян-Өлгий, ХХ	1	4859.5		1	4836.4		2	4847.9	16.3
Өмнөгвь, ХХ	1	4508.2		1	4977.8		2	4743.0	332.1
Дорнод, ХХ	1	4312.4		1	4281.0		2	4296.7	22.2
Увс ХХ	1	5294.4		1	4912.7		2	5103.5	269.9
Бүгд / ккал /	114	4392.8	382.6	103	4305.9	432.5	217	4351.5	408.4

Уг хүснэгтээс харахад өвөл тэдний хоногийн дундаж энерги зарцуулалт офицер ахлагч нарын хувьд отрядуудад 3966.2±164.6, түрүүч байлдагч нарын хувьд 3990.0±220.6 ккал/24 цаг байна. Эндээс үзэхэд ХХБ-ын эрэгтэй офицер, ахлагч нарын хоногийн дундаж энерги зарцуулалт нэгдүгээрт, бүс нутгийн хоорондох байршлын ялгаа /тал хээрийн бүст харьцангуй бага, уулархаг бүст харьцангуй их/, хоёрдугаарт, ХХБ-ын анги салбаруудын доторх ялгаа /отрядад бага, хилийн заставт арай их, хилийн харуулд харьцангуй их/ харагдаж байна.

ХХБ-д алба хааж буй түрүүч байлдагч нарын хоногийн нийт энерги зарцуулалт нь хилийн анги, салбаруудын бүс нутгийн доторх ялгаа нь түүврийн дундаж харьцуулалт хийхэд тодорхой байна. Тухайлбал хоногийн дундаж энерги зарцуулалт нь отрядуудад 4080.6±248.5 ккал/24цаг, заставуудад 4527.8±238.3 ккал/24цаг, харуулуудад 4722.8±218.1 ккал/24цаг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоол, Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан "Хилийн цэргийн алба хаагчийн хүнсний хангалтын заавар"-т хилчдийн хүнсийг 4 нормд хуваан авч үзсэн байна. Хилийн харуул, манаанд алба хааж байгаа алба хаагчийг I норм, хилийн заставт алба хааж байгаа алба хаагчийг II норм, хилийн отрядад алба хааж байгаа алба хаагчийг III норм, Улаанбаатар хүрээний анги, байгууллага, салбарт алба хааж байгаа алба хаагчийг IV нормын дагуу хүнсний хангамжаар хангахаар тогтоож өгсөн байна.

Хүнсний бүтээгдэхүүний нэр				Хүнсний норм (граммаар)			
				I	II	III	IY
Гол нэрийн бүтээгдэхүүн	1	Мах		550	500	450	400
	2	Талх		600	600	600	600
	3	Гурил	Улаан буудайн 1-р гурил	50	50	50	50
			Улаан буудайн 2-р гурил	50	50	50	50
	4	Цагаан будаа		80	80	85	90
	5	Бусад будаа		50	40	30	30
	6	Төрөл бүрийн гоймон		40	40	40	40
	7	Сүү, сүүн бүтээгдэхүүн		100	150	150	200
Нэмэлт хүнсний бүтээгдэхүүн	8	Цөцгийн тос		20	20	20	30
	9	Өөхөн тос		25	25	25	25
	10	Ургамлын тос		25	25	25	15
	11	Элсэн чихэр		30	30	30	40
	12	Цай		6	6	6	6
	13	Иоджуулсан давс		12	12	12	12
	14	Хуурай хөрөнгө		3	3	3	3
Хүнсний ногоо	15	Төмс		300	300	350	400
	16	Байцаа		100	100	150	150
	17	Манжин		30	30	30	20
	18	Лууван		40	40	40	30
	19	Сонгино		30	30	30	30
	20	Сармис		1	1	1	1

Амтлагч	21	Перец	3	3	3	3
	22	Цагаан гаа	2	2	2	2
	23	Цагаан цуу	2	2	2	2
Амин дэм	24	Үзэм	30	30	30	30
	25	Жимсний чанамал	50	50	50	30
Илчлэг/ ккал /			4410	4336	4307	4242

ХХБ-ын хэмжээнд усан хил хамгаалалт зохион байгуулдаг хилчдийн энерги зарцуулалтад дээрх I,II,III,IV дүгээр хүнсний норм нь усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа хилчдийн нэг өдөрт авах 4500-5000 кил калорыг хангаж чадахааргүй байна учир нь усанд шумбах, бэлтгэх хийх, сэлэх нь энгийн үеийн энерги зарцуулалтаас 1 дахин илүү болохыг эрдэмтэд нотолж байна. Судалгаагаар явган алхсанаас илүүтэй /усанд дасгал хийхэд/ хамгийн бага хурд зарцуулалт нь 0.5-7.8%-тай байдаг. Энэ нь идэвхтэй ажилласан булчингийн зарцуулсан энерги юм. Нэг хэвийн температуртай усанд хүн 10 минут болоход дулаанаа алдаж эхэлдэг ба 30С^0 дулаантай усанд 30 ккал зарцуулдаг. Харин 24С^0 дулаантай усанд 100 ккал зарцуулдаг буюу 6 градусаар буурахад 70 ккал ялгаа гарч байна. Энэ нь усны дулааны хэмээс онцгойлон шалтгаалдаг 70 кг жинтэй хүн жирийн үед 1 цагийн хугацаанд идэвхтэй хөдөлгөөн хийхэд хүний биенээс 422 кил калори шатаадаг бол усан дотор 722 кил калори шатаадаг байна. Тэгвэл тал хээрийн нөхцөлд үүрэг гүйцэтгэж буй хилийн заставын хугацаат цэргийн албан хаагчийн зуны цагийн хуваарьт хийсэн илчлэгийн шинжилгээг усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилийн заставын зуны цагийн хуваарьт хийсэн илчлэгийн хэмжээтэй харьцуулж үзье.

Хилийн заставын зуны цагийн хуваарь /илчлэг шатаах процесс/

д/д	Явагдах арга хэмжээ	Эхлэх цаг	Дуусах цаг	Ногдох цаг	Энерги зарцуулалт	Хүнсээр олох илчлэг
1	Түрүүч нарын бослого	05:55	06:00	00:05	12 ккал	
2	Өглөөний бослого	06:00	06:00	00:05	12 ккал	
3	Гүйлт гимнастик	06:05	06:45	00:40	447,2 ккал	
4	Нүүр, гар угаах, ор дэр хураах	06:45	07:05	00:20	49,2 ккал	
5	Өглөөний хоол	07:05	07:25	00:20		1127,2
6	Орчны цэвэрлэгээ	07:25	07:40	00:15	48,6 ккал	
7	Өглөөний үзлэг	07:40	07:50	00:10	67,5 ккал	
8	Нэгдэлт	07:50	08:10	00:20	135 ккал	
9	Эргүүл, жижүүр хүлээлцэх	08:10	08:30	00:20	135 ккал	
10	Хичээлийн бэлтгэл хангуулах	08:30	08:40	00:10	67,5 ккал	
11	Сургалт дадлага /аж ахуйн ажил/	08:40	13:10	04:30	1899 ккал	
12	Нүүр гар угаах	13:10	13:20	00:10	24,6 ккал	
13	Өдрийн хоол	13:20	13:50	00:30		2140,7
14	Бага амралт	14:00	14:40	00:40	30 ккал	
15	Гар нүүр угаах	14:40	14:50	00:10	24,6 ккал	

16	Дадлага	14:50	15:50	01:00	441 ккал	
17	Давтлага	15:50	16:50	01:00	240 ккал	
18	Аж ахуйн ажил	16:50	17:40	00:50	351,6 ккал	
19	Жагсаалын бэлтгэл	17:40	18:00	00:20	225 ккал	
20	Албаны хуваарь, хоногийн манаанд үүрэг авах	18:00	18:20	00:20	120 ккал	
21	Зэвсэг цэвэрлэх	18:20	19:00	00:40	211,3 ккал	
22	Нүүр гар угаах	19:00	19:10	00:10	24,6 ккал	
23	Оройн хоол	19:10	19:30	00:20		1275,3
24	Манааны бэлтгэл хангах	19:30	20:00	00:30	150 ккал	
25	Цаг үеийн мэдээ мэдээлэл үзэх	20:00	20:30	00:30	36 ккал	
26	Соёл олон нийтийн цаг	20:30	21:00	00:30	185 ккал	
27	Хувийн цаг	21:00	21:30	00:30	40,5 ккал	
28	Оройн зугаалга	21:30	22:00	00:30	337,5 ккал	
29	Их амралт	22:00	06:00	08:00	160 ккал	
30	Бие засах			00:10	240,4	
	Нийт дүн			24.00	4568,4 ккал	4,543,2


Усан хил хамгаалалт зохион байгуулдаг хилийн заставын зуны цагийн хуваарь /илчлэг шатаах процесс/

д/д	Явагдах арга хэмжээ	Эхлэх цаг	Дуусах цаг	Ногдох цаг	Энерги зарцуулалт	Хүнсээр олох энерги
1	Түрүүч нарын бослого	05:55	06:00	00:05	12 ккал	
2	Өглөөний бослого	06:00	06:00	00:05	12 ккал	
3	Гүйлт гимнастик	06:05	06:45	00:40	447,2 ккал	
4	Нүүр, гар угаах, ор дэр хураах	06:45	07:05	00:20	49,2 ккал	
5	Өглөөний хоол	07:05	07:25	00:20		1127,2
6	Орчны цэвэрлэгээ	07:25	07:40	00:15	48,6 ккал	
7	Өглөөний үзлэг	07:40	07:50	00:10	67,5 ккал	
8	Нэгдэлт	07:50	08:10	00:20	135 ккал	
9	Эргүүл, жижүүр хүлээлцэх	08:10	08:30	00:20	135 ккал	
10	Хичээлийн бэлтгэл хангуулах	08:30	08:40	00:10	67,5 ккал	
11	Сургалт дадлага /3:30 цаг танхимийн 1 цаг дадлага/	08:40	13:10	04:30	2438,4 ккал	
12	Нүүр гар угаах	13:10	13:20	00:10	24,6 ккал	
13	Өдрийн хоол	13:20	13:50	00:30		2140,7
14	Бага амралт	14:00	14:40	00:40	30 ккал	
15	Гар нүүр угаах	14:40	14:50	00:10	24,6 ккал	
16	Дадлага /Усанд сэлэх/	14:50	15:50	01:00	720 ккал	
17	Давтлага /Усанд сэлэх/	15:50	16:50	01:00	720 ккал	
18	Аж ахуйн ажил	16:50	17:40	00:50	351,6 ккал	
19	Жагсаалын бэлтгэл	17:40	18:00	00:20	225 ккал	
20	Албаны хуваарь, хоногийн манаанд үүрэг авах	18:00	18:20	00:20	120 ккал	
21	Зэвсэг цэвэрлэх	18:20	19:00	00:40	211,3 ккал	
22	Нүүр гар угаах	19:00	19:10	00:10	24,6 ккал	
23	Оройн хоол	19:10	19:30	00:20		1275,3
24	Манааны бэлтгэл хангах	19:30	20:00	00:30	110 ккал	

25	Цаг үеийн мэдээ мэдээлэл үзэх	20:00	20:30	00:30	36 ккал	
26	Соёл олон нийтийн цаг	20:30	21:00	00:30	185 ккал	
27	Хувийн цаг	21:00	21:30	00:30	40,5 ккал	
28	Оройн зугаалга	21:30	22:00	00:30	337,5 ккал	
29	Их амралт	22:00	06:00	08:00	160 ккал	
30	Бие засах			00:10	240,4	
	Нийт дүн				5,827,4 ккал	4,543,2

Тал хээрийн заставын илчлэгийн хэмжээ - Усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй заставын илчлэг= Илчлэгийн зөрүү

4568,4 - 5,827,4 = -1,259



Усан хил хамгаалалтыг зохион байгуулж буй хилийн заставууд нь МУ-ын Хил хамгаалалтын дүрмийн 2 дугаар ангийн 225 зүйлд "Хилийн заставын дарга, орлогч нар заставын бие бүрэлдэхүүнд усанд сэлэх, хөвөх хэрэгслийн ашиглах, аюулгүй арга хэмжээг сахих талаар тусгайлан сургалт явуулна" гэж тусгасны дагуу байнгын бэлтгэл сургуулилтыг хийх шаардлагатай тиймээс тэдэнд зориулсан 5,000-5,800 ккал шаардагдах хүнс хэрэгтэй болж байна.

Мөн усан спортоор хичээллэж байх явцад хүний бие организмд ихэвчлэн шөрмөс татах, хөл, гар бадайрах, куликозын дутагдал орох зэрэг сөрөг талууд гардаг жишээлэхэд ОБЕГ-ын аврах ангийн алба хаагчдын аврах ажиллагааны үед зарим алба хаагчдын шөрмөс нь татаж өөрсдөө хүртэл живэх шахсан зэрэг олон асуудлууд тулгардаг хүний биеийн шөрмөс ямар учраас татдаг вэ гэвэл кальци болон кулизозын дутагдал орсноор ихэвчлэн татдаг байна, илрэх шинжийн хувьд ташаа, гар, хөлийн булчин багтана. Энэ тохиолдолд кальциар баялаг хоол хүнс хэрэглээрэй гэж эмч нар зөвлөдөг байна.

МУ-ын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоол, Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан "Хүнсний хангалтын заавар"-т дараах тохиолдолд

нэмэгдэл хүнс олгохоор тусгасан байна: Үүнд

- Нийтээр тэмдэглэх баярын нэмэгдэл хүнс /425 ккал/;
- Хилийн манаанаы шөнийн нэмэгдэл хүнс /829 ккал/;
- Хүйтний нэмэгдэл /-30 градусаас доош хүртэл 760,1 ккал/ гэж тусгасан байна.

Үүнээс үзэхэд усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчдийн бэлтгэл сургуулилт үүрэг гүйцэтгэх үед нь 500-1000 кил калор нэмэгдэхүйц кальци болон куликозоор баялаг хүнсний нэмэгдэл бүтээгдэхүүн өгөх шаардлагатай гэж үзэж байна.

ДЭМБ-с гаргасан хүний биед 1 өдөрт шаардагдах кальцийн хэмжээгээр:

- Хvvхэд 10-13 настайд 1000 м/г;
- 13-16 настайд 1200 м/г;
- 16-17 настайд 1000 м/г;
- 55 наснаас дээш 1200 м/г шаардлагатай бол кальц хамгийн ихээр агуулагддаг бүтээгдэхүүнд:

1. Үнээний сүү нь шим тэжээл ихтэй, кальцийн хамгийн сайн эх үүсвэр бөгөөд кальцийг сайтар шингээхэд тустай. Үнээний сүү нь төгс төгөлдөрт хамгийн ойртсон хүнсний бүтээгдэхүүн хэмээн өргөмжлөгдсөн хамгийн төгс органик бүтээгдэхүүн юм.

2. Тараг нь мөн кальцийн маш сайн эх үүсвэр бөгөөд нэг аяга 150 мл тараг уухад 10аас доош насны хүүхдийн кальцийн хэрэгцээний 1/3, том хүний 1/5-ийг хангана.

3. Бяслаг нь сүүн бүтээгдэхүүн дотроо кальциар хамгийн баялаг нь бөгөөд энэ кальци нь хүний биед маш амархан шимэгддэг. Харьцуулбал: 250 грамм сүү =200 грамм тараг = 40 грамм бяслаг

4. Кальци агуулсан жүрж нь эмчилгээний шилдэг жимс гэж өргөмжлөгддөг, С амин дэмээр баялаг ойролцоогоор 226 грамм жүржийн шүүсэнд агуулагдаж буй 300 мг кальц нь нэг аяга үнээний сүүн дэх кальцийн агууламжтай ойролцоо байна.

5. Хатаасан бяслаган дахь кальци ба фтор нь яс ба шүдний хөгжилд гол нөлөөтэй.

6. Буурцагны төрлүүдийн шим тэжээл маш өндөр, ихэнх нь кальц ихээр агуулдаг .

7. Шинэ, даршилсан, хөлдөөсөн зэрэг олон төрлийн тод ногоон өнгийн навчит хүнсний ногоонуудыг цөцгийн тосоор амтлан идэж байх нь эрүүл мэндэд тустай.

8. Далайн байцаа кальциас гадна йод ихээр агуулсан учир бамбай булчирхайд маш сайн нөлөөтэй. Уураг, ханаагүй өөх тосны хүчил мөн ихээр агуулагддаг байна.

Монгол Улсын өдөр тутам хүнсэнд хэрэглэгддэг бүтээгдэхүүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн кальциар хамгийн баялаг болох нь дээр судалгаанаас харагдаж байна. Тэгвэл хилийн салбар, ангиуд зуны улиралд сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж байгаач нэмэлтээр дараах байдлаар өгвөл үр өгөөж нь нэмэгдэх юм. Зуны цагт усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэгдэг, сургалт дадлагад оролцож буй хилчдийн хүнсэнд хэрэглэж буй сүү, сүүн бүтээгдэхүүнээ гадна нэмэлтээр нэмэгдэл хүнсийг дараах байдлаар оруулахаар тооцож байна.

Усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэдэг хилийн застав сургалт, дадлагын үед болон зуны улиралд

олгох нэмэгдэл хүнс

1. Бяслаг 100 гр /500 ккал/
2. Шоколад 50 гр /299 ккал/
3. Хөөрүүлсэн сүү 150 гр /120 ккал/
4. Жүржийн жүүс 100 гр /95 ккал/

Тайлбар:

Усан хил хамгаалалтын сургалт, дадлага, аврах ажиллагааны үед үүрэг гүйцэтгэж буй хилийн отряд ангийн офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагч, хугацаат цэргийн алба хаагч нарт олгоно.

Дээрх байдлаар "Хүнсний хангалтын заавар"-т тусгаж өгвөл хилчдийн сэтгэл санаа үүрэг гүйцэтгэх чадвар сайжирч, усан сэлэлтийн үед шөрмөс татахаас урьдчилан сэргийлэх, бие физиологийн тэнцвэрт байдлыг хангах зэрэг олон асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Хоол хүнснээс хүн төрөлхтөн өөрт тохирох эрдэс баялаг, уураг, өөх тос, нүүрс хүчлийг авдаг байна. Энэ нь бидний бие махбод эрчимтэй ажиллах ажиллагааны үндэс болдог юм. Тэгвэл доктор, хурандаа Б.Лхагвагийн "Хилчдийн энерги зарцуулалт" номонд тусгаснаар хилчид өдөр тутмын үйл ажиллагаанд 4000-4500 ккал энерги зарцуулж байдаг учир цэргийн хүнсэнд 4200-4500 ккал илчлэгтэй хүнс олгох хэрэгтэй гэсэн зөвлөмжийг тусгасан байна. Тэгвэл судлаач миний бие тал хээрийн заставын цагийн хуваарьт минут тутамд зарцуулах энергийн хэмжээг тусгай аргын дагуу боловсруулан, үүнийгээ усан хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчдийн зуны дасгал, сургуулилтын үеийн цагийн хуваарьтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Үүний дүнд хоорондын ялгаа нь -1,259 ккал гарсан ба энэ нь тайван цагт хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчнээс усан хилд үүрэг гүйцэтгэж буй хилчин арай илүү их энерги зарцуулдаг болох нь тогтоогдож байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Монголын Анагаах Ухааны Академийн хамтран гаргасан "Монголын хүн амын бүлгүүдэд шаардагдах хоногийн илчлэг, үндсэн шимт бодисууд болон зарим амин дэмүүдийн хэрэгцээ" судалгааны өгүүллийн дүгнэлт хэсэгт Монголын хүн амын хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг 10 жил тутамд хянан үзэж, тодотгон шинэчлэх шаардлагатай гэж үзсэн нь дээрх судалгаатай тохирч байгаа юм.

1. Хилийн салбар, ангиуд зуны улиралд сүү сүүн бүтээгдэхүүн хэрэглэж байгаа ч нэмэлтээр дараах байдлаар өгвөл үр өгөөж нь нэмэгдэх магадлалтай юм. Дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Усан хилд үүрэг гүйцэтгэж буй хилчдийг зуны сургалт бэлтгэлийн үеэр нэмэгдэл хүнсээр хангах;
2. Усанд сэлэх, гүйлт дасгал, марш тактикийн тэмцээний бэлтгэл сургуулилтын үеэр кальци, глюкоз ихтэй бүтээгдэхүүнээр хангах;
3. Дээрх нэмэгдлүүдийг хүнсний хангалтын зааварт тусгаж өгөх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

БНХАУ-ЫН ХИЛИЙН БОЛОН ХИЛИЙН ДЭГЛЭМИЙН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ

Доктор, профессор Ц.Ганболд

БНХАУ-ын хилийн нийт урт нь 22143 км, үүнээс усан хил нь 14500 км бөгөөд 9,6 сая ам дөрвөлжин километр талбай бүхий нутаг дэвсгэртэй, 15 улстай хиллэдэг.

Монгол Улстай 4709,658 км буюу хуурай газрын хамгийн урт газар нутгаар хиллэж, хилийн 13 боомтоор харилцан үйл ажиллагаа явуулж, БНХАУ-ын талаас өөртөө засах Шинжаан, Ганьсу муж, Өвөрмонголын 3 орны нутаг дэвсгэрээр хиллэдэг.

Улсын хилийн боомтын асуудлаар НАХЯ-ны цагаачлалыг удирдах газар, ХАЧА-ийн хил хамгаалах хороо, ӨМӨЗО-ны хилээр орох гарах асуудал хариуцсан шалган нэвтрүүлэх ерөнхий газар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шугамаар харилцан ажилладаг. БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан 284 хилийн боомт байдгаас 146 нь далайн эргийн, 136 нь эх газрын, 27 нь дотор газрын хилийн боомт болно.

БНХАУ-ын хил хамгаалалт, түүнийг зохион байгуулж буй байдал, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлдэг, гарсан зөрчлийг ямар арга тактикаар илрүүлж, захиргааны болон эрүүгийн ямар шийтгэл ноогдуулдаг талаар хятад эх сурвалжийг ашиглан Өвөр монголд уйгаржин монгол дээр хэвлэгдсэн "Хил хамааралтын ухаан" буюу манайхтай дүйцүүлбэл "Хилчний сурах бичиг"-тэй агуулгаараа дүйцэх албан хэрэгцээнд зориулсан номноос кириллд буулгасан, уйгаржин бичгийн болон өвөр монгол хэлний онцлогтойгоор нь танилцуулж байна. Мөн зэргэлдээ улсын хил хамгаалах байгууллагаас хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрхэн явуулдаг талаар тусгав.

Хилийн уулзалтууд ихэвчлэн өвөр монгол орчуулагчдын тусламжтайгаар явагддаг учраас хил хамгаалалтын зарим нэг нэр томьёо, хэллэгийн учрыг олоход танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой гэж үзэв. Тухайлбал, Гоолдлоготой хүн - энэ бол дотоодыг хамгаалах тусгай нэр томъёо болно. Даруй өрх амын хамааралтын ажил дунд ялт ажиллагааны сэжигтэн ба нийгмийн амар түвшинг самруулсан сэжигтэй хилийн хамааралтын оронд улсаас урваж гадагш дотоод ба дайсанд бууж өгөх аюултай этгээдийг зааж байна.

Хилийн хамааралтын ухагдахуун.

Хилийн хамааралтын ухагдахууныг ойлгоход урдаар хилийн хамааралтын холбогдол бүхий үндсэн ухагдахууныг ойлгох хэрэгтэй.

Нэг. **Хилийн зааг.** Нэг улсын нутаг дэвсгэрийг зэргэлдээ улсын нутаг дэвсгэртэй зааглаж харъяат далай ба харъяат агаарыг хувиарлах зааг шугамаар нэг улсын нутаг дэвсгэрийн хүрээ хэмжээг тогтоосныг хилийн зааг гэнэ.

Хоёр. **Хил.** Хил нь даруй улсын нутаг дэвсгэрийн зах хөвөөн орон бүсийг хэлж буй хилийн заагийн дотоод талыг хамарсан зохих орныг ерөнхийлөн зааж байна.

Гурав. **Хилийн дүрэм.** Улсаас улсын дотоодод нийтэлсэн хуулийн холбогдол

бүхий тогтоол ба холбогдол бүхий олон улсын гэрээ ба хэлэлцээрийг үндэслэн тогтоосон хилийн заагийг хамаарах эл зүйлийн бодит арга хэмжээ дүрэм тогтоолыг ерөнхийлсэн хилийн дүрэм гэдэг.

Дөрөв. **Хилийн хамааралт.** Хилийн дүрмийн хамаарал бүхий тогтоолоор хилийн заагийн дотоод талын зохих оронд хамааралт явуулахыг хилийн хамааралт гэдэг.

Хилийн хамааралтын үндсэн үүрэг бол: манай улсын холбогдол бүхий хууль цааз ба төрийн бодлогыг үндэслэн хилийн орны нийгмийн орны амар түвшинг хамаарч хилийн зэвсэглэлээр сэргийлэх, дайсны тагнуул ба бусад ялт этгээдийн хилийн заагт халдах улс ба нийгмийн амар түвшинг самууруулах ажиллагааг сэргийлэх буюу цохилт өгөх, хилийн иргэний хил давах явдлыг хамаарах, хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэж улсын аюулгүй хийгээд хилийн эмх журам тогтоон барихыг хамгаална.

Хилийн хамааралтын үүрэг.

Хилийн хамааралтын үндсэн үүрэг бол улсын эрх мэдэл нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон улсын амар түвшинг батлан хилийн эмх журмыг хамгаална.

Түүний бодит үүрэг нь: олон түмний ажил, улсын хилийн хамгаалах, хилийн орны амыг хамгаалах, эмх журмыг хамгаалах мэдээ, сэлтийг байцаан судлах далдуур арилжаалах, хорт эд бараа наймаалахыг баривчлах, улсын хилийг хулгайгаар давсанд цохилт өгөх ба хязгаарлах, хилийн эмх журмыг зөрчсөн эл зүйлийг эрүүгийн хэргийг илрүүлэх гадаадад холбогдсон хилийн хэргийг шийдвэрлэх зэрэг байна.

Хилийн хамааралтын салаа мөчрийн эрх.

Хилийн хамааралтын салаа мөчрийн ажлын үүргийг үндэслэн доорхи хэдэн зүйлийн эрхтэй байдаг.

Нэг. Засаг захиргааны эрх. Засаг захиргааны гар дүрэх эрх. Хилийн хамааралтын салаа мөчир нь түүний дүрэм тогтоолыг хөнгөвтөр зорчсон үйл ажиллагаанд засаг захиргааны гар дүрэх эрхтэй байж үйл ажиллагаат хүнийг ятган сургах, ятган хориглох, албадан өөрчлөх эрхтэй. Бас засаг захиргааны зарлиг, мэдээлэл, зар нийтэлж хилийн хамааралтын оронд орж ирсэн ба оршин сууж байгаа хүмүүсийг улсын хууль, цааз ба хилийн хамааралтын дүрэм тогтоолыг эрхбиш журамлахыг шаардах эрхтэй байхыг зааж байна. Энэхүү засаг захиргааны гар дүрэх эрхийг зохих ятгах чанар хуулийн хязгаарлах чанар ба албадлагын чанартай. Амрыг хамгаалах засаг захиргааны хамааралтын эрх нь хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн амрыг хамгаалах засаг захиргааны талаар хөгжүүлэх хамааралтын эрхийг зааж байна. Улсын тогтнолыг үндэслэвэл хилийн хамааралтын салаа мөчрийг хилийн орны ажил үйлдвэрлэл, гэр бүлийг данслах оршин суух, явж нэвтрэх зэрэг явдлыг хамаарах эрхтэй. Энэ бол хилийн хамааралтын салаа мөчрийн засаг захиргааны эрхийн бодит илрэл болно. Амрыг хамгаалах засаг захиргааны хамааралтыг дамжин хилийн эмх журмын түвшин тайван байхыг баталж чадна. Амрыг хамгаалах шийтгэн торгох эрх: хилийн хууль дүрмийг зөрчиж тогтоол ёсоор засаг захиргааны шийтгэл өгч болно. Хилийн

хамааралтын салаа мөчрөөс холбогдол бүхий хууль цааз ба хууль тогтоолоор шийтгэл өгөх эрхтэй. Ж-нь: хилийн оронд оршин суухын хамааралт явах нэвтрэх явдлын хамааралтын дүрмийг зөрчиж хилийн хамааралтын салаа мөчрийн ажилтны хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхийг харшлах, хамааралтыг дагахгүй хорьж ятгахыг сонсохгүй. зэрэг зүйлүүд. Амрыг хамгаалах засаг захиргааны шийтгэн торгох эрх бол хилийн хамааралтын салаа мөчрийн засаг заиргааны эрхийн чухал бүрэлдэхүүн болох бөгөөд мөн ч бусад эрх мэдлээ явуулахын бодлого мөн. Хилийн хамааралтын дүрмийг сурган хүмүүжүүлж эл зүйлийн хамааралтын ажлыг сайтар хийхэд чухал утга агуулгатай юм.

Хоёр. Эрүүгийн хэргийг хамаарах хууль

Хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн хаших хаах ба цагдалт дунд илрүүлсэн улсын хилийг хулгайгаар давах далдуур арилжаалах, буу зэвсэг хорт эд зэрэг хилийн хамааралтыг зөрчсөн хэргийг сайн тагнаж байцаан судалж илрүүлэх эрхтэй. Хилийн орны бусад ялт хэргийг хилийн хамааралтын салаа мөчрөөс дотоодыг хамгаалах байгууллагын гол хамаарах салаа мөчиртэй хамжилцан сайн байцаах ба илрүүлэх хэрэгтэй.

Гурав. Цэргийн явдлын эрх.

Хилийн хамааралтын салаа мөчрийн цэргийн явдлын эрх бол түүний хариуцаж байгаа цэргийн явдлын үүргээс тогтоогддог. Түүний үүрэг тушаалын хэмжээнд доорхи эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Зэвсэгт хүчнээр хаших, нэхэмжлэн баривчлах эрхтэй. Хилийн хамааралтын салаа мөчир нь үүрэг гүйцэтгэхэд хилийн амар түвшнийг эвдэх, ялт этгээдийг хаан хаших, нэхэмжлэн баривчлах эрхтэй. Зэвсэгт хүчнээр харгалзан хамгаалах эрх. Манай улсын хилд хууль бусаар орж ирсэн гадаадын хүн, зам харилцааны багаж, хэрэгслийг хилийн хилийн хамааралтын салаа мөчрөөс зэвсэгт хүчнээр харгалзан хамгаалах эрхтэй. Зэвсэгт хүчнээр өөрийгөө хамгаалах эрх. Эл зүйлийн ялт этгээдийг нэхэмжлэн баривчлах үед хил давах ба хилээс гадагш буудаж болохгүй. Хилийн үүрэг гүйцэтгэх явцад хилийн гаднах дайсан тагнуул цөөн тоогоор түрэмгийлэн орж ирсэн дайсны өдөлхийлэлт хийх, халдалт, бүгэлт хийх зэвсэгт хүчнээр хор далдуур арилжаалах бүлэглэлийн зэвсэгт эсэргүүцэл тохиолдох үед, өөрийгөө хамгаалах эрхтэй.

Дөрөв. Гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх эрх.

Холбогдол бүхий тагнуулыг үндэслэн хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн оронд үүссэн гадаадад холбогдсон асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Хилийн дүрэм тогтоолыг үндэслэн хилийн гаднах хилийн хамааралтын салаа мөчиртэй зөвлөлдөх буюу харилцан шийдвэрлэх хэрэгтэй.

Хоёр. Хилийн хамааралтын хууль цаазын дүрэм тогтоол. Хилийн хамааралт бол хууль хэрэгжүүлэх ажиллагаа болно. Түүний журамлах хууль, цаазын дүрмийг хилийн дүрэм тогтоол гэх буюу хилийн хамааралтын хууль дүрэм гэдэг. Энэхүү хууль цаазын дүрэм нь дотоод дахь хууль ба дэлхий нийтийн хууль гэх хоёр хэсгээс

бүрэлддэг.

нэг. Улсын дотоод дахь хуулийн хэсэг. Хилийн эмх журмыг хамгаалахын төлөө улсаас үргэлж улсын дотоод дахь хууль тогтоох аргаар эл зүйлийн холбогдол бүхүй хилийн асуудлын, хууль цаазын дүрэм тогтоодог. Эдгээр дүрмийн доорх зүйлд хувааж болно. Улсын хууль цаазын дотор холбогдол бүхий хилийн дүрмийн тухай тогтоол, хилийн амар түвшнийг хамгаалах ба хилийн сүр сүлдийн төлөө, дэлхий дээрх олонх улс түүний үндсэн хуулиндаа бүр хилийн хамгаалж хамаарах тухай хууль цаазын зүйлийг тогтоосон буюу тусгай хуулийг тогтоодог.

Нэгдүгээр хугацааны гуравдугаар бүгд хуралдаанаас /1989 он. Ц.Г./ хойш манай улс алхам алхмаар хуулиар улсыг засах замд орж хууль дүрмийн байгуулалт тун ихээр хөгжсөн байна. Манай улсын "Эрүүгийн хууль"-ийн 318,319,320,321,322,323 дугаар зурваст тодорхой тогтоосон нь улсын хилийн хөшөө хилийн шонг эвдэх улсын хилийг хулгайгаар давах, бусад хүмүүсийг дагуулан улсын хилийг хулгайгаар давагчдыг хугацаатай хорих, түр хорих буюу захиран хамаарахын хамт зоос мөнгөөр торгож шийтгэнэ. Улсаас нийтэлсэн хилийн хамааралтын ажилтай холбогдолтой бусад хууль цааз нь жишээлбэл, "Бүгд найрамдах Думдад Ард Улсын гадаадын хүний хилээр орох гарах хамааралтын хууль", "Бүгд найрамдах Думдад Улсын ард иргэний хилээр орж гарах хамааралтын хууль", "Улсын харъяатын хууль", "Боомтын хууль" хийгээд хорыг цаазлах далдуур арилжаалах хор панзлахыг ялтан сэтгэх хулгай худалчийн яллан шийтгэх зэрэг холбогдол бүхүй тогтоол байдаг. Энэ нь манай улсын хилийн хамааралтын тухай хууль цаазыг алхам алхмаар сайжран төгөлдөржсөн байна. Улсын Засгийн ордны байгууллагаас тогтоосон засаг захиргааны хууль тогтоолд жишээлбэл, "БНДумдад Ард Улсын гадаадын онгоц сал, далайн гармаар орох гарах хамааралтын арга" Дотоодыг хамгаалах яам, Зам харилцааны яам болон тариалан мал аж ахуй загасны аж ахуйн яамнаас тогтоон нийтэлсэн "Далай дагуу орны онгоц сал, гармын амрыг хамгаалах хамааралтыг чангатгах хэдэн асуудлын тогтоол" зэрэг буй.

Засаг захиргааны тогтоолыг түшиглэн хилийн хамааралтанд хэрэгжүүлэх нь отгын хилийн хамааралтын ажлын нэг зүйлийн үндсэн хэлбэр болно. Орон нутгийн засгийн газраас тогтоосон орон нутгийн чанартай хил хамгаалалтын хууль тогтоол.

Манай улсын хил хязгаар өргөн уудам эл газрын хилийн байдал зөрөөгөөр их байдгаас болоод улсаас нэгдэлтэй хилийн хамааралтын хууль дүрмийг хараахан тогтоогоогүй. Хандлагат чанартай хамааралтыг нэн сайн явуулахын төлөө эл хилийн муж, Өөртөө засах орны ардын их хурал ба Ардын засгийн ордноос улсын холбогдол бүхий хууль цааз ба дүрэм тогтоолыг үндэслэн тус газрын бодит байдалтай уялдуулан орон нутгийн чанартай засаг захиргааны хууль дүрмийг тогтоосон байна. Ж нь: хилийн хамааралтын дүрэм, нарийн дүрэм, зар тунхаг, арга зэрэг буй. Хилийн орон нутгийн хууль дүрэм бол улсын хилийн

хамгаалалтын төрийн бодлогын бодит илрэл болно. Тэр нь тэр нь хилийн хамгаалалтын төрийн бодлогын бодит байдал мөн ч хилийн хамгаалалтын төрийн бодлогын нөхвөрлөл болно. Тэр бол манай улсын хилийн хамааралтын ажлын нэгэн их онцлог байж хилийн эмх журмыг хамгаалах ажлын дунд хүнд чухал үйлдэл үзүүлж байдаг.

Хоёр. олон улсын хуулийн хэсэг. Олон улсын хуулийн хэсгийн хилийн хамааралтын дүрэмд голдуу хөрш улсын хооронд байгуулсан хилийн дүрэмтэй холбогдол бүхий хоёр талын гэрээ хэлэлцээр зөвлөлцөл ба хилийн зорчилт олон улсын хуулийн холбогдол бүхий тогтоол зэргийг заана.

Цохилтоо чангатган хилийг хулгайгаар давах ялт ажиллагааг чангаар яллах нь.

Думдадын Эрүүгийн хуулийн 318, 321, 322 р зурваст \зүйлд\ жич ардын төлөөлөгчдийн байнгын хорооны "Улсын хилийг хулгайгаар давуулахаар бусдыг зохион байгуулж хүргэсэн ялт ажиллагааг чанга шийтгэх тухай нөхвөр тогтоол-д хилээр орж гарах хамааралтын хууль тогтоолыг зөрчих ба ашиг олох үүднээс улсын хилийг хулгайгаар давуулахаар бусдыг зохион байгуулсан ялт этгээдийг яллах.. хилийн хамааралтын хууль тогтоолын холбогдол бүхий зурваст цөм тохиромжтой тогтоолтой юм. Эдгээр нь цөм улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа зэрэгт цохилт өгч шийдвэрлэх хууль цаазын зэвсэг болно, үүрэг тушаалт салаа мөчир нарийн хянамгай хэрэгжүүлж хуулийг зөрчвөл заавал нэхэмжилж хуулийг хэрэгжүүлэхэд заавал чанга байх. Улсын хилийг хулгайгаар давах ажиллагааг гадаадын засгийн газартай нягт хамжилцан, хамтаар сэргийлэн шийдвэрлэх нь.

Наяад оноос нааш улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа бүх улсын хэмжээгээр түргэн хөгжин дэлгэрч хүний тоог нь ч жилээс жилд нэмэгдэж, онц зарим мужаас гадна улсын хилийг хулгайгаар давах явдал цөм товойн ялгарч, улсын хилийг давж гадаадад гарсан хүмүүс дэлхийн хэдэн арван улс ба газар оронд тархжээ. Улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа өмнөөс умарш, далай дагуун орноос дотор газар орон руу хөгжиж, манай улсын нийгмийн нэгэн товойсон асуудал болж, улсын гадаадад тун муу нөлөөтэй болгож манай улсын нэр хүндийг сүрхий эвдэж, зарим улсад бас Думдад улсыг эсэргүүцэх сэтгэлгээг үүсгэсэн байна.

Намын төв хороо, Улсын явдлын хорооноос энэхүү асуудлыг туйлаар хүндэтгэн, олон удаа заавар ба байрлуулалт хийж энэхүү асуудлыг даруй түргэн шийдвэрлэхийг шаардсан байна.

Ялзран доройтохыг эсэргүүцэн дутагдлаа засварлах нь.

Улсын хилийг хулгайгаар давах зарим ажиллагаа нь газар орны зарим удирдлагын дураар нь тавих болон хуулийг хэрэгжүүлж байгаа хүмүүсийн цэгц бус ажиллагаатай холбогдолтой юм. Иймээс улсын хилийг хулгайгаар давах ажилд цохилт өгч хязгаарлах ажлын дунд эрхбиш ялзармалыг эсэргүүцэх тэмцэлтэй нягт уялдуулах шаардлагатай. Намын суртлын асуудал бол нам ба улсын мөхөж сөнөхтэй

холбогдох зангилаа асуудал болно. Иймээс эрхбиш улсын ажилтан ба хуулийг хэрэгжүүлж байгаа хүмүүс улсын хилийг хулгайгаар давах хүмүүсийг далдуур тавих буюу үл мэдэгч, дураар нь тавих зэрэг хууль дүрмийг зөрчсөн ажиллагааг нарийн хянамгай байцаан шийтгэх хэрэгтэй. Энэ бол эзэмшлийг эсэргүүцэх тэмцлийн нэгэн чухал агуулга, мөрдөөн басч улсын хилийг хулгайгаар давах ажиллагааг хориглох нэгэн чухал гогцоо болно.

Далдуур арилжаалахын агуулга хийгээд хор хөнөөл.

Нэг. Далдуур арилжаалах ухагдахуун. Энэ нь боомтын хууль тогтоолыг зөрчин хилийн боомтыг хянан хамааралтаас зайлан дутааж, улсаас хилд оруулж гаргахыг цаазлан хязгаарлах буюу хууль ёсоор боомтын гаальд тушаах ёстой бараа бодисыг зааж байна. Дээрх томъёолол нь даруй далдуур арилжаалах нь юуны өмнө боомтын хуулийг зөрчин, хилийн боомтын хянан хамааралтаас зайлан дутааж байгаа үйл ажиллагаа болно. Хилийн боомт бол улсын хилээр оруулж гаргах эл зүйлийн эд барааг хянан хамаарах байгууллага байж боомтын хуулийн гол хэрэгжүүлэгч болно.

Хилийн боомтын хянан хамааралтаас зайлан дутаах гэдэг нь хууль бусаар эд бараа тээвэрлэн хилийн боомт нээгээгүй газраар хилээр оруулж гаргах зарим нь хэдийгээр хилийн боомтоор гарч орсон ч эд бараагаа хуурмагаар мэдүүлэх, далдлан мэдүүлэх, нуун далдлах зэрэг арга хэрэглэхийг зааж байна.

Хоёрт. Далдуур арилжаалах нь улсын гадаад арилжаа худалдааны хамааралтыг зөрчсөн үйл ажиллагаа болно. Улсын гадаад арилжаа худалдааны хамааралтыг эвдэх хэрэг нь зөвшөөрөлгүй гээр өөртөө улсаас хилд оруулах гаргахыг хязгаарлаж байгаа буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн авч явж хилд оруулж гаргах үйл ажиллагааг зааж байна.

Далдуур арилжаалах үйл байдал нь хүнд, манай улсын “Эрүүгийн хууль”-ийн холбогдол бүхий хууль тогтоолыг зөрчсөн байвал, далдуур арилжаалсан ялыг бүрэлдүүлдэг.

Далдуур арилжаалсан ял хийгээд далдуур арилжаалсан үйл ажиллагаа.

Далдуур арилжааны ял.

“БНДАУлсын боомтын хууль”-ийн 47-т далдуур арилжаалах ялд доорхи мэтээр ийн тогтоожээ.

Улсын хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа хорт бодис, буу зэвсэг, хуурамч зоосыг тээвэрлэх авч явах, шуудангаар оруулж гаргах, буюу улсаас гаргахыг цаазалж байгаа түүхэн дурсгалт бодисыг тээвэрлэх, авч явах, шуудангаар явуулах хилээр гаргах, Боомтын зөвшөөрөлгүй мөрдөөн боомтын, гаалийн нөхвөрлөн тушаах, хилээр оруулахыг онц зөвшөөрсөн гаалийн үлдэгдэл бараа, гаалийн хасахаар онц тогтоосон буюу гаалийн хэлтрүүлэх огц тогтоолтой эд барааг дурааараа худалдаж, тоо хэмжээ нь нилээд их байна. Зэвсэгт хүчнээр далдуур арилжаалахыг хамгаалж, далдуур арилжаалах эд барааг байцаахыг хүчирхэглэн эсэргүүцэж,

тоо хэмжээг бага гэлгүй цөмийг далдуур арилжаалсан ялд багтана.

Үүнээс гадна доорхи үйл ажиллагааг бас далдуур арилжаалсан ялд багтаан шийдвэрлэхээр тогтоожээ: Далдуур арилжаалснаас, улсаас оруулж гаргахыг цаазалж байгаа бодисыг хууль бусаар шууд худалдан авах буюу далдуур арилжаалснаас далдуур арилжаалж оруулж ирсэн бусад бараа бодисыг шуул хууль бусаар худалдан авах бөгөөд тоо хэмжээ нь нилээд их. Дотоод далай, харъяат далайд улсаас оруулж гаргахыг цаазалж байгаа бодисыг тээвэрлэх, худалдан авах, панзлах буюу улсаас оруулж гаргахыг хязгаарлаж байгаа бараа бодисыг тээвэрлэх, худалдан авах, панзалж, тоо хэмжээг нилээд их, хууль ёсны гэрчгүй.

Далдуур арилжаалахын үйл ажиллагаа.

БНДАУлсын Боомтын хуулийн Засаг захиргааны залагал (засаглал.Ц.Г.) хэрэгжүүлэх нарийн дүрэм" ийн 2-3 д Далдуур арилжаалах үйл ажиллагааг доорхи байдлаар тогтоожээ.

Төрийн явдлын хорооноос эрх олгосон байгууллагын зөвшөөрөлгүйгээр боомт байгуулаагүй газраар улсаас хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа бодис, улсаас оруулж гаргахыг хязгаарлах буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн, авч явж хилээр орж гарах,

Боомт байгуулсан газраар өнгөрч, нуун далдлах хуурмаглах, мэхлэн мэдүүлэх, хуурмагаар мэдүүлэх буюу бусад аргаар боомтын хянан хамааралтаас зайлан тогтоож, улсаас хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа бодис, улсаас оруулж гаргахыг хязгаарлаж байгаа буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн авч явж, шуудангаар оруулж гаргах, Боомтын зөвшөөрөлгүй боомтын гаалиа нөхвөрлөн тушааж, хилээр оруулж ирсэн хилийн гаднах тээврийн хэрэгсэл зэргийг дурааараа худалдах, Боомтын зөвшөөрөлгүй мөрдөөн боомтын гаалиа нөхвөрлөн тушааж, гаалийг хасахаар тусгай тогтоосон буюу гаалиас хэлтрүүлэн хэвийн тусгай тогтоосон хэрэгцээтэй эд барааг дурааараа худалдах эсвэл гаалийг хасан хэлтрүүлээд тусгай тогтоосон газар оронд хэрэглэх эд барааг дурааараа хил доторх бусад газар оронд тээвэрлэн хүргэх, Үүнээс гадна доорхи үйл ажиллагааг бас байдлыг үндэслэн далдуур арилжаалах үйл ажиллагаагаар шийтгэхээр тогтоожээ: Далдуур арилжаалснаас шууд далдуур арилжаалж оруулсан эд барааг хууль бусаар худалдан авах, дотоод далай, харъяат далайгаар улсаас хилээр оруулж гаргахыг хязгаарлаж байгаа эд барааг тээвэрлэх, худалдан авах, панзлах бөгөөд хууль ёсны гэрчгүй зэрэг.

Далдуур арилжаалахын хор хөнөөл.

Далдуур арилжаалах ажиллагаа нь манай улсын нийгэм журамт аж ахуйн бүтээн байгуулалт болон нийгмийн үйлдвэрлэл, амьдралын эмх дэглэмд олон талын хор хөнөөл авчран тэр нь голдуу доорх хэдэн талаар илэрч байна.

Далдуур арилжаалах ажиллагаа нь улсын гадаад арилжааны хамааралт ба оруулж гаргах бодисын хамааралтыг эвджээ. Гадаад арилжаа нь улсын хамааралтыг хүлээх бөгөөд эл улсын

хоорондох таваарын үнийг их зөрөө байгаагаас болж хууль бус этгээд хууль бусаар их ашиг хөөцөлдөж арга бүхнийг сүвэгчлэн хамааралтаас зайлан дутааж улсаас хязгаарлаж байгаа эд бараг хувираа тээвэрлэн улсын гадаад арилжааны хамааралтыг төрийн бодлого ба хууль тогтоолыг хүнд сүрхий эвдэж нийгэм журамт аж ахуйн бүтээн байгуулалтыг эвдсэн байна. Далдуур арилжаалах ажиллагаа нь улсын их хэмжээний гааль мөнгийг талаар урсгаж, улсад тун их сүйдэл авчирчээ. Боомтын гааль хураах ба хасаж хэлтрүүлэх ажлыг сайтар хийх нь гадаадтай чөлөөтэй харилцах төрийн бодлогыг доошлуулан, улсын дотоодын үйлдвэрлэлийг ахиулах буюу хамгаалж гадаад аж ахуй арилжааг хөгжүүлэн, улсын эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэхэд цөм чухал үйлдэлтэй юм.

Гэвч далдуур арилжаалсан хуурмаглах, орлуулах зэрэг арга барил хэрэглэн гаалийг дарж гаалиас зайлж улсад их хэмжээний аж ахуйн сүйдэл авчирсан байна.

Зарим нь хилийн арилжаа, бараа солилцох арилжааны нэрээр далдуур арилжаалах, зарим нь гаалийг үлдээх, боомт дамжиж эд бараагаар шалтгаалж далдуур арилжаалах, зарим нь нэг цогцолбор хариултыг олон зүйлд хэрэглэх, зарим нь нэг онгоцонд хоёр адил бус газрын бараа тээвэрлэх хуудастай, зарим нь хуурмаг бичиг материал хэвлэж байцаалтыг аргацаах зэрэг арга барилаар гаалийг дарж гаалиас дутаадаг. Ж нь: 1950 оноос 1979 онд манай улсын хилийн боомтын баривчилсан далдуур арилжаалсан хэргийн өртөг нь нийт 1,5 дүншигүр (дүнчүүр. Ц.Г.) төгрөг байж 1980 оноос 1983 онд далдуур арилжаалахаас болсон боомтын гааль ба үйлдвэр худалдааны гаалийн сүйдэл бараг 50 дүнчүүр төгрөгөөс давсан байна.

Бүртгэлийг үндэслэвэл 1992 онд далай дагуу эл газрын Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир далдуур арилжаалсан хэргийг 2508 удаа байцаан баривчилж түүний дотор 100 түмэн төгрөгөөс дээших том хэрэг 106 удаа байж, далдуур арилжаалсан онгоцыг 1411 баривчилж 15 дүнчүүр төгрөгийн далдуур арилжаалсан өртгийг олзолсон байна. Далдуур арилжаалах ажиллагаа нь үндэсний аж үйлдвэрийн хөгжилтийг нөлөөлж, нийгэм журамт зах дэлгүүрийн аж ахуйг самууруулан улсын ашиг тусыг хүнд сүрхий эвджээ. 1979 оноос 1983 оны далдуур арилжаалсныг баривчилсан бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл бүх улсын далдуур арилжаалсан бодисын өртөг нь бараг 20 дүнчүүр төгрөг байжээ. Далдуур арилжаалж Сингапурт оршиж буй шижир алт, цагаан мөнгө, эмийн материалын өртөг нь 30 дүнчүүр сиянганг зоос болж, өөр газарт бас оршиж орсон байдаг.

Нэг талаар тэр нь хууль бусаар хилд оруулах бодист эд мөнгөний арилжааны нөхцөлийг бэлтгэж их хэмжээний телевиз, шингээлтийн машин, гар цаг, машин тэрэг, тамхи, нилүнг утас зэрэг манай улсын аж ахуйн бүтээн байгуулалтад бачим шаардагдахгүй бодисыг сохор балай хууль бусаар хилд оруулж, нөгөө талаар их хэмжээний төлөвлөгөөт

бодисыг хууль бусаар оруулж гаргаж, манай улсын бүтээн байгуулалтад тун их сүйтгэл учруулсан. Иймэрхүү хууль бусаар оруулж гаргахын үр дүн нь бас нэг зүйлийн сохор балай дур зоригийн хүчийг бүрэлдүүлж, улсын дотоодын зах дэлгүүрийг хүнд сүрхий нөлөөлдөг. Ж-нь: 1988 оны 8 сард манай гадаадаас оруулах тамхины боомтын гаалийг их хэмжээгээр дээшлүүлсэнд улсын дотоод ба гадаадын зах дэлгүүрийн гадаадын тамхины үнэ нь тун их зөрөөтэй болсон байна. Иймэрхүү далай дагуу орноос дотор газар хүртэл тамхи панзлах их урсгал үүсч энэ урсгалаас том бүлэг буй болсон. Баруун өмнөд орны нэг бүлэг тамхины панзчин нь бас нилээд нарийн чанга зохион байгуулалтыг байгуулж, энэхүү зохион байгуулалт нь дотооддоо урт аяны панзлан тээвэрлэх, ойр аяны панзлан тээвэрлэх ба тамхийг хүргэж тосохыг хариуцах зэрэг нарийн чанд ажлын хувиарлалтай байдаг. Тамхины зах дэлгүүр нь хязгаартай далдуур арилжаалж оруулсан тамхи нь боомтын гаалиас дутааж тамхины, тамхины зах дэлгүүрийг самруулж "нийт худалдааны тамхи"-ны эзлэх тоо хэмжээнд нөлөөлсөн байна.

1988 онд бүх улсын зах дэлгүүрт "нийт худалдаалах тамхи" 97 түмэн хайрцаг (хайрцаг бүр 500 боолт) эзэлж байснаас 1990 онд дорогшлоод 43 түмэн хайрцаг болсон байна. Үүнтэй харьцангуй харгалзал нь 1988 онд далдуур арилжаалсан тамхи бараг 200 түмэн хайрцаг байж 1990 он болоход далдуур арилжаалсан тамхи нь нэмэгдээд 350 боолт түмэн хайрцаг болсон байна. Далдуур арилжаалах хөдөлгөөн нь үндэсний аж үйлдвэрийн хөгжилтөд нөлөөлөн харшилснаар барахгүй бас улсын гаалийн орлого ч их хэмжээгээр урсан гээгджээ. Ж нь: зарим нэг газар оронд 1979 онд улсын үйлдвэрлэсэн гар цаг 1220 г худалдаж байсан бол 1980 оноос 1985 оны 3 сар хүртэл үйлдвэрлэсэн бугуйн /гар/ цаг нэгийг ч худалдаалж чадсангүй. Үүний хамт манай улсын телевиз, машин тэрэг, дүрс шингээлтийн машин /камер/ комъютер зэрэг олон аж үйлдвэрийн салаа мөчир хүнд сүрхий сүрдүүлэлд учирч, цаашлаад үүдээ хааж болзошгүй байдаг. 1992 оны сүүлийн хагас жилээс 1993 оны эхний хагас жил болтол зөвхөн Сингапураар (Сияанганг) дамжин Думдад улсын эх хуурайд орж ирсэн машин тэрэг 6,1 түмэн байж үүнтэй адил хугацаанд хилийн боомтод тэмдэглүүлсэн нь зөвхөн 3 түмэн байж 3,1 түмэн машин тэрэг нь манай орны валютыг 9 дүнчүүр доллар урсан гээгдэж, 140 дүнчүүр төгрөгийн гаалийн орлого хасагдсан байна.

1992 оноос 1993 оны 4 сар хүртэлх охорхон 5 сарын хугацаанд зөвхөн күрэй (корей Ц.Г) Думдад улсад худалдан оруулсан машин тэрэг 21 түмэн байж, адил хугацаанд Думдад улсын хилийн боомтод тэмдэглүүлсэн машин тэрэг зөвхөн 200 илүү байж хоёр тоо нь 100 дахин зөрж, зөвхөн машин тэргийг далдуур арилжаалан оруулах нэг зүйл нь жилд урсан гээгдэх валют нь хэдэн арван дүнчүүр доллар хүрч 300 дүнчүүр төгрөгийн гаалийн орлого хасагдсан байна. Далдуур арилжаалах хөдөлгөөн нь манай улсын нийгмийн амар түвшний эмх дэглэмийг хүнд сүрхий самууруулж ялзлан доройтуулах гажуу суртлын

дэлгэрэхийг тусалж нийгмийн амар тогтууныг эвджээ. Хил, далай дагуу орны далдуур арилжаалах хөдөлгөөний өдрөөс өдөрт гаарахыг дагалдан булаан дээрэмдэх зодолдох хорлон алах, зэрэг ялт ажиллагааг дэлгэрүүлж далдуур арилжаалах ажиллагаагаар хүнд сүрхий байх газар орны эрүүгийн хэрэг гарах нь бусад газраас товойм өндөр байдаг. Үүний хамт хээл хахуул идэх, шамшин завших зэрэг нийгмийн гажуу суртлын дэлгэрүүлж кадр олныг ялзруулж нийгмийн ёс моралийг эвдэн, нам ба улсын ашиг тусыг халдан хөнөөсөн байна. 1987 оны 5 сарын 26 нд Төрийн явдлын хорооны түүхэн дурсгалт бодисыг хулгайлан малтах ба далдуур арилжаалах хөдөлгөөнд цохилт өгөх тухай мэдэгдэлд зааж гаргасан нь: "Ойрын хэдэн жилээс нааш манай улсын эл газарт түүхэн дурсгалт бодисыг далдуур арилжаалах ба эртний онгон хуучин буурь, үлдэгдлийг хулгайлан малтах ялт ажиллагаа олонтаа үүсч цөөн бус түүхэн дурсгалт бодис хулгайлагдан хил гаргаж , манай улсын соёлын үлдэгдэл хүнд сүрхий эвдэгдэлд учирснаар барахгүй, нийгмийн суртлыг эвдэн, нийгэм журамт бодисын боловсон ба оюуны бүтээн байгуулалтанд ч хохиролтой болно" гэсэн байна. Гэвч нэн хүнд сүрхий нь Юүнэний пинг ёован орон нь хэсэг хугацаагаар бүх улсын цорын ганцаараа эзэгнэсэн буу зэвсгийн худалдааны талбар болсон байна. Хэрмэн дээр өлгөж байгаа ширээн дээр дэлгэж байгаа, газар дээр дэвсэж байгаа нь цөм хүн амьтныг алах зэвсэг байж, гар буу, явган буу, пулёмет, гар мина гранат, дэлбэрэх хонгио, бас эл зүйлийн сум ба дуу замхруулагч, онилох дуран зэрэг байж их буунаас бүрдэж нүд эрээлжлэм болсон байна.

Тусгайлан энд ирж буу зэвсэг худалдан авах ялт этгээд тун амарханаар санаандаа хүрч дараа нь эдгээр буу зэвсгээрээ булаан дээрэмдэх, хүн алах зэрэг зэрэг ялт ажиллагаа хийж, орон даяар муу үр дүн нь хүрч хүнд эрүүгийн хэргийг үүсгэсээр байна. Хилийн гадаадад холбогдсон явдлын хэмжээ, төрөл зүйл жич мэдүүлэн зөвшөөрүүлэх эрх.

Хилийн гадаадад холбогдсон явдлын хэмжээ.

Хилийн гадаадад холбогдсон явдлын багтаасан агуулга нь нилээд өргөн дэлгэр байдаг. 1988 оны 11 сард нийтэлсэн "Бүгд Найрамдах Думдад Ард Улсын Засгийн ордон ба БНМАУлсын Засгийн Газрын Думдад Монголын хилийн дүрэм тогтоол ба хилийн асуудлыг шийдвэрлэх тухай гэрээ" нд хоёр талын хилийн төлөөлөгчийн байцаах ба шийдвэрлэх чухал асуудлыг 11 талын асуулгыг багтаадаг. Даруй:

1. Хил давж буу харвах буюу эсрэг талын хил рүү буу харвасанаас болж нөгөө талын хил доторх хүнийг шархдуулан алах, эд хөрөнгө сүйтгэх,
2. Хилийн ойролцоо орны нөгөө талын хүмүүст хүчирхийлэл үзүүлэх
3. Хүн, нисэх машин ба бусад тээврийн багаж хэрэгсэл хууль бусаар хил давах жич орчин тойронд хөнөөл учруулах.
4. Эрх аваагүй хүн хууль бусаар хил давж харилцаа холбоо авах

5. Нөгөө талын хил доторхи эд бодисыг хулгайлах эвдэн сүйтгэх
6. Мал, нутгийн хил давах
7. Түймрийн аюул нөгөө талын нутаг дэвсгэрт орох
8. Хилийн тэмдэг, дагалдуулал тэмдэг ба зааг шугамын тэмдэг эвдэгдэн сүйтгэгдэх, шилжигдэх буюу үгүй болох.
9. Ямар нэгэн хилийн хэрэг явдлын үр дүнгээс болж нэг талаас дурьдсан төлбөрийн асуудал
10. Хүчин бүхий хилийн асуудлын гэрээ хэлэлцээр ба зөвшилцлийн бичгийн тогтоолыг зөрчих
11. Гадаад харилцааны арга замаар шийдвэрлэх чухалгүй бусад хилийн асуудал

Дөрөв. Хилийн гадаадад холбогдсон явдлын төрөл зүйл.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг түүний улсын ашиг тусыг хөнөөсөн дэс дарааллыг үндэслэн ердөө гурван төрөлд хуваадаг.

нэг. Хүнд хэрэг. Голдуу хөрш зэргэлдээ улс манай улсын нутаг дэвсгэр, харъяат далайн эрх мэдлийг түрэмгийлэх, зэвсэгт түрэмгийлэл, өдөөлгө хийх, манай талын хүнийг алж шархдуулах жич маргаантай газар оронд хилийн одоох байдлыг зөрчиж, хөдөлгөөний хэмжээгээ өргөтгөх зэрэг явдлыг зааж байна.

хоёр. Энгийн гадаадад холбогдох асуудал. Хүн машин тэрэг, мал унаа, онгоц сал зэрэг хил давах хилийн оронд цэргийн явдлын холбогдол хийх ба үнэн сумын харвалт хийх зэрэг мануусг хүнд хохирол болгосон үгүй байдал зааж байна.

гурав. Хилийн ажил хэргийн асуудал. Гэрээ хэлэлцээр буюу зуршил ёсоор эсрэг талынтай зөвшилдөх хүн мал унаа, онгоц сал эд бодис зэргийг тушаах цаг, газар орон, арга алхам дарааг хэлэлцэн хилийн тэмдгийг засах арга ба хилийн төлөөлөгчийн ажлын дүрэм зэрэг ажил хэргийн шинжтэй асуудлыг зааж байна.

Гурав. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд мэдүүлэн зөвшөөрүүлэх эрх.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх нь улсын эрх мэдэл ба хөрш улсын харьцаатай холбогддог. Улс ба төвийн голлон хамаарах салаа мөчрөөс хилийн гадаадад холбогдох явдлыг дээд хэмжээгээр нэгдэлтэй удирдахын төлөө хилийн гадаад холбогдох явдлыг шийдвэрлэх эрхийн хязгаарт чанга тогтсон байдаг.

Нэг. Хилийн явдал, нутаг дэвсгэр, харъяат далайн харъяалагах явдал ба эсрэг ба эсрэг талын хүн манай талын хүнийг алж шархдуулах явдалд холбогдох жич хилийн хамааралтад холбогдох, гэрч тэмдэг визгүй хүмүүс хилд орж болох эсэх зэргийг багтаасан хүнд их хилийн гадаадад холбогдох явдлыг муж, өөртөө засах орны ард засгийн ордон, төвийн голлон хамаарах салаа мөчир буюу төвөөс хянан зөвшөөрнө.

Хоёр. Эсрэг талын хүмүүс хилийн одоох байдлыг эвдэх маргаантай газар оронд манай хайн цагдах, явж нэвтрэх, ажил үйлдвэрлэл хийх зэрэг хөдөлгөөнийг хориглон харшилж, хилийн хамгаалалтын хэлэлцээр, уулзалтын дүрмийг өөрчлөх зэрэг хилийн гадаадад холбогдох асуудлыг голлон хамаарч байгаа салаа мөчир

муж, өөртөө засах орны засгийн ордон, мужийн цэргийн тойрогт мэдүүлж хянан зөвшөөрөхийн хамт төвийн голлон хамаарах салаа мөчирт мэдүүлэх хэрэгтэй.

Гурав. Чухал агуулга ба энгийн хэлэлцээр жич туслан аврах, нөхөрсөг найр үдэшлэгийн хөдөлгөөнийг муж, өөртөө засах орны дотоодыг хамгаалах тэнхим, гадаад явдлын албан гэрээр хянан зөвшөөрүүлэхийн хамт дотоодыг хамгаалах яамны хилийн хамгаалалтын товчоонд мэдүүлэх хэрэгтэй

Дөрөв. Чухал хэлэлцээр буюу муж, ардын орон алсарсан тойрон үзэх хөдөлгөөнийг дотоодыг хамгаалах яаманд. мэдүүлэх хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй.

Тав. Энгийн гадаадад холбогдох хөдөлгөөн, ж-нь хүн, эд бодисыг солилцож, энгийн гадаадтай харилцах, мэдэгдэх зэрэг ажиллагааг муж өөртөө засах орны дотоодыг хамгаалах тэнхимийн хилийн хамгаалалтын товчоогоор хянан зөвшөөрүүлнэ.

Зургаа. Дээд шатнаас нэгэнт шийдвэрлүүлэх эрх олгосон энгийн гадаадад холбогдох явдлыг газар хот зеу ийн Дотоодыг хамгаалах газар \ товчоо\ын хилийн хамгаалалтын \ хувиар\ товчооноос зөвшөөрүүлэхийн хамт зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол хамаарах байгууллага, зарчим ба үндэслэл.

Нэг. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол хамаарах байгууллага.

1983-2-18-нд Төрийн явдлын хороо, Төвийн цэргийн явдлын хорооноос Ерөнхий штабын газар, Дотоодыг хамгаалах яамны зөвшөөрсөн "Думдад-Зөвлөлт, Монгол, Энэтхэг, Вьетнам... зэрэг хилийн орны Думдад улсын ардын чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг, анги ба ардын хилийн хамгаалалтын зэвсэгт цагдаа, цэрэг ангийн ажлын хувиарын тухай тогтоол"-д Манай улсын эх хуурайн хилийн сэргийлэн хамгаалах үүргийг Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир ба Ардын чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг анги, хамтаар үүргэлж бүр өөр өөрийн чухалчлах тал байдаг. Думдад-Солонгос, Думдад-Бирм ба хөршлөн залгалдаж байгаа Сияанганг, Уомен хилийн хамгаалалтын үүргийг Дотоодыг хамгаалах хилийн салаа мөчрийн хариуцахын хамт бас дотоодыг хамгаалах төлөөлөгч ба хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрэм байгуулж, гадаадад холбогдох явдлын бодитой ажлыг шийдвэрлэхийг хариуцна. Думдад-Вьетнам, Думдад -Лаосын хилд хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрмийг байгуулж, хилийн гадаадад холбогдох явдлыг нэгдэлтэй шийдвэрлэхийг хариуцна. Думдад Зөвлөлт, Думдад Монгол, Думдад Энэтхэг зэрэг хилд чөлөөт цэргийн хамгаалалтын цэрэг анги нэгдүгээр утасны сэргийлэлийн үүргийг хариуцахын хамт, хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрэм байгуулж, хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхийг хариуцна. Дотоодыг хамгаалах салаа мөчрийн ажилтай холбогдох үед (жишээлбэл: хүн, хүүр үхдэлийг тушаан солилцох зэрэг) Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир хүн

томилон уулзалт ба хэлэлцээрийн ажилд оролцоно. Хилийн хүмүүс хил өнгөрөхтэй холбогдох ба зам харилцааны багаж хэрэгсэл жич түүнийг тээвэрлэж байгаа эд бодисыг хилд орох байцаалт дунд үүссэн гадаадад холбогдох асуудлыг Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир хариуцан шийдвэрлэнэ. Думдад - Зөвлөлтийн хил нь одоо нэгэнт Думдад -Орос, Думдад-Казакстан, Думдад -Киргизстан, Думдад-Тажикстаны хилээр орлогджээ. Гэвч манай улсын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх хамаа бүхий тогтоол нь мөн угийн Думдад Зөвлөлтийн хилийн тогтоолыг хэрэгжүүлнэ. Газар орны гадаад явдлын албан гэр бол гадаадад холбогдох ажлын системчлэх салаа мөчир байж чухал их гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд жолоодох хариуцлагатай. Дотоодыг хамгаалах Хилийн хамгаалалтын салаа мөчир, чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг анги, гадаад явдлын албан гэр бол манай улсын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол салаа мөчир болно.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх зарчим.

Нэг. Зарчмыг баримталж тэмцлийг баримтлах нь.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх нь төрийн бодлогот чанараар тун чанга байж, эрхбиш улсын хууль цааз, хууль зарлиг, төрийн бодлогыг тогтоол ба хөрш улс лугаа тогтоосон холбогдол бүхий гэрээ хэлэлцээрийг үндэслэж, хилийн гадаадад холбогдсон явдал ба холбогдол бүхий асуудлыг зөв шийдвэрлэх хэрэгтэй. Хүнд чухал гадаадад холбогдох асуудалд эрхбиш зарчмыг баримтлан, тэмцлийг баримталж, "Ёстой ашигтай" байх хэрэгтэй. Энгийн шинжтэй гадаадад холбогдох асуудалд, адил бус байдал, адил бус шинж чанарыг үндэслэн, адил бус арга хэрэглэж, амьдлаг тохитой шийдвэрлэх хэрэгтэй.

Хоёр. Үнэнийг баримталж ёсоор хүнийг бишрүүлэх нь.

Хилийн явдлаар харилцах үед, зарим асуудлыг нэн сайн шийдвэрлэхийн төлөө, эрхбиш үнэнийг баримталж, ёсоор хүнийг бишрүүлэх зарчмыг баримтлах хэрэгтэй.

Зарчмын асуудлыг хэлэлцэх буюу эсвэл бодитой явдлыг хэлэлцэхэд, цөм бодит хэргийг гаргаж, ёс учрыг тайлбарлах хэрэгтэй. Ингэвэл сая жишсэн зорилгодоо хүрч чадна. Хүн, мал унаа, түймэр зэрэг энгийн хил давсан хэрэгт үнэнийг баримтлах оврыг хэрэглэж ингэх нь эсрэг талын ойлголтыг олж чадах, мөрдөөн мануусt бас тийм их нөлөө болж чадахгүй юм.

Гурав. Зүй ёсонд нийцэж, эрх тэгшээр зөвлөлцөх нь.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дунд, онцгойрон баяр дурсгалын өдрийн нөхөрсөгявалцаа ба эсрэг талтай хэрэг явдал зөвлөлдөх үед, эрхбиш зүй ёсонд нийцэж, эрх тэгшээр зөвлөлцөн харилцан ойлголцож, харилцан найр тавих зарчмыг баримталж, эсрэг талтай нарийн хянамгай зөвлөлцөхийн хамт, эсрэг талын зүй ёсны саналыг хүлээхийг анхаарч, манай талын бодит хүчирдэл, бодитой байдалд ба шаардлагаа хүчирдэл ба зүй ёсны шаардлагад,

манай эрх ашгийг хөнөөхгүй нөхцөлд, бодит байдлаа үндэслэн зохих хэмжээгээр бодолхийлэх ба харгалзах хэрэгтэй.

Дөрөв. Нууцыг хамгаалахыг анхаарч, дотоод гадаадыг ялгаатай байлгах нь.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд оролцох хүн бүхэн төрийн бодлогын тогтоолыг чанд сахиж, эх нутагтаа үнэнч, ард түмэнд үнэнч байж, улсаа хайрлах үзлийг бадруулж үндэстний нэр хүндийг хамгаалж, эх улсад ашиггүй явдлыг хийхгүй, эх улсад ашиг тусгүй үг яриаг ярихгүй байх хэрэгтэй. Гадаадад холбогдох хөдөлгөөний дунд, эрхбиш дотоод гадаадын ялгаатай байх зарчмыг нарийн хянамгай хэрэгжүүлэх. Гадаадад овроо илэрхийлэх үед нэгдэлтэй хэллэгээр илэрхийлэх. Улсын дотоодод илээр нийтлэхгүй аливаа хэрэг явдлыг дээд шатны зөвшөөрөлгүйгээр ямарваа хүн гадагш задруулж болохгүй. Ямарч байдалд хэлж болохгүй үгийг яасан ч хэлэхгүй, хийж болохгүй явдлыг яасан ч хийхгүй байхыг бат цээжилж, хүнд өө сэвээ илрүүлэхгүйг хичээж, идэвхгүй болохоос сэргийлэх

Тав. Өөрийгөө гол болгож, өөрийн эрхээ эзэмших

Хилийн хамгаалалтын гадаад харилцаан дунд, онцгойлон баяр дурсгал ба тойрон аялах зэрэг нөхөрсөг хөдөлгөөн дунд эрхбиш өөрийгөө гол болгох зарчмыг баримтлан, эсрэг талын нөлөөнд орж болохгүй. Эрхбиш лавлаад, сэргэг зоригтой, шулуун байж, өөрийн эрхээ эзэмших. Чи чинийхээ ярь, би өөрийнхөө хэлнэ. Муу хэлэх гэснээ аргалж байгаад хэлж гаргаж, миний хийх гэснээ арга бодож байгаад хийж бүтээнэ.

Зургаа. Цаг тухайд нь хариу мэдүүлж заавар авах зарчмыг баримтлах нь.

Хилийн гадаадад холбогдсон явдал бол ерөнхий байдалд холбогдох болохоор, түүний төрийн бодлогот чанар, цаг хугацаат чанар нь цөм тун чанга байдаг. Иймээс эрхбиш төрийн бодлогын хариуцлагат сэтгэлийг чангатгаж, зохион байгуулалтын ёс, сахилгыг чангатган, хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд их бага гэлгүй, эрхбиш хариу мэдүүлж заавар авахад эрхбиш цаг тухайд нь оновчтой байж, даруй гадаадад холбогдох явдал үүсмэгц эрхбиш даруй түүхэн байдлыг байцаан тодорхойлж, оновчтой хянан магадалж, цаг тухайд нь дээш мэдүүлж, байдлыг нуухгүй буюу хуурмагаар мэдүүлж болохгүй. Чухал дийлэхгүй, бачим тулгам асуудлыг шат алсалж шууд дээш мэдүүлж болно. Барин доороо байцаан тодруулж болохгүй зарим асуудлыг нэг талаар дээш мэдүүлж, нэг талаар байцаан магадалж болно. Урьдаар товч мэдүүлэлт хийж, дараа нь нарийн мэдүүлэлт хийнэ. Гадаадад холбогдох явдлыг дээд шатны заавар ба шаардлага ёсоор шийдвэрлэж, дурааараа буюу эрхээсээ давж шийдвэрлэж болохгүй.

Долоо. Гадаадад нөхөрсөг байх ба ухуулгын ажлыг сайтар хийх нь.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд үргэлж хөрш зэргэлдээ улсын хүмүүстэй явалцан харилцдаг. Баяр дурсгалын өдөрт баяр хүргэх, эсвэл гадаадтай хэлэлцээр хийхэд цөм бодитой байдалд улсын харилцааны

одоохи байдлаас үүсч, төлөвлөгөөтэй, дэс дараалалтай явуулж, хөдөлгөөний зүйлийг хэт олон байгуулахгүй, бас удаа бүрийн уулзалт хийх бүрд заавал хөдөлгөөн тохируулсны хэрэггүй

Уур амьсгалын байдлыг зохистой байгуулах. Манай талын хүн урилгаар эсрэг талын хөдөлгөөнд оролцох үеэс, эрх тэгш зарчмыг бодолхийлж, биднээс эсрэг талд адилавтар шинжтэй хөдөлгөөнийг тохируулж аргагүй байдалд эвтэй сайхан үгээр зайлсхийх хэрэгтэй.

Хэлэлцээр буюу дурсгалын өдрийн дайллагын хөдөлгөөн нь цөм нарийн нямбай урьдчилсан төсөв зохиож, адил бус дүйшээнд чиглүүлэн, зөв талын ухуулга ба эсрэг талыг ойлгох ажлыг хийх.

Манай улсын гадаад дахь нөлөөгөө өргөтгөх. Ухуулгын дунд үнэнийг дэлгэж, ёс чрин, арга маягийг амьдлаг байгуулж, байдлын аяар байж, үр дүнг чухалчлах.

Хэлэлцээр дунд хоёр улсын харилцааг сайжруулах зарчмыг барьж, эсрэг талын ард түмний гэрэл цацрангуй түүх ба үндэсний сэтгэлгээг хүндэтгэнэ. Эсрэг талын улсын удирдах хүнийг нэр дуудан шүүмжлэх, улсын дотоодын төрийн бодлогыг шүүмжлэн буруушааж болохгүй.

Эсрэг талын хүн буруу үг ярих, буруу явдал хийх буюу эсвэл манууст буруу ойлголттой үеэс, зориудаар өдөөлгө хийгээгүй бол мануус хэрэг явдлын бодит байдлыг хэлж тодорхойлохоос бус, шүүмжилж болохгүй. Хэрэв эсрэг тал зориуд өдөөлгө хийсэн байвал, эрс эсэргүүцэж няцааж. зууралдсаны хэрэггүй.

Эсрэг талтай харилцах дунд, боловсныг эрхэмлэн, ёс моралыг анхаарч, өмсгөл зүүдэл цэвэр тэгш, хөдөлж байх эвтэй гутрахгүй, ихэрхэхгүй байх хэрэгтэй.

Гурав. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх үндэслэл.

нэг. Нам ба улсын тогтоосон гадаад харилцааны ажлын чиглэлт ба төрийн бодлогыг үндэслэх нь

Нам ба улсын тогтоосон гадаад харилцааны ажлын чиглэлт ба төрийн бодлого бол мануусын хилийн гадаадад холбогдсон явдлыг зөв оновчтой шийдвэрлэх ерөнхий жолоодох хууль дүрэм ба үндэслэл болно. Манай улс бол тусгаар тогтнож өөртөө эзэн мэдэх гадаад харилцааны төрийн бодлогыг хөгжүүлж байдаг.

Эзэрхэх үзлийг эсэргүүцэн, дэлхийн энх тайвныг хамгаалж, эл улстай нөхөрсөг хамтарч аж ахуйгаа хөгжүүлэн ахиулах нь манай улсын гадаад харилцааны ажлын үндсэн харилцаа болно.

Хилийн гадаадад явдлыг шийдвэрлэх ажиллагаан дунд гадаад харилцааны ажлын ерөнхий чиглэлт, ерөнхий төрийн бодлого ба харилцан хүндэтгэж, найрамдлаар зэрэгцэн орших таван зарчмаар үндэслэл болгох суурин дээр, эл улстай нөхөрсөг хөршийн харилцаагаа хөгжүүлэн ахиулна.

Ах дүү ба нөхөрсөг улстай хамтын ажиллагаагаа чангатган ард түмний хоорондох нөхөрлөлөө ахиулж, халуумсаг нөхөрсөг, даруу хичээнгүй байж, бүлгэмдлээ чангатгах мөрдөөн бас зарчмыг баримтална.

Дотоод гадаадыг ялгаж, хамтаар

хилийн амар тогтууныг хамгаалж хэрэгтэй. Эзэрхэг үзэлтэй тэмцэх, тэмцлийн дунд арга бодлогыг анхаарч, ялгаатай хандаж, гол, дэдтэй, ашигтай, байх ёстой.

хоёр. Улсаас тогтоосон хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоолыг үндэслэх нь

Улсаас хөрш зэргэлдээ улсын шинж чанар, түүний гадаад харилцааны төрийн бодлого ба манай улсын харьцаа зэрэгт чиглэж тус бүрдээ хилийн хамгаалалтын төрийн бодлогыг тогтоосон байна. Энэ бол мануусын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол үндэслэл ба ажиллагааны баримжаа болно

Хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоол нь манай улсын гадаад харилцааны ажлын зарчим ба зогсолтгүй ажиллагааны баримжаа юм.

Хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоол нь манай улсын гадаад харилцааны ажлын зарчим ба зогсолтыг тусгажээ. Хилийн хамгаалалтын төрийн бодлогыг үндэслэн хилийн гадаадад холбогдох асуудлыг шийдвэрлэх бол манай ажлын шууд үндэслэл ба зарчим болно.

гурав. хоёр улсын хооронд тогтоосон гэрээ хэлэлцээр ба хилийн дүрэм хэлэлцээрийг үндэслэх нь.

Хилийн гэрээ хэлэлцээр ба хилийн дүрэм тогтоол бол зохих хуулийн хүчинтэй байж эл улсад зөвшөөрөгдсөн бөгөөд хоёр улсад адилхан хязгаарлах хүчинтэй юм.

Гэрээ хэлэлцээр, хилийн дүрэм тогтоол нь хилд үүсэх явдал жич түүнийг шийдвэрлэх арга хэмжээнд цөм зохих нарийн нягт тогтоол тогтоосон байдаг.

Гэрээ зөвшилцөл, хэлэлцээрээр хилийн гадаадад холбогдсон явдлыг зөв шийдвэрлэх нь улсын эрх мэдэл, амар тайвныг хамгаалж, хилийн амар тогтууныг хэвээр байгуулахад цөм чухал их үйлдэл үзүүлж байдаг.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх арга маяг ба дэс дараалал.

Нэг. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх арга маяг.

Нэг. Захидлын арга маяг. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дунд, захидлаар харилцах буюу зөвшилцөх бол ердийн хэрэглэдэг нэг зүйлийн ажлын арга маяг болно.

Онцлог нь амьдлаг түргэн хэрэглээний хүрээ хэмжээ нь өргөн болно. Ж-нь: хүн хүүр үхдэл, эд бодисыг тушаан солилцох цаг, газар орон зөвлөлцөх эсвэл уулзалт хийх, хэлэлцээр хийх цаг, газар орон, хүнийг мэдэгдэх урьж залах холбогдол бүхий байдлыг мэдэгдэх зэрэг цөм хэрэглэж болно.

Хоёр. Хэлэлцээр, уулзалт хийх арга маяг. Хилийн хэлэлцээр, уулзалт бол хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол ажлын арга маяг болно. Бас ч хоёр талын хилийн явдлыг шийдвэрлэх арга зам болно. Хоёр талаараа хил дээр гарсан асуудлыг цаг тухайд нь зохистой шийдвэрлэхийн төлөө, ердөө хэлэлцээр, уулзалт хийх ажлын дүрмийг байгуулсан байна.

Хилийн хэлэлцээр, уулзалт бол адилавтар мөртлөө бас ялгаатай хоёр ухагдхуун болно.

Уулзалт нь энгийн байдалд хоёр талын холбогдол бүхий хүмүүс тогтсон газар оронд болзон уулзаж, холбогдол

бүхий эрхэт байгууллагын санал зөвлөгөөг дамжуулан тоочихыг зааж байна.

Хэлэлцээр нь Хилийн хоёр талын адил тэгш холбогдол бүхий хүмүүс адил дэсийн төлөөлөгчөөс урьд нь нэгдэн тогтсон ямар нэгэн асуудлын тухай зөвлөлдөж ярилцахыг зааж байна. Энгийн байдалд хэлэлцээр нь үсэг бичгийн хэлэлцээр буюу аман хэлэлцээр гэж байгуулж болдог.

Эсрэг талтай хэлэлцээр хийхэд урдаар төсөв тогтооно. Хэлэлцээрийн зөвлөх сэдэв, ярилцах арга, жич ярих хүнээ тогтоож, тогтоолын ёсоор дээш мэдүүлэн зөвшөөрүүлнэ. Зөвшөөрсний дараа барин түргэн хэрэгжүүлнэ.

Гол ярих хүн холбогдол бүхий төрийн бодлого ба гадаадад холбогдох ёс дүрмийг нарийн хянамгай хэрэгжүүлнэ. Гол ярих хүн холбогдол бүхий төрийн бодлого ба гадаадад холбогдох ёс дүрмийг нарийн хянамгай суралцаж, дээд шатны зааврын үзэл санааг ойлгосны суурин дээр төсвийг олонтаа судалж үүсч мэдэх байдлыг шийдвэрлэх урьдчилсан төсөв тогтоож, гадаадад ярих яриагаа нэгтгэж, хамаа бүхий гэрч баримт, материалыг бэлтгэж, заримдаа гэрээ хэлэлцээрийг үндэслэх ултай хэлэлцэх агуулга газраа урьдчилан мэдэгдэж, хоёр талаараа цөм бэлтгэлтэй байх нь асуудлыг түргэн шийдвэрлэхэд дөхөм байдаг.

Хэрэв эсрэг талаас манийг урьж уулзалт хийхэд мэдүүлэлт хийж амжихгүй бол хүнийг тэвчихгүйгээр урдаар уулзалт хийж, эсрэг талын санааг ойлгосны дараа дахиж мэдүүлж болно. Хэлэлцээр дунд зөвшөөрсөн төсөв ёсоор асуудлыг зөвлөлцөн шийдвэрлэнэ.

Зарчим баримтлах мөрдөөн бас төсвийг үндэслэн эл зүйлийн байдлыг амьдлагаар шийдвэрлэж, голтой, дэдтэй урагшлах бөгөөд бас найр тавьж, эрх тэгш зарчмыг журамлан жишсэн зорилгодоо хүрэхээр чармайна.

Хэлэлцээр уулзалтын дунд хэрэв эсрэг талаас төсвөөс гаднах асуудлыг ярилцах үед дурааараа оврын илтгэх буюу зөвшөөрөн хүлээж болохгүй. Хэрвээ дээд шатны журамлах зарчим үндэслэлгүй бол адил бус байдлыг ялган салгаж, судлах, мэдүүлэх буюу эвтэй үгээр давчвал зохино. Хэрэв эсрэг талаас өдөлгө хийхүед эрс эсэргүүцэж, зохих тэмцэл явуулахын хамт улам нэг алхам харилцах эрхээ хадгалж байхаа тодорхойлно.

Хэлэлцээр дууссаны дараа манай талын хүмүүсийг зохион байгуулж хэлэлцээрийн байдалд бага дүгнэлт хийнэ. Агуулгыг голдуу олсон ололт, анхаарах асуудал жич эсрэг талын байдал ба задлалтыг багтаана. Дүгнэлтийн мэдүүлэлт бичиж цаг тухайд нь дээш мэдүүлнэ. Хэлэлцээр уулзалтын дунд бусад салаа мөчиртэй холбогдох ажил байвал цаг тухайд нь холбогдол бүхий салаа мөчирт мэдэгдэнэ.

Гурав. Тухайн газарт нь шийдвэрлэх нь.

Хилийн ойролцоо илрүүлсэн асуудлыг хоёр талын холбогдол бүхий гэрээ хэлэлцээрийг үндэслэн, тухайн газарт нь шийдвэрлэж болно. Жишээлбэл: хилийн ойролцоо эсрэг талын мал унаа хил давж манайд орж ирсэн тухайн газарт нь хөөж буцаах, хилийн ойролцоо барьж олзолсон эсрэг

талын хууль бусаар хил давсан хилийн иргэн, мануусt бусад хор хөнөөл учруулсангүй бөгөөд бусад сэжигтэй байдалгүй бол тэр доор нь түүний бурууг зааж гаргаж, зарлигдан буцааж болно

Гэвч нарийн нямбай данслан тэмдэглэж, дээд шатанд мэдэгдэж, хэргийн дараа буюу зохих тохиромжтой цагт эсрэг талд мэдэгдэх хэрэгтэй.

Дөрөв. Гадаад харилцааны арга зам.

Энгийн байдалд хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд хоёр талын хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд хоёр талын хилийн хамгаалалтын байгууллагатай харилцаж байгаад шийдвэрлэнэ.

Чухал их байдал, хүнд чухал хэргийг бас хилийн хамгаалалтын газрыг давж шат алгасан, гадаад харилцааны арга замаар, хоёр улсын Засгийн газраас хэлэлцэн зөвлөлдөж шийдвэрлэх болно.

Гадаад харилцааны арга замаар дамжин хилийн гадаадад холбогдсон асуудлыг шийдвэрлэх бол нэг зүйлийн дээд дэсийн асуудлыг шийдвэрлэх хэлбэр болно.

Хоёр. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дэс дараалал

Нэг. Хил дээр гадаадад холбогдсон явдал буюу хэрэг үүсэх үед, хилийн хамааралтын салаа мөчир даруй түргэн хүн томилон хэрэг гарсан газар оронд хүрч хайн байцаах, гэрч авах, хэрэгтэй.

Хэрэг гарсан газрын нэрийдэл, орон байрыг байцаан тодорхойлсны дараа хайн байцаах хүмүүсийг зохион байгуулж тухайн газрын холбогдол бүхий ор мөр, үлдэгдэл бодисыг сүүдэрлэж зурах ба гэрч авна...

Хоёр. Тухайн хүн, байдлыг мэдэх хүн буюу олж мэдсэн хүнийг даруй түргэн эрэн олж, хэргийн үүссэн шалтгаан, өнгөрсөн ба олж мэдсэн явцыг ойлгохын хамт байцаалт хийнэ. Байцаалтын дунд ба нарийн нямбай асууж дахин давтан хянан магадалж, ямарч нарийн хэсгийг ч алдаж гаргаж болохгүй. Хэргийн шинж чанар ба шалтгааныг тодорхойлж, холбогдол бүхий хүмүүсийн гэрч үг, буюу тушаасан материалаа бичихийг шаардана.

Гурав. Цаг тухайд нь дээд шатны голлон хамаарах салаа мөчирт байцаасан дүнгээ бичгээр мэдрүүлнэ. Мэдрүүлэлтэнд гадаадад холбогдсон явдал буюу хэргийг үүсгэсэн цаг, газар, хүн шалтгаан, үр дүн жич шийдвэрлэх саналаа дээд шатанд мэдүүлж, чухал үед газар хүн орон байрын зураг буюу тухайн газрын хавтгай дэлгэсэн зураг жич бусад гэрч баримтыг дагалдуулж дээд шатны зааврыг хүлээнэ.

Дөрөв. Гадаадтай харилцахад урдаар төсөв тогтоож урьдчилан төсөв бэлтгэнэ. Хэлэлцээрийн үүрэг тодорхой болсны дараа эсрэг талын байдлыг нарийн нямбай задалсны суурин дээр даруй түргэн хэлэлцээрийн төсөв тогтоож, дээд шатанд мэдүүлж хянан зөвшөөрүүлнэ. Дээд шатны зааврын зориг санааг ойлгохын хамт бусад бэлтгэл ажлыг хийнэ.

Тав. Шийдвэрлэх ажил дууссаны дараа цаг тухайд нь ажлын байдлаа дүгнэн үсэг бичгийн мэдүүлэг бичнэ.

1970-аад оноос эхлэн БНХАУ нь хил орчмын ард иргэдийгээ хил хамгаалалтанд ХКНам, төрийн

бодлогоороо татан оролцуулж байсан бөгөөд "Хил орчмын даган сэргийлэх хариуцлагын дүрэм" боловсруулж хил орчим оршин суугч иргэдтэй хатуу гэрээ байгуулан ажилладаг байна.

Хил орчмын даган сэргийлэх хариуцлагын дүрэм

"Үндсэн хуулийн холбогдол бүхий зурвасыг үндэслэж эв хамт намаа хүрээлж эх улсаа хайрлан, дөрвөн үндсэн зарчмыг баримтлан хил хязгаараа батлан хамгаалж, "Тавын эсэргүүцэх" тэмцлийг сайтар хийхийн төлөө тус дүрмийг тогтоов.

1. Хил хамгаалалтын төрийн бодлого, дүрэм тогтоолыг чанга нямбай хэрэгжүүлж, хүн, мал хил давахыг сэргийлэн хориглоно.
2. Дотогш шургалан гадагш зугтаанч дайсныг барихын хамт нааш цааш явах хүмүүс, тэрэг хөсөгний гэрч тэмдгийг ялган байцааж, гэрч тэмдэггүй хүмүүсийг явуулахгүй сэжигтэй хүн илэрвэл арга сүвэгчлэн тогтоож, хилийн салбарт түргэн мэдэгдэнэ.
3. Гадагш зугатах бололтой сэжигтэй хүмүүсийг хянан ажиглаж, сэжигтэй байдал илэрвэл, гадагш зугатахаас сэргийлнэ.
4. Дайсны тагнуул, дотогш шургалан гадагш зугтаасан сэжигтэй ба хамт хэрэг үйлдсэнийг мэдвэл, хэргийн газар мөр, эд хэрэглэлийг уул хэвээр хадгалахын хамт, хэрэгтнийг илчлэн баривчлах ажилд хамжилцана.
5. Хил орчмын хамааралтын дүрмийг хэрэгжүүлнэ. Гадагш гарахдаа чөлөө авч, зочин ирвэл мэдүүлнэ. Нааш цааш явахдаа хилийн тэмдэг авч, байцаалтыг хүлээнэ.
6. Дайсны радио нэвтрүүлэг болон бусад төрлийн тэрслүү ухуулгыг сонсож дамжуулахгүй. Хөрөнгөтөн ангийн үзэл санааны ялзралыг эсэргүүцэж, оюун санааны бузартлаас сэргийлнэ.
7. Хилийн багана, овоо тэмдэг, хилийн зааг, шугам хөвөөг хамгаалж, хэрвээ шилжүүлсэн, эвдсэн учрал гарвал, даруй дээш мэдүүлж хилийн багана ба хилийн заагаа батлан хамгаална.
8. Дээрх тогтоол дүрмийг холбосон сэргийлэх дугуйлангийн гишүүн болон гэр бүлийнхэн харилцан хянаж, хамтаар хэрэгжүүлнэ. Гавьяа шагнал гаргасныг хөхүүлэн шагнаж, зөрчигчдыг яллан торгоно.

Тус дүрмийг зөвшөөрөн батлав. Дугуйлангийн гишүүн Өнөрцэцэг.

Тойргийн цагдагч Энхээ.

19... оны 5 дугаар сарын 01

1970 аад оны дунд үеэс эхлэн БНХАУ-д "Боловсон айл гэрийг бүрдүүлэх нөхцөлийн 5 зүйл"-ийг мөрдөж эхэлсэн ба уг зүйлийн 4-д Цэрэг, цагдаа, ардын холбоо харилцаа болон бусад айл өрхтэйгээ эе эвийн энэрэнгүй харьцаа холбоотой байх, хил орчмын төрийн бодлого дүрэм тогтоолыг үлгэр жишээгээр сахиж, хүн малаа хил давуулахгүй байх гэж зааж өгсөн байдаг.

БНХАУ нь улсын хилийг бүх нийтээр хамгаалах болон "Хоёр улс-нэг хил" бодлогыг хэрэгжүүлдэг.

Дүгнэлт:

1. БНХАУ-д хил судлалын шинжлэх ухаан "Хил хамааралтын ухаан" нэртэйгээр өндөр түвшинд хөгжиж байна.

2. БНХАУ-ын Төрийн хилийн бодлого нь олон улстай хиллэдэг учраас улс бүртэй харилцах харьцаа, баримтлах хилийн бодлогыг улс бүрийн онцлогт тохируулан боловсруулжээ.
3. Улсын хилийн болон хилийн дэглэмийн зөрчлөөс урьдчилэн сэргийлэх ажлыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын нягт хамтын ажиллагаагаар уялдан зохицуулж байна.
4. Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчилд эрүүгийн болон захиргааны хариуцлагыг ноогдуулан шийтгэж байгаа бөгөөд эрүүгийн хуулийн 6 заалтад тусгажээ.
5. "Хил хамааралтын ухаан" номыг уйгаржан монголоос кириллд хөрвүүлсэн бөгөөд албан хэрэгцээнд хилчдэд зориулан хэвлүүлэн ашиглах нь эсрэг талынхаа хил хамгаалалтын бодлого, арга тактик, ажиллагааг танин мэдэхэд маш чухал ач холбогдолтой юм.

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ИННОВАЦИ

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЬЕ.

Судлаач. ахмад Ж.Болормаа.
ДХИС. Нэгдсэн хүрээлэн. Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэн



Хил залгаа болон олон улс оронд улсын хил хамгаалалтын дэд бүтэц, инженер техникийн хангалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд цэргийн хөдөлмөрийг хөнгөвчилсөн, аюулгүй байдлыг бүрэн хангасан, техникжсэн, механикжсан өндөр бүтээмжит, ашигт үйлийн итгэлцүүр өндөр технологи, төхөөрөмж, хэрэгслийг өргөнөөр үр дүнтэй ашиглаж байна.

Мөн хилийн шалган нэвтрүүлэх боомтууд дээр хяналт шалгалтын орчин үеийн цогцолборыг бий болгон зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааны ихээхэн урсгалыг хурдан шуурхай шалган нэвтрүүлэх, иргэдийг чирэгдэлгүй, хүний эрхийг нь зөрчихгүй шалгахад ихээхэн анхаарч, шинэ шинэ бүтээмжит техник технологийг нэвтрүүлж байна.

Бид энэ өгүүллэгээр хилийн өргөст торон хашаа татах төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, ачаа бараг богино хугацаанд чанарын өндөр түвшинд шалгах байнгын болон зөөврийн, хөдөлгөөнт рентген төхөөрөмжүүдийг танилцуулж байна.

Өргөст торон хашаа татагч төхөөрөмж

1800-аад оны дундуур өргөст утсыг зохион бүтээснээр 1880-аад он гэхэд өргөст утас нь үл хөдлөх хөрөнгийг хаших үр ашигтай, хямд төсөр арга болжээ. Энгийн, эдийн засгийн үр ашигтай, удаан эдэлгээтэй хашаа хэрэгтэй байв.

Энэхүү өргөст торон хашаа суурилуулагч төхөөрөмж нь шонгоо

өөрөө суурилуулж, өргөст төмөр утсаар 4-5 мөр хашааг суурилуулдаг. Төхөөрөмжийг энгийн техник дээр суурилуулдаг. Хашаа сүлжих төхөөрөмжийг дээшлүүлж, доошлуулан тохируулах бүрэн боломжтой. Энэ машин нь 200-500 метр хашааг нэг доор суурилуулах боломжтой. Хамгийн дээд талдаа 5 мөр төмөр утсаар 2000 метр хашаа хийх боломжтой. Машин баруун, зүүн тийш чөлөөтэй хөдлөх боломжтой бөгөөд анх Канадын зах зээлд зориулан бүтээсэн.

Энэ төхөөрөмж нь өргөст торон хашаа босгоход цаг хугацаа, зардал хэмнэхийн зэрэгцээ ажил хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой. Энэ нь олон талт шинж чанартай бөгөөд телескоп гар эсвэл ухагчийн ир дээр гурван цэгийн холболт, урд бэхэлгээгээр трактор дээр суурилуулж болно[1].



Давхар хэлхээтэй утсан бэхэлгээтэй, хоёр чиглэлд ажиллах чадвартай, маш түгээмэл сонголт бөгөөд одоо байгаа машиндаа угсарч болно.

- Нэг мушгирсан өргөст утас
- Давхар мушгирсан өргөст утас
- Уламжлалт мушгирсан өргөст утсан хашааг суурилуулдаг.

Эдгээр төхөөрөмж нь ажлын 8 цагт нэг операторын удирдлагаар, чанар, технологийн өндөр түвшинд 28 км торон хашаа татах боломжтой юм.

Торон хашаа татагч мастер



Энэхүү төхөөрөмж нь 6 утастай хашаа татдаг. Трактор, ачааны машин эсвэл бобкаттай хамт ашиглахад зориулж хийсэн. Хэн ч ашиглахад хялбар байхаар зохион бүтээсэн[2].

RABAUD–Өргөст утсан тор татагч төхөөрөмж: CLOTURMATIC RXB




Зөвхөн нэг дамжуулалтаар 2, 3, 4 эсвэл 5 утсаар хашаа барих загвар. Туузан бэхэлгээ, тэдгээрийн салангид дискэн торомосны ачаар өргөст утсан нэг ороомгийг 500 м хүртэл сунган байрлуулдаг. Туузны зайг тохируулж болно. Өргөст утсыг тогтоох үдээсний агааараар хадах гар буу нь зэвэрдэггүй ган эсвэл цайрдсан сонголтойгоор борлуулагддаг. Замын гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй.

[1] https://youtu.be/-qYn_qYfLT
[2] https://youtu.be/7FrLaztI7t4










Үдээс хадах гар буу (зэвэрдэггүй ган)
Агаарын компрессор 50 л (агаараар хадах гар буу). Хоолой (8 м урт).




Налуугийн засварлагч +/- 30 °

Техникийн үзүүлэлт: 4 RXB, 5 RXB загварууд нь 4-5 өргөст утас зэрэг татан чангалах зориулалттай, овор хэмжээ нь 1930x2430x2380 мм, жин 1190 кг, хажуугийн зайг тохируулах боломж нь 1000мм болно[3].

[3] https://www.rabaud.com/en/products/netting-and-barbed-wire-unwinding-machine/barbed-wire-unwinding-machine-cloturmatic-rxb.html?filiere=agricole#contenu_options https://www.youtube.com/watch?v=wstCHL4Mgvc

Зөөврийн хяналт шалгалтын цогцолбор М-СКАН 9032



Овор ихтэй ачаа болон тээврийн хэрэгсэлд нуусан эд бараа, тэсэрч дэлбэрэх болон бусад бодисыг илрүүлэх зориулалттай.

Үндсэн тактик-техникийн өгөгдөхүүн (ТТӨ)

Цацрагийн энергийн түвшин, МэВ	4,5 и 9;
Төмөр утсыг илрүүлэх боломж (мм)	100мм төмөр хананы цаадах төмөр утсыг илрүүлэх боломж – 3мм
	250мм зузаан ган хананы цаадах төмрийг илрүүлэх чадвар (зузаан х урт х өндөр) (мм) 100х200х200
Шалгагдаж буй тээврийн хэрэгслийн хамгийн их овор хэмжээ (м)	20х3х4,5
Шалгах хамгийн бага ба их байх өндөр (м)	Газрын гадаргаас дээш 0.4-4.5 м
Хөдөлгөөнгүй обьектыг шалгах хурд, м/мин	6, 12, 24, 36 м/мин
Хөдөлгөөнт обьектыг шалгах хурд, м/мин	20 – 25 м/мин
Аяны байдлаас ажлын байдалд дэлгэх болон хураах хугацаа	30 мин
Цахилгааны эх үүсвэр	~ 3 х 380В ± 5 % – 50Гц ± 1%; ~ 220В ± 5 % – 50Гц ± 1%;
Хэрэглэх эрчим хүч	10 кВт

Автофургон дээр суурилуулсан хөдөлгөөнт “МРК-1” рентген цогцолбор



“МРК-1” нь:

. Авто фургон дээр суурилагдсан, нэг талаас шалгах технологийн горимтой, авто машин, ачааг 3 секунтад шалгана.


- Зогсоол дээр байгаа болон цуваанд хөдөлгөөн үйлдэж буй тээврийн хэрэгсэлд нуусан зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх болон мансууруулах бодис, ачаа бараа, хүнийг;
- Зайнаас зэвсэг, радио холбооны хэрэгслийг илрүүлэх зориулалттай.

Онцлог нь:

- Ачааг буулгахгүй шалгах;
- Шалгагдаж буй обьектод нөлөөлөх радиацийн хэмжээ маш бага.

Үндсэн тактик-техникийн өгөгдөхүүн (ТТӨ)

Шалгах хурд	2-10 км/ц
Обьект хоорондын зай	0,5-2,0 м
Шалгах бүсийн хэмжээ, газрын төвшнөөс дээшхи:	
• 0,5 м зайтай бол	0,3-2,3 м
• 2,0 м зайтай бол	0-3,1 м
Зөвшөөрөгдөх хэмжээ. мм:	
• 0,5 м зайтай бол	5 мм
• 2,0 м зайтай бол	20 мм
Шалгах горимд тасралтгүй ажиллах хугацаа	7 цагаас ихгүй
Нэг удаа шалгахад обьектод үзүүлэх туяаны хэмжээ (доз)	0,2 мкЗв



Авто тээврийн хэрэгслийг шалгах үеийн дүрс-зураг



3м-ийн зайнаас бүлэг хүмүүсийг илрүүлсэн байдал

“ШТОК-МНК” Хяналт-шалгалтын хөдөлгөөнт цогцолбор



Гадаад орнуудын ижил төстэй цогцолборуудаас ялгагдах гол онцлог нь алан хядах ажиллагаанд зоруилагдсан зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, хорт бодис, цацраг идэвхит материалуудыг илрүүлэх тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Цогцолбор нь КАМАЗ-65201 автомашин дээр суурилагдсан.

Зориулалт:

- Том овор хэмжээтэй ачаа бараа, тээврийн хэрэгслийн гаалийн үзлэг болон алан хядах ажиллагаатай тэмцэх зорилгоор ашиглах зориулалттай.

Рентген хяналт шалгалтын хөдөлгөөнт "Дозор" төхөөрөмж




«Дозор» нь автофургон дээр суурилагдсан, хөдөлгөөнт рентген шалгалтын төхөөрөмж юм. Ажиллагааны үндсэн зарчим нь шалгаж буй обьектоос буцаж ойсон цацраг туяаг задлах аргад тулгуурласан. Уг төхөөрөмж нь ил обьектын дүрсийг хар цагаан, өнгөт фото зургаар дүрслэн үзүүлэх боломжтой.

«Дозор» системийн давуу тал нь:

- Тэсэрч дэлбэрэх болон мансууруулах зэрэг аюултай органик бодисыг илрүүлэх;
- Дүрсийг нарийвчлалтай, чанартай, өнгөтөөр зураглан үзүүлнэ;
- Төхөөрөмжийг цуваанд хөдөлгөөн үйлдэж байхад болон өндөр хурдтай явах үед шалгах боломжтой;
- Түргэн шуурхай ажиллах боломжтой;
- Гаргаж буй цацрагийн хэмжээ бага, аюулгүй.

Техникийн үзүүлэлт:

Тээврийн хэрэгсэл	Мерседес Спринтер CDI 515
Технологи	Эсрэг цацраг рентген туяа
Эх булаг	Рентген гуурс, 225 кЭВ
Цацрагийн нэвтрэх чадвар	6 мм ган хавтанг нэвтэлнэ
Үзлэгийн боломж	6 м хүртэл өндөр
Ашиглалтын хувилбар	Хөдөлгөөн дунд, хөдөлгөөнгүй, зайнаас
Үзлэгийн хурд	0,5 - 10 км/ц
Дэлгэх байршуулах хугацаа	~ 10 минут
Цацрагийн хэмжээ	0,1 мкЗв-ээс бага (1,5 км/ц-ийн хурдтай 1 удаа шалгахад ялгарах доз)
Ажиллах температурын хязгаар	-35 -аас +50 хэм
Эргэлтийн радиус	6,3 метр
Жин	4780 кг
Овор хэмжээ	Урт-6,65 м, өргөн-2,44 м, өндөр-2,77 м.





“RAPISCAN EAGLE M60” загварын өндөр хүчин чадал бүхий хөдөлгөөнт рентген төхөөрөмж



6 МВ цацрагийн эх үүсвэртэй Rapiscan Eagle M60 нь өндөр нягтралтай ачааг хаана ч, хэзээ ч, яг шаардлагатай газарт нь шалгаж чаддаг.

- Нягтрал бүхий том оврын ачааг 6 МВ цацрагийн үүсвэрээр шалгана.
- Хориглосон, хязгаарласан ачаа, барааг илрүүлэх боломжтой.
- Eagle системийн тусламжтайгаар нуусан эд зүйлсийг илрүүлэх чадвартай.
- 5 м-ийн өндөр обьектыг шалгах боломжтой.



Eagle системийн тусламжтайгаар нягтрал ихтэй ачаанд нуусан эд зүйлсийг илрүүлж байгаа дүрслэл

6 МВ нь одоо ашиглагдаж байгаа рентген төхөөрөмжийн хувьд хамгийн хүчтэй нь болж байгаа бөгөөд ямар ч нягт ачааг, ямар ч нөхцөлд нэвтрэх, нэвтлэх боломжтой.

Дээрх төхөөрөмжүүдийг зөвхөн хуулийн этгээдэд, бэлэн бус тооцоогоор дараах байгууллага нийлүүлдэг:

- **АВМ-СИСТЕМС**
  - **Адрес:** г. Москва, 105523, Щелковское шоссе, дом 100, корп. 100
  - **Телефон:** +7 (925) 507-63-54
  - **Факс:** +7 (499) 391-98-07

E-mail: info@bnti.ru **WWW:** www.bnti.ru

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД НИСЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЭЛ /ДРОН/-ЫГ АШИГЛАХ НЬ

Доктор, профессор Ц.Ганболд

Дроны үүсэл хөгжлийг харвал 1800 оноос эхлэлтэй. Харин өнөөдөр аж үйлдвэрийн салбар бүрт ашиглагдаж буй дроны хөгжил нь 2009 оноос эхэлсэн. Үндсэндээ нийт 10 жилийн хугацаанд дрон технологи үсрэнгүй хөгжсөн байна. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалд ашиглагдах үсрэнгүй технологи нь дрон технологи байх ёстой бөгөөд бүх салбарт ашиглах боломжтой болсон. Түүнчлэн хүний амь нас эрсдэх аюултай ажиллагаанд хүртэл дроныг ашиглах боломж нээгдэж байна.

Сүүлийн 10 гаруй жилд үсрэнгүй хөгжсөн технологийн жишээ бол нисэгчгүй нисэх төхөөрөмжийн нэгэн төрөл болох "Дрон" бөгөөд "Enterprise Drone" буюу тусгай зориулалтын дроны технологийн хөгжлийн чиг хандлага, ач холбогдол, хэрэглээ, боломжууд ихээр нэмэгдсэн

Дроныг бид зураг авч, бичлэг хийх зориулалттай хэрэгсэл мэтээр хүлээн авдаг байсан бол тус технологийн хэрэглээ асар хурдацтайгаар өсөн нэмэгдсээр байна. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон дрон технологийн үр ашигтай байдал сайжирснаар дэлхийн улс орны төрийн, цэргийн болон бизнесийн байгууллагууд, энгийн хэрэглэгчдийн тус технологид оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсээр ирэв.

АНУ-ын байгууллагууд үйл ажиллагаандаа дроныг нэвтрүүлэх нь сүүлийн 2 жилд 552 дахин өсжээ. Мөн АНУ-ын хууль сахиулах байгууллагын мэргэжилтнүүд 2025 он гэхэд 20,000 дроныг жил бүр ашиглалтад оруулан үйл ажиллагаандаа ашиглах тооцооллыг гаргажээ.

Дроныг анх мэйл хүргэх, зураг авах зэргээр ашигладаг байсан бол өнөөдөр барилгын 3D зураг боловсруулах, онцгой байдал, гал унтраах, хөрсний бүтэц тодорхойлох, кино үйлдвэрлэл, дэд бүтцийн хяналт шалгалт, ашигт малтмалын хайгуул, хилийн хяналт гэх зэрэг маш олон салбарт төрөл бүрийн зориулалтаар ашиглах болсон[4].

Дроныг цэрэг армийн зориулалтаар ашиглаж эхэлсэн түүх шинэхэн бөгөөд 2001 оны 11 дүгээр сард америкчууд "Талибан" хөдөлгөөний эсрэг анх удаа байлдааны дрон ашиглажээ. Тэр үеэс Израйль, АНУ хоёр байлдааны дроныг шинэчлэх, сайжруулах, үйлдвэрлэх тал дээр ихээхэн ажиллаж, дэлхийд ноёрхож эхэлсэн. Аливаа шинэ зүйлээс хоцордоггүй, дууриалган хуулбарлахыг мастер өмнөд хөрш Хятадууд ч энэ чиглэлд ихээхэн анхаарч ажилласны үр дүнд тодорхой амжилтад хүрч, Ойрхи Дорнодын байлдаантай бүс нутагт нийлүүлсээр байна.

Дрон нь хямд төсөр өртөгтэй, радарт баригдахгүй нисдэг, устгаж байгаа байгаа зурагжуулж, дүрсээ дамжуулдаг, устгах байг тодорхойлоод нисгэсэн байхад баталгаатай устгах чадвартай, пуужин, зэвсэг тээж өрсөлдөгч талдаа хөнөөл учруулахаас гадна тагнуулын зориулалттай, мэдээллийн зориулалттай, долгионы саатуулга хийх зэрэг олон зориулалтаар ашиглах болжээ.

[4] Эх сурвалж: МТҮП itpark.mn/

Дронууд нь ажиглалтын, тагнуулын ба цохилтын гэсэн 3 үндсэн зориулалттай. Түүнчлэн камиказе-дрон гэж байдаг бөгөөд энэ нь байг бөмбөгддөггүй, пуужингаар харвадаггүй, харин байг илрүүлсэн даруйдаа дээрээс нь унаж дэлбэлдэг "амиа золиослогч дрон" юм.

Дроны хамгийн том давуу тал бол хямд үнэ. Тухайлбал, хамгийн үнэтэйд тооцогддог Израилийн "Hermes" гэдэг цохилтын дрон 20 орчим сая доллар бол тагнуулын Orbiter 2M нисгэгчгүй төхөөрөмжийн үнэ нь 600 мянга орчим доллар. хамгийн хямд дрон болох Израилийн "Heron" 100 мянган долларын үнэтэй.

Бүтэн өдрийн туршид агаарт байж чаддаг, хэдэн зуун км-ийн холоос оператор удирдаад лазеран овоотой дөрөв хүртэлх пуужинг есөн км-ийн өндөрөөс өндөр нарийвчлалтайгаар чиглүүлсэн байруугаа унагаж чаддаг Туркийн Bayraktar TB2 хэмээх дрон Сири болон Армен-Азербайжаны хооронд өрнөсөн мөргөлдөөнд амжилттай хэрэглэгдэж, нэр алдар нь цуурайтаж, дэлхийн зэвсгийн зах зээл дээр эрэлт ихтэй болж, украйн, сербүүд олноор нь худалдан авч байна[5].



Bayraktar TB2



Энгийн олон зориулалтат дрон

Bayraktar TB2 нь 5 мянган метрийн өндөрт нисдэг, 200 км/цагийн хурдтай, агаарт 27 цаг байж чадна. Пуужингаас гадна MAM гэдэг лазерын онилуур бүхий алсын удирдлагатай тэсрэх бөмбөгийг тээдэг.

Уулын Карабахад болж буй зэвсэгт мөргөлдөөнийг цэргийн шинжээчид "дронуудын дайн" гэж нэрлэж байгаа бөгөөд байлдагч талууд дайсны газар дээрх байнуудыг устгахын тулд нисгэгчгүй төхөөрөмжүүдийг өргөн ашиглаж байгаа нь өнөө үед байлдааны ажиллагаа явуулах арга тактик эрс өөрчлөгдсөнийг харууллаа.

Азербайжан, Армени хооронд дрон олноор нь өргөн ашигласан, хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаагаас тулааны үр дүн хамаарсан анхны дайн болж байна гэж дүгнэж болох юм.

Дроныг тусгай төрлийн будгаар будсан холимог материалууд, хуванцраар хийдэг ба овор хэмжээ багатай бензин ба цахилгаан хөдөлгүүрүүд нь дулаан, чимээ бараг ялгаруулдаггүй, радарын антениас цацруулж буй долгионыг тун багаар буцаан ойлгодог учраас тэдгээрийг илрүүлэн устгахад хэцүү. Гэсэн хэдий ч дронтой тэмцэх аргууд хэдийнээ бий болжээ. Тухайлбал, GPS-ээс дрон руу ирж буй дохиололд саад учруулах, түүнийг дарах байдлаар дроныг

[5] Б.Хулан. Орчин үеийн дайнд ялагчийг дрон тодорхойлно. Өдрийн сонин. 2020.10.16. №215.

төөрүүлэн унагах арга, мөн GPS -ийн байршил тогтоох систем рүү электрон спуфинг дайралт хийх тодруулбал, навигацийн хуурамч өгөгдөл бүхий дохиоллыг дроны хүлээн авагчид өгснөөр тухайн дрон чиглэлээсээ хазайж, хуурамч бай руу довтолдог аргуудыг боловсруулжээ.


Монгол Улсын Хил хамгаалах байгууллагатай нягт хамтран ажилладаг Энэтхэг улсын Хилийн аюулгүй байдлын хүчин дронтой тэмцэх чиглэлээр багагүй туршлага хуримтлуулсан байна. 2018 онд Пакистаны талаас дроноор хил зөрчиж, зэвсэг зөөвөрлөх хэд хэдэн тохиолдлын дараа Энэтхэгийн талаас дрон эсэргүүцэх 4-5 системийг хилийн дагуу байршуулсан бөгөөд уг систем нь нэгээр болон бүлэг ННХ-ийг (сүргийн дайралт) алсаас илрүүлэх чадвартай бөгөөд өөрийн хариуцлагын бүсэд орсон байг 10 секундийн дотор илрүүлж, 360 градусын орчинд эдгээрийг бодит цаг хугацаанд сканердах, илрүүлэх, мөрдөх, саармагжуулах чадвартай[6] гэжээ.

Мөн арабын зарим орнуудад бүргэд, шонхор зэрэг анч шувуудыг бага оврын дрон барих (устгах) аргад сурган тэмцэх оролдлогуудыг хийж байгаа ч тодорхой үр дүнд хүрээгүй байдаг. Манайд ч Баян-Өлгий аймаг дахь хилийн ангиудад туршлагын журмаар анч бүргэд ашиглан дрон ангуучлах санаачлага гарган сургаж бэлтгэж байсан туршлага, сургамж бий.

Мөрөн дээрээс бууддаг зенитийн пуужингийн 9К333 "Верба" цогцолбор, радио саатуулгын Красуха 4 цогцолборыг ашиглах нь үр дүнтэй байгаа болон ойрын ирээдүйд лазерын их буу зэвсэглэлд нэвтэрсэнээр дронуудыг асар хямд өртгөөр устгах боломж гарч ирэх юм.

МУ-ын зэвсэгт хүчин байлдааны дроныг худалдан авч ашиглах нь цаг үеийн асуудал бөгөөд техникийн сонголт хийхдээ дараах улсуудын дронуудаас сонголт хийх нь зүйтэй болов уу гэж үзлээ.

Техникийн үзүүлэлтээр байлдааны дроны шилдгүүдийн жагсаалтанд Америкийн 5, Хятадын 2, Израиль ба АНЭУ-ын тус бүр 1 дрон, түүнчлэн дээр дурдсан Туркийн Bayraktar TB2 дрон багтсан байна. Тухайлбал, жагсаалтыг тэргүүлж буй Америкийн Predator C Avenger нисгэгчгүй онгоцыг 2009 онд General Atomics Aeronautical Systems компанид зохион бүтээж



Predator C Avenger

Харин 5 дугаарт бичигдсэн, дунд өндөрт нисдэг тагнуул-цохилтын хосолсон зориулалттай Хятадын CH-5 дрон агаарт 60 цаг, түүний ард бичигдсэн Yabhon United 40 гэдэг АНЭУ-д зохион бүтээсэн тагнуул-цохилтын дрон агаарт 5 хоног хүртэлх хугацаагаар байж чадна. Харин 2 дугаарт бичигдсэн Израилийн Heron TP

[6] https//economictimes.indiatimes.com/news/defence/bsf-to-be-armed-with-anti-drone-system-for-border-near-jammu-kashmir-soon/articleshow/73701217.cms?from=mdr

дрон агаарт 36 цаг тогтож, нэгэн зэрэг 6 байг онилдог зэрэг үзүүлэлтээрээ ялгаатай[7].


Хөрш ОХУ-ын зэвсэгт хүчинд "Калашников" концернд бүтээгдсэн алуурчин дронуудын цуврал "Ланцет -1, 2, 3" гэсэн Дрон- камекадзенуудыг зэвсэглэлд авч эхлээд байна.

Уг дронууд агаарт чөлөөтэй маневр хийж, 40 минут хүртэл нисдэг, 110 км/цаг хурдална, 3кг тэсрэх бодис тээдэг, цахилгаан хөдөлгүүртэй учраас дуу чимээ бага гаргадаг онцлогтой.

Ланцет-1 нь агаараас төрөл бүрийн байг байнга дагалдах чадалтай ба залуурт сум, эсвэл алуурчин дроныг чиглүүлэн өгөх чадвартай.

Ланцет-2 алуурчин дрон нь агаарт байгаа жижиг, том дронуудыг илрүүлэн олж мөргөж сөнөөх үүрэгтэй юм.

Ланцет-3 алуурчин дрон нь амьд хүч, төрөл бүрийн хуягт техникийн устгах үүрэгтэй.



Ланцет-3

МУ-ын Зэвсэгт хүчин, ХХБ, ОБ, Байгаль орчныг хамгаалах байгуулагын хувьд агаарын болон газрын орон зайд тандалт явуулах, агаараас тоон стерео зургийн фотограмметр, ортофото, байр зүйн боловсруулалт хийх, хүрэхэд хүндрэлтэй, алслагдсан газар орныг хянах, орон зайн тагнуулын мэдээлэл цуглуулах, байн байршил тодорхойлох, заах, байрлалын солбилцолыг тодорхойлох, хөдөлгөөн үйлдэх үед замналын дагуу ажиглалт хийх, гамшиг ослын болон хилийн цагийн байдлын мэдээ цуглуулах, хяналт хийх, ан амьтны байршил тогтоох, тооллого хийх, ойн тандалт хийх зэргээр ашиглаж боломжтой.

Монгол Улсын ОБЕГ сүүлийн жилүүдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан технологийн ололт, инновации нэвтрүүлэхэд идэвхтэй ажиллаж, аврах ажиллагаанд хүн хүчнээс гадна технологийн ололтыг өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал, дроныг ашигласнаар ой хээрийн түймрийн тархалтыг тогтоох, хүн хүчээ оновчтой хувиарлах, удирдлагын шийдвэр гаргах түвшинд ажиллаж чадаж буй явдал юм. Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын газар 20 орчим дроныг ашиглаж байна. Хамгийн гол давуу тал нь цаг хугацаа, хүн хүч хэмнэх явдал тул эрэн хайх, аврах ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх болов.

Өнөөдрийн байдлаар 70 гаруй дроныг Улсын Тусгай Хамгаалалттай Газруудад ашиглаж байгаа ба байгаль хамгаалагчдыг тусгай сургалтад хамруулсан[8].

МУ хилээ хамгаалахдаа хүний хүчин зүйлээр хамгаалах боломжгүй онцлогтой. Улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, найдвартай байдал, чадавхыг дээшлүүлэхийн тулд техник, технологийг нэвтрүүлэх

[7] **Б.Адъяахүү. Эх сурвалжууд: /.**

[8] С.Сарангэрэл. Дотоодын аялал жуулчлагчдын тоо сая давсан. Өдрийн сонин. 2020-11-05. №223 (6589).

шаардлагатай байна[9].

МУ-ын Хил хамгаалах байгууллагад нисэгчгүй нисэх хэрэгсэл-дроныг (цаашид ННХ гэх) ашиглах алхамуудыг хийж байгаа хэдий ч байнгын хэрэглээ болоогүй, техник, технологийн оновчтой сонголт хийгдээгүй, ашиглах дүрэм, журам ч гараагүй, арга тактик нь ч боловсруулагдаагүй байна.

Монгол Улсын хилийн баруун, зүүн чиглэлээр нисэгчгүй нисдэг хэрэгсэл-дроноор хил зөрчүүлсэн хэд хэдэн тохиолдол гарсан бөгөөд устгаж чадахгүй алдсан сургамж бидэнд үлдсэн. Хил зөрчин орж ирснийг илрүүлсэн даруйд нь устгах эрх зүйн орчныг, мөн боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах, агаарын байнд гал явуулах, удирдах ажиллагаанд хилийн манааны ахлагч, харуулын болон салбарын захирагч нарыг сургах нь эн түрүүнд тавигдах болж байна.

Тэмцлийн хэрэгсэл нь аргаа тодорхойлдог цэргийн сонгодог онолын дагуу нисэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалтад оновчтой, үр дүнтэй ашиглах арга тактикаа ч, улсын хил зөрчүүлэн, зөрчин орж ирсэн нисэгчгүй нисэх хэрэгсэлтэй үр дүнтэй тэмцэх, устгах арга тактикаа ч хамтад нь боловсруулж, эрх зүйн үндсийг нь тодорхой болгон хууль, дүрэм, зааварт тусган эрх зүйн чадамжтай болгох, бие бүрэлдэхүүнээ сурган дадлагажуулах, зориулалтын зэвсэг хэрэгслээр (торон болон лазер, импульсын буу, стрела, оса, игла загварын агаарын бай устгах зөөврийн пуужин) хангах шаардлага нэгэнт бий болжээ.

Хил залгаа улсын талаас гэмт хэргийн бүлэглэлүүд (зорилтот бүлгүүд) дрон ашиглан хил орчмын нутаг дэвсгэр, хилийн анги салбар, манаа, харуулын байрлал, үүрэг гүйцэтгэх замнал, арга тактикийг илрүүлэх болон мөнгө валют, алт эрдэнэс, соёлын үнэт өв, хар тамхи, сум галт хэрэгсэл зэргийг зөөвөрлөн нэвтрүүлэхэд ашиглаж байх магадлалтай.

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн одоо байгаа орон тооны хүч хэрэгслээр хэт нам өндрөөр хил зөрчин орж ирсэн нисэгчгүй нисэх хэрэгслийг илрүүлэх, түүнтэй тэмцэх боломж хязгаармагдал учраас Хил хамгаалах байгууллага хил дээр байгаа өөрийн хүч хэрэгслээр тэмцэхээс өөр аргагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Зэвсэглэлд байгаа ПКС суурьт пулёметыг суурийн хамтаар зарим онцлог чиглэлийн анги, салбарыг хангах нь эхний ээлжийн тэмцлийн арга хэмжээ байж болох юм. ПКС пулёметийн суурь (Манайд А.В.Степанов болон Е.С.Саможенковын загварын гурван хөлт суурь байдаг) нь агаарын байнд гал явуулахад зориулагдсан бөгөөд 70 градусаас дээш өнцгөөр хараалан буудах, 360 градус эргэх боломжийг хангасан байдаг.

Хил Хамгаалах Байгууллагад тусгай томилгоот салбарын бүрэлдэхүүнд тактикийн зориулалт бүхий нисэгчгүй нисэх хэрэгсэлтэй бүлэгтэй болох, анги, салбаруудад нисэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах болон түүнтэй тэмцэх бүлэг, тоотыг бий болгох шаардлагатай болжээ. Хил хамгаалах байгууллагад

[9] Ц.Сэргэлэн. Манай улс хилээ дан ганц хүний хүчээр хамгаалах боломжгүй, технологийн дэвшил ашиглах шаардлагатай. Өдрийн сонин. 2020-10-28.№217(6583).

ННХ-ийн операторoop бэлтгэсэн мэргэжилтнээ хэрэгцээтэй газар нь байршуулан, мэдлэг мэргэжлийг нь ашиглах цаг нэгэнт иржээ.

Нисэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалтад ашиглах журам, тактик ажиллагааг болон хил зөрчин ирсэн нисэгчгүй нисэх хэрэгслийг устгах, түүнтэй тэмцэх журам, тактик ажиллагааг мөн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн салбаруудтай мэдээ мэдээлэл солилцох, харилцан ажиллах журам зэргийг шинээр боловсруулагдаж батлагдах "Хил хамгаалалтын дүрэм"-д оруулж өгөх нь зүйтэй байна.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН ХАНГАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

ахмад Т.Баяр-Эрдэнэ.Хилийн албаны сургуулийн
Инженер техникийн тэнхимийн ахлах багш,
Хил судлалын докторант.

Улсын хил хамгаалалтын инженерийн хангалтын түүхийг сөхөж харвал хүн гэдэг субъект нь өөрийнхөө аюулгүй байдал, эд хөрөнгөө гадны халдлагаас хамгаалахын тулд байрлаж, амьдарч буй объектынхоо гадуур хашаа, хайс, хэрэм босгохоос эхлэн улмаар эхлэн улмаар цааш тэлсээр үндэстэн, улс, эх орныхоо хил хязгаарыг хамгаалахад хүрсэн түүхэн туршлага бий бөгөөд үүний тод жишээ нь Чингис хааны үед цэргийн зориулалттай зэвсэг, техник, тэр дотроо инженерийн зориулалттай зэвсэглэлийн талаар тухайн цаг үедээ шилдэг гэж үзэхээр техникжсэн байсныг түүхийн хуудаснаа үлдээжээ.[10] Тухайлбал Монгол цэргийн жанжнууд урьдаар өндөрлөг газарт гарч холын бараа харан уул, усны байц, ирж, очих зам, харилцан хавсарч туслах дөт зам, зөөвөр, тээврийн ажиллагааг сонгодог байсан байна.[11] Чингис хаан болон түүний залгамжлагч нар өнөөгийн ертөнцөд хэн түрүүлж шинэ зэвсэг, техник технологи бүтээж түүндээ тохирсон цэргийн стратеги, тактикийг боловсруулна тэр тал ялах болно гэдгийг батлан харуулж байжээ[12] гэж эрдэмтэн Х.Шагдар, Ш.Арвай нар өөрийнхөө бүтээлд дурьдсан байдаг.

Эзэн Чингисийн их цэрэг байлдааны инженерийн хангалтын үүргийг гүйцэтгэдэг инженерийн цэрэгтэй байсан бөгөөд гүүр, далан барих, зам засах, худаг гаргах, их бууны сум бэлтгэх, галдан шатаах, дэлбэлэх, зэвсэг хэрэгслийг эзэмших, үүлэн шат ажиллуулах, өөрийн цэргийн хүрээнд халхавч, харуул босгох зэрэг үүргийг гүйцэтгэж байсан ба 1218 онд байгуулагдсан уг цэргийн анхны командлагч нь Цагаадай болжээ.[13]

Чингисийн цэргийн байлдааны инженерийн хангалтын үүргийг орчин үеийн байлдааны инженерийн хангалтын үүрэгтэй харьцуулсан хүснэгт.


[10]

[11] Эх орны манаа сэтгүүл. №4.УБ., 2007.

[12] Шагдар.Х. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх. I, II боть. УБ.2000

[13] Нямдорж.Д. "Улсын хил хязгаарын талаар Чингис хаанаас баримталсан бодлого сургамж" эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Чингисийн цэргийн дайн байлдааны инженерийн хангалт.УБ.2006

№	Чингисийн цэргийн байлдааны инженерийн хангалт	Орчин үеийн байлдааны инженерийн хангалт
	Цувааnd тагнуулын сэргийлэх, байлдаанд хянах постын үүрэг бүхий харуулаар инженерийн тагнуул хийлгэх	инженерийн тагнуул явуулах
	Гүүр, далан барих, зам засах	цэргийн хөдөлгөөн үйлдэх зам засах, гүүр барих
	Чулуу шидэгч их буу, харвуур, урвуур, чөдөр оньс, модон түншүүр, үүлэн шат ажиллуулах	саад эвдрэлд гарц, гарам төхөөрөмжлөх
	Суваг, шуудуу татах, ус голыг боох, шивээлэн хороолох, хориглолт зохион байгуулах	саад, эвдрэл байгуулах
	одоогийн ашиглаж байгаа явган цэргийн минийн уугал хэлбэр сөргөөг ашиглах	цэргийн байрлал районд минтэй эсэхийг шалгах, мингүйжүүлэх
	өндөрлөг газрыг сонгон авч командын байр хэлбэрээр ашиглан, байлдааны ажиллагааг зохион байгуулах	удирдлагын байр төхөөрөмжлөх
	худаг гаргах	усны эх булгийг эрж олох, ус хангалт зохион байгуулах
	гүүр бариулах, гатлалтын хэрэгсэл усан онгоц, завь, сал ашиглах	усан сааданд гарц, гарам төхөөрөмжлөх
	далдуур ажиллагаа, дүрсэлсэн болон санаатай төөрөгдүүлэлт хийх, төөрөгдүүлсэн мэдээлэл тараах	өнгөлөн далдлалт зохион байгуулах
	галдан шатаах, дэлбэлэх	ҮОХЗ-ийн хөнөөлөөс бие бүрэлдэхүүнийг хамгаалах
	инженерийн хангалтын үүрэг гүйцэтгэх техник хэрэгслээр хангах	инженерийн зэвсэг техник хэрэгслээр хангах




Улсын хил хамгаалалтын инженер-техникийн хангалтын арга хэмжээ нь улсын хил хамгаалалтын түүхийн тодорхой үе шатанд хилийн аюулгүй байдлыг хангах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангахад зохих үүргийг гүйцэтгэж ирснийг Хил хамгаалах байгууллагын хөгжлийн үе шатуудтай нягт холбоотойгоор авч үзэх нь түүний цаашдын хөгжлийг оновчтой тодорхойлох, шинэ бодлого, төлөвлөлтийг зохион байгуулахад зохих хувь нэмрээ оруулах нь мэдээж. Инженерийн хангалтын хөгжлийн түүхийг эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

Эхний шат 1933-1953 оны хоорондох үе. (Энд Хилийн цэрэг үүсэн бий болсноос хойш татан буугдах хүртэлх үеийг хамруулна). Энэ шатанд улсын хил хамгаалах мэргэжсэн байгууллага бүрэлдэн бий болж,

хилийн дагууд хилийн анги, салбарууд олноор байгуулагдан эх орноо харийн түрэмгийлэгчдээс хамгаалах, өвөг дээдсээс уламжлан ирсэн хилийн шугамыг хэвээр нь хадгалж үлдэх гэсэн ширүүн тэмцлийн үе байсан.

Энэ үеийн хилийн инженерийн хангалт нь ихэвчлэн хориглон хамгаалах шинж чанарыг агуулж байснаас хээрийн бэхлэлт байгууламж, хөнгөн маягийн инженерийн саад, хянах байруудыг гарын доорхи материал ашиглан байгуулах, өнгөлөн далдлалт, тактикийн шинж бүхий инженер-техникийн арга хэмжээнүүдээс голлон бүрдэж байв.



Энэ үед инженерийн мэргэжлийн бүрэлдэхүүн, зэвсэглэл, тусгай зориулалтын техникгүй, инженерийн эд хогшил гэх юмгүй шахам байжээ. Зүүн хязгаарын хилийг хамгаалж байсан хилийн заставууд нь дунджаар 20 орчим километр хэсгийг хариуцан хамгаалж байсан ба хамгаалалттай хэсгийн гүн нь 15-20 км буюу ойролцоогоор 300-400 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр ноогдож байжээ.

Түүхийн энэ шатанд хил хамгаалалтыг зохион байгуулж байсан онцлог нь ардын хувьсгалт цэргийн анги, тэдгээрийн харьяа салбаруудын хүчээр улсын хилийг хамгаалж байсан ба хилийн отряд, заставууд нь хилийн шугамын ойролцоо байрлан ардын журамт цэргийн дэмжлэг, туслалцаатайгаар хил манах, сэргийлэн хамгаалах холимог хэлбэр, тогтолцоог ашиглаж байжээ.

Онцгой чиглэлүүдэд хил хамгаалалтыг бүхлээр нь ерөнхий цэргийн ангиудын мэдэлд өгч байжээ. Монгол Улсын баатар С.Төмөрбаатар гуайн дурсан ярьснаас тухайн үед авч хэрэгжүүлж байсан инженерийн арга хэмжээг дараах байдлаар тоймлон ойлгож болохоор байдаг.

Үүнд "...Халхын голоор явганаар болон мориор гатлаж болох 23 газар байдаг. Хамардавааны чиглэлд бургасанд зэвсэглэсэн бүлгүүдийг нууж болохуйц 20-иод булан тохой байдаг. Халхын голд эрт цас орж, орой хайлдаг нь мөр шалгах байгалийн толь болдог байсан. Бид улсын хилийг эргэж явахдаа дайсан этгээд хил давж орсон эсэхийг нягт шалгана. Эсрэг талд нууцаар хяналт хийж болох овоо, нууц байруудыг өргөн ашигладаг байлаа" гэж дурссанаас үзвэл инженерийн байгууламжийн талаар төдийлөн нарийн ойлголтгүй шахам байсныг гэрчилнэ..

Дараагийн шат (1967-1990 он ХХБ дахин байгуулагдахаас эхлээд Ардчилсан хувьсгалын ялах үе). Улсын хил хамгаалах албыг дахин байгуулж, удирдлага зохион байгуулалт, хангалтын хувьд цоо шинээр бүрдүүлж, орчин цагийн хил хамгаалах албаны

бат суурийг тавьсан үе юм.

Түүхийн энэ хугацаанд МУ-ын хил хамгаалалтын онолын үндэс бүрэлдэн, эрх зүйн үндсэн бичиг баримтууд бий болж, хил хамгаалах мэргэжлийн өндөр бэлтгэлтэй удирдах бүрэлдэхүүнийг ЗХУ-д олноор бэлтгэж эхэлжээ.

Энэ үед манай орны улсын хил хамгаалалтад тухайн цаг үеийн дэвшилтэт техник технологи идэвхитэй нэвтэрч эхэлсэн нь улсын хил хамгаалалтыг зарчмын хувьд цоо шинэ агуулга, хэлбэрээр зохион байгуулах нөхцлийг бүрдүүлжээ.

Улсын хилийн инженерийн хангалтын үндсэн үүрэг нь хилийн шугамын явалтыг газар орон дээр тогтоон тэмдэглэх, хилийн шугамыг арчлан хамгаалах, хяналтын иж бүрэн байгууламжуудыг шинээр бий болгох, хилийн замын сүлжээ, инженерийн төрөл бүрийн саад, хилийн отряд, заставуудын хориглолтын байгууламжуудыг бий болгох явдал байсан ба хил хамгаалалтын зарим техник хэрэгслүүд цоо шинээр нэвтэрч эхэлсэн үе юм.

Энэ хугацаанд хилийн анги бүрт инженерийн мэргэжлийн салбарууд байгуулагдан, улмаар 1993 онд ХЦ-ийн түүхэнд анхны инженерийн мэргэжлийн ангийг Багануурт байгуулсанаар улсын хилийн инженер-техникийн хангалтын систем цоо шинээр бүрэлдэн бий болж, тэр чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж эхэлжээ.

Энэ талаар доктор, профессор Ш.Арвай дурсан тэмдэглэхдээ: "... улсын хил хамгаалалтад зайлшгүй шаардлагатай зэвсэглэл, техник, материал хэрэгслийн захиалгыг тав, таван жилээр гаргаж, зохих журмаар гэрээ хэлцэл байгуулан, хилийн цэргийг хүссэн, шаардсан хэмжээгээр зэвсэглэж, техникжүүлсэн юм" гэвд цааш нь хэлэхдээ "...ЗХУ-аас дурдсан хугацаанд 3000 гаруй техник, 20 мянга гаруй нэг бүрийн болоод бүлгийн зориулалттай зэвсэг, мөн барилга орон сууц зэрэг олон зуун эд хэрэгслийг нийлүүлэв" гэжээ.

Түүнчлэн Хил хамгаалах байгууллагын боловсон хүчнийг бэхжүүлэхэд ЗХУ-аас өндөр боловсролтой, дадлага туршлага бүхий хилчин офицер-мэргэжилтнүүдийг олноор ирүүлж хилийн отрядууд, нисэх, тагнуул, холбоо, ар тал, инженер, техникийн чиглэлээр арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж байжээ.

"Улсын хилд 3000 шахам километр урттай инженерийн торон саад байгуулж, 200 гаруй инженерийн хийцтэй худаг, уст цэг, нисэх онгоцны арав шахам, нисдэг тэрэгний 200 гаруй хээрийн буудлыг байгуулж байсан" гэж дурсан бичсэнээс үзвэл Хил хамгаалах байгууллага, хилчид, тэр дотроо хилчин-инженерүүд зөвхөн төсвийг хэрэглэгч байгаагүй харин өөрт ноогдуулсан алба, үйл ажиллагаагаа нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ материал баялгийг бүтээдэг, эх орныхоо хөгжил цэцэглэлт, тэр дотроо хил орчмын нутаг дэвсгэрт хил хамгаалалтын дэд бүтцийг бий болгох талаар үнэтэй хувь нэмрийг оруулжээ.

Багануурын хилийн инженерийн 0252-р ангийн 35 жилийн ойн түүхэн номд "Тус анги байгуулагдсан цагаасаа 321,6 км шороон замыг шинээр байгуулж, 115 ширхэг хяналтын

цамхагийг шилжүүлэх, засварлах арга хэмжээ авч, 6 ширхэг төмөр цамхагийг дотооддоо өөрийн хүчээр үйлдвэрлэн хилийн шугамд хүргэж ашиглалтад оруулсан бол 185 яндант худагт засвар хийж, 794 км өргөст утсан хашааг байгуулахын зэрэгцээ 395 мянга гаруй торны шонг бэлтгэн газар дээр нь хүргэжээ" хэмээснээс үзвэл хилийн дэд бүтцийг хангахын төлөө их ажил хийж байжээ.

Энэ бүхэнд хилийн отрядуудын бүтцэд байсан инженерийн алба, мэргэжлийн салбарууд, инженерийн ангийн оролцоо ч туйлын их байсныг мартахын аргагүй юм. Тухайлбал, хилийн 0184-р ангийн инженерийн албаны дарга, хошууч Д.Адьяасүрэн, хошууч Д.Дэмбэрэл нарын удирдсан албаны боловсруулсан МХЗ гэхэд Хилийн цэргийн хэмжээнд ямагт үлгэр жишээ болохуйц, үнэхээр л толь мэт байдаг байсныг санахад бахархалтай.

Инженерийн ангийн хүчээр Халхын гол, Хэрлэн, Булган зэрэг томоохон голууд дээр өөрсдийн зураг төслөөр 50-200 м хүртэл урттай гүүрийг байгуулж байсан нь өнөө хэр үр дүнтэй ашиглагдсаар байна.



Энэ үед урд тогтоон, тэмдэглэгдсэн улсын хилийн шугамыг хоёр талын гэрээ, хэлэлцээрийн дагуу хамтран шалгах анх удаагийн шалгалтыг Монгол-Хятадын хилийн хэсэгт явуулж, 23 баганыг сэргээн засварлаж, 474 туслах чанартай тэмдэг шинээр босгож, хилийн шугамын уртыг хамтран шалгасны эцэст нийт 1113 тэмдгээр тэмдэглэснээр хилийн хоёр тэмдгийн хоорондох зай 4,2 км хүртэл богиносч, баганаудын хоорондох орон зайн нягтрал эрс сайжирч, үзэгдэх болсомж харьцангуй дээшилжээ.

Харин хойд хилд 1976-1978 оны хооронд Монгол-Оросын хилийн шугамыг тогтоон тэмдэглэх ажлыг явуулсанаар 1925 тэмдэг босгож, хилийн шугамын нийт урт нь 3485 км болжээ. Хөрш орнуудтай хилийн дэглэм, хилийн асуудлыг харилцан шийдвэрлэх, иргэд харилцан зорчих талаар Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийг байгуулжээ.

Манай улсын хилийг 1962 онд БНХАУ-тай, 1958 онд ЗХУ-тай албан ёсоор тогтоон тэмдэглэж, 1973 онд хилийн тухай анхны хууль батлагдаж, хил хамгаалалтын дүрэм, бусад холбогдох зааврууд зэрэг эрх зүйн үндсэн бичиг баримтууд боловсруулагдан, Хилийн цэргийн бүтэц, зохион байгуулалт бэхжиж, улсын хил хамгаалалтын онолын суурь тавигдсан түүхэн үетэй улсын хилийн инженерийн хангалтын хөгжлийн хоёрдох шат буюу оргил үе нь холбогддог .

Гуравдах шат. 1990-оноос хойших үе. Дэлхий нийтийг хамарсан даяаршил, хоёр туйлт нийгмийн тогтолцоо солигдож, чөлөөт ардчилсан зах зээлийн нийгэмд шилжсэн үеийг хамруулан авч үзэж байна.

Энэ үед ЗХУ задарч, улс үндэстэн бүр өөрийн улс орныхоо аюулгүй

байдал, хил хязгаарын асуудлаа бие даан шийдвэрлэх болсон улс төр-эдийн засгийн томоохон хувьсал эрчимтэй явагдаж байна.

Хангалтын найдвартай эх үүсвэр, хүний нөөцийн сургалт бэлтгэлийн уламжлалт тогтолцооноосоо салсан ХХБ нь түүхийн энэхүү шинэ орчинд улсын хилийг хамгаалах өөрийн гэсэн үзэл баримтлал, онол, арга тактикаа үүссэн нөхцөл байдалд зохицуулан шинээр авч үзэх зайлшгүй шаардлагатай тулгарсан.

Урд нь бүрэлдэн бий болсон хил хамгаалалтын онолыг цаг үед нь зохицуулан өөрчлөх алхамыг ХХБ-аас богино хугацаанд шийдвэрлэж чадсан ч хилийн инженерийн хангалтын асуудалтай холбоотой үйл ажиллагаа өнөө хэр төдийлөн зөв голдрилдоо хараахан орж амжаагүй, хоцрогдсон хэвээрээ үргэлжилсээр байна.

Өнөөдөр улсын хилийг харьцангуй бага хүчээр, эдийн засгийн хувьд бага зардлаар хамгаалах гэсэн зорилгыг хэрэгжүүлж, хугацаат цэргийн албаны бүрэлдэхүүний тоог бууруулж, мэргэжлийн цэргийн чиг хандлага бүхий гэрээт цэргийн албаны бүрэлдэхүүнд тулгуурлан, улсын хилийг газар орны онцлогт нь зохицуулан ялгавартайгаар бүсчилсэн байдлаар хамгаалах хандлагыг Төрийн хилийн бодлогын нэг чиглэл болгон ажиллаж байна.

Социалист системийн үед бий болгосон хил хамгаалалтын инженерийн нөөцийг нэгэнт зарцуулж дууссан, улсын хилийн төхөөрөмжлөл нь өнөөгийн шаардлагаас хол хоцорсон, улсын хил хамгаалалтад зайлшгүй шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлийг зах зээлээс олж нийлүүлэх, худалдан авахад гарах зардал нь улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор улсын төсвийн хараат байдалд орж, техник технологийн шинэчлэл удаашрах хандлагатай байгаа нь дотоодын нөөц бололцоогоо аль болох ашиглах, урд нь байгуулсан инженерийн байгууламжуудаа сэргээн засварлах, шилжүүлэн байрлуулах, зориулалтыг өөрчлөх, хүчитгэх зэргээр ашиглалтын боломж, бололцоог нэмэгдүүлэх шаардлагыг зүй ёсоор тавигдаж байна.

ХИЛИЙН ТҮҮХ

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Доктор, Бригадын генерал Ч.Сайнтөр.
МУ-ын ерөнхийлөгчийн тамгын газрын цэргийн асуудал хариуцсан ахлах референт

Монгол Улс нь төрт улсыг анхлан байгуулсан 2020 жилийн аугаа их өв уламжлалтай ард түмэн билээ.

Монгол төрийн нэрт зүтгэлтэн Манлай баатар, Чин ван Ж.Дамдинсүрэн "Төр улсын ажлыг амьд хүмүүс хөтлөн явуулдагч, суурь нь төр улсын төлөө амь насаа өргөсөн хүмүүсийн яс чөмгөн дээр тогтдог юм" хэмээн төрийн албаны залгамж чанар, өв уламжлал, ахмад үеэ хайрлахын мөн чанарын талаар сургасан байдаг.

Монгол Улсын ХХБ нь олон зууны өмнө үүсч бий болсон хэдий ч бид орчин үеийн ХХБ үүссэн 1933 оноос авч үзэх бөгөөд тухайн байгууллагын боловсон хүчин, хүний нөөцийн бодлогын өөрчлөлт, шинэчлэл, уламжлалын асуудал цаг үеэ даган боловсронгуй болсоор өнөө үетэй золгосон билээ.

Хүний нөөцийн бодлого, хэрэгжилтийг түүхэн уламжлалын хувьд судалж үзэхэд ХХБ-ын боловсон хүчин, хүний нөөцийн эрх зүйн зохицуулалт, нийгмийн болон Хил Хамгаалах байгууллагын хөгжлийг даган, түүний хөгжлийн үе шат бүхэнд өөрийн онцлогийг хадгалан байнга шинэчлэгдэж ирсэн уламжлалтай байна.

Монголын эртний хил хамгаалалт: Манай тооллын өмнөх 209 оноос манай тооллын өмнөх 93 оныг хүртэл манай улсын нутаг дэвсгэрт Хүннү хэмээх улсыг Маодунь хаан байгуулсан нь одоогийн Монгол нутагт байгуулагдсан анхны төрт улс байсан.

Эртний Хятадын эрдэмтэн Сыма Цяны "Шицзы" зохиолд "Хүннү-Дуннугийн хооронд хүн нутагладаггүй мянган газар эзэнгүй нутаг буй. Тэд түүний хажуугаар "Оуто" болон отоглодог (нутагладаг) хэмээжээ. "Оуто"-г хятадын түүхчид хилийн харуул, харуулын цайз хэмээн тайлбарладаг ба энэ нь харуулын хот айл буюу байнга байрлах газрын тухай ойлголт юм. Тэдгээр нь улс орныхоо нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хөрш улсын хил орчмын байдалд хяналт тавих, хааны зарлигаас гадуур зорчин явагчид, худалдаачид, тэнүүлчдийг саатуулан шийдвэрлэх, мөн "Торгоны их зам"-д хяналт тавьж, тэднээс татвар авч хааны санд төвлөрүүлдэг байсан нь өнөөгийн шалган нэвтрүүлэх болон гаалийн албатай төстэй алба байжээ. Хаана албан үүрэг гүйцэтгэнэ, тэнд хүн хүчний асуудал гардаг нь жам ёсны асуудал бөгөөд хил хамгаалах хүн хүчний асуудал энд байсан нь тодорхой.

Их Монгол Улсын үе.

Хүннү гүрнээс улбаатай цэрэг-засаг захиргааны орон нутгийн нэгжүүд хил хязгаараа сахин хамгаалах үүргийг гүйцэтгэж байсан энэ тогтолцоо Монголын эзэнт гүрний үед улам

баяжиж боловсронгуй болсоор 19 дүгээр зуунтай золгосон түүхтэй.

Монгол угсаатны нэгдсэн хаант улс байгуулагдсан үед төрийн албанд зүтгэх хүмүүсийг нэг талаас Чингис хааны удам угсаа, алтан ургийн дотроос цусан төрлийн холбоог гол шалгуур болгож байсан, нөгөө талаас төрөлхийн ухаан, эрдэм мэдлэг, эр зориг, шударга үнэнч, зохион байгуулах авьяас билгээрээ шалгаран товойсон хэнийг ч болов сонгож төрийн албанд зүтгүүлдэг байжээ.

Энэ нь "Их засаг" хуульд аравтыг захирч чадсан хүнд мянгат, түмтийг захируулж болно. Өөрийн аравтыг захирч чадаагүй аливаа ноёныг гэмтэн болгож, аравтын дотроос хэн чадахыг ноён болго. Түмт, мянгат, зуутын ноёд үүн лүгээ адил" хэмээн хуульчлан тогтоосноос харагддаг.

Өгэдэй хааны зарлигаар 1235 онд Төрийн хөвгүүдийн сургуулийн үндсийг тавьж байжээ. Үүнээс өмнө Чингис хааны зарлигаар Мухулай ван, Тататунгаа нар хан хөвгүүдэд хичээл заах ажлыг зохион байгуулж байжээ.

Харин 1271 онд нийслэл Дайду хот буюу одоогийн Бээжин хотод Төрийн хөвгүүдийн сургууль, түүнийг эрхлэх албыг байгуулсан юм. Төрийн хөвгүүдийн сургууль нь эртний хятадын Сүй улсын үеэс эхлэн үйл ажиллагаа явуулж ирсэн зуун зуун жилийн түүхтэй.

Юань улсын үед язгууртан, үндэс угсаа ялгалгүй бүгдэд боловсрол эзэмших боломж олгож, хуульч, удирдагчид, эмч гээд олон төрлийн мэргэжилтнийг бэлтгэж байснаараа онцлог.

Мөн Их монгол улсын харъяанд орсон олон улсуудын шилдэг багш нарыг цуглуулж өөрсдийн судалгаа, шинэ санаа бүтээлүүдээрээ уралдах боломж олгож байсан нь өмнөх үеийн төрийн хөвгүүдийн сургуулиас илүү судалгаа шинжилгээнд суурилсан, өнөөгийн их сургуулийн шинжтэй байсныг, мөн төрийн хүн хүчний бодлогод онцгой анхаарч байсны нотолгоо болж байна.

Их Монгол улсын үед "Түшмэдийн сургууль" анх нээгдэж, язгууртан ноёдын хүүхэд болон төрийн албанд ажиллаж байгаа албат, авьяас чадвартай ардын хүүхдүүдийг бага наснаас сургаж, гадаад улсуудын эрдэмтдийг урьж хичээл ном заалгадаг байсан нь төрийн хүн хүчний бодлогод онцгой анхаарч байсны нотолгоо юм.

Манж Чин Улсын эрхшээлд байсан үеийн хил хамгаалалт (1661-1911 он).

Ар Монголын хил хязгаарыг өрхийн харуул, цагдаагаар хамгаалж ирсэн түүхтэй.

Өрхийн харуулыг хошууны захиргаанаас зөвхөн өөрийн хошууны хилд томилон суулгадаг байсан бөгөөд арваад хүний бүрэлдэхүүнтэй байсан. Суман харуулууд нь гэр өрхөөрөө суусан 30 гаруй дарга, захирал, цэргүүдээс бүрддэг. Үүнд: Занги-1, хүнд-1, Туршуул-2, Хуяглан хүргэгч-2, цагдаа-24 хүртэл хүнтэй байсан. Манжийн үеийн монгол улсын хилийн харуул хамгаалалтыг өрхийн гэр харуул, цагдаа харуул, суман харуул гэж гурван төрөлд хувааж байсан бөгөөд эдгээр харуулууд нь хилийн гадаад цагийн байдал, үүрэг гүйцэтгэж

буй газар орны онцлогоос хамаарч бүрэлдэхүүн, зэвсэглэл, хангамжаараа ялгаатай байсан.

Хилийн харуулыг шалган зааварлах, сайн ажиллагсдыг урамшуулах, алдаа дутагдалтайг нь шийтгэх, мөн албан тушаал дэвшүүлэх, бууруулах, сургалт бэлтгэлийн түвшинг тогтоож арга хэмжээ авах, орон нутгаас шилж сонгон авах гээд хүний нөөцийн бүхий л асуудлыг шийдвэрлэж байсан байдаг. Харуулын бүрэлдэхүүнийг нутаг алгасуулан ирүүлэн суулгаж байсан нь хээл хахууль, хуйвалдаанаас сэрэмжилж байсантай холбоотой бөгөөд орон нутгийн иргэдийг орон нутагт нь алба хаалгадаггүй байсан.

Мөн харуулуудын хангамж нь албаны ачааллаас шалтгаалан ялгаатай байсан төдийгүй албан тушаалын хангамжийн ялгаа их байсан нь хүний нөөцийн бодлогод ихэд анхаарч байсны илрэл юм.

Бэлчээр нутаг олгон хувийн мал ахуйтай байх, үр хүүхдийг нь удам залган алба хаахыг дэмждэг байжээ. Энэ нь амьжиргаа, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэж байсны илрэл юм.

Өрх бүрт морь 5, бод мал 25, бог мал 40-ийг олгож байжээ. Харуулын албанд хуягуудыг тухайн орон нутгаас нь авдаггүй, алс холын Халх дөрвөн аймгаас сонгож авдаг журамтай байсны дагуу Уялган харуулд алба хааж байсан хуяг цэргүүд нь Сайн ноён хан аймгийн олон хошуунаас ирсэн хүмүүс байсан бөгөөд одоогийн Баянхонгор, Өвөрхангай, Булган аймгаас ирсэн өрх айлууд юм.

Сайн ноён хан аймгийн харуулын албанд хэрэглэсэн данс бүртгэлээс үзэхэд, Эринцалам зэрэг 6 харуулын 1886 оны 11 дүгээр сарын 12-ноос 12 дугаар сарын 14 хүртэл 32 хоногийн хэрэглэлд иргэн хонь 36-гийн 54 лан, унд, лаа, нүүрс, хатуу цай 105 зэргийн хөлс 21 лан, Арханбуурал харуулаас галч, улаагийн албанд 56 хоног явсан 3 хүний уяа уналгын морь 5, майхан 1, хомтой тэмээ 7, түлээ авч байсан тэрэгтэй шар 1-ийн хөлс зэрэгт 210 лан, 6 пүн, 6 ли, 6 ху, 6 си зэргийг зарцуулснаа тэмдэглэсэн байдаг.

Дээрх баримтуудаас үзвэл харуул тус бүр өөрийн гэсэн мал сүрэгтэй, хэрэглэх цай, нүүрс, түлээ, гэр, зэргийг улсаас олгодог, хийсэн бүх ажилдаа тодорхой цалин хөлс авдаг байсан бөгөөд цалин хөлсийг Улиастайн амбанаас олгодог байжээ.

Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг сургуультай байсан бөгөөд орос, монгол, манж, хятад хэлний орчуулагч бэлтгэдэг "Өргөөгийн орчуулагчийн сургууль" Хаант Орос, Манж Чин улсын хил дээр ажиллах орчуулагч боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж байсныг онцлон тэмдэглэж байна.

Манж Чин улсын үеийн монгол хилийн харуулын сонголт, үүрэг гүйцэтгэх нөхцөл, хангамж, зэвсэглэл, цалин хөлс, хэрхэн шалгалт авдаг, сайшаал, шийтгэл, ахуйн талаар Оросын судлаач Я.П. Дубровын бичиж байсныг толилуулж байна.

Орос-Манжийн хооронд хил тогтож, энх тайван харилцаа тогтосноос Монголын засаг захиргаа хилийн ойролцоох 7-н хошуу бүрээс тус бүр гурван өрх гарган хилийн харуулд үүрэг гүйцэтгүүлэх болов. Дараагийн 7–н

хошуу дараагийн харуулд хүнээ илгээх гэх мэтээр ээлжилж байсан.Тухайлбал, Бэлтэс (Билтыс) харуулд Ми гүн, До гүн, Да засаг, Далай бээл, Баатар бээл,Түшээ гүн, Сайн ноёны хошуудаас томилсон хүмүүс алба хааж байв. Хошуунаас харуулд томилогдогсод гэр бүл, орон гэр, мал сүргийн хамт үүрэг гүйцэтгэх харуулд очдог. Мөн заавал уналгын 4 морь, 10 толгой үхэр, 50 толгой хоньтой байх ёстой байжээ. Хэрвээ ээлж дагуу харуулд томилогдох этгээд дээрхи шаардлагатай хонь малгүй бол засаг олгох эсвэл дараагийн боломжит хүнийг илгээдэг байсан.

Сүүлчийн тохиолдол нэр төрөө эрхэмлэдэг нүүдэлчдийн хувьд маш ховор гарах тохиолдол бөгөөд гэмт хэрэг мэт үздэг байв. Харуулын цагдаагийн алба хаах хугацаа байнгын цэргийнхтэй адил[14] гэж Тимковский тэмдэглэсэн ба эрүүл мэнд, хүч чадал нь л хүрдэг бол 18-60 нас хүртэл алба хаах боломжтой. Эсрэг тохиолдолд халж, ээлжээ хүлээж буй өөр нэгээр сольдог. Өвчтэй цагдаа харуул дээр амьдарч болох боловч харуулын бүх бүрэлдэхүүн нийлж шийдвэрээ гаргадаг ба эсрэг санал гарсан бол өөрийн хошууруугаа нүүх ёстой болдог. Гарсан орон тоог аль нэг боломжтой амьдралтай хүнээр нөхөх шаардлагатай боловч хошууны хувьд ядуу иргэнд холбогдох мал хөрөнгийг нь гаргаж өгөөд насан туршид харуулд суулгах нь ашигтай байжээ. Харуулд алба хаагчид янз бүрийн албан татвар, гувчуураас чөлөөлөгдөх ба харуул орчмын бэлчээр нутгийг хязгааргүй ашиглана.

Харуулынхан өөрсдийн эрх ашгийг хамгаалж, 21 өрхийн тоог яс барих ба энэ нь бэлчээр нутгийн эзэмшил, багтаамжаас хамааралтай. Харуулын цагдаагийн алба хаах нь манай казакуудтай адил үе залгамжлан хаах боломжтой de facto бөгөөд de jure биш юм. Цагдаа харуулын хүүхэд үе залгамжлан алба хаах боловч эцгийнхээ болон бусад хэн нэгний өмнөөс хааж болохгүй юм. Төрөлх нутаг хошуунаасаа алслагдсан байдал, алба хааж буй газар орондоо ээнэгшэн дасал байдал, алба хаах хөнгөлттэй нөхцөл болон бусад нөхцөл байдлаас шалтгаан нутаг буцах асуудал бол маш ховор гардаг үзэгдэл байжээ.

Харуулын бүрэлдэхүүн 21 гэр бүлийн өрхийн тэргүүнүүдээс бүрддэгийг дээр дурьдсан ба энэ жижиг нийгмийн бүлгийн тэргүүн харуул зангийг (зангина) тэд сонгох эрхтэй бөгөөд энэ албан тушаалд томилогдогсдыг Улиастай дахь амбан баталгаажуулдаг. Харуул занги насан туршдаа томилогдох боловч тэр ямар нэг алдаа дутагдал гаргавал өөрчлөх боломжтой бөгөөд харин энэ асуудлыг Сайн ноён хаанд өргөн мэдүүлж баталгаажуулдаг байна. Харуул зангийн гүйцэтгэх үүрэг бол манай хил хамгаалалтын тусгай ангийн даргын үүрэгтэй адил юм. Занги нь харьяа цагдаа харуулуудын гаргасан жижиг зөрчлийг шийдвэрлэх ба харин эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрх тухайн аймгийн бүх харуулыг захирагч даргад хамаарна. Харуул занги нь хүнд (кундая) гэж цолтой өөрийн туслахыг сонгодог ба мөн харуулын бичиг хэргийг хариуцсан бичээчтэй/ бишеша-

[14] Тимковский. Живое путешествие по Азии Эйртэ, перевод Е.Карта. 1840. С.35

писарь/.

Тэр нь бичиг үсгийн чадвар бүхий харуулын цагдаа дундаас сонгогддог. Албаны бүх бичиг хэрэг зөвхөн монгол хэл дээр явагдана. Харуул занги нь өөрийн харьяа цагдааг сахилгын зөрчлийн учир 50 удаа ташуурдах болон 20-иос илүүгүй хоног баривчлан хорих эрхтэй.

Хиагтаас Минусинск хүртэлх бүх шугамын харуулууд 2 аймагт харьяалагддаг. Эхний аймагт дараах харуулууд хамаарагддаг.

Үүнд : Хөх толгой, Дархинт, Уйлган, Архан буурал, Эрэнцалам, Төмөртэй, Ордог бургалтай, Жирхитэй, Хавтгайт, Хар хужир, Цагаан ус гэх 11 харуул Хиагттай хаяа нийлдэг бөгөөд Хөвсгөл нуурын өмнөт үзүүрээс баруун хойт зүгт Хиагттай залгах ба Сайн-Ноён–Хан аймгийн удирдлага, харьяалалд байдаг.

Бэлтэс, Цагаан булаг, Агар, Шаварт, Хачиг, Зайгал, Баян булаг, Жинжилиг харуулууд Засагт хан аймгийн харьяа удирдлагад байх ба Жинжилиг харуул Минусинскийн тойрогтой зах нийлдэг. Хиагтаас цаашхи зүүн хойт зүгийн харуулууд илүү олон хүнтэй бөгөөд зарим харуул 30-40 хүнтэй гэж нэг монгол ярьсан.

Харуул хоорондын холбоо харилцааг зохицуулах зорилгоор бүх хилийн дагуу өртөөг зохион байгуулсан байдаг. Гол өртөө зангийн дэргэд байрлах ба завсрын өртөө харуул хооронд байдаг. Тухайлбал, Бэлтэс, Хатгал харуулуудын хооронд завсрын өртөө “Ужикь Таба”гэдэг газар байрладаг ба Хатгал, Хөх толгойн харуулын хооронд “Алаг сайр”-ын өртөө байрлаж байв. Өртөөг харуулууд өөр хоорондоо харилцах болон харуулуудыг шалгах ноёдын хөдөлгөөнийг хангах зорилгоор байгуулсан. Өртөөний морьд хэрэгслийг эдгээр ноёдоос бусад хүмүүс ашиглахыг хатуу хориглох бөгөөд эдгээрийн зардлыг хошуунаас гаргадаг. Өртөө, хилийн шугамын арчлалт, хамгаалалтыг харуулын цагдаа нар хариуцдаг. Хилийн харуулыг удирдах хааны дараах хоёрдох хүн бол “да гүн” хэмээх цолтой цэргийн ноён юм. Да-гүн харуулын цагдаа нарын гомдлоор харуул зангийг өөрчлөх, шүүх үйл ажиллагааг зохион байгуулах, харуулыг томилсон аймаг болон харуул, цагдаатай холбоотой бүхий л асуудлыг хянан шалгах үүрэгтэй байлаа.

Да гүний дараах гол хүн бол “Ирүүл” юм. (Ирьюль) Энэ албан тушаалтны үүрэг бол манай цэргийн шалгагч нарын үүрэгтэй адил. Жил бүрийн хавар ирүүлүүд хилийн шугамыг шалгаж, цагдаа нарт үзлэг хийх, зэвсэг хэрэгслийн байдал, цагдаа нарын нум сумаар харвах ур чадвар зэргийг шалгах ба харин харуулуудын иргэний үйл ажиллагаанд оролцох эрхгүй байжээ. Хилийн харуулын хариуцсан хилийн харуулыг шалгахын тул ирүүлүүдийг ээлжлэн томилдог байсан. Нэг аймгийн ирүүлүүд үүргээ 5 жилийн хугацаатай гүйцэтгэх ба дараагийн таван жил нөгөө аймгийн ирүүлүүд үүргээ гүйцэтгэдэг. Одоо 1884 онд Сайн ноён хан аймгийн ирүүлүүд үүргээ гүйцэтгэж байгаа ба 1885 оноос Засагт ханы ирүүлүүд үүрэгт ажилдаа орох юм. Ийм ээлж дараалал энэ хоёр аймгийн хувьд үйлчлэх бөгөөд дараагийн аймгууд ч мөн иймэрхүү дараалалтай.

Харуулын цагдаа нар манай цэргийнхэн шиг дүрэмт хувцасгүй бөгөөд жирийн бүхий монголчуудын адил хувцас дээл өмсдөг. Тэдний үндсэн үүргэгт нум сум, 4-н хоромсого сумыг ямагт бэлэн байлгах бөгөөд үүнээс өөр галт зэвсэг, сэлэм , жад зэрэг Европ цэргийнхий зэвсэг хэрэгсэлгүй.

Харин хүмүүнлэг, бусдыг ах дүү шигээ үзэх хүнлэг сэтгэлээр хүмүүжсэн байдаг. Байцаагч нарын үзлэгээр ирүүлүүд цагдаа нарын нум, суманд маш нарийн үзлэг хийх бөгөөд тэдгээр нь Европ бидний хувьд хүүхдийн тоглоом мэт санагддаг. Үзлэгийн үед бүх цагдаа нар нэг эгнээ жагсах ба жагсаалын жигүүрт модон морь байрлуулж, түүний хооронд дээс татсан байх ба цагдаа бүр өөрийн хөлд дээстэй зэрэгцүүлэн нум, сумаа тавьсан байна. Үзлэг хийгч нум сумны чанар байдлыг шалгах ба ирүүл нум сум бүрээс шалгалтын харвалтыг "бумбук" нэртэй байнд гурван зайнаас үйлдэнэ. Эхний зай арван нумын зайтай (10 нумын зай нь 10 саженьтай) тэнцэнэ. Хоёр дохь зай 15-н нум, гурав дахь зай хамгийн хол буюу 30 нумын зайтай тэнцдэг ба эхнийхэд 1, хоёр дох зайд 2, гурав дах зайд 3 бай байрлуулдаг. Бумбукь гэж нэрлэдэг бай нь малын арьсаар хийсэн хүний толгойн хэмжээ, хэлбэртэй бөгөөд нэг их өндөр биш багананд өлгөдөг. Харвалтыг явганаас ба морины явдал дундаас үйлддэг.

Мэргэн, сайн харвасан цагдааг ирүүл шахмал цай болон боодол хятад дүнсээр шагнадаг ба нэг сум л байнд оноогүй бол шийтгэдэг байсан. Шагнал, шийтгэл хоёр хоорондоо асар их зөрүүтэй бөгөөд оноогүйн төлөө гурван настай үхрээр торгож, тэр дор нь 50 удаа ташуурддаг байв. Сахилгын зөрчлийн төлөөх шийтгэлийг занги оногдуулах ба хууль ёсны тушаал шаардлагыг биелүүлээгүй бол цагдааг нэг мориор торгож, 15 удаа ташуурддаг байв. Гэхдээ ийм тохиолдол маш ховор гарах бөгөөд занги, цагдаа нарын хооронд хамгийн нөхөрсөг, хүнлэг харьцаа тогтсон байх ба цагдаа хэзээч зангийг ахлах даргаа гэж хүндэлдэг. Ерөнхийдөө харуул занги, цагдаа нарын алба, амьдрал, үүрэг манай казакуудын суурин, тэдний аж амьдралтай яг адил юм. Харуул болгон дээр дуган байх ба тэнд байнга суудаг ламгүй бөгөөд харуулын цагдаа нар ламын үүргийг мөн гүйцэтгэдэг.

Харуул занги, харуулын цагдаа нарын албан тушаалын ялгагдах онцлог, онцлох тэмдэг нь занги малгайн орой дээрээ цэнхэр өнгийн шилэн жинстэй бол хүндийнх цагаан өнгөтэй байдаг байсан.

Харуулууд манай орос винтов буутай ч түүнийг хүнд биш зөвхөн ан агнахад л зориулдаг байсныг онцгойлон тэмдэглэж байна. Бэлтэс харуулын хариуцсан хэсгийг бид 6 цагийн хугацаанд туулсан бөгөөд энэ нь 24 версть гэж ойлгож болох ба мориор нэг цаг явах газрыг 4 версть гэж тооцдог болой" гэжээ[15].

Оросын судлаачдын гярхай ажиглалтын үр дүнд Манж Чин улсын үеийн монголын хилийн харуулын алба, ахуй амьдрал гээд хүний нөөцийн бүхий л асуудал тэнд байсан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байсныг тодорхой

[15] Дубров Я. П. " Поездка в Монголию". 1884. Иркутск., Типография Н.Н.Синицын. С. 24-31

мэдэх боломж тохиож байна.

Энэ жишээг бид өөрсдийгөө гадны хүний нүдээр харахад ямар байсныг олж харахад сонин болов уу? гэж сонгосон юм.

Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсын үеийн хил хамгаааалт (1911-1920 он).

Богд хаант Монгол Улсын үед хил хязгаарыг орон нутгийн тогтолцоогоор төвлөрсөн удирдлага бүхий хошуу нутгийн хамгаалалтанд тулгуурласан хилийн харуулын хүчээр хамгаалж байв.

Дотоод цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас 1911 оны 12 дугаар сарын 28-нд аймгуудын чуулган дарга, туслах жанжин нарт тушаахдаа "Монголчууд урьд Чин улсын төрийг дагаж явах цагт Орос, Монгол хоёр улсын нутгийн хилийн наад захаар 4 аймгаас харуул хэмээх түшмэл цэрэг үлэмжийг гаргаж, тэдэнд нутаг олгож сэргийлүүлэн суулгажээ. Одоо монголчууд нэгэнт тусгаар улс болж тулгар төр байгуулж Орос улстай найрамдыг зузаатгахаа илтгэжээ. Иймээс 4 аймгаас тэгшээр гаргаж суулгасан харуул цэрэг, түшмэл бүгд 980 өрх, товчлон захирах түшмэл 14, дааж захиарх засаг 4, бүгд захирах засаг 2, эднийг бүрэн татаж буцааж түшмэл цэргүүдийн харгалзаж суусан хил, овоо нутгийг хоосноор үл орхиж болох тул Хиагтын 2 этгээд 47 харуулаас харуул тутам хошоод өрх цэргийг хэвээр үлдээж уг хил, овоо нутгийг харгалзан цагдаж суулган мөн үлдэх 94 цэргийг захирахад аймаг бүрээс нижгээд түшмэл гаргаж хуучин ёсоор баримтлан захирч байхаар тогтоов" гэжээ.[16]

Харуулууд нь Манжийн үеэс уламжлагдан ирсэн уналганд хэрэглэж ирсэн албаны мориноос бусад төрлийн хангалт байсангүй, тэд хил орчмын орон нутгийн ард иргэдийн адил амьдрал ахуйгаа залгуулж ирсэн.

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны хууль зүйн бичигт"... Нийслэл хүрээний газраас монголын зах хязгаарыг батлан хамгаалахаар гаргасан цэргүүдийг бүрнээ хураан хороо зохиож 200 цэргийг нэгэн хороо... 10 цэрэг тутамд аравны дарга нижгээд, 50 цэрэг тутамд ангийн дарга нижгээд, хороо тутам хорооны дарга нижгээдийг тус тус байгуулна" гэж заасан байдаг[17].

1912 оны өвлийн сүүл сарын 26-нд зүүн өмнө зүгийн цэргийг захирах жанжнаар Манлайбаатар Дамдинсүрэнг тохоон томилсон байна.

Харуулын хүмүүс орон нутгийн ард иргэдийг оршин суугаа газраас нь өөр нутаг орон руу явуулж тэдэнд төвөг чирэгдэл учруулахгүй байх, ард түмний сүсэг бишрэлийг хүндэтгэх, сэтгэл санааг нь засахын тулд харуул бүрийн дэргэд жижиг сүм, дуган байгуулж, занги, хилийн харуулууд болон харуулын ойр орчмын олон түмнийг сүм дуганы хурал, шашны зан үйлийн ажиллагаанд хамруулж, хамтран ажилладаг байжээ.

Энэ бүгдээс харахад хилийн харуулууд орон нутгийн иргэдтэй нягт харилцан ажилладаг, сэтгэл зүйн асуудлыг нь хариуцдаг байжээ. Харуулын хүн хүчний аливаа асуудалд төрөөс иэхэд анхаарч байсан түүхэн уламжлалын жишээг эндээс харж

[16] МУТТА. Ф-А-179. Хн-26
[17] МУТТА. Ф-А-30. Хн-150

болохоор байна.

Богд Хаант Улсын түшмэдийн тухай хуулинд төрд ажиллах хүнийг сонгохдоо дөрвөн болзол тавьж байсан нь түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Үүнд: шунал үгүй, долигонуур зангүй, эрдэм чадал төгс, нас идэр тэнхлүүн байх гэж заасан байдаг бөгөөд утга агуулгын хувьд маш чухал заалттай хууль байжээ.

Ардын хувьсгалын эхэн үеийн хил хамгааалт (1921-1933 он).

Ардын хувьсгал ялсны дараагаар хил хязгаарыг илбэн тохинуулах асуудал төрийн бодлогын чухал асуудал болж, "Ардын засгийн газар тухайн үед хамгийн нарийн төвөгтэй байсан зүүн ба хойд, өмнө, баруун өмнө, баруун хязгаарыг тохинуулж хамгаалах арга хэмжээг яаравчлан авсан байна. Хилийн цэрэг 50 жил. УБ., 1993.

Дорнод хязгаарт Г.Бумцэнд, Цэцэн хан аймагт М.Дугаржав, Зүүн хязгаарт Гэлэгсэнгэ, баруун хязгаарт Ц.Хасбаатар, Баруун өмнө хязгаарт Балжинням, Ховдын хязгаарт С.Магсаржав нарыг томилон цэрэглэн хөдөлгөж хязгаар нутгийг хамгаалах цэргийг суулгажээ. 1922 оны 4 дүгээр сараас хил хязгаарыг сэргийлэн хамгаалж буй цэргийн ангиудын хамгаалж буй хэсгээс бусдыг харуулын цагдаагаар сэргийлэн хамгаалах болж, "Монгол Улсын хил хязгаарыг хэрхэн хамгаалах тухай төлөвлөсөн дүрэм"-ийг бий болгожээ.

1922 оны 7 дугаар сард Засгийн газрын 28-р хурлаар Дотоодыг хамгаалах газар байгуулж, даргаар нь Д.Балдандоржийг томилжээ. 1923 онд харьяанд нь Цэргийн бөгөөд Хязгаарын хэлтсийг байгуулсан ба мөн хэлтсийн дагаж мөрдөх дүрмийг нь 1925 оны 4 дүгээр сарын 23-нд баталсан.

1928 онд "Гадаад улсуудтай зах нийлсэн олон аймаг хошуудын хил хязгаараар суулгасан цагдаа нарын түр дагаж явах дүрэм"-ийг баталсан нь анхны хүний нөөцийн дүрэм гэж үзэж болох юм.

ДХГ-ын цэргийн бөгөөд хязгаарын хэлтсийн 1926 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн тушаалаар 6 анги, 28 комендатыг байгуулсан. Эдгээр анги комендатыг анх байгуулахдаа аль аймаг, хошууны нутагт хамаарч байна тэр харьяаллаар нь орон сууц, уналга, буу зэвсгээр хангадаг байжээ.

Хилийн шинэ харуулуудыг байгуулж эхэлсэн бөгөөд харуулын даргаар өмнө нь алба хаасан хуучин цэрэг байсан, буу зэвсэг эзэмшиж чадах, бие эрүүл, хилийн албанд тэнцэх хүмүүсийг шалгаруулан авч байх журам тогтоон хэрэгжүүлжээ. Тухайн үеийн харуулын анги, комендантын бүрэлдэхүүний хангалт, цалин харьцангуй өндөр байсан байдаг. Тухайлбал, буу зэвсгээс гадна морь, тэмээ уналга, гэр, хүнсний зүйлийг нормоор, аргал түлшийг хошууд дааж, хувцсыг өөрсдөө хариуцдаг байжээ. Товчлох ангийг тэргүүлэх төлөөлөгч-110 төг, бусад ангийг тэргүүлэх төлөөлөгч-95 төг, туслах төлөөлөгч комендант нар-70 төг, комендант нарын туслах-60 төг, зарлага ажлын хүмүүс-20 төг, цагдаа нар-40-50 төгрөгийн цалин авдаг байжээ.

Мөн Ардын Хувьсгалын үед 1923 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан "Нутгийн Захиргааны Дүрэм"-д төр засгийн эрхийг

хэрэгжүүлэх албан тушаалтны 4 шалгуурыг заахдаа: ард олны зовлон зүдгүүрийг нэвтэрхий мэдэх, амиа бодох биш ард олны тусыг бодох, аливаа буруу зүйлд холбогдохгүй цэвэр шударга байх, өөрийн хариуцсан засаг төрийн ажил албыг магадаар бүтээж чадах...хэмээн заасан байдаг.

1930 оны 09 дүгээр сарын 15-нд Засгийн газрын хэрэг эрхлэх товчоо "Харуулын цагдааг бэхжүүлэх тухай" 57 дугаар тогтоол гаргасан бөгөөд мөн 10 дугаар сарын 02 –ны өдрийн 02 тоот тогтоолоор харуулын цагдаа нарт ялгах тэмдэг хэрэглүүлж эхэлсэн бөгөөд энэ нь цэргийн цолны анхдагч үүсэл байжээ гэж дүгнэж болохоор байна.

1921-1933 он хүртлэх энэ хугацаанд Засгийн газар, Төв хорооноос хил хамгаалалтын хүний нөөцийг бэхжүүлэх талаар 14 тогтоол, тушаал шийдвэр гаргасан байна[18].

1933-1950 он бол орчин үеийн Хилийн цэрэг байгуулагдсан үе.

БНМАУ-ын Засгийн газар хил хязгаарыг сэргийлэн хамгаалж байсан цагдаа харуулуудыг татан буулгаж, төрөл мэргэжлийн цэргийн хүчээр хил хамгаалалтыг явуулах болж, хилийн отряд, комендатур, заставуудыг олноор байгуулж, улсын хил хамгаалалт бэхжиж эхэлсэн үе юм.

1939 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр БНМАУ-ын Дотоод Явдлын Яамнаас "Шинэ хүчний хэлтсийн үйл ажиллагааг журамлан, ажлыг эрчимжүүлэх тухай" тушаал гаргасан нь боловсон хүчний асуудалд онцгой анхаарсан, хүний нөөцийн удирдлагын тухай анх тусгасан ач холбогдолтой тушаал болсон байна.

1930-аад оны дунд үеэс зах хязгаарын сумдад улсын хил хамгаалалтад туслах сайн дурын үүсгэл санаачлага гарч, хилчдэд туслах болсон нь хүн хүч хэрэгсэлд өөрчлөлт орсон онцлог үе юм.

Энэ үеийн ХХБ-ын хүний нөөцөд гарсан ихээхэн өөрчлөлт нь 1939 оны Халх голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, 1948 оны Баруун хилийн тулгаралт, 1930-аад оны их хэлмэгдүүлэлт зэрэгтэй нягт холбогддог.

1938-1940 онуудад Хязгаарын ба Дотоодын цэргийг удирдах газар, түүний харьяа отряд, ангиудын удирдлагуудыг шат дараалан барьж, хатуу эрүү шүүлт тулган, жирийн цэргээс газрын дарга хүртэл 370 гаруй хүнийг хилс хэрэг тулган шийтгэж байсан нь

Хилийн цэргийн хүний нөөцөд бодит хохирол учруулсан хар жилүүд байжээ. Эдгээрийн тал хувь нь даргалах бүрэлдэхүүн, 190 нь жагсаалын дарга, салааны туслах, тасгийн дарга, пулёметын наводчик, агаарын зенитын бууны дарга, түгээгч, номын багш, жолооч, сувилагч, хилчин, мөнгөний нярав нар байжээ[19].

Тухайн үед Хилийн Цэргийг хэлтэс, газар байхад нь даргалж байсан Эрдэнэцогтын Намсрай, Сэржмядагийн Цэнд, Анжилын Бүрэн, Очирын Дашчарви, Дэндэвийн Гомбо, Готовын Дамба, Баянгийн Аримнийсүрэн, штабын дарга асан Жанцангийн

[18] Лувсанбалдан Э. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. 1921-1944он. I дэвтэр. УБ., 1995. 1 дэх тал.

[19] Алтангэрэл Ч. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ., 1993. 187 дахь тал.

Намсрай, улс төр, сурган боловсруулах хэлтсийн дарга Шиндэгийн Самдан, Цогт-Очир, Лувсаннямын Осорбазар, Бат-Очир зэрэг хилийн цэргийн нэрт зүтгэлтнүүд хэлмэгдэн цаазлуулснаар гадаад, дотоодод улсын асар их зардлаар, он удаан жил бэлтгэгдсэн мэдлэг, дадлага туршлагатай олон ажилтнууд устгагдаж, хүний нөөцөд олон жилийн уршигтай, ихээхэн хохирол учирч байжээ.

Баригдсан хүмүүсийн тоогоор отряд бүр харилцан адилгүй ч Тамсагийн отрядоос 142, Халх голын отрядоос 63, Хэрлэнгийн отрядоос 51, Сангийн далайн отрядоос 39, Дарьгангийн отрядоос 15 хүн баригдсан нь Дорнод, зүүн талын отрядуудаас олон хүн баригдсан байна[20].

Хэлмэгдлийн ид үед буюу 1937 оны 11 дүгээр сард маршал Х.Чойбалсангийн 221 тоот тушаал гарч, "Эсэргүү байгууллагад элсэгдсэн цэргийн албан хаагчид өөрсдөө буруугаа хүлээж биеэ илчлэн хэлбэл ял зэмлэлд оруулахгүй өршөөл үзүүлнэ" гэж НТХ, СнЗ-ийн нэрийн өмнөөс мэдэгдсэн нь хилчдийг ихээр хэлмэгдүүлэхэд нэрмээс болсон.

Баруун хязгаарт үүрэлсэн дээрэмчдийг бут цохиход хилийн 5 дугаар отряд, Ховдын 4 дүгээр морьт хороо ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

1934-1950 онуудад явагдсан Баруун хилийн зэвсэгт халдлага, байлдааны ажиллагааны үед 166 хилчин офицер, ахлагч, байлдагч амь үрэгдсэн байдаг[21].

Улсын Бага Хурлын дэргэдэх Тэтгэврийн комиссын 1939 оны дөрөвдүгээр хурлаас Эх орны төлөө шударга үнэнчээр байлдан тэмцэж амь үрэгдэгсдийн ар гэрт тэтгэвэр тогтоохдоо Ховд аймаг Буянт сум, хөрөнгө бод 50, ам бүл 6, Батын Галсангийн ар гэрт 1100 төгрөг, Увс аймгийн Зүүнхангай сум, бод 3, ам бүл 2, Хуушангийн Дашдоржийн ар гэрт 1500 төгрөг, мөн аймаг Бөхмөрөн сум, бод 1, ам бүл 3, Бат-Очирын Жалбаагийн ар гэрт 1200 төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламж болгон олгож байжээ.

Баруун ба баруун өмнөд хилийг хамгаалахад ДЯЯ-наас ихэд анхаарч, харуул, заставуудын дотор улс төрийн ажлыг өргөн явуулах, хилчдийн санал сэтгэлийг судлах, урам зоригийг нэмэгдүүлэх, сонор сэрэмжийг дээшлүүлэх, сургалтыг сайжруулахад туслах, застав, комендатурыг хүн хүч, боловсон хүчнээр хангах, зөвлөх мэргэжилтэн ажиллуулах, ар талын хангалтыг сайжруулах, аж ахуй, санхүүгийн талаар бодитой туслалцаа үзүүлж байсан.

Халх голын дайн гарахын өмнөх үеийн онцлог нь Хилийн цэрэг эх орны дорнот хязгаарын хил хамгаалалтыг Ардын цэргээс хүлээж аваад удаагүй, 1938 оны 01 дүгээр сараас улсын хилийг өөрийн хүн хүчээр хамгаалж эхлээд байсан онцлогтой. Хилийн застав, отрядуудыг хил рүү ойртуулан байрлуулах, хүн хүчийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн хэдий ч, хэлмэгдүүлэлтийн хор уршиг хүний нөөцөд муу үр дагаврааа үзүүлсээр байсан бөгөөд хилийн зарим хэсэгт цаг агаарын байдал хүндэрч, ихээхэн

[20] Алтангэрэл Ч. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ., 1993. 188 дахь тал.

[21] Даваадорж Н. Эх орны төлөө. УБ., 2018. 304-312 дахь тал.

цас орж хүндэрснээс уналгын агт морь төдийгүй хүн хүчний хувьд ч хохирол үзэх болжээ. Тухайлбал, дайны гол чиглэл болсон Эрс уулын заставт 1939 оны эхээр гэхэд 8 хилчин, 14 уналгын морьтой үлдээд байсан үе байна.

1939 оны Халх голын дайнд Хязгаарын цэргийн 24, 27, 31 дүгээр отрядууд оролцсон бөгөөд 27 дугаар отряд Халх голын адаг, Цагаан овооны чиглэлд, 31 дүгээр отряд Хэрлэнгийн урд талд, 24 дүгээр отряд фронтын гол хэсэгт Зөвлөлт-Монголын армитай хамтран ажиллажээ. Халх голын дайнд хилчдээс .....хүн амь үрэгдсэн болон шархаджээ. Халх голын дайнд хилчдийн гүйцэтгэсэн үүргийг төр засгаас өндрөөр үнэлж, 1939 онд ХЦ-ийн 7 дугаар заставыг, 1972 онд 6 дугаар заставыг Байлдааны гавьяаны улаан тугийн 1 дүгээр зэргийн одонгоор тус тус шагнаж, Баянхошууны заставыг БНМАУ-ын БХТ-ийн 1969 оны 8 дугаар сарын 18-ны зарлигаар Халх голын ялалтын 30 жилийн ойн нэрэмжит, 1979 онд 0198 дугаар ангийг (Халх голын отряд) хошой баатар, маршал Х.Чойбалсангийн нэрэмжит болгон, 1984 онд Байлдааны гавьяаны одонгоор шагнав. Хилийн 24 дүгээр отрядоос Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор 67, Алтан гадас одонгоор 59, чекистийн хүндэт тэмдгээр 44 хүн шагнагдсаны дотор 7 дугаар заставын дарга П.Чогдон, 6 дугаар заставын дарга С.Төмөрбаатар, байлдагч Д.Гуулин, Н.Жамбаа, Э.Шийлэг нарт БНМАУ-ын баатар цол олгожээ[22].

1945 оны чөлөөлөх дайнд Замын-Үүдээс Тарваган дахийн овоо хүртэл улсын хил хамгаалж байсан 8 отряд улсын хилээ хамгаалахын зэрэгцээ байлдааны ажиллагаанд оролцсон юм. Энэ үеийн хүний нөөцийн асуудлын онцлог нь байлдааны ажиллагаатай жилүүд байсан учраас олон хүнийг албан тушаалд шинээр болон дэвшүүлэн томилсон, олон хүнийг төр засаг, байгууллагын шагналаар шагнасан тушаалууд гарч байснаараа өвөрмөц байна. Тухайлбал,УБХТ-ийн 1945 оны 10 дугаар сарын 4-ний 83, 1946 оны 2 дугаар сарын 5-ны 7, мөн оны 7 дугаар сарын 6-ны 47 дугаар тогтоолуудаар 330 хилчнийг төрийн одон медалуудаар шагнаж байжээ. Шагналын хажуугаар гэм буруутныг шийтгэх ажиллагаа ч хийгдэж эх орноосоо урвасан, оргон зайлсан 20 гаруй хилчин байсан этгээдүүдийг илрүүлэн шийтгэжээ.

1933 онд Дотоодыг хамгаалах газрын дарга Намсрайгаас Намын Төв хороо, Ардын Сайд нарын Зөвлөлд албан бичиг илгээж "Цаг үеийн нөхцөл байдлын зайлшгүй шаардлагаас Дотоодыг хамгаалах газрын харьяанд цэрэг, улс төрийн мэдлэг боловсролтой боловсон хүчин, дунд дарга нарыг бэлтгэх тусгай сургуультай болгож өгөхийг хүсчээ[23]

Намын Төв хороо, Ардын Сайд нарын Зөвлөл хянаж үзээд 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газарт дунд сургууль байгуулахыг зөвшөөрчээ.

Энэ шийдвэрийг үндэслэн ДХГ-ын ерөнхий газрын 1933-12-1-ний өдрийн 450 дугаар тушаалаар Хязгаарын

[22] Хилийн цэрэг 50 жил. УБ., 1983. 101 дэх тал.

[23] Жамьян Ж. НАХЯ-ны Цэргийн Дээд Сургуулийн түүхэн танилцуулга. УБ., 1984.

ба гүйцэтгэх ажилтан бэлтгэх түр курс байгуулагдаж, ДХГ, Хязгаарын цэрэгт мэргэжилтэй боловсон бэлтгэж эхэлжээ.

Энэ үед 1935 онд 64, 1936 онд 50, 1937 онд 42, 1938 онд 35, 1939 онд 41, 1940 онд 50 нийт 282 боловсон хүчин бэлтгэн гаргажээ. ДЯЯ-ны сайдын 1938-6-26-ны өдрийн 172 тоот тушаалаар Төв сургуулийг Хязгаарын ба Дотоодын цэргийн нэгдсэн сургууль болгон өөрчилж, хилийн заставын дарга, орлогч нарыг тусгай хөтөлбөрөөр сургаж байжээ. 1941 онд ДЯЯ-ны Хүн эмнэлгийн дунд сургуулийг 21 хүн, 1942 онд Яамны мал эмнэлгийн дунд сургуулийг 26 хүн төгсөж хилийн отряд, ангиудад хуваарилагдан томилогджээ. 1951 онд тус сургуулийг татан буулгасан[24].

Хязгаарын цэрэг тусгай мэргэжлийн боловсон хүчнээ мөн гадаадад ЗХУ-д 1938 оноос бэлтгэж ирсэн бөгөөд 1940 онд анхны төгсөлтөөр 24, 1943 онд 28, 1945 онд 27 хүн тус тус төгсчээ[25].

Энэ үеийн боловсон хүчний нэг онцлог нь нийт бие бүрэлдэхүүнийг шинэ үсэгт сургах, бичигтэн болгох ажил өрнөж байсан цаг бөгөөд тухайлбал, Хязгаарын цэргийн 20 дугаар отрядод 1942 онд ажиллаж байсан дарга нарын 80 гаруй хувь нь, цэргүүдийн 70 орчим хувь нь шинэ бичиг үсэгтэн болж байжээ[26].

Монгол Улсын хил хамгаалалтыг хүн хүчний хувьд бэхжүүлэх, томилох, шагнаж урамшуулах зэрэг боловсон хүчинтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийг 1933-1944 онуудад 58, 1945-1946 онд 27, 1947-1959 онуудад 39-ийг тус тус гаргаж байжээ[27].

Хилийн цэрэг татан буугдсан үе. 1950-1967 он. Эх орны дайн дуусч, улс түмний найрамдал хамтын ажиллагааны шинэ үе эхэлсэн бөгөөд Монгол Улс БНХАУ-тай 1950 оны 6 дугаар сард дипломат харилцаа тогтоож, эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан нь хил хязгаарын тайван байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хөгжин бэхжиж байсан Хязгаарын цэргээ найрамдалт хөршүүдтэй болсон, улс орны дотоод, гадаад байдал бэхжсэн учир улсын хил хамгаалалтын хүч хэрэгсэлд их хөрөнгө зарах шаардлагагүй хэмээн үзэн, 1951-1953 онуудад өмнөд хилийн 10570 хүний бүрэлдэхүүнтэй, 12 отряд, шугамын 30 суман, 135 заставаас хилийн 4 отряд, 1 тусгай суман үлдээж, тэдгээрийн 80 хувийг цомхотгосон ба улсын хилийг бага хүчээр хамгаалж эхэлсэн[28].

Хилийн цэрэг татан буугдаж оронд нь үлдсэн 213 хүний бүрэлдэхүүнтэй, хилийн 10 пункт нь хилийн цэргийн үндсэн нэгж болж тус бүрдээ офицер, ахлагч 3, хугацаат албаны түрүүч, байлдагч 9, бүгд 12 хүн, зэвсэглэлийн хувьд гар буу 3, винтов 9, уналгын хувьд жагсаалын морь буюу тэмээ 36-

[24] Хүүжий Г., Г.Аюулгүй Г. ХХБ-ын хүний нөөцийн хөгжлийн түүхэн товчоон. УБ., 2016. 92 дахь тал.

[25] Тагнуулын Ерөнхий газрын тусгай архивын хэлтэс

[26] ХХЕГ-ын төв архив

[27] Лувсанбалдан Э. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. 1921-1944 он. I дэвтэр. УБ., 1995. 1 дэх тал. 1945-1946 он. II дэвтэр. УБ., 1996. 1 дэх тал, 1947-1951 он. III дэвтэр. УБ., 1997. 1952-1958 он. IV дэвтэр. УБ., 1998. 1 дэх тал.

[28] Алтангэрэл Ч. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ., 1993 он. 280 дахь тал.

тай үүрэг гүйцэтгэж байсан. Өмнөд хилийн 4600 км хэсгийг 100 гаруйхан хүн хамгаалах болов.

Энэ үед боловсон хүчинтэй холбогдон гарсан онцлог ач холбогдолтой тушаал, заавар бол ДЯЯ-ны сайдын 1953 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 1196 тоот тушаал бөгөөд хилийн комиссар төлөөлөгч нарын ажлын тухай түр зааврыг баталсан нь хилийн комиссар болон хилийн пунктүүдийн ажлаа явуулах анхны эрх зүйн акт болсон.

ЗХУ-ын Хилийн цэргийн командын дээд сургуулийг1961 онд 15, 1963 онд 15, 1964 онд 15 хүн төгсчээ.

Монгол Улсын хил хамгаалалтыг хүн хүчний хувьд бэхжүүлэх, томилох, шагнаж урамшуулах зэрэг боловсон хүчинтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийг 1959-1966 онуудад 30-ыг тус тус гарган мөрдөж байжээ[29].

Хилийн цэрэг дахин байгуулагдаж бэхжсэн үе. 1967-1990 он.

1960-аад оноос эхэлсэн Зөвлөлт-Хятадын харилцааны хямрал Монголд нөлөөлж Монгол-Хятадыг харилцаа тасарч, хилийн будлиан удаа дараа үүсэх болж Монгол Улсын аюулгүй байдалд заналхийлж эхэлсэн учир БНМАУ-ын төр засаг 1966 оноос хил хамгаалалтын асуудлыг улс орны хэмжээнд буюу стратегийн түвшинд авч үзэж эхэлсэн бөгөөд 1967 онд НАХЯ-ны Хязгаарын ба ДЦХЭГ-ыг байгуулж, өмнөд хилд 1967-1972 онуудад 2 комендатур, 16 заставыг шинээр байгуулан хил хамгаалтанд шилжүүлсэн бөгөөд боловсон хүчнийг сургаж бэлтгэх талаар ЗСБНХУ-ын Хилийн цэрэгтэй хамтран ихээхэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн[30].

Тухайн үед хилийн хамгаалалтын асуудлыг МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн тогтоолыг үндэслэн НАХЯ-ны сайдын тушаалаар ажил хэрэг болгодог журамтай байсан.

1972 оны 6 дугаар сарын 3-нд СнЗ-өөс "Хилийн цэргийг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргаж Дорнот, Баян-Өлгий аймагт хилийн комендатур байгуулахыг ХЦ-т даалгажээ. 1973 оны 2 дугаар сарын 19-нд СнЗ-өөс "Өмнө зүгийн хилийн хамгаалалтыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай" 42 дугаар тогтоол гаргаж, хилийн зарим застав, барилгын батальон, холбооны ротыг нэмэгдүүлэн, шинээр анги 3, застав 25, комендатур, инженер-сапер, барилга засварын рот, бага даргын сургууль байгуулж, 1973-1977 онд ЗХУ-ын Хилийн цэргийн дээд сургуульд 20, дунд сургуульд 80 хүнийг жил бүр явуулж сургах, ХЦ-ийн аж ахуйг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

1974 онд СнЗ-ийн 287 дугаар тогтоол гарч Цэргийн тусгай дунд сургуулийг байгуулсан. 1977 онд 38, 1980 онд 25, 1981 онд 44, 1982 онд 40, 1983 онд 45 бүгд 192 офицер боловсон хүчнийг бэлтгэн төгсгөжээ.

БНМАУ-ын СнЗөвлөлийн 1982 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 241 дүгээр тогтоолор НАХЯ-ны Цэргийн дээд сургуулийг байгуулж, 1985 онд 85, 1986 онд 104, 1987 онд 114, 1989 онд 108, 1990 онд 50 (команд-22, улс төр-

[29] Лувсанбалдан Э. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. 1959-1969.V дэвтэр. УБ., 1999. 1 дэх тал

[30] Бат-Эрдэнэ Б. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг судалсан нь. Докторын диссертаци. УБ., 2003. 113 дахь тал.

28) бүгд 565 офицер, боловсон хүчинг бэлтгэн гаргажээ.

ЗХУ-д 1990 он хүртэл 20 удаагийн төгсөлтөөр 350 дээд боловсролтой хилчин офицерыг бэлтгэсэн байна.

Голицины Хилийн цэргийн улс төрийн дээд сургуулийг 1972-1992 онуудад 17 удаагийн төгсөлтөөр нийт 136 офицер суралцан төгсжээ[31].

1981 онд СнЗ-ийн "Улсын хилийн хамгаалалтыг бэхжүүлэх арга хэмжээний тухай" 22 дүгээр тогтоол гарч, ЗХУ-ын цэргийн дунд, дээд сургуульд бэлтгэх мэргэжлийн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, БХЯ-ны шугамаар гадаад, дотоодын цэргийн дунд, дээд сургууль төгсөгчдийн 15%-ыг хилийн цэрэгт шилжүүлэн өгөх, Дорноговь, Өмнөговь аймгийн зарим отрядыг ерөнхий боловсролын дунд сургуультай болгов.

1973 онд анхны хилийн тухай хууль батлагдсан нь энэ үеийн онцлох үйл явдлуудын нэг болсон. Өөрийн хуультай болсон нь Хилийн цэргийн аливаа асуудал хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэгдээд явах боломжтой болсон явдал юм. Энэ үед хилийн цэргийн бие бүрэлдэхүүний 80% нь улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байсны дийлэнх нь өмнөд хил дээр төвлөрч байсан онцлогтой. 1980-аад оны дунд үе гэхэд ангийн удирдлага 100% академи төгсөгчид, салбарын захирагч нарын 80 орчим хувь нь цэргийн дунд, дээд сургууль төгсөгчид болсон байжээ. Офицеруудын 66% нь 40 хүртэл насны, 80 гаруй хувийг нь мэргэжлийн боловсон хүчин эзэлж байв. Хугацаат цэргийн албан хаагчид, хилийн заставын офицер, ахлагчид 100% орон сууцаар хангагдаж, отрядын төв, Улаанбаатар гарнизоны ихэнхи офицер, улирагсад орон сууцаар хангагдсан үе байлаа.

Офицер, улирагсад, ажилчин албан хаагчдын цалинг бололцоотой хэмжээгээр нэмэгдүүлж, дээр нь удаан жил алба хаасны 5-30%, байгаль, цаг уурын нөлөөллийг харгалзан хилийн 10-35%-ийн нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмэн олгож, хилийн цэрэгт алба хаасан 1 жилийг 1 жил 3 сараар тооцдог болж, ээлжийн амралт дээр 5-10 хоногийн нэмэгдэл амралт олгон, амралтаар хилийн цэргийн онгоцоор Улаанбаатарт ирэх буцах зардлын нэг талыг хөнгөвчлөх зэрэг хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлийн олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ.

Гэр бүлийн хүмүүсийг ажлын байртай болгохын тулд анги, салбаруудад орон тоог хүрэлцэх хэмжээгээр бий болгож, ажиллаагүй тохиолдолд, улсад тасралтгүй ажилласанд тооцон, хүүхдүүдийг нь сургууль, цэцэрлэг, яслид хамруулах, эмнэлэг, худалдаа, соёлын үйлчилгээг хүртээмжтэй болгох ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлж иржээ.

Энэ үед, 1967-1991 онуудад хилийн цэргийн удирдах боловсон хүчнийг бэлтгэх, сургах, албан дээр нь дадлагажуулахад, хил хамгаалалтад шинээр нэвтэрч буй зэвсэг техникийг хил хамгаалалтад бүтээлчээр нэвтрүүлэхэд Зөвлөлтийн хилийн цэргийн зөвлөх мэргэжилтнүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байдаг.

[31] Хүүжий Г., Аюулгүй Г. ХХБ-ын хүний нөөцийн хөгжлийн түүхэн товчоон. УБ., 2016. 54 дахь тал.

Төр засгаас улсын хил хамгаалах үйлст амь биеэ зориулсан алдартнууд, хамт олны амжилт бүтээл, гавьяаг үнэлэн ХЦ-ийн олон анги, салбарыг баатрууд, алдартнуудын нэрэмжит болгох, одон тэмдгээр шагнах болон 8 хилчинд БНМАУ-ын баатар хэмээх эрхэм хүндэт алдар цолыг олгосон байдаг.

Энэ хугацаанд 7604 хилчин төрийн дээд шагнал одон медиалаар шагнагдахын зэрэгцээ 1978 онд МХЗЭ-ийн Төв Хорооноос буй болгосон "Хилчний алдар" медалиар олон арван застав хамт олон, 500 хилчин, СнЗ-ийн 347 дугаар тогтоолоор 1982 онд буй болсон "Хүндэт хилчин" тэмдгээр 120 хүн, мөн "Онц хилчин" тэмдгээр 2000 хүн шагнагдсан байна.

Хилийн цэргийг боловсон хүчин болон бүх талаар бэхжүүлэхэд тэр үеийн хилийн цагийн байдал болох 1967 оноос эхлэн Монгол-Хятадын харилцаа эрс муудсан үе, 1979 онд тухайн үеийн Хятадын эрх баригчид Вьетнам улсад довтолсон түрэмгийлэл ихэд нөлөөлсөн байдаг.

Энэ үеийг "Хүйтэн дайн"-ы үе гэж нэрлэдэг бөгөөд хилчид яг л дайны өмнөх үеийнх шиг байдалд бие бялдар, сэтгэл зүйн, албаны ихээхэн ачаалалтай алба хаан ажилладаг байсныг тооцон, төр засгаас Хүйтэн дайны үед алба хаасан хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тэр үеийн олон ахмад хилчид санал бодлоо илэрхийлсэн байдаг бөгөөд энэ асуудлыг цогцоор нь авч үзэн шийдвэрлэхийг хурандаа Д.Бухбатын "Хүйтэн дайны үеийн ахмад хилчдийн нийгмийн асуудал" нэртэй асуудал дэвшүүлсэн өгүүллэгт тодорхой дурьдсан байдаг[32].

Монгол Улсын хил хамгаалалтыг хүн хүчний хувьд бэхжүүлэх, томилох, шагнаж урамшуулах зэрэг боловсон хүчинтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийг 1967-1990 онуудад 99-ийг тус тус гаргаж байжээ[33].

Нийгмийн шилжилтийн үеийн Хилийн цэрэг. 1990-2000 он.

1990 онд НАХЯ татан буугдаж, УАБХЕГ байгуулагдан, түүний харьяанд Хилийн цэрэг үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 1993 онд Хилийн тухай хууль батлагдаж, ХЦУГ-ыг байгуулан, 1996 он хүртэл Засгийн газрын дэд бүтцийн байгууллага болсон. 1996-2000 он хүртэл БХЯ-ны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг болсон.

Нийгэм, улс төр, эдийн засгийн ихээхэн өөрчлөлт гарсан шилжилтийн энэ жилүүдэд ХХБ-ын боловсон хүчний 4/1 хувь нь хилийн цэргээс өөрийн хүсэлтээр гарсан судалгаа байдаг[34].

1990-1996 онуудад дотоод, гадаадын дэвд сургууль төгссөн мэргэжлийн боловсон хүчнээс 1303 офицер янз бүрийн шалтгаанаар халагдсан нь хилийн застав, отрядын даргалах бүрэлдэхүүний тоо болон чанарт ихээхэн муугаар нөлөөлсөн байна.

1997 оны байдлаар ХЦ-ийн бие бүрэлдэхүүний хангалт 66.4-81.1

[32] Хил судлал сэтгүүл. УБ., 2016 он. №1-2. 75-79 дэх тал.

[33] Лувсанбалдан Э. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. 1969-1973 он. I дэвтэр. УБ., 1995. 1 дэх тал, 1974-1977 он. II дэвтэр. УБ., 1996. 1 дэх тал, 1978-2002 он. III дэвтэр. УБ., 1997. 1 дэх тал.

[34] Хүүжий Г., Аюулгүй Г. ХХБ-ын хүний нөөцийн хөгжлийн түүхэн товчоон. УБ., 2016. 54 дахь тал.

хувь, үүнээс офицер 81.1 хувь, ахлагч 66.4 хувь, ХЦАА 76.5 хувьтай байсан бөгөөд нэг хилийн отряд дунджаар 65–70 хувийн нөхөн хангалттай байгаагаас хамгаалалтын нягтрал 30-35 хувиар буурч хилчдийн ачаалал төдий хэмжээгээр нэмэгдэж байв.

1990-1996 онуудад дотоод гадаадын сургууль төгссөн мэргэжлийн боловсон хүчнүүдээс олон офицер янз бүрийн шалтгаанаар халагдсан нь хилийн застав, отрядын даргалах бүрэлдэхүүний тоо, чанарт муугаар нөлөөлжээ. Зөвхөн Баян-Өлгий аймаг дахь Хилийн 0165-р ангиас 48 офицер, ахлагч албаа хаян Казахстан нүүсэн нь хил хамгаалалт, албаны бэлэн байдалд ноцтой хохирол учруулж байжээ.

1997 оны 1-р улирлын байдлаар ХЦ-ийн офицерийн бүрэлдэхүүний 48.6 хувийг дээд, 28.9 хувийг тусгай дунд, 16.2 хувийг бүрэн дунд боловсролтой хүмүүс эзэлж байлаа.

1997 оныг 1990 онтой харьцуулахад офицерийн бүрэлдэхүүнээс дээд боловсролтой хүмүүс 13.4 хувиар, тусгай дунд боловсролтой хүмүүс 3.4 хувиар тус тус буурсан байна[35].

ХЦ-ийн бие бүрэлдэхүүний 23.1 хувь нь ХЦУГ, төвийн үйлчилгээ, хангалтын анги салбарт, 25.3 хувь нь хилийн хорооны төвд байхад дөнгөж 51.6 хувь нь хилийн суман, харуулд үүрэг гүйцэтгэж байгаа нь хилийн цэргийн удирдлага, үйлчилгээ, хангалтын салбарын болон хилийн хорооны төвд ажиллагсдын орон тоо нь жинхэнэ хилээ манаж байгаа бүрэлдэхүүнтэй харьцуулахад нүсэрдсэн болохыг харуулж байлаа.

1997 оны 5-р сарын байдлаар Хилийн 31-р хорооны бие бүрэлдэхүүний хангалт 78 хувьтай, үүнээс офицер 84 хувь, ахлагч 50 хувь, ХЦАА 82 хувьтай байсан бөгөөд хилийн заставуудын офицерийн хангалт 90 хувь, ахлагчийнх 73 хувь, хугацаат цэргийн хангалт 30 хувьтай байсан байна. Мөн офицер бүрэлдэхүүний 59 хувь дээд, 16 хувь дунд, 13 хувь нь курс төгсөгчид байгаа бөгөөд 12 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байжээ. Мөн отрядын ахлагч нарын 2.1 хувь нь дээд, 6.5 хувь нь тусгай дунд, 44.5 хувь нь бүрэн дунд болон боловсролгүй хүмүүс эзэлж байжээ. Тэдгээрээс зөвхөн 23.9 хувь нь ахлагчийн курс төгссөн байлаа[36].

Нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс улсын хилээ эргэн тойронд нь бүрэн хамгаалах асуудал хүн хүч, хөрөнгө төсвийн хязгаарлагдмал нөхцөлд явагдах болсон. Мэргэжлийн боловсон хүчнээ дотоотод бэлтгэх болон ахлагч бүрэлдэхүүнээс офицерийг давтан бэлтгэх курсээр бэлтгэх болов. АИХ-ын депутатаар 5 ангийн захиаргч сонгогдож, 1992 онд шинэ үндсэн хуулийг батлалцсан ба ХЦ-ийн штабын дарга хурандаа Д.Базарсад хилчдээс анх удаа Их Хурлын гишүүнээр сонгогдсон онцлогтой үе байсан.

Засгийн газар 1991 оны 5 дугаар сарын 3-нд "Улсын хил хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 141 дүгээр тогтоол гарган, мэргэжлийн цэргийн хамгаалалтад шилжих, гэрээт цэргийн албыг бий болгон, хил хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулж эхэлсэн. Мөн

[35] Монгол улсын уламжлалт хил хамгаалалт ба орчин үе. УБ., 1998 он. 60 дахь тал.

[36] Монгол Улсын уламжлалт хил хамгаалалт ба орчин үе. УБ., 1998. 40-41 дэх тал.

алба бэлтгэл сургуулийн хөтөлбөрт өөрчлөлт оруулан албаны бэлтгэлийг цөөрүүлж, Монгол улсын түүх, монгол бичиг, морь тэмээний бэлтгэл, иргэний хамгаалалтын хичээлийг түлхүү судлах болсон. Монгол Улсын хилийн тухай хууль шинэчлэгдэн батлагдав. 1990-1994 онд Цагдаагийн дээд сургуулийн Хилийн тэнхим болсон ба 1991 онд 39 (команд 24, улс төр 15), 1992 онд 43 (ШНА13, команд 15, улс төр15), 1993 онд 24 (команд 12, улс төр 12) 1994 онд 25 хүн, нийт 131 офицерыг бэлтгэжээ.

Цэргийн их сургуулийн хилийн факультет 1994-1996 онуудад 1995 онд 30 (команд 15, улс төр 15), 1996 онд 23 бүгд 53 офицерыг, 1995 онд офицерын дамжаагаар заставын орлогчоор 37 хүнийг сургаж төгсгөжээ.

Цэргийн их сургуулийн харьяа Хилийн цэргийн дээд сургууль 1996-2001 онуудад 1997 онд 24, 1998 онд 44, 1999 онд 56, 2000 онд 59, 2001 онд 130, бүгд 478 офицер боловсон хүчинг бэлтгэжээ[37].

1990-2000 он бол ХХБ-ын хүний нөөцөд тооны төдийгүй чанарын хувьд ихэд хохирол учирсан, мэргэжилтэй боловсон хүчний нөөц, хангалтыг дахин бий болгоход ихээхэн хүчин чармайлт, цаг хугацаа шаардсан он жилүүд байлаа гэж дүгнэж байна.

Монгол Улсын хил хамгаалалтыг хүн хүчний хувьд бэхжүүлэх, томилох, шагнаж урамшуулах зэрэг боловсон хүчинтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийг 1990-2005 онуудад 14-ийг тус тус гаргаж байжээ[38].

2000 оноос өнөө үе хүртлэх Хил Хамгаалах Байгууллага. ХЗДХЯ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж, Засгийн газрын тохируулагч агентлаг-ХЦУГ, ХХЕГ нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Энэ үед ХХБ-ын хүний нөөцөд гарсан онцлог үйл явдал бол "Гэрээт хилчин"-ий албыг зохион байгуулсан явдал юм.

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичгийн 2 дугаар бүлгийн 2.11-т заасан "Улсын ХХБ-ын албан хаагчдыг мэргэшүүлэх" заалтын дагуу ХХБ өөрийн үүрэг, зориулалт, үйл ажиллагааны онцлогоос хамаарч 2007 оноос эхлэн 2 отрядын 17 заставыг иж бүрнээр, 18 отрядын 21 застав, 2 тусгай томилгоот бүлэг буюу нийт 40 заставт "Гэрээт хилчин"-ий албыг зохион байгуулжээ.

Харуулын дарга, холбоочин, жолооч, сантехникч, малчин гэрээт цэргийн орон тон дээр 575 гэрээт хилчид үүрэг гүйцэтгэж байгаа ба энэ тоо улам бүр нэмэгдэж, сонгон шалгаруулалт, сургалт бэлтгэл, алба хаах нөхцөл, гэрээний үр дүнг тооцох, шагнах, урамшуулах, шийтгэх халах, дэвшүүлэх гээд хүний нөөцийн бүхий л үйл ажиллагаа улам бүр төгөлдөржин боловсронгуй болжээ.

Хил Хамгаалах Байгууллагын мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчин офицер, ахлагч нар 2005 оноос Олон улсын энхийг сахиулах, дэмжих ажиллагаанд Ирак, Серрьа-Леон, Афганистан, Чад, Өмнөд болон Хойд Судан зэрэг 6 оронд 94 офицер,

[37] Хүүжий Г., Аюулгүй Г. ХХБ-ын хүний нөөцийн хөгжлийн түүхэн товчоон. УБ., 2016. 94 дэх тал.

[38] Лувсанбалдан Э. Монгол Улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. 1969-1973 он. I дэвтэр. УБ., 1995. 1 дэх тал, 1974-1977 он. II дэвтэр. УБ., 1996. 1 дэх тал, 1978-2002 он. III дэвтэр. УБ., 1997. 1 дэх тал.

74 ахлагч, нийт 323 хилчин үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн. Хилчид Олон улсын энхийг сахиулах, дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэснээр мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүй, гадаад хэлний мэдлэг дээшилж, улмаар улсын хил хамгаалалт, хүний нөөцийн чадавхид эерэг ахиц гаргасаар ирсэн.

Хилчдэд англи хэлний мэдлэгийг шат дараатайгаар олгох үүднээс ХХЕГ-т 2005 онд гадаад хэлний танхимийг байгуулсан бөгөөд анхан шатны сургалтаар 150, дунд шатны сургалтаар 300 гаруй албан хаагч сертификат авчээ. ХХЕГ-ын даргын 2015-4-8-ны өдрийн Б/277 тоот тушаалаар англи хэлний 22 багшийг хилийн анги, отрядод томилон ажиллуулж, тодорхой үр дүнд хүрчээ.

Хилийн цэргийн дээд сургууль 2001-2019 онуудад төрөл мэргэжлийн 2816 хилийн цэргийн офицер боловсон хүчин бэлтгэжээ. Ийнхүү 1934-2019 онуудад дотооддоо нийт 3900 орчим офицер, боловсон хүчин бэлтгэн, ХХБ-ын отряд, анги, салбаруудыг боловсон хүчнээр хангасан байна.

ХХБ-ын хүний нөөцийг шатлан сургах, гадаадын цэргийн академийн боловсролтой болгоход анхаарч гадаад болон дотоодын академиудаар удирдах түвшний офицеруудыг эрчимтэй бэлтгэж эхэлсэн ба 1979-аад оноос өнөөг хүртэл ЗХУ-ын Жанжин шабын академид 4, Фрунзийн нэрэмжит ерөнхий цэргийн академид 36, Ленины нэрэмжит цэрэг улс төрийн академид 22, Ар талын академид 22, Цэргийн холбооны академид 12, Цэргийн инженерийн академид 5, Хуягт танкийн академид 5, Цэргийн химийн академид 3, Цэргийн нисэх хүчний академид 3, Цэргийн хөгжмийн академид 1 хүн тус тус суралцаж төгссөн.

ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын академийг 1997-2018 онуудад нийт 97 хүн төгссөний 21 нь 3 жилээр бүрэн курс, бусад нь 10 сараар суралцсан байна. ОХУ-ын Хабаровск, Курган, Калининград хотуудад 2001 оноос өнөөг хүртэл 135 хүн хуульч-хилийн албаны ажилтан, радио техникийн инженер мэргэжлээр суралцан төгсөөд байна.

ХХБ нь 2000-2019 онуудад АНУ, Их Британи, ОХУ, Хятад, Энэтхэг, Итали, Таджикстан, Герман, Сингапур, АБНЕУ, Франц, Малйаз, БНСУ, Турк зэрэг 20 гаруй оронд бие бүрэлдэхүүнээ мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт, гадаад хэл болон нарийн мэргэжлээр 2000 гаруй албан хаагчдыг сурган дадлагажуулсан байна.

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БОЛОН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТҮҮХИЙГ БАЯЖУУЛЬЯ

Доктор, профессор Цагааны Ганболд
Ахлах судлаач, Дэд хурандаа М.Ганбаатар.
ДХИС. Нэгдсэн хүрээлэн. Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэн

Саяхан Сэлэнгэ аймгийн нутагт орших домогт Буур хээрийн талд, Буур голын эхэнд МУ-ын хилийн болон хил хамгаалалтын түүхийг баяжуулсан томоохон үйл явдал болсныг мэдээлж байгаадаа, тэр үйл явдлын гэрч, оролцогч, санаачлагч болсондоо баяртай байна.

Буур хээрийн тал, Буур голын хөндий Монгол Улсын хувь заяаны түүхийн хүрдийг эргүүлсэн олон томоохон үйл явдлууд өрнөж байсан домог түүхт, ариун дагшин газар билээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод оршин суугч Ө.Бавуу, "Хил судлал" сэтгүүлийн эрхлэгч, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа М.Ганбаатар, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод байрлах ХЦ-ийн...дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөмөр, захирагчийн орлогч, дэд хурандаа Г.Мягмардорж, дэд хурандаа Б.Баянмөнх бид 1727 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Хаант Орос-Манж Чин гүрний хооронд улсын хил тогтоосон гэрээг байгуулж батламжилсан Буур голын эхэнд орших, Хиагт хотоос 12 км-т орших эртний **Буур хилийн харуул** байрлаж байсан газрыг олж тогтоов.

Уг түүхэн газруудыг олж тогтохдоо гадаад , дотоодын орос, монгол, манж, хятад хэл дээрх түүхэн эх сурвалжууд, тэдгээрт тэмдэглэгдэн үлдсэн газар орны болон тоон өгөгдөхүүн, Манжийн үеийн болон өнөөгийн байр зүйн зураг ашиглан холболт хийх, газар оронд үзлэг хийх, байр зүйн болон хээрийн хэмжилт хийх, хилийн газар зүй,түүхэн газар зүйн судалгааны түгээмэл аргууд, орон нутгийн иргэдийн дунд үе дамжин, ам дамжин яригдаж үлдсэн домог, хууч яриа, түүхэн үйл явдлуудыг улируулан, мөшгин судлах зэрэг аргуудыг ашигласан болно.

(1 версть 1050 м-тэй тэнцдэг). Манай өвөг дээдэс газар орны хэмжээг маш өндөр нарийвчлалтай бараг метрийн зөрүүгүй тогтоож байсан нь үнэхээр гайхал төрүүлж байлаа.

Буурын хилийн харуулын байр нь 1932 он хүртэл хадгалагдаж байсан ба тэр орчимд Алтанбулаг сумын "Хөдөлмөр" нэгдлийн бригадын төв, ЗХУ-ын Скот импортын мал бааз, контор байсан ба 1973 онд татан буугдаж, барилга байшинг нь Алтанбулаг, Шаамар сум, аймгийн төв рүү зөөвөрлөн авчээ.

Эх сурвалжуудад: Гэрээг 1727 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Хиагтаас 8 версть газар орших Буур голын хөвөөн дээр байгуулснаар түүхэнд Буурын гэрээ гэж нэрлэгдэх болсон.

Энэ гэрээгээр Оросын өмнөд хил Хиагтаас Енисей мөрний эх хүрэн, баруунаас цаашлан Горбицы гол хүртэл

тогтоогдов[39].

"Хөрш Монгол Улсад Хиагтаас 8 верст газарт Буурын гол гэж нэрлэгдэх ихээхэн талбайг эзэлсэн намаг байх бөгөөд намгийн баялаг ан, шувуугаараа Хиагтын анчдын хорхойг хөдөлгөхийн зэрэгцээ 1700-аад оны эхээр Манжтай "Буринский трактат" хэмээх хилийн гэрээг энд байгуулсан түүхээрээ алдаршсан"[40] гэжээ.

Өөр эх сурвалжид: "Хиагтаас 20 верст газар орших Буур голын эхэнд.."[41]." гэж дурьдсан байдаг.

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоох ажиллагаа 1727 оны 4-р сарын 12-ны өдөр Халхын Түшээт хан аймгийн Цэрэнжав гүний хошууны нутаг Буур голын эх Буур харуулын нутаг дээр эхэлжээ. Энэ ажиллагаанд Хаант Орос улсыг төлөөлөх бүрэн эрхтэй комиссыг Сава Владислав Рагузинский гүн тэргүүлж, түүний нарийн бичгийн дарга Глазунов, Илийский, хязгаарын цэргийн комиссар Иван, Глобунов нар болон Халхаас Оросын нутагт цагаачилж суурьшсан Харгана отгийн зайсан Олборын Даш, отгийн засуул Болтрого нар, Манж чин улсын талаас томилогдсон бүрэн эрхт комиссыг ван Цэрэн эфү тэргүүлж, Манж чин улсаас Халхад суугаа амбан сайд Амба сэгэ, түшмэл Түлишээк, манжийн дэд зэргийн хиа Хувьт, Гадаад монголын төрийг засах яамны түшмэл хаван Наянтай, түшмэл Нямдолцон нар оролцжээ. Талуудын комисс нь бүрэн бүрэлдэхүүнээрээ 1727 оны 4-р сарын 22-ны өдөр Бүрхэтэй уулын баруун өмнөд этгээдээс 7 км зайтай орших Ноёны уулын оройд гарцгаан, нэгэн овоог чулуугаар босгож дор бүрнээ олбог дэвсэн сууцгааж, Голын овоо хэмээн нэрлээд, ёслол үйлдсэний дараа Буур харуулын байранд ирж хэлэлцээр эхэлжээ. "Буурын гэрээ"-гээр 2 тал хүлээсэн үүргийхээ эхний хэсгийн ажлыг Голын овооноос баруун, зүүн чиглэлд нэгэн зэрэг эхэлж, мөн оны 8-р сарын 21-ний өдөр хүртэл 152 хоногийн турш гүйцэтгэжээ. Тэд тус бүрийн хийсэн ажлын тайлан, тэмдэглэлүүдээ мөн оны 10-р сарын 21-ийг хүртэл нэгтгэн боловсруулж 10-р сарын 22-ны өдөр Шавинайн даваан дээр уулзан, тус тусын материалаа солилцож, хил тогтоох ажиллагаа өндөрлөсний билэгдэл болгон чулуун овоо босгожээ.

Энэхүү материалаас үзэхэд нарийвчлан тогтоосон хилийн зурвасын дагуу 58 хос овоог чулуугаар босгож, тэдгээрийн газар зүйн байршлын цэгүүдийг монголын уламжлалт 24 зүг чигээр, овоо хоорондын зайг газар, алхам, тохой, төө гэх мэт монгол хэмжүүрийн нэгжээр илэрхийлжээ.

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоосон өдөр бүрийн тэмдэглэл, бусад баримт бичгийг 2 талаас солилцсон тухай протоколд Манж чин улсын талыг төлөөлж ван Цэрэн Эфү, Хаант Орос улсын талыг төлөөлж Сава

[39] Русско-Китайские договорно-правовые акты (1689-1916) Сост. И.Т.Морозов, В.С.Мясников. М., 2004. С.30-32.

[40] Г.М.Осокин. На границе Монголии. Очерки и материалы к этнографии юго-западного Забайкалья.1906. С.16.

[41] Сычевский Е.И. Историческая записка о китайской границе, составленная советником Троицко-Савского пограничного правления Сычевским в 1846 году / сообщ. В. Н. Баснин изд. О-во истории и древностей рос. при Моск. ун-те. - Москва: В Универ. тип., 1875. С.18.

Владислав Рагузинсзий гүн нар гарын үсэг зуржээ[42].



Буур хилийн харуулын туурин дээр (Баруун талаас ХЦ-ийн дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөмөр, доктор , профессор Ө.Бавуу, Ц.Ганболд нар)



Буур харуулын туурин дээр байгаа өвөрмөц чулуунууд

Төгсгөө булаг: (Мааньт чулууны хөтөл) Алтанбулаг сумын төвөөс 5-6 км зайд Сэлэмт хөшөө байдаг. Хөшөө босгосон өндөрлөгийг Мааньт чулууны хөтөл гэж нэрлэдэг ба түүний баруун урд талд элсэн довцогоос эх авсан булгийг Төгсгөө булаг гэдэг.

Төгсгөө булаг бол эртний уламжлалт хилийн ууулзалт хийж байсан газар байх бөгөөд энд хоёр талаас уулзан майхан, палаткаа барин, хивс, ширдгээ дэвсэж, идээ будаагаа дэлгэн Төгсгөөгийн хэрэг шийдвэрлэдэг байжээ[43]. (**Төгсгөөгийн хэрэг гэж улс, аймаг, хошууд хооронд ард иргэн дутаан одсон, автсан зэрэг албат харьяатын маргаантай хэрэг шийдэхийг Манжийн үед нэрлэдэг байсан).**



Төгсгөө булаг



Төгсгөө булгийн баруун талд орших зүлэг бүхий хэсэгхэн тэгш энэ газар бол бидний өвөг дээдэс, харуул зангиуд хилийн уулзалтаа хийж байсан газар болой.

Дундын буюу голын овоог доктор Б.Цэдэн-Иш, хурандаа Г.Хүүжий нарын тодорхойлон үлдээсэн сурвалж дагуу олж, ахмад хилчдийн залгамж болсон залуу үедээ зааж үлдээсэнд гол ач холбогдол оршино.

Дундын овоо нь Алтанбулаг суурин болон Хиагтын голын баруун талд, Эрээн хамар өндөрлөгийн оройн үл ялих нахиу дээр улсын хилийн шугам, монголын хилийн торон саад хоёрын хооронд шороо овоолж босгосон ганц овоо байна. Овооны өндөр нь 1м, сууриараа өргөн нь 3 м орчим, гадна талаараа хээрийн өвс ургаж хөрсжсөн, ойрхон очихгүй бол газрын гадаргуугаас онц их ялгагдахгүй болсон байлаа.Овооны баруун талаар элсэрхэг хөрстэй жалга хойноос урагш уруудсан тогтоцтой, хойд талд 200 м хэтрэхгүй зайд Монгол-Оросын 650 дугаар тэмдэг, Оросын манааны газар дээр ил

[42] Ө.Бавуу. Буурын гэрээ, түүний үр дагавар. Сүхбаатар хот. 2018 он

[43] Б.Цэдэн-Иш. Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхээс. УБ. 2011 он.

барьсан байр харагдана. Зүүн талаар нь Хиагтын голын баруун эрэг буюу Эрээн хамрын зүүн хажуугийн эгц ташуу хүр байна.Зүүн өмнө талд 500 м орчимд хуучин Дөрвөлжин сүмийн суурин дээр босгосон дурсгалын самбар байна.

Дундын овооны байршил нь 1727 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Эргүнэ мөрний Авгайт уулнаа Манж-Оросын хооронд солилцсон солилцох бичиг, хилийн овоо тэмдгийн данс бүртгэлд тэмдэглэсэнтэй газар орны шинж байдлын хувьд тохирч байна[44].

Ухаант ахмад үе минь бидэндээ хилийн түүхийн ямар их мэдлэг, мэдээлэл, өв үлдээгээ бэ?. Уг овоог босгоод 300 орчим жил болж байгаа, дан шороогоор босгосон учраас цагийн эрхээр атаршин мэдэхгүй хүнд бол жижигхэн ногоон довцог /Бугор/ болсон байна. Хашиж хамгаалах, тайлбар самбар зэргийг хийх зайлшгүй шаардлагатай.

Нутгийн хүмүүс, манай нөхдүүд дундын буюу голын овоог Оргойт харуулын зүүн талд орших өндөрлөг дээр босгосон овоо гэж андуурдаг бололтой.



Түүхт Дундын овоон дээр



Одоогийн Номтын хилийн заставын харуцсан хэсэгт хилийн 645 дугаар баганын хажууд орших 1727 онд босгосон хилийн түүхт хос овоо (Оросын талд нэг нь байгаа бөгөөд 297 жилийн өмнө босгосон яг тэр хэвээрээ хадгалагдан үлджээ).

Монгол Улсын хилийн түүхт эдгээр газруудыг хамгаалалтад авч хөшөө, дурсгалын самбар босгон тохижуулах, мөнхжүүлэх, сурталчилах, аялал жуулчлалын замналд оруулах нь түүхийн, танин мэдэхүйн, хамгаалж буй хязгаар нутгаараа бахархах, эх оронч, хилч үзлийг төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Сэлэнгэ аймагт байрлах хилийн ангийн захиарагч, хурандаа Б.Гантөмөр, В.Намхайнямбуу нар аймгийн удирдлагатай хамтран ажиллаж, түүхэн газарт бүтээн байгуулалтын ажил хийхээ илэрхийлж, бүхий л бололцоогоор тусалж, хамтран ажилласанд талархалаа.

Хилчин бидний саналыг хүлээн авч дэмжин, хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харамгүй хуваалцсан Ө.Бавуу гуайд урт удаан наслахын, бүтээл туурвилын өндөр амжилт хүсч байгаагаа энэ ялдамд дахин илэрхийлье.

Эдгээр түүхэн газруудыг тогтоох асуудлыг яаравчлан зүтгэсний учир нь Буур голын эх, Буур хээрийн

[44] Г.Хүүжий. Монгол Улсын хилийн түүхэнд холбогдох зарим асуудлууд. УБ., 2003 он. х-153-154

талд иргэдэд газар олгох шийдвэр гарсан байгаагаас үүдэлтэй. Энэ орчим хувийн өмчлөлд орчихвол хүндрэлтэй асуудал үүсэх боломжтой юм. Нэг айлын хашаанд ороод, ОО барьчихвий, чулуунуудыг нь зөөгөөд гэр даруулчих юм уу, малын хашаандаа нэмэрлэчихвий, хонжоо харж жоорлочихоод үнэ хаяад гүрийчих вий яанаа гэдгээс үнэнхүү айнам.

Хүдэрийн хилийн заставаар орохдоо, тэдний хариуцсан хэсэгт орших Дорнодын Чулуунхороотод байх "Чингисийн далан-Чингис вал"-тай адил Хишигтийн тохойгоос 22 гаруй км урт үргэлжилж, 7 км гаруй тасарч цааш 10 км орчим үргэлжилж, Эмээлтийн уулын шилээр давж Хэнтийн нуруу чиглэсэн адил нэртэй "Чингисийн далан" байдгийг болон Хүдэрийн хилийн 8 дугаар, Уялгын хилийн 9 дүгээр түүхэн овоодын байрлалыг очиж үзээгүй учраас өөрийн уншиж мэдсэний хэмжээнд зааж өгч, олохыг, очиж үзэхийг хүсэв. Мөн Хүдэр сумаас баруун хойш 5-6 км-т орших Хүдэр харуулын занги асан Цэрэнбалжир /нутгийнхан Балжир галдаа гэдэг/ галдаагийн өвөлжөөг зааж өгөв.

Буриад зоны шүтээн Хөхтэй хан хайрхан өнөөгийн Уялга харуулын ойролцоо хилийн цаана Цөх голын эрэгт орших бөгөөд орой нь хавтгай тэгш овооны наадам хийж, морь уралдуулж, бөх барилдуулдаг байсан хэдий ч өнөө атаршин мод ургасан байдаг. Энд хилийн овоо байсан талаар Цэдэн-Иш генерал над хэлсэн гэж Ө.Бавуу гуай ярьсан бөгөөд тахилгын овоо юу, хилийн овоо юу гэдгийг нягтлахсан гэж шунал хөдөлнө. Заставын даргаас эдгээрийн учир холбогдлыг нутгийн иргэдээс тодруулахыг хүслээ.

Энэ мэтээр хилчин бид хамгаалж буй хязгаар нутгийнхаа түүхийг дараагийн хүмүүстээ уламжлуулан хэлдэггүй, зааж өгдөггүйгээс цагийн эрхээр бүдгэрч, баларч байна.

Сулинхээрийн хязгаарт явж байхад ангийн удирдлага, хамт олон Чөлөөлөх дайны ялалтад зориулж, тус ангиас Э.Халтар, Ядмаа нарын удирдсан группын Улаанцав аймаг, Бат хаалгыг чөлөөлөхөөр хил давсан болон буцаж орж ирсэн газарт дурсгалын хөшөө, самбар босгосныг сонсоод баярлав.

Энэ мэт эх оронч, хилч үүсгэл санаачлагыг бодлогоор, санхүү, хөрөнгөөр дэмжих нь зүйтэй.

- Хилээр явж байхад хилийн түүхэн газар усны нэрийг өөрчилсөн, бүдэгрүүлсэн, сэтгэл эмзэглүүлсэн тохиолдлууд тааралдах юм аа. Уламжлалт газар орны нэрийг хадгалахад анхаармаар санагдана.

Тухайлбал: Хангийн ШНБ анх байгуулахдаа "Баянбулаг" ШНБ гэж нэрлэж байсан. Хангийн заставтай андуурагдах болж газар зүйн мэдээллийн болон авто замын сүлжээнд тусгагдаагүй байна. Сыргалийн застав-Ээмэгтийн застав юм л даа. Тэнд казах нэртэй, нэршилтэй нэг ч газар байгаагүй, байх ч ёсгүй юм.

Увс аймгийн Давст сумын нутагт орших Торхилог хилийн голыг зарим зурагт Тохилогын гол, Торголык гол хэмээн орос байдлаар болон огт буруу нэрлэж тэмдэглэсэн байх жишээтэй.

Түүхэн сурвалжийг эргэн харахад, эрдэмт өвгөдийн тод төлөөлөл Ө.Бавуу гуай нартай ярилцахад их л зүйлийн

учиг тайлагдах юм. Номтын застав гэхэд л Нумт булгийн эхэнд нэгэн том нумыг тахиж байснаас "Нумт" гэж нэрлэж байсан, мөн Алтанбулагийн зүүн хойт талын уулыг бид Бүргэдэй гэж нэрлээд заншчихсан болохоос уг нь "Бүрхэтэй уул" байх жишээтэй. Уйгаржин монголоос кириллд буулгахдаа алдаа гаргасан бололтой.

Бүрхэтэй уулын өвөрт Гурван мэргэдийн Удуйд мэргэн захирагч төвлөрөн нутаглаж байсан түүхтэй гэж Ө.Бавуу гуай хууч өрнүүлсэн билээ.

Хил, хилчдийг, хилийн байгаль, байдлыг сурталчилсан "Би, бид байхын учир", " Эх түүхийн жимээр", "хурандаа В.Дамдинсүрэнгийн явган аялал", "Морьт залуусын аялал", хурандаа Баасанжаргалын хийсэн олон сайхан аяллын нэвтрүүлэг бий.

Гэхдээ л улсын хилээ, хилийн болон хил хамгаалалтын түүх талаас нь, хил хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулах онол, практик талаас нь судлах, сурталчлах хээрийн шинжилгээний экспедици хэлбэрээр хилийн судалгааны бүлэг явуулаасай гэж мөрөөддөг юм. Уг нь Монгол-Оросын хил хамтран шалгах ажлын өмнө явуулбал ихээхэн үр дүн, ач холбогдолтой болох юм.

Газар зүйн шинжлэх ухааны салбар шинжлэх ухаан болсон түүхэн газар зүй, хилийн газар зүйн ухааныг хөгжүүлэх шаардлага нэгэнт бий болжээ.

Хилчид бид Монгол орны хамгийн үзэсгэлэн төгөлдөр, түүхэн үйл явдал өрнөж байсан газруудад алба хааж, хамгаалж байдгаас хилийн аялал жуулчлалын маршрутыг бий болгомоор байна.

Тухайлбал, Сэлэнгийн хилийн ангид ирсэн хүмүүс хилийн харуулын дэргэдэх Сайханы хөтөл-Ханын хөндий-Номтын түүхэн овоо-Буур харуулын туурь-Төгсгөө булаг-Хулан хатны хөшөө-Мэргэдтэй хийсэн тулааны самбар-Сэлэмт хөшөө-Дөрвөлжин сүмийн туурь-Дундын овоо -Алтанбулаг (Хувьсгалын музей, Булигаарын заводын туурь, Оросын консулын байшин, монголын анхны банк, бага сургуулийн барилга гэх мэт) гэсэн замналаар явбал мөн сайхан аа гээд хилийн анги болгоны хариуцсан хэсэгт энэ мэтээр аялал, эх орноо, хил хязгаараа танин мэдэхүйн замнал зохиолгож болох юм.

"БУУРЫН ГЭРЭЭ" ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Чорос Өөлдийн Бавуу
Түүхийн ухааны доктор, профессор
ОХБНБурУ-ын Соёлын Гавъяат ажилтан,
Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудын Хүндэт иргэн,
Сэлэнгэ судлал ТББ-ын судалгааны багийн ахлагч

Нэг. Гэрээнд холбогдох зарим газрын нэр, тэдгээрийн товч танилцуулга

"Буур" гэдэг нь шаазан хийх зориулалттай наанги шавар, олон зуун хүнд хоол хийх боломжтой том тогоо, хээлтүүлэгч тэмээ гэсэн гурван утгыг илэрхийлнэ гэж Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд тодорхойлжээ. Тэгэхээр энэ гурван тайлалын нэгнээс ***"Буур"*** гэдэг үг үүссэн гэж болов уу гэж ойлгож байна. Гэхдээ тэмээн сүргийн үндсэн тэжээл болох харгана, халгай, давс хужир зэрэг хөрсний нөмрөгийн зохистой бүтэц бүхий, билчээр Буур голын хөндийд байхгүй учраас ***"Буур"*** хэмээх нэршлийн тэмээ лүгээ холбогдох утга нь тус газрын нэршлийн гарал үүсэлд үл хамаарна гэж үзэв.

Харин улаан шаргал, цайвар шар, улаан, хүрэн өнгийн наанги шавар Буур голын хөндийд өргөн тархацтай байдаг. Энэ шавраар хийсэн гоёмсог загвартай ваар, дийз, аяга, таваг, дээврийн хучилт, тоосго зэрэг эртний хийцтэй эд өлгийн, чулуун болон хүрэл зэвсгийн үлдэгдэл, тэр үеийн хүмүүсийн сууц, оромжийн тууриуд ч элбэг бий.

Аян замын хүмүүст хол цайгаар үйлчилж, хоноглуулах Дэн буудал буюу Буурчийн газар, Буур голын эх, Халзан бүрхэтэй уулын өвөр орчимд нилээд эртнээс байсан түүхэн мөр улбаа цөөнгүй бий.

Буур голын хөндий бол Мэргид аймгуудын холбооны унаган нутаг болохыг гэрчлэх түүхэн баримтууд бий. Ж нь: "Мэргэд аймгуудын холбооны тэргүүн Тогтоа бэхийг "Дайд бурын талд дализалзан суугаа буй за..." гэж МНТ-ны 104-р зүйлд тэмдэглэжээ.

Дайд гэдэг нь дэлхий, өргөн уудам орон зай гэсэн утгатай эртний монгол үг гэж мөн толь бичигт тодорхойлжээ.

Эдгээрээс үзэхэд Буур голын хөндийд Мэргид аймгуудын холбооны төв хэсэг байсан учраас түм түжигнэж, бум бужигнасан олны их хөлийн газар байсан учраас Буурчийн газар гэдэг нэршилтэй холбоотой болов уу хэмээн үзэх нь үнэнд ойртоно гэж үзэв.

Буур голын хөндий нь 1206 оноос Чингис хааны өрлөг жанжин Сорхон шарын эзэмшил нутаг болж, дараа нь Даян хаан Батмөнхийн Жимсгэнэ хатнаас төрсөн Гэрсэнз жалайр хунтайжийн хүү Онорүй үйзэний эзэмшил нутаг болжээ. Үүнээс хойш 4 үеийн дараа болсон Ойрадын довтолгооноос зугатсан халхчууд Манж чин улсад дагаар орсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчилсэн хуваариар 1691-1911 он хүртэл Халхын Түшээт хан аймгийн Умард замын дунд зүүн гарын адгийн хошуу (хуучнаар Халхын Түшээт хан аймгийн Цэрэнжав гүний хошуу)-ны нутагт харъяалагджээ. Дараа 1911-1915 он хүртэл Богд Хаант Монгол улсын

Түшээт хан аймгийн Эрдэнэ засаг хошой чин ван Намсрайн хошууны, 1915-1919 онд Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засаг хошой чин ван Намсрайн хошууны, 1919-1921 онд Дундад иргэн улсын /ДИУ/ Эрдэнэ засаг хошой чин ван Намсрайн хошууны, 1921 оноос АТЗГ-ын Алтанбулагийн хязгаарыг товхинуулах яамны, 1924 оноос БНБЭАУ-ын Богд хан уулын аймаг дахь Алтанбулагийн яамны, 1931 оноос БНМАУ-ын Газар тариалангийн аймгийн, 1932 оноос Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хотын нутагт тус тус харъяалагдах болжээ.

Тус хошууны сүүлчийн Засаг ноён Намсрай нь Чингис хааны 26 дахь үеийн ясан төрлийн ач бөгөөд Богд Хаант Монгол улсын Шүүн таслах яамны анхны сайд байжээ.

Монгол Улсын Сэлэнгэ аймгийн үндсэн харъяат нарын дотор Чингис хааны алтан ургийн ясан төрийн хойч үеийнхний гэрт төрж өссөн 2 хүн байдгийн нэгэн нь эдүгээх УИХ-ын гишүүн Наваан-юндэнгийн Оюундарь, нөгөөх нь 8-р Богдын хадам Хөвчийн жонон ван Цогбадрахын ач хүү Шийтэрийн Отгонбаяр нар юм. Эдгээр хүмүүст Сэлэнгэ түмэн гүн хүндэтгэлтэй ханддаг билээ.

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоох хэлэлцээр хийсэн Буур харуул, МНТ-нд тэмдэглэсэн Дайд буур нь одоогийн Монгол улсын Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт буй Буурын хөдөө мөн. МНТ зохиогдсоны 750 жилийн ойг тохиолдуулан МЗЭ-ийн шагналт Н.Сүхдорж, Т.Доржсүрэн, Дүрслэх урлагийн салбарын эрхлэгч Норовригчен, Түүхч И.Цоодол нарын зэрэг уран бүтээлчдийн санаачлагаар Дурсгалын гэрэлт хөшөө босгосон юм.

Орос-Манжийн хилийн анхны хэлэлцээр хийсэн Буур харуул хэмээх газар бол үе үеийн Монголчуудын үндэсний ашүүлгүй байдлыг хангахад чухал ач холбогдол бүхий стратегийн түшиц газруудын нэгэн нь бөгөөд Монголын түүхэнд гарсан өөрчлөлт шинэчлэлтүүдийн мөр, улбааг дархалсан түүхт нутаг мөн.

Хоёр. Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоох зайлшгүй шаардлага

Манж Чин улсын бүрэлдэхүүнд орхоос татгалзсан халхчуудын зарим нь Орос улсын нутгийн гүнд хэсэг хугацаанд цагаачлан нутаглах болжээ. Энэ үед "Буурын гэрээ"-г хүчин төгөлдөр болох хүртэл Халх-Оросын хилийг нарийвчлан тогтоогоогүй байв. Иймд Халхын нутгийн хойт хязгаарт нутаглагч ард иргэд, ялангуяа Цэрэнжав гүний хошууныхан нь одоогийн Монгол-Оросын хилийн зурвасын ойролцоох орон зайн хүрээнд ус билчээрээ сонгон нүүдэллэхэд нарийн хяналтгүй шахам байжээ. Иймд Халхчуудыг Манж Чин улсад дагаар орсны дараа Халхаас Орос руу дайжин нүүж цагаачлах хөдөлгөөн эрс идэвхижсээр 1727 оны байдлаар Халхын 2000-аад өрхийн 17353 хүн нутгийн гүнд цагаачлан нутаглаж байжээ. Энэ тоо цаашид ч нэмэгдэх төлөвтэй байв. Үүнд Манжийн эрх баригчид дургүйцэж, Халхаас нүүж очсон иргэдийг орон нутагт нь даруй буцаахыг шаардсан албан бичгийг Оросын эзэн хаанд хүргүүлжээ. Гэвч

Оросын тал түүнийг нь эс ойшоон, харин ч халхын цагаачдыг саадгүй хүлээн аваад Сэлэнгэ, Хилга, Цөх голуудын адаг орчимд нутаглахыг зөвшөөрдөг болжээ.

Өмнөх шаардлагаа 2 дахь удаагаа илэрхийлсэн албан бичгийг Манжийн хаанаас Орос улсын хаанд хүргүүлжээ. Манжийн хаанаас тавьсан уг шаардлагыг Оросын тал энэ удаад хүлээн аваад Халхын цагаачдыг нутагтаа буцахыг шаардах тухай албан бичгийг Эрхүүгийн орон нутгийн удирдлагаар дамжуулан тэдэнд хүргүүлжээ. Гэвч энэ шаардлагыг хүлээн авсан халхын цагаачид нь нутагтаа буцахаас татгалзаж, Орос улсад дагаар орохоо илэрхийлэхээр санал нэгдэн Цэрэнжав гүнгийн хошуунаас цагаачилж очсон *"Галзагууд"* овгийн буриад Бадам зайсан тэргүүтэй төлөөлөгчидийг Орос улс руу илгээжээ. Тэд 6000 гаруй км замыг туулан Орос улсын нийслэлд очиж эрх бүхий хүмүүст хүсэлтээ тавьжээ. Тэдний хүсэлтийг Оросын тал хүлээн саадгүй хүлээн аваад, Сэлэнгэ мөрний зүүн этгээд, Хилга, Хүдэр, Уялга зэрэг Манж чин улсын хойт хязгаарын дагуух нутгуудад оршин суухыг зөвшөөрсөн тухайгаа Эрхүүгийн орон нутгийн удирдлагын тэргүүн Юрий Шишковичоор дамжуулан халхын цагаачдад мэдэгджээ.

Ирүүлсэн албан шаардлагуудадыг нь эс ойшоон, халхын цагаачдыг илэрхий өөгшүүлэн дэмжиж байсан тул Санкт-петрбургт очиж Оросын эзэн хаантай биеэр уулзах эрх бүхий төлөөлөгчдийг Манжийн засгийн газраас Орос руу явуулжээ. Манжийн төлөөлөгчдийн шаардлагыг Оросын тал хүлээн аваад, 2 улсын хилийг нарийвчлан тогтоосны дараа Халхын цагаачдыг Орос улсын нутагт оруулахгүй хэмээн амалсан байна.

Орос улсын нутагт цагаачлан сууж буй Халхын цагаачдын тухай асуудлаар 2 тал ийнхүү тохиролцсон боловч халхаас ирэх цагаачдын хөдөлгөөн идэвхтэй үргэлжилж, 2 улсын олон талт харилцааг хүндрүүлж болзошгүй хэмжээнд хүрсэн тул 2 улсын хилийн зурвасыг нарийвчлан тогтоох хойшлуулж болохгүй хэмээн үзэцгээсэн тул 2 улсын гэрээг хийн, хил тогтоох ажилд яаравчлан орцгооожээ.

Гурав. Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоосон нь

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоох ажиллагаа 1727 оны 4-р сарын 12-ны өдөр Халхын Түшээт хан аймгийн Цэрэнжав гүний хошууны нутаг Буур голын эх Буур харуулын нутаг дээр эхэлжээ. Энэ ажиллагаанд Хаант Орос улсыг төлөөлөх бүрэн эрхтэй комиссыг Сава Владислав Рагузинский гүн тэргүүлж, түүний нарийн бичгийн дарга Глазунов, Илийский, хязгаарын цэргийн комиссар Иван, Глобунов нар болон Халхаас Оросын нутагт цагаачилж суурьшсан Харгана отгийн зайсан Олборын Даш, отгийн засуул Болтрого нар, Манж чин улсын талаас томилогдсон бүрэн эрхт комиссыг ван Цэрэн эфү тэргүүлж, Манж чин улсаас Халхад суугаа амбан сайд Амба сэгэ, түшмэл Түлишээк, манжийн дэд зэргийн хиа Хувьт, Гадаад монголын төрийг засах яамны түшмэл хаван Наянтай, түшмэл Нямдолцон нар оролцжээ. Талуудын комисс нь бүрэн

бүрэлдэхүүнээрээ 1727 оны 4-р сарын 22-ны өдөр Бүрхэтэй уулын баруун өмнөд этгээдээс 7 км зайтай орших Ноёны уулын оройд гарцгаан, нэгэн овоог чулуугаар босгож дор бүрнээ олбог дэвсэн сууцгааж, Голын овоо хэмээн нэрлээд, ёслол үйлдсэний дараа Буур харуулын байранд ирж хэлэлцээр эхэлжээ. "Буурын гэрээ"-гээр 2 тал хүлээсэн үүргийхээ эхний хэсгийн ажлыг Голын овооноос баруун, зүүн чиглэлд нэгэн зэрэг эхэлж, мөн оны 8-р сарын 21-ний өдөр хүртэл 152 хоногийн турш гүйцэтгэжээ. Тэд тус бүрийн хийсэн ажлын тайлан, тэмдэглэлүүдээ мөн оны 10-р сарын 21-ийг хүртэл нэгтгэн боловсруулж 10-р сарын 22-ны өдөр Шавинайн даваан дээр уулзан, тус тусын материалаа солилцож, хил тогтоох ажиллагаа өндөрлөсний билэгдэл болгон чулуун овоо босгожээ.

Энэхүү материалаас үзэхэд нарийвчлан тогтоосон хилийн зурвасын дагуу 58 хос овоог чулуугаар босгож, тэдгээрийн газар зүйн байршлын цэгүүдийг монголын уламжлалт 24 зүг чигээр, овоо хоорондын зайг газар, алхам, тохой, төө гэх мэт монгол хэмжүүрийн нэгжээр илэрхийлжээ.

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоосон өдөр бүрийн тэмдэглэл, бусад баримт бичгийг 2 талаас солилцсон тухай протоколд Манж чин улсын талыг төлөөлж ван Цэрэн Эфү, Хаант Орос улсын талыг төлөөлж Сава Владислав Рагүзинсзий гүн нар гарын үсэг зуржээ.

Энэхүү хилийн дагуу тавьсан Минж, Цөх, Хүдэр, Уялга, Ивцэг, Чагтай, Хираан, Буур, Төмөрт, Бооц, Зэлтэр зэрэг гэр болон суурин харуулууд нь одоогийн Монгол Улсын Сэлэнгэ аймгийн нутагт бий. Тэр үед босгосон зарим овоо нь тухайн үеийн ЗСБНБуриад улсын Хиагтын районы Ранжуров хамтралын нутаг Цөх голын хойт эрэг Хөхтэй хан уулын орой дээр байв хэмээн БНМАУ-ын Хязгаарын цэргийн удирдах газрын дарга асан генерал Цэдэн-Ишийн над ярьснаас үзэхэд Орос-Манжийн хилийн газар зүйн байршилыг Оросын тал бага зэрэг өөрчилсөн бололтой байна.

"Буурын гэрээ"-нд заасанаар бол Манжийн хилийн харуулуудыг удирдах төв нь Буур харуул дээр төвлөрөх бөгөөд төвийн дарга 1, түүний туслах ноён 1, мэйрин 2, залан 3, бусад ажилтан 419, бүгд 426 хүний бүрэлдэхүүнтэй байжээ.

Хил тогтоох ажлыг ийнхүү амжилттай гүйцэтгэсэний баярыг Манжийн тал тэмдэглэн Буур голын эх Талын нарсны зүүн бэлд том хэмжээний наадам хийж 512 бөх барилдахад Халхын Түшээт хан аймгийн умард замын зүүн дунд гарын адгийн хошууны бөх Өдэйхүү түрүүлжээ.

Энэхүү гэрээгээр Манжийн умард хил дээр анх босгосон Голын овооноос Авгайт уул хүртэл 15, Голын овооноос Хавтгайтын Шавинайн даваа хүртэл 6 харуул... гэх мэтчилэн 25-35 км дутамд 1 харуул тавьсаар бүгд 86 гэр болон суурин харуул тавьжээ. Эдгээр харуулын 23 нь одоогийн Сэлэнгэ аймгийн нутаг дээр байжээ.

Бусад улс орнуудтай залгаа орших хилээ Манжийн тал нарийвчлан тогтоогоох гэж яаравчлаагүй атлаа Орос-Манжийн хилийн тухай асуудлаар ийнхүү яаравчилсан нь

Халх монголыг бүрэлдэхүүндээ эхний ээлжинд багтаах замаар үндэсний аюулгүй байдлаа хамгаалах томоохон түшиц газартай болж, улмаар Европын зах зээлд дангаараа нэвтрэх хамгийн дөт бөгөөд хямд өртөгтэй замыг түрүүлж эзэгнэх гэсэн Манж Чин улсын стратегийн бодлого байжээ хэмээн үзэв.

Дөрөв. Орос- Манжийн хилийг нарийвчлан тогтоосоны дараах үе

"Буурын гэрээ"-г байгуулж гарын үсэг зурсан өдөртөө Манжийн талын зарим хэсэг нь Орос улсын Хиагт очиж "Орос - Манжийн худалдааны гэрээ" байгуулжээ. Энэ гэрээнд зааснаар бол 2 улсын худалдааны харилцааг улам өргөжүүлэх таатай нөхцлийг аль аль тал нь бүрдүүлж, 200-аас илүүгүй тооны орос худалдаачдыг 3 жилд 1 удаа Бээжин хотод очуулж байхаар тохиролцжээ.

Дараа нь Халх монголд оршин сууж буй манжийн харъяат иргэд, худалдаа арилжаа эрхлэгчид, албан ажлаар 2 улсын хооронд явж байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий 500 цэргээр хамгаалуулсан Заргачийн яам, Наймаачин хотын Халзан бүрхэтэй уулын өвөрт байгуулах шийдвэрийг Манж Чин улсын засгийн газраас олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд тус комиссыг гаргажээ.

Зохион байгуулалтын эдгээр арга хэмжээг шуурхайлан авсаны дараа монгол нутгаас алт олборлох, малын гаралтай түүхий эд, ангийн үс зэргийг худалдан авч хагас боловсруулалт хийгээд Европын зах зээлд экспортлох зорилгоор Манжийн томоохон худалдааны пүүсүүдийн салбар, Булигаарын заводыг Маймаачин хотод, Алтны уурхайг Ерөөд байгуулах зэрэг ажлыг шууд оржээ.

Манж, Оросыг холбосон зам, харилцаа холбоог сайжруулах, худалдаачдын аюулгүй байдлыг хангах зорилгоор харилцаа холбооны салбар 2, Хүрээ Хиагтыг холбосон морин өртөө 11, сайжруулсан зам барих зэрэг томоохон ажлуудыг хийж эхэлжээ.

Орос-Манжийн хилийг нарийвчлан тогтоож баталгаажуулахад онцгой гавъяа байгуулсан хүмүүст Манжийн хааны хишиг хүртээхэд Халхаас Орост цагаачилж дагаар орсон буриад отгийн зайсан Сэдэдийг угсаа залгамжлах Тайш цолоор шагнажээ.

Үүний зэрэгцээ Халхын материаллаг бааз дээр түшиглэн Ойрадын хаант улсыг мөхөөж, улмаар бүх монголчуудыг Манж чин улсад нэгтгэх бодлогоо хэрэгжүүлэх ажлыг маш шуурхайлан хийжээ.

Орос болон дагаар орсон халхын эрх баригчдын дэмжлэгтэйгээр саадгүй явууж хэрэгжүүлсэн эдгээр олон талт арга хэмжээний үр дүнд Халх монголд Манж чин улсын байр сууь бэхжиж улмаар Ойрадын хаант улсыг 1750 онд мөхөөн, бүх монголчуудыг эрхэндээ оруулсан байна.

Монголын нутагт хятад үндэстэнийг удаан хугацаагаар оруулахгүй байх бодлогыг 184 жилийн турш хатуу баримталж байсан боловч Манжийн төр мөхөж, түүний орыг Дундад иргэн улс залгамжлан авсанаас хойш монгол орны байгалын баялаг, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг цөлмөх, мөнгө хүүлэх замаар монголчуудыг ядууруулан туйлдуулах бодлого

явуулсан тухай олон баримт түүхийн сурвалжуудад бий.

Чингис хааны байгуулсан Их монгол улсын тулгар төрийн голомт бүрмөсөн мөхөөгүй түр цогшиж байгаад Манж Чин улсын бүрэлдэхүүнд багтаж байсан 184 жил, Богд хаант монгол улс болж оршин тогтносон 5 жил, Дундад иргэн улсын /ДИУ/ харъяа Автономит улсын статустай болсон 4 жил, Дундад иргэн улсын /ДИУ/ мөлжлөгт байсан 2 жил (1919.09.27- 1911.12.29) нийт 220 жилийн хугацаанд харийнханы нөмөр нөөлөгт царайчилж байхын амтыг мэдэрсэн монголчуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийн үр дүнд тулгар төрийн голомтоо 1911 онд сэргээсэн боловч 1915 онд БИУ-ын автономит улсын статустай болж, 3 улсын гэрээг ДИУ-ын санаачлагаар 1919 онд автономит улсын эрхээ устгуулж, 1921 оны Ардын хувьсгалаар тусгаар тогтнолоо дахин олж авснаас хойш монгол төрийн голомт одоо хүртэл мандан бадарч байна.

Халхчууд нь Манж Чин улсад дагаар орж, бүрэлдэхүүнд сайн дураар багтсаныг орчин цагийн улс төрчид, түүхчдийн зарим нь шүүмжлэлтэй ханддаг тал бий. Үүнтэй би бээр санал нийлдэггүй юм.

Миний үзэж байгаагаар бол Халхчууд Манж Чин улсад дагаар орсон нь Халх, Ойрад хэмээх монгол үндэстнийг мөхлийн аюулаас хамтад нь хамгийн хохирол багатайгаар аварч, Монгол төрийн голомтыг мөхөөхгүй авч үлдсэн алсын хараатай зөв шийдэл гэж үзэв.

Тав. Дүгнэлт

Аливаа юмс үзэгдэлүүд нь эерэг сөргийн нэгдэл байдаг учраас Орос - Манжийн хийлийг нарийвчлан тогтоосон нь монголчуудын хувьд эерэг, сөрөг 2 талтай юм.

Эерэг тал нь гэвэл 1727 онд нарийвчлан тогтоосон хил нь 1970-аад оны дунд үе хүртэл үндсэндээ өөрчлөгдөөгүй учраас одоогийн Монгол улсын хойт хил олон зуун жил баталгаажиж Монголчуудын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах олон талт нөхцлийг бүрдүүлжээ.

Халхчууд нь Манж чин улсын бүрэлдэхүүнд багтах болсоноор Чингис хааны байгуулсан монголын тулгар төрийн мандан бадарч байсан дагшин голомтыг 220 жил цогшуулан, тусгаар тогтносон бүрэн эрхт байдлаа 237 жил алдагдсаны бурууг өөрсдөөсөө эрэхийн оронд Манж чин улс, Дундад иргэн зэрэг улсуудад тохож, хятад үндэстнийг бүхэлд нь үзэн ядах гаж үзлийг орчин цагийн монголын нийгмийн сэтгэлгээнд нутагшуулж болох сөрөг талтай гэж үзэв.

Өвгөн түүхч миний буруу зөвийг эдүгээх болон хожмын их мэргэд тунгаан тольдох буй заа...

Ашигласан материалууд:

1. *Монголын нууц товчоон. Ардаажав.Э. Хөх хот., 1984.*
2. *МНТ-ны утгачилсан орчуулга, монгол сийрүүллүүд . УБ.*
3. *Монгол үндэстний нэвтэрхий түүх. БНХАУ-ын НУХ. Хөх хот., 1995.*
4. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. МУ-ын ШУА. ХСХ. 2007.*

5. *Монгол улсын 33-ны 3Б-ын өөрчлөлт шинэчлэл. Д.Сономдагва. УБ., 1998.*
6. *Дэлхийн монголчуудын түүх. Балжинням. УБ., 2012.*
7. *БНМАУ-ын түүх. Хамтын. УБ., 1966-1969.*
8. *Халх товчоон. Д.Гонгор. УБ., 1970, 1978.*
9. *Ховдын хураангуй түүх. Д.Гонгор. УБ., 1964.*
10. *Монгол улсын түүх. Ж.Болдбаатар. УБ., 1999.*
11. *Монголын түүхийн дээж бичиг. iV. Чимид-доржиев. У.Удэ., 1992.*
12. *Дайчин улсын үеийн монголын түүх. Намсрай. УБ., 1993.*
13. *Галдан бүшгит хаан. Ц.Цэмбэл. УБ., 1994.*
14. *Буриадай түхэ бэшэг. Хаатын. Улан-Удэ., 1990.*
15. *Монгол Улсын хязгаар бүрэлдэн тогтсон түүх. Цэдэн-Иш. УБ., 2011.*
16. *Сэлэнгийн түүхийн товчоон. Ө.Бавуу. УБ., 2001.*
17. *Хоймор нутгийн хийморь. Хамтын. УБ., 2011.*
18. *Эв модны наадам. Д.Бадарч. УБ., 2015.*
19. *Судалгааны бүтээлүүд. Сэлэнгэ судлал ТББ. 2011-2019.*

БАЙТАГИЙН ХИЛЧИН БААТРУУДЫН БАЙЛДААНЫ ХҮЛЭГ, ТЭГШЭЭГИЙН ХҮРЭН ХАЛЗАН МОРИЙГ АЛДАРШУУЛЪЯ

Доктор, профессор Цагааны Ганболд
Ахмад хилчин, дэд хурандаа С.Зэсэндүйчэр

Монголчууд хүлэг морио хоёр дахь амь хэмээн эрт дээр үеэс шүтэн дээдэлсээр ирсэн билээ.

Нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудын амьдралын нэг хэсэг нь морины соёл бөгөөд нэн эртний түүх, уламжлалтай.



Үүний баталгаа нь хадны сүг зураг хэлбэрээр төдийгүй хөшөө байдлаар хадгалагдан өнөөг хүрсэний нотолгоо нь Говь-Алтай аймгийн орон нутгийг судлах музейд хадгалагдаж буй Төмрийн эриний эхэн үе, МЭӨ III-VII зуунд хамаарагдах Жаргалан сумын нутгаас 1965 онд олсон хосгүй үнэт үзмэр хүрэл морины хөшөө юм.

Морины хэлбэр, хэв шинжийн дүрслэл нь хүлгийн бие галбирыг нарийн уран чамин хийцтэй, гоёмсог согоо чихтэй, ихэд бодитойгоор бүрэн баримлаар хавтгай суурин дээр цутгаж урласан байна.

Түүний сүүлийг мушгиж гоёсон, нүдийг дугариг нэвт цоорхой, дэлийг нарийсган, өвдөг, боривны үеийг залгаатай байдлаар урласнаас гадна суурь нь эргэн тойрон иржгэр хээтэй бүтээгдсэн нь сонин содон харагддаг.

Уг хүрэл морь нь 2005 онд болсон Монголын музейн шилдэг үзмэрийн уралдаанд түрүүлж байсан ба Говь-

Алтай аймгийн түүхэн дурсгал есөн гайхамшигийн нэгээр өргөмжилж, хүрэл морины хөшөөг Алтай хотод сүндэрлүүлсэн.

Мориныхоо хүч чадал, ухаан, цог залиар л дэлхийн дайдыг эзэлж явсан, тулалдаж явсан эрт болон эдүгээгийн аугаа түүх бидэнд бий.

Дэлхий дээр хамгийн олон адуутай орны жагсаалтад 2018 оны байдлаар Монгол Улс 3939983 толгой адуутайгаар, 10531109 толгой адуутай АНУ болон 6381291 толгой адуутай Мексик, 54566175 толгой адуутай Бразил, 5262347 толгой адуутай Хятад улсуудын дараа айргийн тавд жагсаж байна. (Эх сурвалж: www.fao.org. НҮБ-ын Хүнс, ХАА-н байгууллага).

Монголчууд 11125 морьтон зэрэг жагсааж, 4276 хүлэг морио зэрэг уралдуулж дэлхийн өвөрмөц амжилтын түүхийн Геннисийн номонд бүртгэгдэж, 100000 морь уралддаг "Монгол наадам" нь ЮНЕСКО-гийн дэлхийн өвөөр батламжлагдсан байдаг билээ. Чингис хааныг есөн шарга морьд, байлдааны ам цагаан хул морьгүйгээр нь, Цогт хун тайжийг алаг, жанжин Д.Сүхбаатарыг ухаа хонгор, Халхын голын дайны домогт баатар Лодонгийн Дандарыг алаг, Баруун хил, Байтаг Богдын эрэлхэг баатрууд Ж.Нэхийт, Баянбалын Тэгшээ нарыг хүрэн халзан мориноос нь ер нь Монголчуудыг мориноос нь салгаж ойлгодоггүй, морьтон монголчууд гэдгийн учир энэ буюу.

Монгол түмэнтэйгээ мянга мянган жилийн туршид, мандан бадарч явахад нь ч, мөхөн доройтож байхад нь ч, байлдаж дайтаж байхад нь ч, баярлан цэнгэж байхад нь ч хамт байсан, байсаар ч ирсэн, цаашид ч зуун зууны туршид байх монгол морьдоороо бахархаад ханашгүй. Миний энэ өгүүллэгт дайн тулаанд болон нийтийн, нийгмийн үйл хэрэгт зүтгэж алдаршсан цөөн хэдэн морьдыг төлөөлөл болгосон билээ.



Монголын агуу удирдагч Чингис хааны хөшөө бол дэлхийн хамгийн том морьтой хөшөө бөгөөд 2008 онд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 54 км-т Туул голын эрэг дээр Цонжийн-Болдогд баригдсан. Домогт өгүүлснээр Чингис алтан ташуур эндээс олжээ. Хөшөөний өндөр нь 40 м, 36 метрийн баганатай арван метрийн дөрөөг оруулаагүй (эрх баригч хааны тоо дагуу). Энэхүү баримал нь зэвэрдэггүй 250 тонн гангаар хучигдан бүтээгджээ.





Монгол Ардын намын журамт цэргийн жанжин Д.Сүхбаатарын унаж явсан ухаа хонгор морь нь Эрдэнэвангийн хошууны туслах Бадамсэд (одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум) гэдэг хүний адуун сүргээс төрсөн унага ажээ.


Хурдан шинж нь тодорч аймаг, хошууны наадамд олон жил түрүүлж,айрагдсан сайханч морь болж тэр үед ардын цэрэгт цэрэг элсүүлж, агт морь татаж байсан, ардын хувьсгалын партизан Лувсан, Чоймбол, Нанзад нар Бадамсэд туслахын ирж хэдэн морьд авахад ухаа хонгор морь орж сайхан хийц галибартай, номхон, хөл хөнгөнтэй болохоор нь Д.Сүхбаатар жанжинд унуулахаар аваачиж өгсөн түүхтэй гэдэг.

1922 оны улсын баяр наадмын их насны морины уралдаанд Их жанжин Д.Сүхбаатарын ухаа хонгор морь түрүүлж байжээ.

1939 оны Халхын голын дайнд түүхэн ялалт байгуулахад амь, биеэ үл хайрлан, тулалдаж явсан олон мянган дайчдын дундаас байгуулсан гавьяа, нэр хүндээрээ тодрон гарсан олон баатрууд бий. Тэдний магнайд яах аргагүй ард түмнийхээ дунд "Алаг морьт Дандар баатар" хэмээн алдаршсан БНМАУ-ын Гарамгай баатар Лодонгийн Дандар залрах биз ээ.








Л.Дандар баатар нь 1914 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын Рашаант гэдэг газар төрсөн. Тэрбээр ЗХУ-ын Тамбов хотын морин цэргийн дунд сургуулийг төгссөн бөгөөд эх орондоо ирэхэд нь дэслэгч цол олгон Монголын Ардын армийн 6 дугаар морь дивизийн 17 дугаар морьт хорооны захирагчаар томилсон. Дандар баатар нь энэ хорооны захирагч байхад 1939 оны тавдугаар сараас Япончуудын өдөөсөн Халхын голын байлдаан эхэлжээ.

1939 оны тавдугаар сарын нэгэн тулалдаанд зургаадугаар дивизийн захирагч Шаарийбуу баатарлагаар амь үрэгдсэний дараа энэ дивизийн захирагчаар Дандарыг томилсон байна.

Халхын голын тулалдаануудад Дандар олон удаагийн морин дайралтыг биечлэн удирдаж байсан бөгөөд сэлмээр гарамгай цавчдаг байсан нь монгол-зөвлөлтийн цэргүүдийн дунд төдийгүй япончуудын дунд ихэд алдаршуулсан ба түүнийг унасан мориор нь Алаг морьт баатар гэж нэрлэдэг байжээ. /С.Шүрэнчимэг/





Түүхэнд мөнхөрсөн Нийгмийн хонгор

Халхын Цэцэн хан аймгийн Ёст бээсийн хошуу нь Баглаа хээр, Зандан хүрэн, Нийгмийн хонгор гэдэг эрт дээр үеэс түмэнд алдаршсан хурдан хүлэг төрдөг тал хээр нутаг.

1961 онд нэгдлийн адуучин Э.Дорж өөрийн адуулан маллаж байсан адуунаас хонгор даагыг барьж сумын наадамд уясан байна.

Ардын хувьсгалын 40 жилийн ойгоор хонгор даага сумын наадамд, дараа жил нь аймаг байгуулагдсаны 20 жилийн ойн баяр наадамд хонгор шүдлэн үрээ мөн л түрүүлжээ. Аймаг сумын наадамд тоосоо өргөн түрүүлж хурдан хүлэг болохоо харуулсан хонгор морь, нэгдлийн түмэн сүргээс олж уяж сойн тодруулсан уяач хоёрын алдар ч төдхөн олонд түгэн тархаж, "Нийгмийн хонгор" нэрийг нутгийн олноосоо хүртсэн гэдэг.

Ардын хувьсгалын 50 жил буюу 1971 онд Нийгмийн хонгор улсын наадамд очиж уралдсанаас хойш улс, аймаг, сумын наадамд 20 гаруй удаа түрүүлсэн байна.

Хонгор морины чихмэлийг нийслэл хотоос авчирч Сүхбаатар сумын

Д.Сүхбаатарын музейд байрлуулжээ. Сүхбаатар сумын төвд Нийгмийн хонгор морины хөшөө байдаг. /**Г.Сүхээ**/

Монгол морь Чингис хааны үед дэлхийн талыг туулан Адриатын тэнгисээс ус ууж, арлын Чэжүд нутагшин үржиж, аугаа их эх орны дайнаар Берлин хүрч, Эльба мөрөн дээр хөлсөө сэврээж, Вьетнамын балар шугуй, балчиг намагт зэвсэг хэрэгсэл хүргэж, эх орны дайны фронт, Англи, Вьетнам орнуудаас нутаг тэмцэн гүйж, "оргож" явсныг дэлхий хүндэтгэн өвдөг сөгдөн, тэргүүнээ бөхийлгөн хүндэтгэж, олон хөшөө дурсгалаа зориулж байхад аугаа баатарлаг адгууснуудын төрөлх эх нутагт арай өөрөөр хандаж байдгийг зөвтгөх аргагүй.

Монгол дайны морьдыг дэлхий хүндэтгэн, хүлээн зөвшөөрч, хөшөө дурсгалаа зориулсан хоёрхон жишээг оруулав.



Дэлхий даяар моринд зориулсан хөшөө дурсгал их байдаг ч дайнд оролцсон гавьяаг нь үнэлж, хөшөөгөө босгуулсан адгуус ховор. Тэгвэл Дэлхийн II дайны үед Зөвлөлтийн армид зүтгэж явсан монгол морьдын "Ялалтад тэмүүлсэн морьд" хөшөөг 70 жилийн дараа Москва хотын төвд сүндэрлүүлжээ. Уг морины хөшөө нь Берлины зүг хүнд их буу, техник чирч яваа монгол адууг дүрслэн хийгджээ.

"Хэдийгээр дайнд хүмүүс ялалт байгуулсан ч дайны баатрууд зөвхөн цэргүүд байсангүй. Фронтод хүчин зүтгэж явсан морьдыг эргэн санах нь зүйтэй" хэмээн Оросын нийтлэлч Рюстем Адагамов өөрийн блогтоо бичжээ.

Монголоос Зөвлөлтөд хүргүүлэх адуу, морьд 1941 оны эхээр эх орноосоо гарсан бөгөөд дайны дөрвөн жилийн жилийн хугацаанд 500 гаруй мянган монгол үүлдрийн адуу фронт руу тусламжийн нэгэн хэсэг болон хүргэгджээ.

"Монгол морьд хагас зэрлэг, магадгүй маш тэсвэр тэвчээртэй байдаг нь Европын эрс тэс нөхцөлд дасан зохицсон байдаг. 1943 оны давшилтаар Зөвлөлтийн армийн тэргүүн салаа бүрт дор хаяж таван монгол адуу байсан" хэмээн тухайн үеийн орос генералууд дайны тэмдэглэлдээ бичин үлдээжээ. /Эх сурвалж: Т.Бат/

Америкчууд Монгол моринд зориулан дурсгалын хөшөө босгожээ





Жараад жилийн тэртээх Солонгосын дайны үеэр бөмбөгдөлтөд өртөн шархадсан АНУ-ын цэрэг болон галт зэвсэг зөөвөрлөхөд Реклэс нэртэй гүү ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ба түүхэнд мөнхөрсөн аж. Түүнд АНУ-ын цэргийн дэд түрүүч цол олгосон бөгөөд дайны морь тэмдгээр шагнаж байжээ.

Солонгосын дайны үед Америкийн "Усан цэргийн корпус"-д үйлчилж байсан Монгол гүү 1953 оны гуравдугаар сард болсон таван өдрийн тулалдааны үеэр 51 удаа ганцаараа байлдааны голомт, хуарангийн хооронд давхин нийт 4 мянга 543 кг сум болон тэсэрч дэлбэрэх материал зөөвөрлөсөн байдаг.

Тэрээр хуаранд хурдан дасаж, хүйтэн шөнө тэнгисийн явган цэргийн майханд унтдаг байв. Реклэс хуаран дундуур чөлөөтэй тэнүүчлэх эрхтэй бөгөөд өндөг, шар айраг, Coca-Cola зэрэг таарсан болгоныг идчихдэг байжээ.

Америкчууд Реклэсийг гүү биш усан цэрэг байсан хэмээн дурсдаг аж. Түүнээс Фэйрлэ, Чэсти, Даонтлэс нэртэй гурван унага гарчээ.


2016 оны гуравдугаар сарын 25-ны өдөр Виржина мужид орших "Усан цэргийн корпус"-д Монгол гүү дэд түрүүч Реклэс гүүнд зориулсан дурсгалын хөшөөний нээлт болсон бөгөөд гурван метрийн өндөртэй уг хөшөөг уран барималч Жоклин Расел бүтээжээ. /Эх сурвалж: М. Уянга/


"Монгол бол хөшөө дурсгалын эх орон мөн" гэж Зааны ясан улсын төв хэвлэл DMN онцолжээ. Тус улсын монголч эрдэмтэн Лаурен Жбагбо Монголд хоёр жил судалгаа явуулсаны эцэст хэлэхдээ: "Монгол орны сум болгонд таван хошуу малын хөшөө байдаг. Үүн дотроо бод малын хөшөө дурсгалгүй нэг ч суурин байхгүй. Монгол бол мал аж ахуйн орон мөн" гэж бичжээ.

Үүнд нарийвчилсан тоо гаргахад 1032 морины хөшөө, 538 бөхийн хөшөө, 341 төр нийгмийн нэрт зүтгэлтнүүдийн хөшөө, хонь ямааны 1652, аргаль янгирын 123, үхэр, тэмээний хөшөө 756, Чингис хааны 27, Өэлүн эхийн 11, нохойны 231, эвтэй дөрвөн амьтны 26, тарваганы 25 ширхэг хөшөөтэй гэж тэмдэглэгдсэн байх юм. /Эх сурвалж: Хөшөө судлаач Цэрэнтогтох/.

Зөвхөн 1990 оноос хойш 26 жилийн дотор Монгол Улс сансарын 5 пуужин, атомын 2 цахилгаан станц, 6000 цэцэрлэг, 4000 гаруй эмнэлэг, 2500 сургууль, 20 сая хүүхдийн мөнгөөр хөшөө босгосон байна гэж олон улсын "Эмнести интернэшл байгууллага" дүгнэлт гаргасан байдаг.

Аливаа юм хэмжээнээсээ хэтрэхээрээ зовлон, мөн дутахаараа асуудал дагуулж байдаг жамтай.







Архангай аймгийн музейд байгаа Тэгшээгийн хүрэн халзан морины чихмэл.

1948 оны 7дугаар сарын 8-нд Байдагийн бүдүүн харгайтын тоот өндөрлөгт болсон тулгаралт байлдаан эхлэх мөчид Тэгшээгийн хүрэн халзан морийг унаж холбоочны үүргээ гарамгай гүйцэтгэсэн Увс аймгийн Өндөрхангай сумын харьяат Чойжилсүрэнгийн Пэлжээ гуайтай уулзаж билээ. Өглөөний нар нилээд дээр гарсан байсан дайсан манай пост руу буудаж, буун дуу тачигнаж эхлэхэд яаралтай холбоо хүргэх үүрэг надад өгсөн юм. Би агтны байрлалд ирэхэд буун дуу улам ширүүсэж зарим морьд уяагаа таслаад зугтаж байсан юм. Хүрэн халзан морийг хамгийн сайн гэдгийг бид мэддэг.




1993 он. Ховд Үенч. Отрядын 60 жил. Зураг дээр: Холбоочин Ч.Пэлжээ, хорооны комиссар байсан Дагвадорж Үенчийн отрядын штабын дарга ахмад Г.Пушкин нар.

Хүрэн халзан маань цулбуураас нь барьж мордох хооронд нилээд цовхчиж билээ. Дайсан довтолж байгааг адгуус хүртэл мэддэг юм билээ. Би моринд үнэхээр сайн байжээ. Хөл дөрөөнд хүрсэн л бол ямар ч хангал догшин дээр суудаг байлаа. Газраа сайн мэддэг болохоор Баруун хуурай ороод түүнээс зүүн явж Дамжигийн усанд байсан сумандаа бага үдийн хэрд очиж холбоо барьсан. Дөчин км газар дөчин минут явсан гэдэг үнэнүү энэ тэр гээд хүмүүс байнга асуудаг юм. Хатираа, давхиа хоёроос өөр явдлаар яваагүй нэг цаг орчим л явсан байх... гэж дурсан ярьсансан.

Баярын өдрүүдэд надад их дотносож сайн хүү байна. Ажлаа сайн хийгээрээ.

Одооч цаг сайхан болжээ хүү минь. Ах нь худлаа үнэн ярих дургүй. Мэддэг юмаа л ярих хэрэгтэй. Бидний үед цаг төрийн байдал хэцүү байсан шүү гэж дахин дахин ярьж билээ.



Монгол улсын баатар Ж.Нэхийтийн хүрэн халзан морь.

Гол зорилго, санаа маань бол дээр дурьдсан 1032-өөр тоологдсон морьны хөшөөнд багтаагүй жинхэнэ дайны хүлэг, жинхэнэ баатруудын унаа болсон Нэхийт, Тэгшээ баатруудын хүрэн халзан морины талаар онцгойлон өгүүлэх гэсэн юм.

Сумын наадамд 5 түрүүлэн, шагнал байгаар булуулан, айраг цагаагаар бялхуулан мялаалган, хөшөө дурсгалаа босгон мөнхжүүлсэн орон нутаг, жалга довын олон хүлгийг, суман мөндрийг 30 гаруй удаа сөрж, наадмын шулуун замд бус, дайны дайрган замаар хурд, тэнхээ хуваан, үхэх сэхэхийн хувь заяаг шийдэхийн төлөө зүтгэж явсан энэ домогт хүлгийн дайчин замналтай харьцуулахад агуулгаараа ч, ач холбогдлоороо ч, чанар чансаагаараа ч асар их ялгагдана.

Домогт Байтаг богдын тулааны талбарт нь энэ хүлгийн сайхан хөшөөг босгож алдаршуулах юмсан. Гэхдээ зүгээр л нэг морьны хөшөө байдлаар биш цогцолбор байдлаар хиймээр санагдана. Цэргийн агтнаас нутаг гүйж байгаа болон Баруун хилд цэргийн агтанд явуулж байгаа Шагдар гуайг оруулан, Бугат нутгийг нь багтаасан, Нэхийт баатраас Тэгшээ баатарт хүлээлгэн өгч байгаа, хил зөрчигч дүүрчихсэн, том үхэр чулуун дээгүүр харайж байгаа, хэл хүргэхээр Пэлжээ давхиж байгаа, туслах хүчинтэй буцаад давхиж байгаа гээд бүхий л холбогдох үйл явдлыг багтаасан, харуулсан байдлаар хиймээр санагдахыг бүтээлч нөхдүүд мэргэн оюундаа тунгаана биз дээ.

Доорх баримтуудаас дүгнэлт хийхэд Тэгшээгийн хүрэн халзан морины гарал, үүслэл, эзнийх нь талаар Говь-Алтай аймгийн Бугат сумын Сиймэн хэмээх Шагдар гуайн унаган адуу, Говь-Алтай аймгийн Тонхил сумын Бүс-Уул багийн Чантуу гуайнх бөгөөд 1967 онд зуданд үхсэн, цэргийн ангийнхан чихмэл хийж амжаагүй, Архангай аймгийн унага байсан бөгөөд нутаг гүйн буцаж ирээд Архангайд үхсэн, чихмэл нь Архангай аймгийн музейд хадгалагдаж байгаа, мөн Дорнод аймгийн Халх гол суманд Тэгшээгийн хүрэн халзан морины чихмэлийг эзнийх нь санаанд хүртэл хийсэн гэж боддог гэсэн 4 түүх яригдаж байна.

Миний хувьд хүмүүсийг талцуулах, яс хаях бодол санаа огт агуулаагүй бөгөөд түүх домогт орсон, хоёр ч баатар эрийн хүлэг унаа болох ховор тохиолдлын гэрч, жинхэнэ дайны хүлэг, баатруудын унаа болсон монгол морь, хилчдийн үнэнч хань гэдгээр нь л мөнхжүүлэх бодолтой л асуудал

дэвшүүлж байгаа юм.

Тэгшээгийн хүрэн халзан моринд зориулсан, С.Жавхлангийн дуулсан "Тэнгэрлэг хүлэг" хэмээх сайхан дуу бас байна шүү.

Хүрэн халзан морины талаар багагүй материал цуглуулж, уншиж судалсны дүнд энэ морь Говь-Алтай аймгийн Бугат сумын Шагдар гуайн унаган морь юм байна гэсэн итгэл үнэмшил төрж байгаагаа хэлэх нь зүйтэй гэж үзлээ.

Бугат сумынхан бас нэгийг бодож, тунгааж бүтээнэ байх гэж найднам.

Түүхч, эрдэмтэн мэргэдийн бичсэн өгүүллэг, дурсамжуудыг та бүгдийн мэргэн ухаанд толилуулья, нэгийг бодож, хоёрыг тунгаана биз дээ.

Баатар Тэгшээгийн хүрэн халзан Монгол улсын тусгаар тогтнол халдашгүй дархан байдлын төлөө одоогын зарим төрийн түшээдээс илүү чухал үүрэг гүйцэтгэсэн хүлэг сайн морины түүх. Цэргийн агтанд ирсэн морьдоос нэгэн хүрэн халзан морийг Дамжигийн сумангийн байлдагч Тэгшээ, Ж.Нэхийт нар цэргийн эрдэмд сургаж эзнийхээ дохиогоор газар унаж сэлэмтэй талруу налж өгч цавчилт хийлгэх мөн хурдан хурцаараа ялгарч, бусад морь шиг буун тажигнасан чимээ бөмбөгдөлт сүрнээс халгихгүй зоригтой ороо сөрөн давхихаараа үнэнхүү ялгарч олон удаагийн хилийн зөрчил тулгараалтанд онцгой гавъяа байгуулж байснаас хамгийн сүүлд цэргийн эрдэмд сургаж өгсөн эзэн Тэгшээ Нэхийт нартайгаа орсон сүүлийн тулалдааны тухай түүхэн баримт сөхөе.

1948 оны 7 сарын 8-ны өглөө Дамжигийн сумангийн улс төрийн орлогч Г.Хаянхярваагаар ахлуулсан Б.Гиваан, Б.Тэгшээ, Л.Даваадорж, Н.Дандархайдав, Э.Архад, Т.Баян, Л.Гончигзэвгэ, Д.Чойжин, Ч.Пэлжээ нарын бүрэлдэхүүнтэй хилийн манаа Байтаг богд уулын Бүдүүн харгайт голын хавцлын аман дахь харуулын цэг дээр үүрэг гүйцэтгэж байтал дайсан этгээдүүд Бүдүүнхаргайтын эхээр хил нэвтрэн орж ирэхэд, Пэлжээд Тэгшээгийн хүрэн халзан морийг унуулан 50 км-т байгаа суман руугаа хэл хүргүүлэхээр давхиулжээ. Пэлжээ хүрэн халзан морьтой бартаа саад ихтэй "Уушгын" уулсын дундуур 30 км газар зогсолтгүй давхисаар суманд мэдээ хүргэснээр даасан этгээдүүдыг дахин цөмрүүлэлгүй устгасан билээ. 1940-ood оны сүүл тавиад оны эхээр Ховд аймгийн Булган сумын Байтаг богд орчимд болсон их бага хэмжээний олон удаагийн тулаанд, хүрэн халзан морь гарамгай амжилт үзүүлж, тодорсон байдаг. Энэ алдарт дайны хүлэг, баатруудын хүлэг морь Говь-Алтай аймгийн Бугат сумын иргэн асан Х.Шагдарын унаган морь байжээ. /@ khurdanaduu Company/

Миний ажиллаж байсан Бугат суманд ч бас ийм түүх байдаг. Энэ бол Вьетнамаас бүү хэл бүр алс холын Орос-Герман фронтоос "оргон" нутагтаа гүйж ирсэн морины түүх юм. Хуучнаар Засагт ханы Урианхай Дайчин бээлийн хошууны тайж, өнөөгийн Говь-Алтай аймгийн Бугат сумын Шагдар гуай хурдан хүрэн халзан морио Эх орны дайны үед фронтод өгчээ. Гэтэл хоёр жил орчмын дараа өнөөх Хүрэн халзан

нь гүйгээд ирж. Шагдар гуай нэгэнт Фронтод өгсөн юм, юутай ч айл гэрт биш, аян дайны хүлэг тул тэнд нь хэрэглэг гээд, дайн дуусчихсан тул тухайн үеийн хатуу ширүүн тулаан өрнөж байсан Баруун хязгаарын Ховд V отрядын цэргийн агтанд өгсөн нь 1947-1948 онуудад болсон Байтагийн алдарт тулгаралтын үеэр олон удаагийн тагнуулын болон өртөө улаанд үүрэг гүйцэтгэж, 30 км газарт 40 минут давхин, хэл хүргэж байсан алдарт Хүрэн халзан юм. Монгол Улсын баатар Тэгшээгийн Хүрэн халзан гэдэг нэрээр нь олон мэднэ. Ер тэр Сиймэн Шагдар гуай ажигч гярхай нь нутаг даяараа гайхагддаг хүн байсан гэдэг. Тиймээс Хүрэн халзангаа дайны хүлэг мөн гэдгийг нь баттай мэдэж байсан биз ээ.

"Энгийн үед ороо, ардаг догшин гэмээр ч дайн тулааны үед номхон, үргэж туйлна гэж огтоос үгүй, эзэн лүүгээ л налж өгөөд байдаг, тийм атлаа атаканд ороход хамгийн урд хүзүүгээ сунгаад шуурч явдаг, хүн шиг ер бусын ухаантай морь байсан даа. Хүнээр бол мөн ч их юм үзсэн амьтан, хөөрхий" хэмээн тэр хүрэн халзан морины тухай аав маань хуучилж байсныг санаж байна. Аав маань 1944-1948 онуудад Байтаг болоод Баруун хязгаарт өрнөсөн гол үйл явдлуудад оролцож, Улсын баатар Ж.Нэхийт, Тэгшээ, Даваадорж нартай нэг салаа, тасагт мөр зэрэгцэн тулалдаж явсан учир нүдээр үзэж, харснаа тийн дурссан хэрэг. Өнөө Хүрэнхалзан морь нэгэнт домог болжээ. Алдарт Хүрэн халзангийн эзэн Шагдар гуайн үр хойчис илүү нарийн ширийн зүйлсийг өгүүлэх биз ээ. /Б.Номинчимэд. Болдоггүй "Оргодол" Монгол морьд. Zindaa.mn/

Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж багийн Бууч овогт Доржийн Ишбатын ярианаас: Хөвчийн нуруу, Бижийн гол хэзээнээс гайгүй домогтой адуу их байсан. Сээмэн Шагдар гэж миний нагац болох хүний хүрэн халзан морь фронтод очсон. Одоо энэ Халиун эмгэнийх (Ш.Халтар) гэсэн үг. Баатар Тэгшээгийн хүрэн халзан гэдэг чинь тэр. Хүрэн халзан морь тахийн эрлийз байсан. Хувын Шагдар, Далай гээд ах дүү нар байсан. Нэг хавар Алаг нуурын ар дээр тахийн адуу орж ирээд болдоггүй. Тэгэхээр нь азаргыг нь ах дүү хоёр барьж авч сургаад унасан. Нөгөө тахийн азарга бүтэн жилдээ өнөтэй явж байгаад намар нь хэн гэлээ дээ нэг хүн буудаад алчихсан гэж дуулдаж байсан. Тэгээд тэрнийх нь унага жижигхэн хүрэн халзан морь, эрхгүй тахийн удам болохоор ааштай л байгаа шүү дээ. /Эх сурвалж: www.polit.mn. М.Энхбаатар. ШУА-ийн Эрдэм шинжилгээний ажилтан/

Пулемётчин МУ-ын баатар агсан Б.Тэгшээ нь малд гярхай, сэргэлэн цэрэг байсан бөгөөд түүний хүрэн халзан морийг байлдагч Пэлжээ унан Уушигын уулсын 30 км гаран бартаат замыг хагас цаг орчим туулсаар Дамжигийн усны застаавт мэдээ өгсөн байдаг. Хүрэн халзан морь олон тулаанд оролцсон бөгөөд Монгол улсад энх цаг тогтсоны дараа хөгширч хорь хол гарсан насандаа төрсөн нутаг Архангай аймагт гүйж хүрсэн гэсэн яриа байдаг. Монгол морины ухаан хийгээд хүч чадал ямар агуу байдаг нь энэ сайхан эрдэнэт хүлгээс тодхон

харагдана. Эр хүн, эргэмэг хүлэг хоёрын байгуулсан гавъяаг дурсаж баршгүй. Эзэн Чингисийн үеэс эрэлхэг баатрууд нь эмээл дээрээсээ дэлхийн талыг эзэлсэн агуу түүхтэй ард түмний минь хийморь сүлд нь эр хүн та юм шүү. /эх сурвалж: wikipedia Байтаг богдын хилийн мөргөлдөөн, Байтаг богд МУСК пэйж хуудаснаас...*Анна/*

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Бүс уул багийн харьяат, аймгийн алдарт уяач Чантуугийн Бузанков 2017 онд Говь-Алтай аймгийн "Тод магнай" сэтгүүлд өгсөн ярилцлагадаа: "Баатар Тэгшээгийн хүрэн халзан морь бол манай *аавынх байсан юм билээ. Цэргээс хүмүүс ирээд "Та нарын амь насыг хамгаалж* байна. Унаагүй ядарч, зүдэрч явна" гэж хэлээд "сайн дурааараа морио өг" гэж тушаахад нь "үгүй" гэж хэлж чадалгүй хоёр хүрэн халзан морио өгсөн байгаа юм. Намайг 1971 онд намайг цэрэгт очиход нөгөө морийг онголоод, сэтэрлэчихсэн байгаа юм. Миний алба хаасан цэргийн ангид шүү. Тэгээд тэр морь маань 1967 оны зуднаар үхчихсэн юм. Отряд нь чихмэл хийж авч үлдэж чадаагүй" гэж ярьсан байдаг.

Байтаг Богдын тулааны арван хилчин баатрын нэг Доржийн Чойжингийн охин Оюунгэрэлтэй уулзаж хөөрөлдсөн сэтгүүлч Лхагвасүрэнгийн Батцэнгэлийн ярилцлагаас: Энд байлдсан хилчид байтугай Тэгшээгийн хүрэн халзан морь хүртэл арваад жил тэтгэвэртэй байсан гэж би сонсож байлаа. Тэгэхэд аав тань харин ч бүр "Эх орноосоо урвагч" гэх шахуу хэлэгдэн хэлмэгдэж явсан гэхээр мөн ч гунигтай санагдлаа?

Ховор амьтныг биеэр нь үзэж чадахгүй учир музейгээс жинхэнэ төрхөөр нь үзэн таньж мэддэг. Үүнд музейн ажилтнууд тэр дундаа чихмэлчид ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Байгалийн түүхийн музейн ууган ажилтны нэг Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан, музейн чихмэлчин Д.Дагиймаатай хийсэн ярилцлагаас:

Та бас адуу малын чихмэл хийж байсан гэсэн. Чухам хаана, ямар адууны чихмэл хийж байв?

Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд "Нийгмийн хонгор" гэж зард гарсан хурдан хонгор морины чихмэлийг хийсэн. Бодит хурдан морины чихмэл хийх хэцүү. Хүмүүс хөл нь тийм байх ёстой, сэрвээ нь намхан байна гэх мэтийн өө хэлээд байх юм билээ. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Хишигбатын хонгор морины чихмэл хийсэн. Мөн Дорнод аймгийн Халх гол суманд Тэгшээгийн хүрэн халзан морины чихмэлийг эзнийх нь санаанд хүртэл хийсэн гэж боддог. / Эх сурвалж: Г.Нямсүрэн. "Монголын үнэн" сонин/

Дээрх асуудлыг Дорнод аймгийн Сүмбэр сум дахь Халхын голын дайны Ялалтын музейн эрхлэгч, Соёлын гавьяат зүтгэлтэн Мягмарсүрэнгээс лавлахад: "Тачанка чирсэн хүрэн морины чихмэл бий. Үүнийг хүмүүс Тэгшээгийн хүрэн халзан морьтой андуурдаг" гээд, харин Дандар баатрын алаг морины чихмэл байдаг гээд түүний зургийг явуулсныг дээр оруулсан болно.

ИХ ХҮРЭЭГ ЧӨЛӨӨЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД

Ардын хувьсгалын партизан Лувсанцэрэнгийн Цэвээновын тухай

Профессор С.Билэгсайхан

Нийслэл хүрээг Гамингаас чөлөөлсний 100-н жилийн түүхт ой Хотол төгс хэмээх Төмөр хулгана жилийн сүүлээр болох юм.

Түүхийн хуудас сөхөвөөс, манай улсын нийслэлийг гамингаас хошой Чин Ван Барон Унгерн фон Штернберг 1921 оны 7-р сард цагаантнаас чөлөөлжээ. 2021 онд энэ үйл явдлын 100-н жилийн ой тохионо.

Аливаа улсын нийслэлийг харийнхнаас чөлөөлөх үйл явдал нь түүхэнд тод томруунаар үлддэг, тэмдэглэдэг ажээ. 1921 оноос энэ үйл явдлыг өргөнөөр тэмдэглэж ирсэнгүй. Монгол Улсын түүхтэй танилцаж уншиж явахад энэ тухай товчхон дурдаад жирийн үйл явдал мэтээр үзэж ирсэн. Ер нь бараг дурсдаггүй. Би л лав 70, 80, 90-н жилийг нь онцлон тэмдэглэснийг санахгүй байна. Халх голын ялалтын ойг жил бүр онцлон тэмдэглэж ирснийг бид мэдэж л байгаа.

Их Хүрээг чөлөөлсний дараа Хиагтыг чөлөөлснийг бол Ардын хувьсгалтай уялдуулан байнга ярьж, онцлон бичиж иржээ.

Халх голын ялалтыг тэмдэглэж ирснийг би үгүйсгэсэнгүй. Гэтэл Нийслэлээ чөлөөлсөнөө бараг дурсдаггүй нь нэн буруу үйлдэл, даруй засах ёстой юм. Харин жил бүрийн 12 дугаар сарын 29-ний өдрийг тэмдэглэдэг болсныг нэн талархдаг, бахархдаг.

Хиагтыг чөлөөлөхөд 400 ардын журамт цэрэг цахиур буутай, шийдэм, бороохой, ташуур зэвсэгтэй дайран 10000 гаминг ялсан баатарлаг үйлсийг бидний үе сурагч ахуйгаасаа бахдаж ирсэн билээ.

Дөрвөлжин сүмийн үүдэн дээр
Дөрвөн пулемет зоогоод
Дөтлөөд ирсэн гамингуудыг
Дөтийн замаар тонилговоо ... гэж дуулцгааж ирсэн.

10000 хүн гэдэг бол өнөөгийн Монголын Зэвсэгт хүчин болон монголын цагдаагийн бие бүрэлдэхүүнтэй тэнцэх тоо юм. Тэгэхлээр байнгын бэлтгэлтэй армийг 4-хөн пулемёттой, бүрэн бус зэвсэглэсэн 400 хүн дайраад эзэлчихсэн. Бидний ойлголтоор эхэлж дайраад /энэ бол бодит гэж боддог/ бүтэхгүй болохоор 2 дох дайралтаар эзэлсэн мэтээр бичигдаж түүхэнд үлджээ. Дараа дайрахад нь Зөвлөлт Оросын цэрэг их буугаар дэмжлэг үзүүлсэнийг дурссан байдаг. Буриад, халимаг цэргүүд монгол дээл өмсөн дайтсан ч мэдээ байдаг. Естой л 20-р зууны түүхэнд үлдсэн цагаан зурвас гэлтэй.

Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ судлал ТББ-ын судалгааны багийн ахлагч", түүхийн ухааны доктор, профессор Ө.Бавуу гуай 400 партизаныг нэгд нэггүй тэмдэглэн тодруулсныг сонссон, тэгэхлээр Монголын түүхийн энэ хэсгийг тодруулж үнэн бодитоор түүхэндээ тусгах нь бидний үеийн зорилтын нэг гэж бодож байна. Энэхүү байдлыг судалж, сонирхож явахад нилээн хэдэн баримт анхаарал татаж байна.

Эн тэргүүнд мэргэжлийн байнгын бэлтгэлтэй армийг сайн дурын 400 партизан цэргүүд ялан дийлсэн гэдэг нь бодит бус юм. ОХУ-ын ШУ-ны академийн Дорно дахины Улаан-Үүд хот дахь хүрээлэнд "Историй 1000 солдат" гэсэн түүхэн баримт "маш нууц" гэсэн тэмдэглэлтэй хадгалагдаж байна.

"Казачий полк" гэж байнга яригддаг цэргүүдийн тухай болов уу? Тэгвэл Казачий полк-ын удирдагч нь хэн байв? Нэг хүн байв уу? Хэд хэдэн хүн байв уу? Казачий полк нь Ардын журамт цэрэг, Зөвлөлтийн цэрэгтэй эвсэж Гамингийн армийг буулт хийхэд хүргэв үү? Хэдэн мянган гамингийн цэргүүдийг Улаан-Үүд, Чита, Манжуураар Бээжин явах нөхцөлийг бүрдүүлсэн нь ямар тохиролцоогоор хийгдэв? Мөн 20-30% нь шууд Монголын нутгаар дамжин говь руу хөдөлсөн, хэдэн хүн нутагтаа очсон бол? Үлдсэн эсэх гэх мэт түүхийн олон асуулт судлагдахуунаа хүлээсээр байна. Мэдээж, түүхэн үйл явдалд оролцогч этгээдүүд голлох үүрэг гүйцэтгэдэг.




Тэгвэл би энд Ардын хувьсгалын партизан, Ерөнхий цэргийн 1 дүгээр газрын орчуулагчасан Лувсанцэрэнгийн Цэвээнов гэдэг Казачий полкын нэг төлөөлөгчийн хувьд онцлон бичмээр байна. 1885 онд ЗХУ-ын Буриад улсын Оронгойн хошуунд төрсөн. 1933 онд нас барсан. (Үнэндээ бол гэрийн гадна талаас нь хутгалж хөнөөжээ.) Оросын Цагаан хааны үе дамжсан офицер. Тэрбээр "Саган сагда" гэдэг Буриадын казакуудын отрядад алба хашиж байсан. 1919 онд одоогийн Хөвсгөл аймгийн Хатгал сумын нутгаар хил давж Хатанбаатар ван Магсаржавтай нэгдсэн байна. Тэгээд Вантай хамт Барон Унгерны командант орж, дараа нь баруун зүгт цагаантныг устгахад идэвхитэй тэмцэж явжээ.

Партизан Мягмарын дурдатгалд энэ хүний тухай нилээн тодорхой мэдээлэл бий. Тухайлбал, Эрхүүгээс явж буй Оросын цэргийн дарга нартай буриад Цыбенов гэж хүн явсан. Энэ үед Мягмар партизан эзэнтэйгээ муудалцаад хар гэрт орох шахаад оргоод явж байгаад ийнхүү уулзсанаа яриад, цаашид Ардын журамт цэрэгт элсэн орох, хаашаа явах, хэнтэй уулзах тухай түүнд хэлсэн тухай дурджээ.

Ардын хувьсгалын партизан /партизаны үнэмлэхний дугаар 65/ Лувсанцэрэнгийн Цэвээнов нь Хатанбаатар Магсаржавын шууд удирдлагын дор Барон Унгерныг угтах, Богд хааныг зуут зохион байгуулж Манзушрийн хийдээс босгуулан Их хүрээнд авчирсан операцийг удирдаж, Нийслэл хүрээг чөлөөлөхөд оролцсон байгааг архивын шаралсан хуудас гэрчилж байдаг. Энэ зуутыг буриад

бага дэслэгч Туванов Цэрэндаш Жигмитовичээр төвдүүдийг удирдуулан шууд дайралт хийсэн, ар хударгаар Богд хааныг хатантай нь жуузанд суулган Хүрээнд авч иржээ. Мөн Хиагтыг чөлөөлөхөд Казачий полкын нэгкомандлагчнь байсан нь мэргэжлийн удам дамжсан офицерын хувьд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Орос хэл төгс эзэмшсэн төдийгүй Хатанбаатар Ван Магсаржавын шадар хүний хувьд Монголын талаас идэвхитэй байр суурь эзэлж, Зөвлөлтийн талтай хэлэлцээр хийхэд нөлөөлсөн байх нөхцөл байдал ажиглагддаг.

Бароны тушаал гаргуулан одоогийн УИД-ээс зүүн тийш Сүхбаатарын талбайд байрласан Өндөр хогийг цэвэрлүүлж байжээ.



МОНГОЛ УЛС
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ
БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВ

АРХИВЫН ТАВЛАГАА


ЛАВЛАГАА ГАРГАСАН:
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН
ДЭД ХУРАНДАА: Ж.ГАНТУЯА

Лувсанцэрэнгийн Цэвээнов нь 1921 онд Цэргийн сургуулийг үүсгэн байгуулахад оролцож, анхны сургагч багш, анхны цэргийн комендатын дарга байжээ.

Хатанбаатар Ван Магсаржавыг Цэргийн яамны тэргүүн дэд сайд байхад нь зөвлөхөөр, дараа нь Цэргийн яамны жинхэнэ сайд болоход нь Цэргийн зөвлөхөөр ажиллаж, Ванг нас барахад нь МХАЦ-ийн армийн улс төрийн газрын дарга, комиссараар 1933 он хүртэл ажиллаж байжээ. Тэрбээр Нийслэл хүрээний анхны комендант, Ёслолын албыг санаачлан үүсгэн байгуулсан эрхэм хүмүүн билээ. Энэ хүний хөрөг нь 032-р ангид үүсгэн байгуулагчийн хувьд хүндэтгэлтэй тавигджээ.

Цэргийн түүхийн музейн үзмэрт Монгол Улсад дагаар орох өргөдөл, гар буу эзэмших эрхийн болон партизаны үнэмлэх нь байна. Цэргийн яамны тэргүүн сайд, сайдын зөвлөх байсны хувьд Шинэ тулгар улсын Зэвсэгт хүчнийг шинээр зохион байгуулах, зэвсэг техникээр хангах, бие бүрэлдэхүүний цэрэгжилт, байлдааны

бэлэн байдлыг хангах, мөн Зөвлөлтийн Улаан армитай болон Зөвлөлтийн БХЯ-тай байгуулсан гэрээ хэлэлцээрт идэвхитэй оролцсон нь зайлшгүй.



Улаан -Одон сонины 1933-03-27-ны өдрийн №24 дугаарт хэвлэгдсэн эмгэнэлийн бичиг

Судлаачийн хувьд дараах саналыг дэвшүүлж байна:

1. Монголын түүхийн цагаан зурвас болсон Нийслэл хүрээг чөлөөлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх,
2. Хиагтыг чөлөөлөх байлдааны үйл явцыг нарийн тодруулах,
3. Эрхэм хүн Лувсанцэрэнгийн Цэвээновын амьдрал үйл ажиллагааны талаар тодорхой судалгаа хийж нийтийн хүртээл болгох. Учир нь, энэ Эрхэм Барон Унгернтэй, Хатанбаатар Ван Магсаржавтай нэг хэсэг хамтарч байсан нь улс төрийн хувьд бүдгэрэх шалтгаан болсон байх магадлалтай. Энэ зорилгоор эрдэм шинжилгээний хурал санаачлан зохион байгуулах, харин хувийн зүгээс илтгэгч судлаачдыг урамшуулах болно.
4. Энэ хүнийг алдаршуулан аль нэг анги нэгтгэлийг түүний нэрэмжит болгох.
5. ОХУ-ын ГХЯ-ны архиваас холбогдох бичиг баримт а/. тэр үеийн цэргийн гэрээ хэлэлцээр, оролцогчийн талаар мэдээлэл авах, б/.1000 цэргийн түүхийг нууцаас чөлөөлүүлэх хүсэлт тавьж Монголын талд авах.
6. Нийслэл хүрээг чөлөөлсний 100-н жилийн ойг бэлтгэн өнгөрүүлэх комисс байгуулах тухай Ерөнхийлөгчийн зарлиг гаргах,
1. Нийслэл хүрээг чөлөөлсний ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг НЗД-ын захирамжаар байгуулах.

Ашигласан сурвалж бичиг:

1. Ардын журамт цэргийн дурдатгалууд, УБ., 1969. х-564, 565.
2. Бимба лам Доржиев. Иволга голда суудалтай зоной угай бэшэг. Улаан-Үүд хот., 2012. 206-р тал.
3. Д.Дамдинжав. Барга Буриадын түүхийн сэдэв. 2-р боть. х-161.
4. Монголын үнэн сонины 1933 оны ...дугаар.
5. Монгол Улсын түүх, 5-р боть, 2004.
6. Ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ.,1985. х-617-620. Партизан Лувсанравдангийн Мягмарын /1896-1972/дурдатгал.
7. Улаан Од сонин. 1933 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн №24.

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД
THEORETICAL AND PRACTICAL ISSUES OF PATRIOTISM

Б.Буд. МУБИС-ийн докторант

Удиртгал

Даяаршлын үйл явц болох улс орнуудын зах зээл, санхүү эдийн засгийн харилцан, хамаарал гүнзийрч, мэдээлэл, технологийн эрчимтэй хөгжил, ардчиллын үзэл санаа улс үндэстэн бүрт түгэн хүрч хөгжил дэвшлийн чиг хандлагад үзүүлэх нөлөө улам бүр өсөн нэмэгдсээр байна. Ийм нөхцөлд эх оронч үзлийн талаархи эртний гүн ухаантан, эрдэмтдийн онол, арга зүйн үндэслэл, үзэл баримтлал, түүхэн эх сурвалжийг тодруулж, түүний мөн чанарыг тодорхойлох нь залуу үеэ эх оронч үзлээр хүмүүжүүлж төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нэг. Эх оронч үзлийн түүхэн эх сурвалж

"Patriotism" буюу бидний хэлж заншсан "Эх оронч үзэл" гэдэг нь төрөлх нутгаа хайрлан хамгаалах үзэл юм. Үгийн уг гарал нь "patris" гэсэн грек үгээс үүсэлтэй "Эх орон нэгтэн", "эх орон" гэсэн утгыг илэрхийлдэг. Эртний грекүүд эх оронч үзлийг үндэстэн-улс гэхээсээ илүүтэй хэл, шашин шүтлэгтэй холбон авч үздэг байжээ. Хиндү хэл дээр гарсан эртний "Рамаяна" туульд /Janani Janma Bhoomischa Swargadapi Gariyasi/ гэж бичсэнийг монголчилбол "Эх орон" нь тэнгэрээс аугаа гэсэн утгатай бөгөөд уг үндэстний хувьд эх оронч үзлийн суурь дэвсгэр болдог.

Эх оронч үзэл гэдэг хийсвэр ойлголт бус. Туургa тусгаар улс, ард түмнийхээ эрх чөлөө, аж амьдралын сайн сайхны төлөө үе үеийн баатарлаг зоригт хүмүүсийн итгэл үнэмшлийн үр дүн болохыг баталж байна.

Харин XVIII зууны Сэргэн мандалтын үед эх оронч үзлийг үндэсний үзлээс тусдаа ер нь хүмүүн төрөлхтөнд буян үйлдэх үзэл гэж тайлбарлаж байв.

Зөвлөлүүдийн төрийг үндэслэгч, онолч В.И.Лениний тодорхойлсноор эх оронч үзэл бол нийгмийн үзэгдэл. Тийм учраас түүхийн үүднээс, нийгмийн бусад үзэгдэл, үйл явц, түүхийн тодорхой туршлагатай холбож үзэх нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

Хүн төрөлхтөний амьдралын түүх талаас нь авч үзвэл хүмүүн эрт балар цагаас төрсөн нутаг, амьдрах орон зай, үндэсний соёлын өв уламжлалаа хүндэтгэж ирсэн уламжлалтай. Хувийн өмч, ангийн ялгавар бүрэн тодорхой болоогүй байсан тэр үед хүмүүсээс ураг төрөл, амьдрах орчноо гэх сэтгэлгээ үзэл суртлын хэмжээнд хүрээгүй, урсгал төсөөллийн шинжтэй байжээ. Ер нь араатан амьтанд хүртэл тухайлбал: арслан барс бас нутгийн заагаа хамгаалж булаацалддаг, адуу нутаг руугаа гүйдэг зөн билэг байдаг.

Мөн зөвлөлтийн эрдэмтэн Н.И Губанов "Эцэг өвгөдийн шарил булш тухайн ард түмний түүхийн чухал хэсэг

байдаг. Тэднийгээ хүндэтгэн дээдлэх нь ураг төрлийн ухамсарын нэг хэлбэр гэж үзэж болох талтай. Эдүгээ цагт Баян-Өлгий аймгийн нутагт казакууд өвөг дээдсийнхээ шарилыг байгалийн чулуугаар булш бунхан өрж үлдээсээр байна.

Эх нутгийнхаа төлөө тулалдсан ардын баатарын хөшөө дурсгал ч түүхэн эд өлгийн зүйл болж байв. Тийм учраас скифчүүд ураг төрлийнхөө булш бунханыг "эх орон" гэдэг ойлголттой холбож үздэг байжээ"[45].

Улмаар газар тарилан эрхэлж, үйлдвэрлэл хөгжихийн хирээр хүн ард тодорхой газар нутагт суурьшиж эхэлсэн. Тухайн үеийн сэтгэгчид хүмүүсийн төрсөн нутгийн тухай сэтгэлгээ нилээд гүнзгийрэн хөгжиж буйг мэдэрч, энэхүү сэтгэл хөдлөлийг үзэл суртлын талаар тодохойлон дүгнэх оролдлого хийж байв. Тухайлбал: "Эх орон бол эцэг эхээс ч үнэтэй зүйл..." гэж эртний грекийн гүн ухаантан Платон хэлжээ. Иймэрхүү санаа боол эзэмшлийн үеийн яруу илтгэгч нар ч олонтаа дурдаж байжээ. Ромын уран илтгэгч Цицерон "Хүмүүсийг дотногшуулан ойртуулах явцад нэгэн хэл, гарал үүсэл гэх мэт олон шат бий. Гэхдээ тэдгээрийн дотроос хамгийн ойр, дөхөм нь нэгэн ураг иргэний (civitas) бирилдлагаа мөн" гэжээ.[46]

Эртний гүн ухаантнууд "эх оронч үзэл бол жирийн нэг иргэний үүргээ биелүүлэх явдал төдий бус харин эх орноо эрэлхэгээр хамгаалх, төр улсаа удирдахад оролцох явдал мөн" гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Харин энэ үзэл нь гагцхүү ноёлогч ангийн төлөөлөгчдийг алдаршуулан магтахад шууд чиглэгдэж байв.

Феодолын буюу дундад зууны үеийн үзэл сурталчид эх оронч үзлийг шашин төрөө хамгаалах зорилгод ашиглан хүмүүсийг шашин шүтлэгээрнь ялгаварлан гадуурхах үзэл дэлгэрүүлэх болсон. Францын их хувьсгалын үзэл сурталчид энэ үзэл санааг шүүмжилж, эх оронч үзлийг эрх чөлөөний төлөө, феодолын хэмжээгүй эрхт ёс дэглэмийн эсрэг хийх тэмцэлтэй шууд холбон үзэж байв. Жишээлбэл: Поль Гольбах эх оронч үзлийг "Эрх чөлөөний хамгийн сайхан үр дагаварын нэг гэжээ[47] "эрх чөлөөгүй газар эх орон байх үндэсгүй"[48] (мөн тэнд 369 дэх тал) хэмээн тунхаглажээ. "Эх оронч сэтгэлгээ бол хувийн ба нийгмийн ашиг сонирхлын нэгдлийн тодорхой илрэл мөн" гэж Гельвеций хэлсэн байдаг. Манай ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг С.Зориг ашиг сонирхлыг дараалан эрэмбэлсэн байдаг. "Эх оронч үзэл" гэдэг нэр томьёо улс төрийн толь бичигт анх түрүүнд Францын хөрөнгөтний их хувьсгалын үед гарч иржээ. Тэд эх орон, эрх чөлөөг талархагчид, феодалын хэмжээгүй эрхт ёсыг эсэргүүцэгчдийг "эх орончид" гэж нэрлэж байв. В.И Ленин "Эх оронч үзэл XVIII зууны үеийн Францын их хувьсгалаас үүсэлтэй" гэж бичсэн байдаг.

Хоёр. Марксизм ба эх оронч үзэл.

Өнгөрсөн зууны Зөвлөлтийн ном хэвлэлд "Отечество", "Родина" гэдэг

[45] Н.И Губанов. Отечество и патриотизм. М. 1960 г. 34-35-дахь тал

[46] История Рима.М.1970 г. 9-дэх тал

[47] П. Гольбах. Избранные пройзведения В двух томах. II боть. М.1963 г. 42 дахь тал

[48] П. Гольбах. Избранные пройзведения В двух томах. II боть. М.1963 г. 369 дахь тал

хоёр нэр томьёо харилцан өөр утгаар хэрэглэгддэг. Харин бид энэхүү хоёр ойлголтыг хамтатган "Эх орон" гэдэг нэрээр орчуулан хэрэглэсээр ирсэн. Ер нь "Отечество" гэдэг нь "Родина" гэдэг ойлголтыг бодвол арай өргөн утга агуулгатай. Тодруулбал: тухайн улс орны төрийн байгууламж, газар нутаг, хэл соёл, зан заншил. Өв уламжлалыг бүхэлд нь хамаардаг. Нийгмийн байгууламж, улс төрийн агуулга, хэв шинжээр нь феодал, хөрөнгөтөн, социалист хэмээн ялгаварлах хандлага буй болсон.

Тийм учраас К.Маркс Ф.Энгельс "Эв хамт намын тунхаг" бичигтээ "Капиталист мөлжлөгийн нөхцөл пролетариуд эх оронгүй" /Отечество/ гэж бичжээ. Монгол хэлэнд бол / Отечество/ гэдэг нь "Эх орон", "Родина" гэдэг нь Төрсөн нутаг буюу "Унасан газар, угаасан ус" гэсэн ойлголтыг өгч байна.[491]

Оросын эрдэмтэн сэтгэгч Г.В.Плеханов "эх оронч үзэл ба социализм" хэмээх өгүүлэлдээ эх оронч үзлийг эдийн засгийн хөгжлийн хандлагын үүднээс тайлбарласан. Тэрээр, "Эх орон гэдэг бол түүхийн чанартай, тухайлбал үндсэн агуулгынхаа хувьд дэлгэрэн баяжих шинж чанартай ухагдахуун. Овог аймгийн отог, омгийн ухамсараас өнөөгийн улс үндэстний хэмжээний үзэл санаа болон дэвшиж ирснийхээ нэгэн адил "эх оронч" үзэл санаа ч мөн адил хүн төрөлхтнөө гэх зүйрлэшгүй өргөн үзэл санаанд уусан нэгдэх юм. Эх оронч үзлийг бүрэлдүүлж хувьсган дэвшүүлэгч гол хүч бол эдийн засгийн хөгжил" гэж үзсэн байна.[502]

Марксизмын онолчид "...эх оронч үзлийн тухай өмнөх үеийн гүн сэтгэгчдийн сургааль нь түүх, нийгэм, улс төрийн хувьд явцуу хязгаарлагдмал. Түүхийн тайзнаа мөн чанараараа интернационалч хүч болсон ажилчин анги гарч ирсний үр дүнд эх оронч үзлийн нийгэм эдийн засгийн үндэс эх оронч үзэл хийгээд интернационалист үзлийн диалектик холбоо, эх оронч үзлийн ардчилсан буюу ангийн утга агуулгын тухай асуудлыг цоо шинээр тайлбарлах шаардлага гарч ирсэн. ...Дан ганц оюун санааны амьдралын мөн чанар гагцхүү ардчилсан энэрэнгүй үзлийн үүднээс биш юуны өмнө бүх хөдөлмөрчдийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, туйлбартай хувьсгалч анги болсон пролетариудын улс төрийн язгуур эрх ашгийн үүднээс авч үзэж шийдвэрлэх нь чухал" гэж үзсэн байна. Тэд энэ асуудлыг юуны өмнө нийгмийн хөгжлийн материаллаг нөхцөл, түүхийн тодорхой туршлагатай холбохын зэрэгцээ эх оронч үзлийн мөн чанарыг зөв авч үзэх, тайлбарлах ганц зөв зам бол түүнийг ажилчин анги, хөдөлмөрчдийн ашиг сонирхол, ангийн зорилгын үүднээс авч үзэх явдал мөн" гэж үзсэн. В.И. Ленин "Их оросынхны үндэстний бахархлын тухай", "Питирим Сорокин үнэнээ хүлээлсэн нь" зэрэг олон бүтээлдээ эх оронч үзлийн ангич чанарыг тодорхой нээн харуулжээ. Нийгмийн аливаа анги, давхарга бүхэн хүмүүсийн эх орноо гэх сэтгэлгээг өөрийн ангийн ашиг сонирхолд ямагт ашиглаж ирэв. Феодал язгууртны болоод хөрөнгөтний

[49] [1] В.И.Ленин. Бүрэн эмхэтгэл. М. 16-дугаар боть 451 тал

[50] [2] Г.В.Плеханов. Избранные пройзведения, Т. III. М. 1957. 93 дахь тал

“эх оронч үзэл” гэгч нь ард түмнүүдийг ямагт бие биенээс үндэстнээр зааглан тусгаарлаж тэдний дунд үл итгэлцэх байдал төрүүлэн, цуст дайн түрэмгийлэлд ч хүргэж байна” гэжээ.

Тухайн үеийн оросын үгээгүй ядуучуудын хувьсгалт ухамсар, гал халуун эх оронч үзэл нь Октябрын хувьсгалыг хийх, иргэний дайнд ялалт байгуулах, хувьсгалын дараах өлсгөлөн, гуйланчлалыг сөрөн туулах, аж ахуйг сэргээн босгосх,гадны зандалчдыг бут цохих, эх орондоо социализм, коммунизмыг байгуулах бүхий л тэмцэлд ялалт байгуулахад чиглэгдэж байжээ.

Эх оронч үзлийг авч үзэх марксизм- ленинизмын өөр нэг чухал зарчим бол түүнийг пролетарийн интернационализмтай шууд холбон үүнээс тасархай “эх оронч үзэл бол” үндсэрхэх үзэлтний хоосон чалчаа яриа байхаас хэтрэхгүй гэж үзэж байв. Д.Маркс, Ф.Энгельс 1847 онд “Коммунист намын тунхаг”-таа дэвшүүлсэн “Орон бүхний пролетари нар нэгдэхтүн” гэсэн уриа хөрөнгөтний эсрэг тэмцэлд ажилчин ангийн эрх ашиг нийтлэг болохыг илэрхийлж, энэ тэмцэлд янз бүрийн улс үндэсний ажилчин ангийг нэгтгэхийн чухлыг онцлон заасан байдаг.

Улмаар XIX зуунд үндэсний үзлийн нөлөөн дор эх оронч үзэл бусдын өмнө хариуцлага хүлээх гэсэн өөр утга агуулгатай болжээ.

Дайн тулалдаан, аливаа улс үндэстний аюулгүй байдал заналхийлэл бодитой нүүрлэсэн үед эх оронч үзэл дэвэрч, тайван цагт намжмал байдалд шилждэг зүй тогтлыг эрдэмтэд ажигласан байна.

Эх оронч үзлийн түүхэн эх сурвалж нь олон зуун жилийн турш төрөлх нутгаа хамгаалах, үндэсний хэл соёлоо дээдлэх, тусгаар улсынхаа бүрэн эрхт гишүүн байх өөриймсөх сэтгэлгээтэй салшгүй холбоотой. Эх оронч үзэл бол эх орноо хайрлан хамгаалах, эрх тэгш, эрх чөлөөтэй, энх амгалан амьдрах, түүний төлөө өөрийн ашиг сонирхлыг золиослоход бэлэн байх агуулга бүхий ёс суртахуун, улс төрийн зарчим, нийгмийн мэдрэмж юм.

Эх оронч үзэл өөрийн орны хөгжил цэцэглэлт, түүх соёлоор бахархах, уламжлалт зан суртахуун, ёс заншлын онцлогийг хамгаалах, өөртөө шингээх хүсэл эрмэлзлэл, эх орондоо хамааралтай байгаагаа мэдрэх сэтгэл хөдлөл юм. Мөн түүнчлэн ард түмэнтэйгээ өөрийгөө адилтгах, эх орон ард түмнийхээ эрх ашгийг дээдлэн хамгаалах эрмэлзлэлтэй байхыг шаарддаг. Эх оронч үзэл өөрсдийгөө дөвийлгөн хэт үндсэрхэх, бусдыг тохуурхан гадуурхах зэрэг сөрөг үзэгдэлд харш юм.

Үндэстэн ба үндэсний төрт улс бүрэлдэн буй болох XYIII зууны үед эх оронч үзэл нийгмийн ухамсрын үндсэн хэсэг төдийгүй улс орон, үндэстний хөгжлийн хөшүүрэг болсон. Эх оронч үзэл санаа эх орон ард түмнээ хайрлан хамгаалах эерэг зан чанарыг төлөвшүүлдэг.

Гурав. Эх оронч үзэл ба үндэсний үзэл

Оросын эх оронч үзэл. Орос орон түүхэндээ олон ээдрээтэй асуудалтай тулж явсан нь Оросын үндэсний үзэлд ул мөрөө үлдээсэн байдаг.

Үүнд орос гүрэн олон зууны турш бөглүү тусгаарлагдмал,зах хязгааргүй том газарт сунан байршсан, зам, харилцаа, холбоо бүдүүлэг, тариачны ахуй ихэд нөлөөгөө үзүүлж байжээ. Түүхийн цагийн аясаар Орос оронд өрнийн нөлөө тусч эхэлсэн XIX зуунд Оросын үндэсний гэх үзэл анх эхээ авсан гэж хэлж болох юм. Орос оронд хамжлагын ёс халагдаж, Польшид бослого тэмцэл гарсантай холбогдуулан Славофилүүдийн славян үндэстнүүдийг нэгтгэх хөөрөл дарагдаж, славофилизм илүү орос маягийн үндэсний үзэл буюу шинэ славофилизм болж хувирах эхлэл болсон.

Шинэ славофилизмын төлөөлөгч Данилевский "Оросын эзэнт гүрний хил хязгаарыг тэлэх явдал оросын амин сонирхол" гэж байсан бол Леонтьев цагдаагийн улс байгуулах нь Европын нөлөөнөөс Оросыг хамгаалах хэрэгсэл гэдгийг сурталчилж байв. Улмаар Ф.Достоевский, Н.Данилевский, К.Леонтьев нар славофилизмын консерватив хэлбэр болох "Почвеничество" (хөрсөндөө буух гэсэн утгатай) үзлийг хөгжүүлжээ. Энэ бол Оросын үндэсний үзлийн суурь дэвсгэр байсан.

Октябрийн хувьсгалын дараагаас 1930-аад оны дунд үе хүртэл Зөвлөлт холбоот улсад "эх оронч үзэл " гэдэг ойлголт эрс сөрөг шинж чанарыг агуулж байв. Энэ ойлголтыг "хөрөнгөтөн", "хувьсгалын эсэргүү" ойлголттой адилтган үзэж байсан. Тухайн цаг үед иймэрхүү харилцаа зөвхөн өндөр дээд тушаалын удирдагч төдийгүй олон түмний дунд ч түгэж их хэлмэгдүүлэлт явагдсан түүхтэй. Эх оронч үзэл хяхан хавчих бодлого утга зохиол, урлаг, шинжлэх ухаан ялангуяа түүх, боловсролын салбарт ч өргөн дэлгэрсэн. Энэхүү урсгалын нэг тод төлөөлөгч нь М.Н.Покровский. Нийгэмд эх оронч үзэл санааг нухчин дарах зайлшгүй шаардлага дэлхийн пролетарийн төр улс байгуулахад үзэл санааны ихээхэн саад бэршээл учруулж байна гэж үзсэнтэй холбоотой. Жинхэнэ эх оронч үзэл бол ангич, интернационалч байх ёстой. Өөрөөр хэлбэл бүх дэлхийн пролетари нар улс үндэстэн хамаарахгүйгээр нэгдэх ёстой гэсэн үзлийг сурталчлах болсон. Үндэсний, уламжлалт эх оронч үзэл дэлхийн хувьсгалын үйл хэрэгт хортой төдийгүй дайсан гэж үзсэн. Гэвч 1930-ээд оны дунд үеэс Сталин үндэсний эх оронч үзлийг пролетаритай хамтатган оросын ард түмэн түүхэн дэвшилтэт хүч хэмээн сурталчилж эхэлсэн. Энэхүү хандлага Аугаа их эх орны дайны үед улам хүчээ авч, 1950 оны эхэн хүртэл улиг болтлоо сурталчилагдсан. Бүх холбоотын Лениний комсомолын байгууллагын 1962 онд XIY их хурлаар батлагдсан дүрмэнд "комсомолын гишүүн Зөвлөлт орны цогтой эх оронч бөгөөд хэрэгцээтэй цагт амиа өгөхөд бэлэн байна" гэсэн заалт оруулсан. Тус байгууллагын 1989 онд хуралдсан их хурлаар батлагдсан дүрмэнд заалтыг авч хаясан. Энэ байгууллагын Төв хороо пионерийн байгууллагаар дамжуулан сурагчдын дунд эх оронч үзлийг өргөн дэлгэр сурталчилж байлаа. Нийгмийн ухааны зарим салбарт ялангуяа гүн ухаанд 1960 оны сүүлч 1980 оны эхээр эх оронч үзлийг нийгмийн ухамсрын

үзэгдэл мөн гэсэн үзэл бодол өргөн тархсан. Улмаар 1980 оны дунд үеэс эх оронч үзлийг нийгмийн оюун санааны амьдралын нэг хэсэг гэх хандлага давамгайлах болсон. Зарим нэг бутээлд эх орны түүхэн хөгжлийн явц дахь оюун санааны онцгой шинж чанарын илэрхийлэл, янз бүрийн нийтлэгийн сэтгэл зүй хэмээн судлагдсан. Оросын холбооны улсын холбооны засаг захиргааныхан өнгөрсөн зууны 90-ээд онд хүүхэд залуучуудын "эх оронч хүмүүжил"-ийн асуудлыг огт анхаарахгүй орхигдуулсан. Харин орон нутгийн удирдлагууд энэ асуудлаар хааяа нэг арга хэмжээ зохиож байгуулж байсныг дурьдан хэрэгтэй байв. Гэвч өнөөгийн Оросын удирдлага Оросын үндэсний үзлийг орлуулахын тулд "Патриотизм"-ыг нийт иргэдийнхээ албан ёсны үзэл санааны үндэс болгож байна. Оросын үндэсний үзэл Тэрээр өнгөрсөн оны сүүлчээр болсон сэтгүүлчидтэй хийдэг уламжлалт хэвлэлийн бага хурал дээр "Эх оронч үзэл бол төр улсыг бэхжүүлэх үндэс байх ёстой. Ямар нэгэн сэтгэл хөдлөлөөр бус энэ үгийн хамгийн сайн сайхан, өргөн утгаар бол манай төр улсыг бэхжүүлэх үндэс байхаас өөр аргагүй" хэмээн оросын нийгмийн орчин үеийн үзэл суртлын агуулгыг тодорхойлсон. /Президент России Владимир Путин поддержал идею создания в России телепередачи о национальных ценностях и выразил убежденность в том, что патриотизм должен быть основой укрепления государства. «Я считаю, что в самом хорошем, не квасном смысле этого слова, патриотизм не может не быть основой укрепления нашего государства, в широком и в самом благородном смысле этого слова», -сказал президент на ежегодной большой пресс-конференции, отвечая на вопрос журналиста о современной идеологии российского общества/. (Путин назвал патриотизм основой укрепления государства. Пресс конференция 25 декабря 2018). Улмаар: "Эх оронч үзэл (патриотизм) үндсэрхэг үзэл (национализм) болон өргөжиж болох бөгөөд энэ бол аюултай хандлага. Зарчмын хувьд бид үүнийг анхааралдаа авч ийм явдал гаргуулахгүй байхын төлөө бүгдийг хийх хэрэгтэй. Би бол Орос оронд байгаа хамгийн том үндэсний үзэлтэн (националист). Хамгийн зөв үндэсний үзэлтэн. Үндэсний үзэл бол бодлого, үйл ажиллагаагаа ард түмний сайн сайхны төлөө эрэмблэх явдал. "Патриотизм может перерасти в национализм и это опасная тенденция. В принципе, мы должны это иметь ввиду и делать все, чтобы этого не случилось. Самый большой националист в России - это я. Но самый правильный национализм, это выстраивание действий и политики, чтобы это пошло на благо народу" гэж энэ хоёр үзлийн ялгааг тодруулсан байна. Орчин үеийн оросын христийн шашны тэргүүн II Алексей "...Эх оронч үзэл бол чухал ач холбогдолтой гэдэгт эргэлзэх зүйлгүй. Энэ мэдрэмж бол ард түмэн, хүн бүрийг эх орныхоо аж амьдралын төлөө хариуцлагатай болгож өгсөн. Эх оронч үзэл гэдэг бол хариуцлага. Эх орныхоо төлөө хүн бүр хариуцлагатай байх ёстой. Эх оронч үзэл байхгүй бол хариуцлага гэх зүйл

байхгүй. Хэрвээ ард түмнийхээ тухай бодохгүй бол гэр бүл, удам судрын тухай ярих нь утгагүй. Гэр орон гэдэг бол зөвхөн таатай орчин биш. Энэ гэр бүлд дэг журамтай байх ёстой. Энэ нь үр хүүхдүүдийнхээ төлөө хариуцлагатай байна гэсэн үг. Эх оронч үзэлгүй хүн гэдэг бол угтаа эх оронгүй хүн юм. Түүнд өөрийн гэсэн эх орон байхгүй. Харин дэлхийн хүн гэдэг бол гэргүй хүнтэй агаар нэг. Бас нэг чухал зүйл бол эх оронч үзлийн мэдрэмжийг бусад ард түмэнтэй дайсагнах үзэлтэй хольж хутгаж болохгүй. Энэ нь хэт үндсэрхэг үзэл" (Владимир Соловьёв, Национальный вопрос в России) гэж хэлсэн байна.

Хятадын үндэсний үзэл гэдгийг Хятад соёлтой ард түмний нэгдмэл төр улс байх үзэл гэж хэлж болох юм. Хятадын анхны төр, улс байгуулагдсан түүхийг Шан (Shang Dynasty), өөрөөр Yin Dynasty династийн үеэс тоолбол 3000 гаруй жил болно. Америкийн хятад судлаач Lucian W. Pye (1921-2008) "Хятадын үндэсний үзлийн илрэх хэлбэр дэндүү өргөн барьцгүй учир Хятад гэж чухам хэн бэ гэдгийг хэлэх бололцоогүй, утгагүй" гэж тэмдэглэж байлаа. Гэтэл зарим эрдэмтэн "ийм тодорхойгүй байх нь хятадуудад дотоод, гадаадын хямрал, нөлөөнд зохицоход тустай эрэг байсан" гэж үзэх нь бий.

Хятад гүрэн XIX зууны сүүлч үед Манжийн эрхшээлд байсан нь үндэсний үзэлд үл нийцэх харш хэмээж бослого тэмцэл гарч байжээ. Манж чин улсын Засгийг унагаах цорын ганц хэрэгсэл нь хувьсгал хийх явдал мөн" үзсэн. БНХАУ-ын албан ёсны үзэл суртал нь Хятад улс-олон үндэстний улс, хэдийгээр хүн амын 90 гаруй хувь нь хан үндэстэн боловч бүх л үндэстний хэл, соёлыг тэгш хүндэтгэх зарчимтай. Гэвч практик дээр жижиг үндэстнээ хан үндэстэн хүний олонлогоор аажмаар уусгаж байгаагаас харахад хятадын үндэсний үзлийг хан үндэстний ноёлох байр суурийг бэхжүүлэх үзэл гэж болох юм. Хятадын үндэсний үзэл өнгөрсөн зууны 1960, 70-аад онд эх газартаа марксизмтай хутгалдаж илүү интернационалч шинжтэй болсон гэж үздэг. Харин Тайваны хятадуудын хувьд үндэсний үзэл гэдэг нь Сун Ят Сений үзэл санаа, түүний үндэслэсэн Гоминдан намын коммунизмыг эсэргүүцэх үзэл хэлбэртэй болсон байна. Хэдийгээр хятадын үндэсний үзлийг БНХАУ болон Тайваньд өөр өөрөөр ойлгох болсон ч аль аль нь бие биенийхээ нутаг дэвсгэрийг өөрийн гэж үздэгээрээ нэгдмэл юм. Тайваний үндэсний үзэлтнүүдийн гол зорилго нь эх газрын Хятад, Тайвань хоёрыг нэгтгэх явдал. БНХАУ, Тайвань аль аль нь 1991 он хүртэл бие биенээ нэгтгэх зорилгоо албан ёсоор зарлаж байсан. Харин 1991 оноос Тайвань албан бусаар энэ байр сууринаасаа ухарсан байдаг. Үүний гол шалтгаан нь Тайваний үндэсний үзэлтнүүд дотроо хуваагдсантай холбоотой. БНХАУ-ын зүгээс Тайванийг тусгаар тогтнолоо зарлавал цэргийн ажиллагаа явуулна хэмээсэн нь тусгаар тогтнохыг эрмэлзэгчдийн дургүйцлийг хөдөлгөсөн байж болох юм.Зөвлөлт холбоот улс болон түүний тэргүүлсэн социалист тогтолцоо 1990-ээд онд задран унаж, эх газрын Хятад эдийн засгийн хувьд хөгжиж байгаа

зэрэг нь хятадын үндэсний үзлийг шинэ маягаар харах шаардлагыг бий болгож байна. Тодруулбал өнөөгийн ХКН улам хятадчилагдан үндэсний үзэл нь улам гүнзгийрэх хандлага гарч байна. Хүйтэн дайн төгсгөл болж коммунизмаас түргэн салсан хятад орны хувьд хятадын үндэсний бахархлыг сэргээх үүрэг БНХАУ-д тулгамдсан зорилт болсон. Хятадын Ардын Чөлөөлөх армийн 90 жилийнхээ ойг өмнөд хөрш 2017 онд сүрлэг тэмдэглэсэн. Энэхүү арга хэмжээний үеэр Өвөр Монголын Жүрихэ буюу "Зүрх" гэдэг монгол нэртэй "Жиезе" баазад хийсэн цэргийн сүрт парад дээр Хятадын тэргүүн Си Жин үг хэлэхдээ "Өнөөдөр бид хятад үндэстнийг сэргэн мандуулах зорилгодоо хамгийн их ойртоод байна. Хятад улс өөрийн зорилгодоо хүрч, аюулгүй байдлаа хангахын тулд түүхэндээ байгаагүй хамгийн хүчирхэг армийг байгуулах хэрэгтэй. Одоо манай улсад хүчирхэг арми урьд урьдынхаас илүү хэрэгтэй байна. Манай арми халдан довтолсон бүх дайсныг ялж, үндэсний тусгаар тогтнолоо хамгаалан улс орны аюулгүй байдал, хөгжлийг хангах бүрэн чадвартай" гэж мэдэгджээ.[511] Улмаар ХКН-ын XIX их хурлын нээлт дээр тус улсын дарга Си Жинпин хэлсэн үгэндээ "Хятадын социализм байгуулах үйл явц Марксист үзэл суртлын жолоодлогоор явж ирсээр нэг намын тогтолцоо оршин тогтноход аюул заналхийлж буй шинэ эринд шилжлээ. ...Намын удирдлага дор Хятад улс шийдээгүй олон асуудлаа шийдэж, төлөвлөж байсан ч хэрэгжүүлээгүй ажлаа хэрэгжүүлж, улс, намд саад болж байсан бэрхшээл саадыг давлаа. Дорноос өрнө зүгт, умардаас өмнөд хүртэл нарны доорх бүхэн намын удирдлагад захирагдана"[522] хэмээн цохон тэмдэглэсэн нь эх оронч үзэл үндэсний үзэл болн өргөжиж байгааг тодхон харуулж байна.

Америкийн нэгдсэн улсын үндэстний үзэл АНУ бол үндэсний үзлийг хамгийн их үзэн ядагч боловч өөрөө хамгийн үндэсний үзэлтэй орон юм. Үндэсний үзлээ их гүрний эх оронч үзэл бодлогоор хэрэгжүүлдэг. Дэлхийн II дайнаас хойш дэлхий дээр АНУ нэн хүчирхэгжиж ЗХУ задарч хүйтэн дайн төгсгөл болсноос хойш бүрэн давамгайлж ирлээ. Эх оронч үзлийн далбаан дор үндэсний үзлийг агуулдаг.

Америкчууд өөрсдийн байгуулсан ардчилсан үзэл санаа, зарчим, төрийн байгуулалт, аж төрөх ёсоо давуу талтай гэж үзэн түүнийгээ бусад үндэстэнд эх оронч үзлээр дамжуулан түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой. Энэ утгаараа америкийн эх оронч үзэл интернационалч шинж чанартай. Америкийн эх оронч үзэл цаг хугацааны хувьд аажим хувьсалд орж хөгжиж ирсэн түүхтэй.

АНУ-ын эдийн засаг, цэрэг зэвсгийн тасархай ноёрхол нь эх оронч үзэлтэйгээ хослон дэлхийн тэргүүлэх гүрэн болгож хувиргалаа. Америкчуудын бүтээсэн орчин үеийн поп соёлын урьд хожид үзэгдээгүй түрлэг давалгаа орж ирж дэлхий дахиныг хошуурууллав. 2001 оны дараахь терроризмын эсрэг дайн америкийн эх оронч үзлийн шинэ үе шат болж байна. "Эх оронч үзлийн хууль" гарч, дэлхийн халуун цэгүүдэд эх оронч үзлийн төлөө цуст дайн

[51] [1] Z indaa.mn. 2017 оны 08 сарын 02

[52] [2] News.MN .news.mn/r/513035/

мөргөлдөөн үргэлжилж байна.

Америкийн үзэл санаа, эдийн засгийн хүч чадлын давуу талыг бусад үндэстний үзэл санаа, соёл иргэншлүүд тэр бүр хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж эхэлсэн цаг үед бид аж төрж байна. Америкийн эх оронч үзлийг нийгмийн хөрөнгө чинээний анги бүлгүүд бараг ижил хэмжээнд хүлээн зөвшөөрдөг тул ангийн биш шинжтэй гэж үздэг. Гэхдээ нийгмийн анги бүлгийн орлого буурах тусам илүү хүчтэй байдаг. Дээд ангийн олигарх хэсэг нь илүү либерал бөгөөд эх оронч үзэл багатай байдгийг америкийн философич Хантингтон ажиглаж шүүмжилсэн байдаг. Америкийн эх оронч үзэл илүү хувь хүний шинж чанартай байдаг бөгөөд хувь хүмүүс өөрсдөө санхүүжүүлдэг гэсэн онцлог гэж үздэг.

АНУ-ын төрийн хувьд дотоодоо эх оронч үзлийг шууд санхүүжүүлдэггүй ч дэлхий даяар НҮБ, дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагаар дамжуулан санхүүжүүлдэг. Эх оронч үзлийг өмнөх түүх уламжлалтайгаа бус харин ирээдүйтэй холбож үздэг нь америкийн эх оронч үзлийн нэг онцлог шинж чанар.

АНУ-ын конгресс 2001 оны эмгэнэлт үйл явдлын дараа "Эх оронч үзлийн тухай" хуулийг 10 сарын 25-нд түр хугацаагаар батлан гаргаж, алан хядагчидтай тэмцэх зорилгоор цагдаа, тусгай албадын иргэдийн утас чагнах, өвчтөний түүх, номын сангаар үйлчлүүлэгчдийн талаар мэдээлэл авах эрхийг өргөжүүлсэн. Гэсэн хэдий ч энэ үйлдэл нь АНУ-ын оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй, харин ч иргэдийн эрх чөлөөг хязгаарласан хэмээн хүний эрхийг хамгаалагч, сөрөг хүчний эсэргүүцэлтэй тулгарсан.

Дөрөв. Монголчуудын эх оронч сэтгэлгээ.

Эх оронч үзэл гэдэг хийсвэр ойлголт бус. Туурга тусгаар улс, ард түмнийхээ эрх чөлөө, аж амьдралын сайн сайхны төлөө үе үеийн баатарлаг зоригт хүмүүсийн итгэл үнэмшлийн үр дүн болохыг баталж байна.

Манжийн хаант улсад дарлагдаж байх үедээ үндэсний тусгаар тогтнолоо сэргээхийн төлөөх 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 он Ардын хувьсгал, 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, МАХН-ын зөв мэргэн удирдлага дор ЗХУ-ын "ахан дүүгийн харилцаа"-нд түшиглэн пролетарийн интернационализмд үнэнч байж, социализм нийгэм байгуулахын төлөөх нөр их хөдөлмөр тэмцэл эх оронч үзлийн тод томруун илрэл байсан болохыг үгүйсгэхийн аргагүй юм.

Улмаар 1921 оны Ардын хувьсгал ялалтын үр дүнд ардын ардчилсан буюу социалист эх орон бий болж, түүний 70 шахам жил улс орон хөгжиж ирсэн. Тухайн үед МАХН-ын XV их хурлаас баталсан МАХН-ын программд: «Социалист эх оронч үзэл, пролетарийн интернационализм хоёрын салшгүй холбоо нэгдэлтэй байдгийг баримтлан, хөдөлмөрчдийг өөрийн эх орон, Зөвлөлт Холбоот Улс, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронд хязгааргүй үнэнч, хайртай байх үзлээр, хөрөнгөтний харгис үзэл суртлын нөлөөний эсрэг, марксизм-ленинизмд харш үзэл санааны эсрэг

шийдвэртэй тэмцэх үзлээр, олон улсын ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, орон бүхний хөдөлмөрчидтэй эв санааны нэгдэлтэй байх үзлээр хүмүүжүүлнэ»[531] гэж заасан нь ард түмний эх оронч үзлийн эх булаг байсан.

Улмаар МАХН-ын XVII их хуралд Ю. Цэдэнбалын тавьсан илтгэлдээ: "...нийгмийн тусын тулд цуцалтгүй хөдөлмөрлөх, хүн бүр социалист эх орноо хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, империализм харгис хүчний аюул заналаас социалист ололтоо хамгаалахад гуйвалтгүй бэлэн байх, социалист нийгмийн гишүүд хаана хэзээ боловч үндсэрхэх үзэл, зөвлөлтийн эсрэг үзэлтэй эвлэршгүй тэмцэгч байх зэрэг үндсэн бүх асуудал бол хөдөлмөрчдийн социалист эх оронч үзлийн хүмүүжлийн салшгүй бүрэлдхүүн хэсэг мөн"[542] гэсэн шинэ зорилт нь ард түмний итгэл үнэмшил болж байсан. Энэхүү түүхэн үйл явцаас үзэхэд эх орны тухай ойлголтын тодорхойлогч гол хүчин зүйл нь байгаль, газар зүйн орчин, үндэсний хэл төдий бус, харин тухайн улсын газар нутаг дээр тогтнож байсан нийгэм, төрийн байгууламж, тухайн ард түмний амьдралын хэв маягтай салшгүй холбоотой болохыг баталж байна.

Шинэ цагийн Үндсэн хуулиар даяар олноо зарлан тунхаглагдсан "...Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго" өнөөгийн Монголчуудын эх оронч үзлийн хууль эрх зүйн эх үндэс, "...улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх" нь[553] гол арга зам нь болж байна.

Ардын багш, Гавьяат хуульч Б.Чимид "Үндсэн хуулийн, төрийн, ард түмний идеал гэж гаргаж ирэх ёстой. Идеал гэж Грек гаралтай, Францаар дамжсан үг.Утгачилбал, туйлын хүслэн гэж хэлж болох юм.Өмнө нь монголчууд социализм, коммунизм байгуулна гэсэн тэмүүлэлтэй байсан.Одоо олон ургальч үзэл гээд хүн бүрийн нэгдэх үзэл санаа, хүслэнгүй болчихсон хэрэг үү гэвэл тийм биш.Үндсэн хуулийн үзэл санаа бол тэр нэгтгэгч хүчин зүйл нь мөн. Үүнийг Үндсэн хуулийн нэг чиг үүрэг функц гэж ярьдаг.Тэрхүү чиг үүргээс хүмүүжүүлэх үүргийг онцгой байранд авч үзмээр санагдах болж, ахад нь. Газар, мал гэж хашгирах төдийг эх оронч гэдэг бус, харин өнгөрснөө дүгнэж, өнөөгөө байгуулж, ирээдүйгээ зөв төсөөлж буй тэр хүмүүсийг эх оронч гэж болно. Эрх зүйн өндөр соёлтой орны гол шүтээн нь Үндсэн хууль байдаг юм." гэсэн сургамжийг амьдралд хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.[561]

Улмаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга мөрийн хөтөлбөртөө "Мянганаар өртөөлсөн Монгол үндэстний төрт ёс, түүх соёл, язгуур

[53] [1] МАХН-ын программ. УБ.1966 он. 16дахь тал

[54] [2] Ю.Цэдэнбал.МАХН-ын XYII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. УБ.1976 он.

[55] [3] Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он.

[56] [1] "Зууны мэдээ" сонин. 2002.1.13.

уламжлал, орчин цагийн ололт амжилт, өрнөх ирээдүйн их хүслийн гурван цагийн хэлхээнд орших эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт халдашгүй дархан байдал, ардчилал, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж хөгжин бадарсан "ХҮЧИРХЭГ МОНГОЛ УЛС"-ыг цогцлоох Эх оронч Ерөнхийлөгч байна" гээд "Эв нэгдлийг эрхэмлэж, үндэсний эрх ашиг, эрх чөлөө, шударга ёсыг сахин хамгаалж, иргэнээ дээдлэх, эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлэх, экологийн тэнцвэрийг хангаж, газар нутгаа хамгаалах" хэмээн тунхагласан нь ард түмний итгэл найдвар, эх оронч үзлийг бадрааж байна.

Дүгнэлт.

Эх оронч үзэл бол тодорхой газар нутаг, эдийн засгийн болон соёлын нийтлэг, түүхийн уламжлал, зан сэтгэцийн онцлогтойгоор холбогдсон тодорхой ард түмэн, хүмүүсээс эх орноо хайрлах сэтгэлгээ учраас тэр нь үндэстний хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой бөгөөд улс үндэстэн төлөвшихийн хирээр эх оронч үзлийн тухай ойлголт улам бүр тодорхой, эмх цэгцтэй үзэл санаа болж төрийн бодлого болон хөгждөг байна. Хүмүүний эх орноо гэсэн үзэл нийгмийн ухамсрын бие даасан тодорхой хэлбэр төдийгүй улс төр, ёс суртахуун, гоо зүй, эрхийн ухамсрын хэлбэрээр тодорхой илрэн харагддаг байна. Түүний улс төрийн тал нь гол төлөв нийгмийн гишүүдээс нийгэм төрийн байгууллагыг дээдлэн хүндэтгэх, гоо сайхны тал нь төрөлх нутгийн байгалийг сайхныг болон үндэстний соёлын сайн сайхан зүйлийг нандигнан хайрлах бодит үйлээр илэрдэг байна.

Ард олондоо эх оронч үзлийн тухай онолын ухамсар суулгаж, амьдралд бодит үйл хэрэг болгох нь урсгалаар биш тодорхой субъектээс зохион явуулах улс төр, хүмүүжил, соёл гэгээрүүлэх урт хугацааны зорилго чиглэлтэй, иж бүрэн, системтэй ажлын үр дүнд бий болдог гэдгийг амьдрал харуулж байна.

ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГЭЛ ЗҮЙ БА ОЮУН УХААНЫ ТУХАЙ

Б. Эрдэнэ-Очир.
Боловсрол судлалын ухааны доктор, дэд профессор.

Танин мэдэхүйн сэтгэл зүй ба оюун ухааны тухай хөгжлийн талаар судалсан эрдэмтдийн онолыг судалж, өөрийн бодлоо дэвшүүлж харьцуулан дүгнэлт гаргаж, амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг сурталчилах, бүх нийтийн хүртээл болгох болно.

Ардчилал, шинэчлэлийн үр дүнд оюун ухааны хөгжил, сэтгэцийн дэвшлийн асар том өөрчлөлт гарч, сайн сайхан үйлсэд хүч чадлаа сорих бололцоо нээгдсэн билээ. Аз жаргалтай амьдралын утга учир нь аливаа зүйлсүүдийг танин мэдэх, оюун ухааны цар хүрээ боломжоо хөгжүүлж, сайн сайхан бүхнийг цогцлон бүтээж, амжилтанд хүрэхэд хувь хүний бүтээлч сэтгэлгээ, сэтгэцийн үйлдлүүд, мэдлэг, чадвар, дадлага, боловсролоос ихээхэн хамаардаг билээ. "Танин мэдэхүйн үйл ажиллагаа", "Оюун ухааны хөгжлийг онцлог" зэрэг асуудлууд судлаачдын анхаарлыг татсаар л байна.

а) ***Танин мэдэхүйн сэтгэлзүй***

XX-р зууны сүүлчээр биологийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, дэвшил гарснаараа танин мэдэхүйн үйл ажиллагаа ба сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл судлалын салбар үүсэж, бие даасан шинжлэх ухаан болох боломжтой болсон юм. Танин мэдэхүйн сэтгэл судлаачид "Учир шалтгааныг мэдэх гэдэг нь мэдлэг олж авах, мэдээлэл боловсруулах үйл явц юм" гэж тодорхойлсон байдаг. Жишээлбэл:

- ОХУ-ын судлаач Лев Вычайский нийгмийн болон соёлын явцыг хамарсан "Танин мэдэхүйн хөгжил" хэмээх онолыг боловсруулсан юм. /1920 он/
- АНУ-ын эрдэмтэн Альберт Бандура "Нийгмийн суралцах онол"-оо дэвшүүлсэн юм. /1977 он/
- Акрон Бек танин мэдэхүйн сэтгэл судлалд эмчилгээний аргуудыг хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байв.

Шинээр гарч ирсэн танин мэдэхүйн онолууд нь нийгмийн сэтгэл судлалд маш их нөлөө үзүүлсэн юм.

Хүн өөрийг нь хүрээлэн буй орчны юмс үзэгдлийн онцлог, шинж чанарыг таньж мэдэж авдаг. Танин мэдэхүйн үйл ажиллагаа нь юмс үзэгдлийн мөн чанар, харилцаа, холбоог нээн илрүүлж, бодит байдлыг шууд ба шууд бус замаар таниж, дүгнэн, нэгтгэж тусгасан тусгалын үр дүнд явагдана. Байгалийн тухай үнэн, зөв мэдлэг нь гагцхүү хүний сэтгэхүйн үйлдлийн туслалцаатайгаар явагдах нь маш чухал юм.

Хүний сэтгэцийн хийсвэрлэл, бодол санаа нь хүрээлэн буй ертөнцийг танин мэдэх логик аргачлалд тулгуурласан байдаг гэж өрнийн шинжлэх ухаан үздэг. Танин мэдэхүй нь мэдлэг олж авах, мэдээллийг боловсруулах үйл явц юм. Энэ үйл явцад суралцагчдад удирдан чиглүүлсэн, дэмжин урамшуулсан үйлдэл хэрэгтэй бөгөөд эрдэмтэн Бруслер үүнийг багшийн үүрэг хэмээн үзсэн байна.

Сурагчдийн сурах үйл ажиллагаа нь багшийн шууд удирдлаган дор явагдана.

Багш, сурагчдын хамтарсан идэвхтэй үйл ажиллагааг сургалт гэнэ. Суралцах үйл ажиллагааны үр дүнд мэдлэг, чадвар, дадлагатай болж, сурагчдын бие даасан, бүтээлч үйл ажиллагаа ба сэтгэхүй хөгжиж, мэдлэгийн сан арвижиж, боловсролтой болно.

Мэдлэг, чадвар, эв дүй, хөгжил, хүмүүжил, дадлага, сургалтын цогц байдлыг боловсрол гэнэ. Суралцагчид боловсролыг ерөнхийд нь 2 байдлаар хүлээн авч эзэмшдэг байна. Үүнд:

1. Сургуулийн танхимд багш нараар хичээл заалгаж (танхимийн сургалтын маш олон янзын хэлбэр байдаг) боловсролыг эзэмшдэг.
2. Өдөр тутмын үйл ажиллагаанаас бие даан суралцаж, амьдралын боловсролыг олдог.

Хүмүүсийн гаргаж буй үйлдэл, ярьж буй үг бүрийг анхааралтай ажиглан сонсож, дотроо тунгаан, түүнээс санаа сэдэл авч байх нь маш чухал ач холбогдолтой.

в). Оюун ухааны тухай

XVII-р зууны үед биологи, сэтгэл судлалын шинжлэх ухааны хөгжилд шинэ үе нээгдэж, шинжлэх ухааны хөгжилд сэтгэц, ухамсрын хөгжлийг үзэх үзлийн талаар үндсэн эргэлт гаргасан юм. Үүнд:

- Францын эрдэмтэн Рене Декарт хүний сэтгэцийн мөн чанар, түүний үүсэж буй зүй тогтлын тухай анхны материаллаг онолыг боловсруулсан.
- Английн философич, сурган хүмүүжүүлэгч Джон Локк анхны туршилтын сэтгэлзүйн онол (Эмпиризм)-ын үндэслэлийг боловсруулжээ.
- ОХУ-ын социологич И.М.Сеченев хүний сэтгэц, ухамсар үүсэж, хөгжих зүй тогтлыг тайлбарлаж, сэтгэцийн үзэгдэл нь амьд биеийг хүрээлэн байгаа гадаад орчны тусгал болохыг баталсан юм.
- ЗХУ-ын физиологич И.П.Павловын тархины гадаргуунд бүрэлдэх мэдрэлийн түр холбоос ба дохионы I, II-р системийн тухай онолууд нь онцгой үүрэг гүйцэтгэсэн юм.

Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь физиологийн шинжлэх ухааны онол ба нээлт дээр тулгуурлаж, хүний сэтгэл, ухамсрын асуудлуудыг жинхэнэ үнэн, зөвөөр тайлбарлаж чадсан билээ.

Сэтгэц нь тархины үйл ажиллагааны илрэл юм. Сэтгэцийн тусгал нь хүн ба гадаад орчны хоорондын харилцаа холбоог илэрхийлсэн идэвхтэй үйл ажиллагаа юм. Сэтгэц нь хүний гадаад үйл ажиллагааг зохицуулахаас гадна дотоод эрхтэн, эд, эсүүдэд нөлөө үзүүлдэг. Ийм учраас хүний сэтгэцийн байдлаас түүний ажлын амжилт, биеийн эрүүл мэнд, хөгшрөх зэрэг үзэгдлүүд шууд шалтгаална. Сэтгэц нь оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөнийн үйл ажиллагааг өөртөө багтаадаг.

Сэтгэл судлаач нар "Эрч хүч" хэмээх ойлголтыг авч үздэг. Энэ нэр томьёо нь "Сэтгэлийн хөдөлгөөн бол хүний сэтгэл, санаа, бодол, оюун ухаан мөн болно" гэж нотлодог байна.

Хувь хүн бусдаасаа ялгарч байдаг нэгэн хүчин зүйл нь оюун ухаан билээ. Оюун ухаан нь хүрээлэн буй орчноосоо хамаарахаасаа илүү удамшиж ирдэг шинж чанартай гэж үздэг. Мөн сэтгэн бодох чадвар, сэтгэцийн байдал, танин мэдэх үйл ажиллагааны үйлдлийн үе шатны сэдэлжүүлэлтийн агуулгаар тодорхойлогдоно. Ямар нэгэн зүйлийг ажиглах, сонирхох,

турших, эргэцүүлэн бодох, харьцуулан жиших үйл ажиллагаа нь оюун ухааны шавхагдашгүй эх булгууд юм. Тэдгээрийг ашиглах боломж хүн бүрт нээлттэй бөгөөд тэгш заяагдсан байдаг.

Хүн оюун ухааны чадавхжуулсны хүчээр өөрийнхөө сэтгэл санааг өөрчлөх тал дээр ихээхэн амжилт гаргаж болдог. Хүн оюун санааныхаа тогтвортой байдлыг барьж сурах нь маш чухал бөгөөд энэрэнгүй, хүнлэг зан чанар бүрэлдэн тогтоно. Энэ нь оюун ухааны суурь хэмээх оюунлаг байдлын нэгэн түвшин билээ. Бид өөрсдийн дотоод мөн чанарыг нээж, гэгээрэх үзлийг төлөвшүүлж, бодь сэтгэлийн замаа олох хэрэгтэй. Түүнийг олсны хүчинд өөрийн амьдралын баяр баясгаланг нээдэг.

Шинжлэх ухааны үүднээс үзэхэд хүн өөрийн хүрээлэн буй орчныг таньж мэдэн, хөгжүүлсэнтэй адилаар дотоод сэтгэлээ ч мөн хөгжүүлсэн бол өнөөдөр гайхамшигтай оюун ухаантай болсон байх учиртай. Хүн өөрийгөө байнга сэдэлжүүлж, сэтгэн бодож, танин мэдэх боломжуудаа хөгжүүлэхийн тулд тогтмол хичээллэх шаардлагатай байдаг. Оюун ухааная хөгжүүлж, ашиглахын тулд бүх анхаарлаа төвлөрүүлж, үр бүтээлтэй ажиллаж сурах нь чухал ач холбогдолтой.

Хорвоо дэлхий дээр хүн болж төрнө гэдэг хосгүй их хувь тавилан билээ. Эд эрхтэн бүтэн хэдий ч сэтгэл гутралаа ялан дийлж чадалгүй, аз жаргалгүй амьдарч байгаа хүн цөөнгүй буй атал эд эрхтэн дутуу боловч түүнийгээ ялан дийлж, аз жаргалаа олж, хүсэл мөрөөдөлдөө хүрч, сэтгэлийн тэнхээтэй байсны ачаар өөрийгөө аварч чадаж байгаа хүмүүс ч олон байна. Жишээлбэл:

Гаргүй гитарчин: Нялх хүүхэд хөлд орохдоо олон удаа унаж, тусан эргэж босч байж анхны алхмаа хийдэг. Харин энэ хүүхэд төрөлхийн гаргүй учир унах үедээ нүүрээрээ газар унадаг. Энэ бол түүний зовлонгийн эхлэл байв. Гэвч тэрээр өөрийн бүх зовлонг даван гарч, алсдаа гитарчин болсон байдаг. Тони өөрийн хөлийн хуруугаараа гитар хөгжим сурахын тулд өдөрт 7 цагийг зарцуулдаг байсан байна. Өдгөө өөрийн амьдралаараа үлгэр жишээ болж, олон хүнд урам зориг өгч байна. Тэрээр дэлхийн олон орноор аялж, өөрийн амьдралын түүхээ хуваалцдаг бөгөөд одоогоор нийт 40 гаруй орноор аялсан байна.

“Авьяаслаг Хятадууд” тэмцээний ялагч эр: Лио Вэй гэгч эрэгтэй “Авьяаслаг Хятадууд” тэмцээний тайзан дээр гарч, гайхалтай сайхан аялгуу тоглох үед үзэгчдийн нүдэнд нулимс цийлэгнэжээ. Энэ залуу “Mariage d’Amour” дууг гунигтай дуулангаа, хөлийн хуруугаараа маш чадварлагаар төгөлдөр хуур тоглож байсан аж. Тэрээр золгүй тохиолдлоор хоёр гараа алдаад жил гаруй болж байгаа боловч, тэрхүү хугацаагаа гутарч өнгөрөлгүйгээр хөлийн хуруугаараа төгөлдөр хуур тоглож сурахад зарцуулжээ. Авьяаслаг Хятадууд” тэмцээний ялагч эр Лас Вегас хотод гурван долоо хоног аялах эрхийн бичгээр шагнуулсан байна.

Гаргүй зураач: Гайхалтай сайхан уран зургуудыг гараараа биш хөлөөрөө зурсан Петер Логст хэлэхдээ “Та бүхэн гайхах хэрэггүй, миний баруун хөл яг

л та нарын баруун гар шиг чадвартай" гэсэн байна. Тэрээр 2009 онд өөрийн зургийн үзэсгэлэнгээ Лондон хотноо гаргаж байжээ. Өдгөө 48 настай энэ эр уран зураг зураад зогсохгүй, хувийн аж ахуй эрхэлж, хотынхоо залуучуудын хөлбөмбөгийн багийн дасгалжуулагчаар ажилладаг гэнэ.

Оюун ухааны үйл ажиллагаа нь хүнийг удирдан чиглүүлж чаддаг бөгөөд түүнд нөлөөлөгч олон ухагдахуун байдаг. Үүнд:

- Ухамсар
- Гүйлгээ ухаан
- Өөдрөг үзэл ба өөртөө итгэх итгэл
- Суралцах арга барил
- Өөрийгөө сэдэлжүүлэх
- Зорилго ба мөрөөдөл
- Сэтгэцийн бүх үйлдлүүд
- Бүтээлч сэтгэлгээ
- Хүмүүстэй харьцах харилцаа зэрэг болно.

Эдгээр ухагдахуунууд нь бие хүнийг чадварлаг болгон төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийнхүү хүний оюун ухаан, сэтгэлийн тэнхээ нь өөрийгөө бүрэн ухаарч, мэдрэхэд тус нэмэр болдог байна.

Дүгнэлт

Танин мэдэхүйн сэтгэл судлал нь суралцах, мэдлэг эзэмших, оюун ухаандаа туршлагыг хэрхэн хуримтлуулахыг заадаг сэтгэцийн явцыг судалдаг.

- Та оюун ухааны чадавхийг (баялгийг) зөв ашиглаж чадсанаараа богино хугацаанд амжилтад хүрч, мөрөөдлөө биелүүлж, сайн сайхан амьдрах болно.
- Хүнийг өөрчлөх цорын ганц арга нь оюун ухаан юм. Гэсэн ч хамгийн гол нууц нь хүний оюун санаа, бодол, хийх үйлдэлд оршдог.
- Таны мэдлэг, чадвар, туршлага, сурч мэдсэн зүйлсүүдийг хэн ч булааж авч чадахгүй.

Ном зүй

Б. Эрдэнэ-Очир. /Боловсрол судлалын ухааны доктор, дэд профессор/

Сурган- сэтгэлзүй, согог судалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан

"Нэг сэдэвт бүтээл ба судалгааны ажил". УБ., 2005 он.

Катерина Коллин., Ваула Гранд и др. Психологи. УБ., 2014 он.

Б. Эрдэнэ-Очир. Оюун ухааны чадавхийн онцлог. УБ., 2009 он.

ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

ХИЛ ДЭЭР БҮТЭЭСЭН "ГАЗРЫН ЗУРАГ"

Сэтгүүлч С.Уганбаяр.

Алтай таван богдын салбар уулс, түүний ай сав нутагт уулын түргэн гол, хадан хясаа, өвс мод гээд жигүүртний мөр ч үл үзэгдэм дагшин газарт гагцхүү хилчид л мөрөө үлдээдэг гэлтэй. Жинхэнэ эрийн шандас шалгахаас гадна эх орончдын сэтгэл зүтгэлийн нэгээхэн агшны дүр зургийг гагцхүү энд л буулган авч болдог байх гэж бодогдмоор. Энэ л онгон дагшин нутаг, зөвхөн хилийн зурваст амьдралынхаа 30 жилийг өнгөрөөнө гэдэг тэр бүрий хүнд тохиох тавилан биш.



Тэгвэл "Цэргийн хүн, цагаан зээр хоёр нутаггүй" гэдэг үгийг ажил үйлсээрээ няцааж амьдарсан хүн бол Хайдавын Түвшинсайхан дэд хурандаа. Ямартаа л хамт ажиллагсад, хилчид нь түүнийг **"Газрын зураг"** хэмээн нэрлэж байхав дээ. Энэ л газар нутагт 30 жил ажиллаж, ширхэг чулууг нь хүртэл таних болсон хурандаатай ярилцаж суухад эх орон, үндэсний аюулгүй байдал гэх сэтгэлийн зовнил юу юунаас илүүтэй мэдрэгдэж, бидний эх оронч сэтгэлгээ даяаршлын шуурганд аажим аажмаар алдагдаж байгааг ч сэтгэл зовнингуй өгүүлнэ лээ. Чингэхдээ "Үндэсний аюулгүй байдал хүнд байдалд орлоо, төрийн нууц хадгалах гэдэг зүйл байхгүй болж, төрийн залгамж чанар алдагджээ" хэмээсэн.

Цэргийн хүн нэг газраа 30 бүү хэл гурваас илүү жил ажилласан нь ховор учраас энэ тухай асуухад "Ажиллаж байхад өөр анги нэгтгэлд тушаал дэвшин ажиллах, гадаад, дотоодын сургуульд явах санал ирж байсан. Би залуучуудаа дэмжээд явуулах санал хэлдэг байлаа" хэмээн өгүүлнэ. Яагаад гэхээр "Хэдэн хүүхдийнхээ ирээдүйг л бодсон. Олон газар дамжин явахаар хүүхдийн сурлага, төлөвшилд нөлөөлдөг учраас татгалзаж байсан. Тэгээд ч би хилээ хамгаалах гэж сургуульд нь сурч, тангараг өргөсөн хилчин шүү дээ" гэнэ.

Энэ тухай насаараа Баян-Өлгий аймгийн боловсролын салбарт ажилласан А.Гонгор хэлэхдээ "Түвшээгийн хүүхдүүд бүгдээрээ манай сургуулиар дамжсан, сурлага хүмүүжил сайтай, спортод авьяастай хүүхдүүд дээ. Энэ бол аавынх нь нөлөө юм. Газар газар дамжсан офицерын хүүхдүүдийн сурлага, төлөвшил бас ч сайнгүй байдгийг нуугаад яахав. Харин Түвшээ бол хүүхдүүдийнхээ ирээдүй, боловсролд анхаарч нэг насаараа л

Баян-Өлгийд ажиллаж, амьдарсан хүн. Түүнээс түүн шиг шударга, ажил мэргэжилдээ үнэлэгдсэн хүн хаашаа ч дэвшээд ажиллаж болно" хэмээснээс харвал тэр яах аргагүй сайн аав, өрхийн сайн тэргүүн. Ингэж л үрсийнхээ ирээдүйн төлөө ажиллаж амьдарсан хурандаатай хөөрөлдөн суухад юу эсийг бодох сон билээ.

Ургийн хэлхээ, аавын захиас

Тэрээр өдгөөгөөс нэгэн жарны өмнө Алтайн салбар уулсын сүр бараа, тунгалаг Буянтын хөвөөнд эхээс төржээ. Орчлонд есөн хүүхэд төрүүлж өсгөсөн түүний эцэг Хайдав өөрөө 1939, 1945 оны дайнд оролцож, хил тогтоогоогүй үед хилийн асуудлаар баруун хязгаарт томилогдон ажиллаж, хятадуудтай уулзаж явсан гэдэг. Дайны дараа эцэг Хайдав Хужирбулан, Улаанхуаранд цэргийн алба хааж байгаад Баян-Өлгийн Цагаан нуурт албаа үргэлжлүүлэн хааж, тэндээсээ халагдан ирж байсан гэхээр нэгийг бодогдуулна. Харин Х.Түвшинсайхан 1978 онд аравдугаар анги төгссөн хүү, аав ээжийнхээ хайр энэрлийн тэврээс Хилийн цэргийн командын ангид сурахаар аяны дөрөө авч байв. Ийм л ачлалын элгэн дээрээс анх удаа алс явж байгаа аравдугаар ангийн хүүд Хилийн цэргийн сургууль ёстой л цоо шинэ ертөнц байсан нь ойлгомжтой.

Сургуулийн босгоор давсан хормоос эхлээд бос суу, зэрэгц команд дор, карантинд 45 хонож, суралцах хугацаандаа хугацаат цэргийн алба хаагч шиг казармд өнгөрөөсөн гэдэг. Тэр хэдийгээр хайр халамжаас эр цэргийн хатуу чанга дэглэм дор ирсэн ч эрх танхи, ажил мэддэггүй нэгэн байгаагүй. Аав нь Ховд аймгийн Ойн ангид ажиллаж, Х.Түвшинсайхан тавдугаар ангиасаа ой мод үржүүлгийн газарт өөрөө мөчир суулгацаа бэлдэн суулгах зэргээр ажиллаж хөдөлмөрийн амт, хөлсний үнэ цэнийг ойлгожээ. Дөрвөн зүг, найман зовхисоос ирсэн олон аавын хүүтэй нэгэн команд дор хоёргүй сэтгэлээр нөхөрлөж, 1981 онд дэслэгчийн мөрдөс гялалзуулсан цэл залуухан боловсон хүчин хилийн зүг хүлгийн жолоо залсан.

Аав нь түүнд "Чи тангараг өргөсөн төрийн хүн, төрдөө шударга ажиллаарай" гэдэг үгийг захидаг аж. Өдгөө тэр ч үр хүүхдүүдээ аавынхаа энэ л захиасыг уламжлан захиж ирсэн. Түүний том хүү Т.Баярхүү АТГ-т хариуцлагатай алба хашиж байгаа бол мөн нэг хүү нь удам залгаж, Хилийн цэрэгт ажиллаж байгаа гээд тангараг өргөсөн хоёр ч хүү бий.

Том хүү Т.Баярхүү "Аав маань шударга хүн, өөрийнхөө карьерыг орхиж, насаараа зах хязгаарт ажиллаж амьдарсан. Үүний хүчинд л бид дөрөв өдий зэргийн эрдэм боловсрол эзэмшин, ажиллаж амьдарч байна" хэмээн аваараа бахархангуй өгүүлнэ лээ. Түүний насны хань, дөрвөн сайхан үрийн эх Х.Оюунбилэг нэг ангид сурч байсан, Ховд нутгийн унаган хүүхэд, Украйнд Хими, механикийн сургууль төгсөж ирээд Ховд аймгийн Хүнсний комбанитад лаборант, инженерээр ажиллаж байсан намтартай. Гагцхүү хувь заяаны эрхээр 1985 онд Х.Түвшинсайхантай гэрлэж, хилчин болжээ.

Хилийн чанад үнэ цэнтэй мэргэжил эзэмшсэн ч ийнхүү нэгэн насаараа

хилчний ар гэр, сайн ээжийн үүрэг гүйцэтгэхдээ хүнсний нярав, залгагч, оёдолчин, ариун цэврийн зааварлагч, тогооч гээд хийгээгүй ажил түүнд байхгүй.

Х.Түвшинсайхан зургаан эрэгтэй, гурван эмэгтэй есөн хүүхдийн дунд нь онож төрсөн хүү. Зургаан эрэгтэй бүгдээрээ эр цэргийн алба хааж, тангараг өргөсөн бол өөртэй нь нийлээд гурван офицер бий. Түүний нэг дүү нь Хилийн цэргийн сургууль төгсөж, сүүлд Ерөнхий сайд асан П.Жасрайн бие хамгаалагчаар ажиллаж байгаад Тагнуулын газраас чөлөөнд гарчээ. Мөн хамгийн бага дүү нь Хилийн цэргийн тагнуулд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан байна. Түүний нэг ах нь насаараа сурган хүмүүжүүлэх үйлсэд зүтгэсэн багш бол, нөгөө нэг ах нь нэгэн насыг алтан шар замд өнгөрүүлсэн тээврийн жолооч. Мөн нэг эрэгтэй дүү нь жолооч гэхээр эдний удамд хоёр алтан шар замын эзэн байна. Тэгвэл том эгч нь эмч, дараагийн эгч нь барилгын салбарт ажиллаж, АИХ-ын депутаар сонгогдож явжээ. Харин аливаа удамд аль нэгэн хүүхэд нь өндөр дээдсийнхээ голомтыг сахиж үлддэг жамтай учраас хамгийн бага эмэгтэй дүү нь өндөр дээдсийнхээ голомтыг бадраан Ховддоо аж төрж байна. Ийнхүү тэдний удам судрыг цухасхан дурдахад Хайдав хэмээх эцэг үр хүүхдүүдээ хэрхэн өсгөж хүмүүжүүлсний нэгээхэн жишээ харагдана.

Боломжоос зугтсан бодгаль

Зах зээлийн нийгэмд шилжиж, "Хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж" байв. Ийм л торгон цаг үед тэрээр отрядын төвд Хилийн албаны даргаар ажиллаж байв. Тухайн цагийн хамгийн үнэ цэнтэй алба бол энэ. Ангийн захирагчаас эхлээд аймгийн дарга, эвэртэн туурайтан бүгд түүнээс шалган нэвтрэх бичиг авахаас эхлээд бүхий л зөвшөөрөл мэдэлд нь байсан хэрэг.

Алмата руу нисэх буудлын боомт, Орос руу Цагаан нуурын боомт, Хятад руу Даянгийн боомт гээд гурван боомт Х.Түвшинсайханы мэдэлд байжээ. Казакстаны нүүдэл ч ид хөвөрч байсан үе юм. Өнөөх л ноолуур, спирт, ан амьтны гаралтай бүтээгдэхүүн гээд хилээр хориотой бараа гаргах гэсэн наймаачдын урт дараалалтай цаг.

Эд хөрөнгө, мөнгө төгрөг гээд түүнд амлаагүй зүйл байгаагүй ч тэр "Би хилээ юугаар ч худалдахгүй" гээд өнөөх л төрөлх араншин, аавынхаа захиасын дагуу ажиллаж ирсэн гэдгийг алба хаагчид нь дурсдаг. Хаалттай нийгмээс чөлөөт нийгэмд хөл тавьсан энэ үед хилийн байдал ч амаргүй байв. Тувагаас малын хулгайчид, олз хайсан хятадууд, монголчуудын хууль бус наймаа гээд амаргүй үед Хилийн алба, шалган нэвтрүүлэхийн дарга гэх албыг нэр төртэй хашсан.

Гурван боомт мэдэлдээ байлгаж байгаа хүн учраас хүмүүс "Түвшинсайхан бол нууц ноёнтон, хөрөнгө, мөнгөө цааш нь нуудаг" хэмээн хардана. Гэтэл өнөөх "Нууц ноёнтон" маань цалингийн зээл авч хүүхдүүдээ сургана. Ингэхдээ "Та нарт оюуны хөрөнгө оруулалт л хийнэ. Эд хөрөнгө өвлүүлж чадахгүй" хэмээн захиж сургаж ирсэн хүн. Энэ тухай ярихдаа "Би машин авч унаад яах юм, албаны машин байна, бүх зүйл албан хүрээнд өрнөж завгүй байхад надад өөр

юу хэрэгтэй юм. Социализмын үеэс л баяжих боломж байсан ч бидэнд тийм бодлын нэгээхэн ч сүүдэр байсангүй" хэмээнэ. Би гэж ярих гавьяа дүүрэн энэ эрхэм ерөөсөө "би" гэж ярихгүй, дандаа л "бид", "манай хилчид", "манай ангийнхан", "манай заставынхан" хэмээх нь түүний даруу занг илтгэнэ.

Заставын дарга



Анир буйдхан хилийн застав Монгол Улсын тусгаар тогтнолын нэгэн том баталгаа болон эгэлхэн оршино. Х.Түвшинсайхан ийм л нэгэн үнэ цэнтэй орчин, Дэлүүний заставт орлогчоор 21-хэн настай томилогдон очсон түүхтэй. Тухайн үед гурван жилийн цэргийн албанд гадаад дотоодод их дээд сургууль, техник мэргэжлийн сургууль төгссөн номтой бол номтой, бяртай бол бяртай залуус угтан авчээ. Арга ч үгүй, 21-хэн настай залуу дэслэгчид 20 насны босго аль эрт давж ажил, амьдрал үзсэн хал цэргүүд бол нэг талын нөмөр нөөлөг. Хамгийн наад зах нь хал цэргүүд газар нутгаа сайн мэднэ, байгалийнхаа араншин, унаж буй мориныхоо зан гээд тэдэнд мэдэхгүй зүйл үгүй. Энэ үед хэдийгээр "Номыг нь үзэж, нормыг нь биелүүлсэн" ч гэлээ Заставын орлогчид тэс өөр ертөнц байсан байх. Ийнхүү эгэл боргилын туйл харагдах хэдий ч эх орны сүр хүч, эгэл ардын хувь заяаг даатган орших заставын амьдралд юу юугүй л дасаж таарна. Х.Түвшинсайхан эндээс Даянгийн заставт ажиллахаар очиход аль эрт хал үзэж, халуун чулуу долоосон туршлага бүхий офицер болчихсон байв.

Заставын даргын морь, эдлэл хэрэглэл гээд бүхий л зүйлийг цэргийн гараар бий болгоно. Цэргүүдэд чадахгүй зүйл гэж үгүй. Тэд бүхнийг өөрийн гараар, хийнэ, хийж чадахгүй, мэдэхгүй зүйл гэж тэдэнд үгүй. Мал сүргээ адуулна, онгорхой цоорхойгоо нөхнө, хилээ манана, сааль сүүгээ боловсруулна гээд юу эс мундах билээ. Гагцхүү энэ бүхнийг Заставын дарга удирдан зохицуулна. Ойр дотны нөхдийнх нь ярьж байгаагаас анзаарахад Х.Түвшинсайхан хурандаа цэргүүддээ нөмөр нөөлөг нь, хилийн ажиллагааг сайтар зохион байгуулдаг шилдэг офицер байсан гэдэг. Үүнийг гэрчлэх ганцхан жишээ дурдъя.


Наяад оны сүүлээр НАХЯ-ны орлогч сайд Ш.Арвай генерал бүх отрядуудаар гэнэтийн шалгалт хийсэн гэдэг. Энэ үед Х.Түвшинсайхан Их Жаргалантын заставт даргаар дэвшин ажиллаж байв. Гэтэл Ховдын отрядыг шалгаж байсан генерал Их Жаргалантын заставыг шалгахаар ёстой л гэнэт буучихаж. Харин Х.Түвшинсайхан даргатай Их

Жаргалантын застав улсын хэмжээнд нэгдүгээр байранд орж, заставын 10 хүнийг Унгарт аялуулж, хаалттай нийгмээс чөлөөт нийгэмд хөл тавьж байсан тухай сайхан дурсамжийг тэр өөрөө ярьсан.

Тэрээр хэдийгээр төвд төрж өссөн ч моринд эрэмгий байсан нь яах аргагүй хилчний онцлог. Тэгэхдээ "Хилийн цэргийн буянд морины сайныг эдэлсэн. Хилийн цэрэгт байхдаа одоогийн баячууд шиг явдаг байлаа" хэмээн инээмсэглэж суусан. Учир нь Заставын дарга сумын наадамд УАЗ-469 машинаа хөлөглөж, араасаа ГАЗ-66 машин дээр зочид төлөөлөгчдөө суулган дагуул нэхүүлтэй наадмын талбай дээр ирэхэд, даргын морийг дэлийг нь засаад хөнгөрүүлчихсэн хөтлөөд тосож байдаг байж. Эмээлийн ганзага, гөлөм энэ тэр бол гарын уртай цэргүүдийн бүтээл учраас бусдаас ялгарна.

Олон аавын хүүхдүүд дунд морь уяаны эрдэм өвлөн авсан цэрэг ч байх, аймаг сумын цолтой хүчтэнгүүд ч байдаг учраас заставын нэрийг сумын наадамд дуудан цоллуулж явсан өдөр цөөнгүй байсан гэдэг. Тэр ийм л дарга, ийм л хилчин явсан.

Хилийн албаны дарга



Хилийн гурван застав дамжиж ажилласан ид туршлага бүхий ахмад цолтой залууг Их Жаргалантын заставын даргаар ажиллаж байхад отрядын төв татлаа. Энэ бол нийгэм шилжиж ахуй цаг, 1991 он. Ангийн захирагч, хурандаа С.Самдандовж тушаал гаргаж, өдгөөгийн генерал, тухайн үеийн хошууч, Хилийн албаны дарга М.Заяабаатарын удирдлага дор Сургалтын офицерын алба хаших тушаал авчээ. Ийнхүү тун удалгүй туршлага бүхий офицероо хамгийн чухал алба болох Хилийн албаны даргаар томилсон байдаг. Зах зээл эхэлсэн цагаас хойш бүх боомтууд ажиллаж, энэ хэрээр эмх замбараагүй байдал үүсэж байсан цагт тушаал авч байсан хүн. Тиймээс хилийн зурвас уулын салхинд хэдэн хоног, сараар явж хил зөрчигч, хууль бус зүйлтэй тэмцдэг байсан гэдэг. Машинтай гарсан хилчид машин явах аргагүй хад асга, өндөр уулын бартаанд тулахаар машинаа орхиод мориор явна. Уулын цас нуранги, гуу жалга гээд морь явах аргагүй болохоор морио орхиод уулын цанаар явна. Ингэж л хилээ хамгаалж байв. Тэдний багт дэлхийн дээвэр Эверэстэд анх авирсан Уулын спортын мастер Н.Жуков байжээ. Хил зөрчигч барьж байцаахад Х.Түвшинсайхан орчуулна. Хилийн цэргийн командад гурван жил хятад хэл заалгасны идийг энэ үед л гаргана. Уул гэснээс Х.Түвшинсайхан хурандаа Уулын спортын зэрэгтэй аж. Зэрэг дэв байхаас ч өөр аргагүй, тэдний ажил бол байнга л 3000 метрээс өндөрт хэдэн өдөр, сараар өрнөнө.

Шилжилтийн үед цагийн байдал

ороо бусгаа, хангалт тааруу байж, майхан платкаар хилийн дайралтын хувцас хийж өмсдөг байсан тухай зүдүүхэн дурсамж ч хилчдийн амьдралд бий. Энэ тухай тэрээр "Ууланд чоно яаж амьдарна, тийм л амьдарна. Сар гаруй ууланд явна. Гэрээ мартсан гэсэр шиг явдаг байлаа. Бүсэлхийнээс доош нойтон, хаа нэг оймс, жийргээ гаргаж мушгиад явна" хэмээн идэрхэн залуугийн гал дүрэлзсэн явдлаа дурссан юм.

Гишгээд эргээд харахад мөр нь арилах их цасан шуурга, үргэлжилсэн их бороо гээд цагийн ямар ч хатууд уул хадаар гэр хийн, хилээ манаж явсан өдрүүдийн жаргал зовлонг ярьж суугаа буурал хурандаагийн харцнаас идэрхэн насных нь цог заль бадран байгааг төвөггүй харж болно. Ийнхүү аймгийн төвд штабын даргын орлогч, хилийн албаны даргын албыг 12 жил нэр төртэй хашсан хүн. Энэ хугацаанд хүүхдүүд ч Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд авч. Түүний тухай Хилийн 1 дүгээр отрядын штабын дарга асан А.Хавдсалем "Би Түвшинсайхантай 1996-2003 онд хамт ажиллаж байлаа. Тэр нэг ангид 30 жил ажилласан өвөрмөц онцлогтой офицер. Газар нутгийнхаа онцлогийг мэднэ, ямар ч ажлыг нэг эхлүүлсэн бол дуусгаж байж санаагаа амраадаг. Тэр тусмаа боомтууд нээгдсэн хилийн нэлээд амаргүй үед шалган нэвтрүүлэх албыг тэргүүлж, тэр их ачаалалтай үед зөв зохион байгуулж ажилласан. Өөрөө их шударга хүн болохоор ажил нь ч саадгүй явдаг байсан байх. Яах аргагүй манай шилдэг офицер, хилчдийн нэг байгаа юм" хэмээн мөр зэрэгцэн ажиллаж явсан нөхрөө бахдангуй дурссан. Хилийн албаны дарга заставаар байнга явна. Тэнд ажил өрнөж, амьдрал буцалж байгаа учраас алдаа оноо гарна. Х.Түвшинсайхан, Заставын дарга болон бусад алба хаагчдынхаа цалинтай нь ярьдаггүй, ухуулан учирлах замаар гэр бүлтэй нь дуудаж авчраад хувийн арга хэмжээ авдаг байсан гэдэг. Ингэхдээ "Отрядын даргад чиний энэ байдлыг илтгэхээр цалинг чинь 20 хувь хасна, чиний хүүхдүүдийн талх хасагдана" гэх зэргээр учирлан ухааруулж суудаг тухай удирдлага дор нь ажиллаж байсан офицер, алба хаагчид ярьж байсан.

Эзэн Чингисийн гэрэгэ хүртсэн хилчин

Нар хур тэгширсэн дэлгэр цагт Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн баярыг орон даяар өргөн дэлгэр тэмдэглэв. Монгол төрийн тулгын чулууг тулсан энэ түүхэн жил Х.Түвшинсайханы амьдралд нэгэн том дурсамж бахархлыг бий болгосон байдаг. Тодотговол, эзэн Чингисийн өлгий нутгаас болон Монгол Улсын дөрвөн цэгээс хөрс шорооны дээж залсан үйл явдал болов. Баруун цэг-Монгол Алтайн нурууны Тахилт уулнаас, хойд цэг-Монгол шарын даваанаас, зүүн цэг- Соёлз уулнаас, өмнө цэг-Орвог гашууны бор толгойгоос гээд дөрвөн цэгээс хөрс шорооны дээж залахад баруун цэг-Алтай нурууны Тахилт уулнаас дээж залж ирсэн хүн нь Х.Түвшинсайхан.

Тиймээс түүнд Чингисийн алтан гэрэгэ хүртээж байжээ. Арав гаруй жилийн цаана үлдсэн энэ дурсамжийг нэхэн санавал дөрвөн хонгор морь,

унасан дөрвөн хилчин Сүх жанжны талбай дээр дүрэмт хувцастай их л сүрлэг орж ирж байсан нь нүднээ харагдана.

"Ах нь уулын өндөр, усны цэнгэг, цэцгэн дунд алба хаалаа"

Олон ястны өлгий нутгаас амьдралын замаа сунгасан арван хэдтэй хүү эрдмийн аянаас 21 настайдаа жолоо сунган үндэсний цөөнх, казах түмний дунд амьдралынхаа 30 жилийг өнгөрүүлсэн. Тэрээр "Хил манаж байгаа хүн ард түмэн, орон нутгийн удирдлагуудтай ойлголцож ажиллах нь юу юунаас чухал. Гэхдээ хил орчмын айл, ард түмэн цаанаа нэг өөр, зочломтгой, эх оронч байдаг" гэж байсан. Учир иймээс Х.Түвшинсайхан нутгийн иргэдтэй яс үндэс үл харгалзан ойлголцож, сайн нөхөр нь, ах, дүү нь болж ирсэн гэдэг.

Тийм дээ ч Штабын дарга асан А.Хавдсалем "Манай Түвшээ ангидаа төдийгүй ард түмний дунд ч ихээхэн нэр хүндтэй хүн" хэмээсэн буй заа. Тэрээр "Заставаас заставын дунд холбоо барих боломжгүй, зам гэж байхгүй, зун өвс, өвөл цас харагдана, газар сайн мэдэхгүй хүн бол явалтгүй. Тийм л цаг агаар, байгалийн хатуу араншин дунд хилээр явна" гэж цээж дүүрэн өгүүлнэ лээ. Тухайн цагт ажиллаж байсан офицер, жолооч нар Х.Түвшинсайхан даргатай явах ихэд дуртай байж. Учир нь тэрээр газраа сайн мэддэг учраас цагийн ямар ч үед эрсдэлгүй туулах газраа туулдаг байсан гэдэг. Газар нутгийн онцлог, уул усны учрыг сайн мэддэг учраас нөхөд нь, алба хаагчид нь түүнийг "Газрын зураг" хэмээн нэрлэнэ. Өдгөө ч тэр ажил амьдралынхаа оргил цаг үеийг өнгөрөөсөн нутагтаа зун болгон очдог аж. Зун болохоор төрж өссөн нутаг Ховдоор дамжаад Баян-Өлгий явдаг байна. Энэ тухайгаа тэр "Хүний амьдралын 30 жил гэдэг урт хугацаа, тиймээс Баян-Өлгий бол нутгаас илүү санагдана. Зүүдэлсэн ч хилээ л зүүдлэнэ. Хэдэн тарваганы дош нь хүртэл танил. Монгол Алтайн нуруу, Хөтөн нуур, Хорго нуур гээд мундаг нуурууд бий. Байгалын сайхан, уулын өндөр, усны цэнгэг, цэцгэн дунд л алба хаалаа, ах нь" хэмээн бахархангуй өгүүлж сууна лээ. Ийм л нэг бэлтгэл хурандаа бие сэтгэл тэнүүхэн ч эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдалд сэтгэл чилээн сууна.

ХОЛЫН ХҮНИЙ ҮГИЙГ СОНСОХУЙ... ДОКТОР, ПРОФЕССОР М.ЛХАГВАСҮРЭНТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Доктор, профессор Ц.Ганболд

А. Эрхэм хурандаа таны амрыг эрье, уулзсандаа талархаж, ярилцах болсондоо олзуурхаж байна.

Х. Та бүгдийн амар амгаланг эрэн мэндчилье! Хил тайван, хязгаар амгалан, хилчид сэргэг биздээ. Би Монголын бахархалт уламжлал, дайчин нөхөрлөлийн билэгдэл "нөхөр" үеийн цэрэг малгайтай ёсолж магнайдаа хүргэн адисладаг дээдэлдэг хэвээр. Хилчидтэйгээ учрах болсон завшаандаа их талархалтай байна.

А. Нөхөр хурандаад баярлалаа. Таныг Москвад эмчлүүлэн өвөлждөг гэсэн нутагтаа ирээд тавлаг биздээ.

Х. Бие тунх, сайжирч байна. Москвад гэргий Д.Навчаа, зээ хүү Ц.Бадрангуй бид 4 жил өвөлжиж байна. Гэргий маань анх Москвад Наран уламжлалт эмнэлэгт зөвлөхөөр ирж ажилласан, одоо Цагаан дарь эмнэлэгт ажиллаж байна. Зээ маань 4 дүгээр ангид сурч би гэртээ амьдрахуйд суралцаж монгол хүний чадвар чанарыг харуулах гэзд дор бүрнээ хичээж байна. Надад тохиолдсон харвалтаас үүдэлтэй саажилт засарч, оюун ухаан ухаанд ил бие хөдөлгөөн заслаар тамиржиж шөрмөслөг бяр сэтгэхүй тэнхээний бяд дээрдэж хүч өдөр бүр л нэмэгдэж байна. Хүүг хичээлээ дуусгамагц нутаг руугаа тэмүүлдэг. Ирмэгц хөгшидийн сэтгэлийн таашаал, зээ хүүгийн монгол заншил, сэтгэц, ахуй мэдлэг дээшилнэ. Төрөлх нутаг сайхан, миний монгол хүн төрөлхтний хувь заяаг хэдэн зуунаар хөтлөн тэдний төлөөх дэвшилийг өртөөлөн авч ирсэн үлэмж манлайллын түүхийг уншиж бахархалтайгаар "Би Монгол" гээд алхаж байна.

А. Танд талархаж байна. Та алба хааж байсан тухайгаа ярина уу?

Х. Би 1969 оноос хилчин холбоочин цэрэг-офицер, хилийн застав-отрядын дарга, Х ба ДЦУЕГ-ын байлдааны бэлтгэл-хилийн /оператив/ болон тамгын хэлтэст дарга, ХЦДС-д багш-сургалтын албаны дарга-захирал, төрийн захиргааны төв байгууллагад дэд зэргийн ахлах түшмэлээр алба хааж, судлаач-эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад эрүүл мэндээс үүдэн чөлөөлөгдсөн. 1976-1980 онд ЗХУ-д М.В.Фрунзын нэрэмжит цэргийн академид суралцан төгсөөд заставын даргаас оператив-тактикийн эрэмбийн офицероор бэлтгэгдэн байлдааны бэлтгэл хэлтсийн орлогч даргаар ахлах дэслэгч цолтой томилогдон, оператив түвшинд алба хашсан. Хязгаарын цэрэгт албаа эхэлж, Хилийн цэрэгт албаа дуусгасан түүхтэй.

А. Та хүйтэн дайны ид үе гэзд онцлог үед албаа хаажээ, энэ үе цагийн байдлын ихээхэн өрнөлт,өөрчлөлттэй үе байсан шүү дээ.

Х. Алба эхлэх үед ХЦ дахин байгуулагдаж "А"-гаас эхэлж байсан үе. Офицерууд л гэхэд байлдаан тулгаралтыг биеэрээтуулсан, чөлөөндөө байсан ахмад хилчид, цэргээс дэвшин боловсрох эрмэлзлэлтэй кадр, ЗХУ-д ном үзэж, нүд тайлсан офицеруудаас

бүрдэж байв. Би дундах хэсэгт хамаарна. Отрядын дарга, хурандаа Дамдин, холбооны дарга, хошууч Очирбат, заставын дарга, хошууч Гомбо, хөрш заставын дарга, хошууч Лувсандавга зэрэг ахмадууд, Хба ДЦУЕГ-ын дарга, генерал Ш.Арвай, штабын дарга, генерал Ж.Дашдаваа, отрядын дарга Г.Хүүжий, штабын дарга Амгаа, хэлтэсийн дарга хурандаа Шажинбат гээд шинэ үеийн офицерууд, мэргэжилтнүүдээс ихийг сурч эрдмээр гангарч байлаа. Хилийн цагийн байдал өөр, Өмнөдөд улсын хилтэй (1969) боловч цэрэг-улс төрийн байдал хурцадмал, хойдод хязгаар нутгийн хил (1915.1958 оны хэлэлцээгээр тогтсон) боловч тайван байв. Хилийн застав морин цэргийн, төвийн нөөц хүч мотобуудлагын хэв загвартай. Харин хилийн застав-суман-отряд гэсэн уламжлалт гуравтын тогтолцоог ашиглаагүй өвөрмөц бүтэцтэй байв. Хилийн асуудал, хил хамгаалалтыг хилийн хэлтэс, оператив-тактикийн бэлтгэл, бэлэн байдал, Дотоодын Цэргийн хамгаалалтыг байлдааны бэлтгэл хэлтэс хариуцдаг, дарга нар нь ХЦ-ийн штабын орлогч,цол хэргэм нь хурандаа-хошууч генерал зэрэглэлтэй байв. Мөн байлдааны бэлтгэл хэлтэс нь бага даргын сургалт-арга зүй, бага мэргэжлтний мэргэжлийн бэлтгэл, жигдрэлтийн сургуулалтыг бүрэн дайчилгаатай үзүүлэх, туршилтын хэлбэрийн хээрийн сургуулалтаар явуулж онол-практикийн хувьд баталгаажуулан "хил дээр шаардагдах бүхэнд цэргийг сургах" зарчмаар явуулж байв. Мөн БХЯ-наас явуулах хил халхлалтын цугларалт, хээрийн сургуульд байлдааны бэлтгэл хэлтэс ХЦ-ээ хөтлөгч байдлаар оролцож байв. Харилцан ажиллагааг нэгдсэн бодлогоор зохицуулж байсан.

А. Уучлаарай, өнөөгийн байдалтай харьцуулан өөрийн санал бодлоо хэлнэ үү?

Х. Хувийн сэтгэгдлээ товчоор илэрхийлбэл: Миний амьдралын эрмэлзлэл бол ухаарах, ойлгох, зөв хандах, зөв үйлдэх-энэ үүднээс асуудлын учир начрыг тунгаах, үр дагаврыг төсөөлөн тооцож байхыг хичээдэг. Залуудаа бол зөвхөн үр дүнгээр төгсгөх гоомой ойлгоцтой байсандаа залуучууддаа мэдрүүлэхийг хичээдэг, ихэнх нь хүлээн авдаг, зарим нь ухвар мөчид ханддаг талтай. Ж нь: Асуудлыг шинж чанарын хүрээнд төдийгүй мөн чанарыг мэдрүүлэхээр тууштай хандахад "зөрүүд", мэтгэлцэх гэхээр "маргалаа" гэх байдал гардаг, ахмад бидний одоогийн үүрэг бол зөв ойлгуулах, таниулах, ухамсарлуулах, нөхцөл байдлын бодитод мэдрүүлэх гэж ойлгодог. Дулимаг ойлголтоос үйлдэл дутмаг болдог, үйлдэл хийсэн үр дүн байвч үр дагавар ээдрээ, хүндрэлийг авч ирдэг. Ялалт-үр дүн,түүний хэрэгжилт-үр дагавар болно. Мах голлон хэрэглэдэг үед бага иддэг, голдуу "шөлөөр цаддаг" байсан тэр үеийг ядуу байсан, одоо сайжирсан гэдэгч үр дагавар нь гоолиг охид, шөрмөслөг эрчүүд цөөрч, бүдүүн бөх, хэт мяраалаг, хөвсгөр бүсгүйчүүдтэй болсон. Энэ байдал ахуйд нөлөөлөөд зогсохгүй амьжаргааг өөрчилж, бүдүүнүүд барилга, зам гүүр, мал маллах зэрэг биеийн хүчний ажил хийх чадваргүй болж, үр дагавар нь хятад

ажилчдын хэрэгцээ зогсолтгүй өссөн. Монгол хүний үнэлэмж доошилж байгааг монгол ажил олгогч эздийн сонирхолоос харж болно.

Эдгээрийг жишээ татаж байгаа нь зөв ойлгохын ач холбогдлыг мэдрүүлэх гэсэн юм. Ардын ухаалаг хэлцэд, ойлгоцыг "яс маханд нь хүртэл" эм чөмгөнд нэвтэрч байж үр дүнд хүрэх гэх мэт. Харин өнөөгийн байдлыг ярилцлагаар бүрэн илэрхийлэх чадвар надад дутагдаж байна, гэхдээ хамтран учрыг олохыг хичээе.

Чингисийн үеийн морьт цэргийг одоо хүртэл залгамжилж байгаа гуравт суурилсан аравтын тогтолцоог хэрэглэхээ больж, үүнээс үүдэн шадар захирагч, шавь сургалт орхигдсон. Гэтэл энэ тогтолцоог дэлхийн бүх улсууд хэрэглэж байгаа ба 10 цэрэг тасаг, 30 цэрэг салаа, 100 цэрэг суман, 3 суман батальон, 3 батальон хороо, эсвэл 3 танк салаа,10 танк рот, мөн 3 онгоц звено/ салаа/, 10 онгоц эскадриль /суман/ болдог. Бид батальон, эскадриль, рот, батарей гэхээр манай гаралтай тогтолцоо биш гэж ойлгодог, гэтэл Хүннү үеийн гаралтай бүтэц, тогтолцоо "Драгунский полк"-г европын бүтэц мэт, оросууд "тюрк" үг ч гэдэг. Гэтэл эзэлсэн орноо тохинуулах гол хүчнийг "дарангуй цэрэг", түүний удирдаж даргалах гэсэн Монгол бүтэц бөгөөд тэд анх Орос болон Хятад, Перст хүн амын тооллого явуулсан, хэв журам сахиулсан, татварын системийг тогтоосон. Энэ бүтцийг Америкт эхлээд, Европчууд өөрийн хэлэнд хөрвүүлэн командир, комендант, комендант цэрэг гэснийг Монголын БХЯ хуулбарласан, өөрөөр хэлбэл төрөлх улсдаа, өөрсдөө "дарангуй цэрэг"-ийг мэдэхгүй, ЗХУ-тай хамтран ажилласан мэт үе бий. Эдгээр нь санаатай хийсэн үйлдэл биш дутмаг ойлгоц, бусдыг ягштал дууриадгийн үр дагавар гэж боддог.

А. Баярлалаа. Таныг дэмжиж байна.

Х. Чин сэтгэлийн ярилцлага сэтгэлийн дэмийг мэдрүүлж байдгаас ямагт үгүйлэгдэж байдаг. Хамт олондоо хэрэгтэй хэвээр гэж мэдэрч, мэдрүүлж сэтгэлийн тэнхээ өгдөг, хамт олныг нягтруулан албаараа, бахархах ойлголтыг батжуулдаг. Ж нь: Би ХЦ-т алба хааснаараа бахархдаг. Зөв үйлийн төлөө зөв хандаж гэдгээ мэдэрдэг. 10 дугаар анги төгссөн надад, хурандаа, цэргийн ухааны доктор, үндсэн хууль тогтоогч, цэргийн болон төрийн захиргааны хос тангарагтан, ангийн захирагч, ХЦДС-ийн багш, захирал, төрийн захиргааны төв байгууллагын ахлах түшмэл зэрэг зиндаанд алба хаах боломжийг ХЦ, хилчин хамт олон олгосныг сайтар тусгаж ойлгохыг хичээдэг. Анх АИХ-ын депутат болчихоод: "ХЦ-ийн таван ангийн захирагч депутат боллоо", би мундагчуудын эгнээд өөрийн хүчээр орж, төр барилцах боллоо гэж боддог үе байсан.Тунгаан бодвоос, 5, 6 дугаар отрядын хилийн хэсэгт баруун хилийн тулгаралт, 12 дугаар отрядын хэсэгт чөлөөлөх дайн, 5 замын байлдаан, 17 дугаар отрядын хэсгээр чөлөөлөх дайны гол хүчний ажиллагаа, 5 замын байлдаан, 24 дүгээр отрядын хэсэгт Халх голын тулаан болж хязгаар нутгийн ард иргэд ХЦ-тэй хамт хүндийг үүрч байсан, төр өөрчлөгдөж байгаа үед хамтын итгэл, зүтгэл хэвээр байгааг баталгаажуулсан сонголт

байжээ гэдгийг ойлгон хязгаар нутгийн иргэдийн сэтгэл зүйн онцлогийг мэдрэх болсон. Улсын хилийг ХЦ ганцаар бус, хязгаар нутгийн ард иргэдийн дэмээр хамтран хамгаалах жамтай, хэрэв дангаар хамгаална гэвэл суурьгүй байшин мэт хэврэг байхыг ойлгосон. Хамтын ажиллагаа өмнөт хил дээр сайн, хойт хил дээр бэхжүүлэх, иргэддээ ойлгуулах шаардлагатай гэж боддог.

Сайн гэдгийг дайн тулааны үеэр хамтран үнэлсэн, бэхжүүлэх шаардлагатай гэдгийг 1924 оноос 1980-аад он хүртэл хамгаалалтыг орхисны үр дагаварыг бодолцон хэлж байгаа юм. Улсын хил ямагт хамгаалалттай, гэхдээ хилийн нөхцөл байдлын дагуу тайван үед сахих, хурцадмал үед халдлагаас сэргийлсэн, түрэмгийллийн үед хориглон хамгаалах төрөл байна гэж ойлгодог. Үүнийг ХЦ-ийг дахин байгуулах үед улсын өмнөд хилийг аюул халдлагаас сэргийлэн хамгаалах зайлшгүй байсан, үүнээс өөр төрөл байхгүй мэт ойлгох /ЗХУ-ОХУ-тай жиших/ хандлага байдаг.

Орос Улс холбооны бүтэцтэй, тэдгээрийг нэгтгэсэн гүрэн бөгөөд ерөнхийлөгчийн засаглалтай, 1917 оноос хойш одоо ч гэсэн хил дээр, хилийн гадна, нутаг дээрээ дайн, байлдааныг явуулж байсан, одоо ч хэвээр зэргийг хамгалзах сэргийлэн хамгаалалт нь зайлшгүй нөхцөл гэж боддог. Манай улс одоо ХЦ-ийг дахин байгуулах үеийн нөхцөлтэй биш, 1950-аад оны дэглэм сахиулах бус, мэргэжлийн цэргийн хүчээр улсын хилээ байнга сахин хамгаалах асуудал мөнхийн ашиг сонирхол болох учиртайг гүнээ ойлгох шаардлагатай. Монгол Улс цагдаагаар хэв журамд хяналт тавиулдаг, цагдаа суурьшмал нөхцөлд зохицсон бүтэцтэй нэгж болохын хувьд хил хязгаарт ХЦ-тэй хамтран ажиллах нь дөхөмтэй болохоо 1953 оны үеийн хилийн нөхцөл байдал харуулсан гэж дүгнэдэг.

А. Та "Гуравт", "Аравт"-ын тогтолцоо хүн төрлөхтний түүхэн дэх ихэд алдаршсан бүтэц гэсэн. Одоо ХЦ-т ашиглахгүй байгаагийн шалтгаан нь юу бол?

Х. ХХБ 1933 оны өмнө өөр, 1933-1953 он хүртэл 3-тын тогтолцоотой, 1967 оноос дахин байгуулахдаа салбарын бүтэц 3-тын тогтолцоотой, хилийн застав, морьт отрядын нөөц хүч мотомеханикжсан холимог бүтэцтэй байсан. ХЦ хамгийн хүнд үеийг 3-тын тогтолцоогоор гэтэлсэн, холимог бүтцийн эцэслэн шалгах дарь үнэртсэн хэрэг явдал гараагүй, харуулын бүтцийг Увс-Тувагийн хэсэгт шалгуурт өртөн эцэслэн хэлэх битгий хэл, явцын судалгаа хийгдээгүй байгаа.

Өмнөд хилд Хойт Солонгосын иргэд хил зөрчин ирэх үед харуул, харуулын байр гол чиг баримжаа болж байсан. Хил манах ажиллагаа илт байж болно (Энхийг сахиулах гэх мэт), харин сэргийлэн хамгаалах үед зайлшгүй нууцлаг байх ёстой. Хүн бүх юмаа дэлгээд байдаггүй, нуух хаах, сэрэмжлэх, сэргэг байх зэргээр амьдрах чадвараа хадгалдаг. Отряд, заставын бүтэц шууд бүлэглэл байдаг. Отряд заставаас, застав ээлжлэн солигдох харуулаас бүрдэх бүтэцтэй. Харин "3-тын тогтолцоо 1.2.3-ыг нэг бүлэгт багтаан, удирдлагыг төвд

нь байрлуулдаг. 1 баруун гарыг, 2 зүүн гарыг, 3 төвд байрлах ба тэнд байрлаж буй суман, түүний нөөц хүчний хамт байрлах суманг "товчлон удирдах" хэмээн нэрлэж байсан. Өөрөөр хэлбэл, отряд-суман-застав-тасаг гэсэн шаталсан эрэмбэтэй байв. Удирдлагын энэ товчлол үр дүнгээ өгч, цаг алдалгүй асуудлыг шийдэх боломжийг морин уналгатай үед бүрэн олгож байсан. Одоогийн застав даргад шууд удирдагдсан офицер, ахлагч, цэргүүдээс бүрдэж байна. Хилийн харууулд гарсан үед л манааны ахлагч, харуулын дарга учир захирагдаж байна. Харуулын дарга, манааны ахлагч шадар дарга биш харуул, манааг хил хамгаалах дүрмийн дагуу удирдаж байгаа хилчид, эд нар застав дээр ирээд л цэргийн дүрмийн дагуух ахлах цолтон, байлдагчийн албан хаагч харьцаа үүсдэг. Бүрэлдэхүүн цөөн учир заставын дарга бүгдэд хүрч байгаа. Бүх шатны шалгалт нэг бүрийн анхан шатны сургалтаар явагддаг учир шадар дарга, цэргийн сургалт (тасаг,салбарын жигдрэлт) хэрэггүй мэт байдаг. Үүнд ойлголт дасаж буй нь гол эмзэглэл. ХЦ нь бэлэн байдлын удирдамжтай мөрддөг байсныг цаг тайвширлаа, шаардлагатай цаг үед нь мөрдөнө гээд, зөвхөн тайван үеийн албаны удирдамжийг мөрдүүлсэн. Шаардлагатай үед мөрдөх удирдамж (ХХБ,ХО-ын) архивт шилжсэн, хэрэгтэй үед архиваас авч шуудангаар хүргэх юм байх. Монголын төр ХЦ-ийн тайван болон байлдааны үеийн ажиллагааг хилийн хуульд мөрдөхөөр, дүрмээр хэрэгжүүлэхээр зарилагдсан хэвээр байна.1990 оны УАХЕГ-т байсан ХЦ-ийн удирдлагаас эхтэй товчлол үргэлжилсээр, үр дагавар нь ХЦ биш цагдаа байж болно гэсэн ойлголтыг бий болгоод байгаа нь бүр эмгэнэлтэй. Одоо 3-тын бүтэц, товчлох салбар нь нэн зохимжтой гэж боддог. 1.2.3 застав дээр 2-3 офицер,1 ахлагч,10 цэрэг нэмэхэд л бидний хил хамгаалах чадварыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ. Нөөц хүчээ мэрэгшүүлэх, сургах, дадлагажуулах боломжтой учир нь өөр бүр хамгаалалтанд гарахгүй, улиралд нэг удаа заставууд дээр ээлжлэн (заставт 10 хоног) баруун, зүүн харуулд гарч нөхцөл байдал, газар орноо судална. Дадлагын үед застав бүрэн бүрэлдэхүүнээрээ застав дээр цугларч сургалт, жигдрэлт хийх боломжтой болно. 3 хоног нэг бүрийн, 3 хоног тасаг, харуулын, 3 хоног салбарын жигдрэлтийг хийн нэг хоногт үр дүнгээ ярих боломжтой. Энэ аргаар дараагийн удирдлагыг амжилтаар гэтлэх сэтгэл зүйн болон бие бялдрын бэлтгэлтэй болно. Би зөвхөн эдлэж болох боломжийг ярилаа. Үр дүнг хэлээгүй, үр дагавар сайн гарна гэж итгэж байна. Учир нь: Хилийн хэсэг дээр, бодит газар орон дээр үүргээ хүлээсэн хилчид суралцах, мэргэжилтны сургалтанд хамрагдахын буруу гэж юу байхав, хилд санаа зовох юмгүй нэг эрэмбэ дээгүүр салбар биечлэн хариуцаж байгаа тул бие бүрэлдэхүүнээрээ чанарын хувьд ахицтай байх учиртай, судлах, турших, хэрэгжүүлэх "инноваци", үүний адилаар ХЦ-т оператив сургалт байгаа эсэх, оператив бэлтгэлийг операци гээд ....

А. Бидний ярилцлага их сонирхолтой, авууштай, бодмоор

асуудлуудыг хөндөж байгаад талархаж байна.

Х. Чамд их талархаж байна. Ихэнх сурвалжлагуудыг ажиж байхад "асуулт тавиад, өөрийн бодлогыг тайлбарлаад л баахан ярьсны дараа таны бодол" гэдэг, хариулт нь "тийм эсвэл үгүй" гэхээс өөр боломж гаргахгүйгээр хөтлөж байдаг. Чи арга барил өөр, ухаарал, хүндлэлийг хослуулан, бодлоо уудлах дэм өгч байгааг хүндэтгэж, зөрөх бус зөв ярихыг эрмэлзэж байна.

А. Та торгон болон шадар цэрэг, хишигтэн алба зэрэг цэргийн онцлог уламжлалыг дурьдсан, ойлголтоо тодруулах, баталгаажуулах үүднээс лавлаж байна.

Х. Онцлог уламжлал гэж зөв өгүүллээ. Одоо уламжлал л болж, уг нь бүтээлчээр хэрэглэхүйц, түүхэн, бүх улс орон хүлээн зөвшөөрч хэрэглэсэн, хэрэглэж байгаа хэллэг, нэр томьёо шүү дээ. Торгон цэрэг гэж шугамын буюу дайн байлдаанд түрүүлэн, манлайлан ордог дайчдыг хэлдэг. Одоо бол ерөнхий цэргийг хэлж болно. Ерөнхийлдэг бус ямарч үүргийг гүйцэтгэх чадвартай, нийтлэг чадамжтай, өөрийгөө хамгаалах (гадаад биш дотоод үүрэгтэй) цэрэг. Толгойн сэргийлэхэд явдаг сэргэг дайчдыг хэрээ цэрэг гэдэг байсан ба Орос, Европт гусарь-галуу цэрэг хэмээдэг. Хаанаа, төрийн өргөөг хамгаалдаг цэргийг шадар цэрэг гэдэг, А.Дюма " Шадар гурван цэрэг" гэдэг гайхалтай ном бичсэн билээ. Тэдний гүйцэтгэж буй албыг "хишигтний алба" гэдэг. Шадар цэрэг албанд гармагц хишигтэн болж онцгой эрх эдэлдэг. Чингис хаан хишигтний эрх үүргийг онцолж байсан болохоос бүх шадар цэргүүдийг тийм онцгой эрхээр хангаагүй гэж бас ойлгогддог. Одоо хуулиар хилийн манаа, цагийн манаач зэрэг үүрэг гүйцэтгэгчид зэвсэг хэрэглэх эрхийг олгож байгаа нь уламжлагдсан эрх юм. Монгол Улс Манжид дагаар орсон үеэс цэрэг-захиргааны засаглал өөрчлөгдөн цэрэг байхгүй болгосноор шадар цэргийг мартсан, мартуулсан. Одоо шадар сайд гэж захиргааны чиглэлээр үлдсэн. Хишигтэний албыг төрийн тусгай хамгаалалт гээд төрөө хамгаалж байгаа юм уу төр тусгай хамгаалалт эрхлээд байгаа юм уу, цэрэг үү, тагнуул уу гэдгийг тодорхой болгомоор. Төрийн бодлогыг улсын хил дээр хамгаалах шаардлага үүссэн. Хаант Оросын үе "козак" хасаг цэрэг хаанаа, төрийн ордноо, хилээ хамгаалж байсан уламжлал Монголоос, Алтан ордоос эхтэй. "Казак" нэршил хишиг, хишигтнээс улбаатай. /хишиг-хасаг-казак-козак-кезик/. Дараа нь ХЦ байгаад одоо тагнуулын арга хэмжээг голлох болсноор тагнуулын байгууллагын асуудал хурцадсан үед арми, үндэсний гвард цохилтын гол хүч болох байдал харагдаж байна. Монгол Улс энэ уламжлалт нэршлийг хэрэглэх боломжтой төдийгүй шаардлагатай. Одоо бид Орост хэрэглэхээ болсон отряд, заставыг хэрэглээд байгаа. Мода Монголоор гэдэг, ядахдаа төрийн алба минь монголжих хэрэгтэй, шаардлагатай. ХЦ, ЕЗЦ гэхээр ХЦ нь алслагдсан, ЕЗЦ нь ерөнхий маягын байдлаар тусдаг. Шадар цэрэг гэвэл төрдөө ойр, шадарласан торгон гэвэл шаардлага гарсан үед хутганы ир мэт байж, хэн, хэзээ, ямар эрэмбэтэй

байгааг шууд илэрхийлнэ. Энэ миний бодол, гаргалгаа. Асуудлыг зөв ойлгох шаардлагатай.

а/. Хуулинд "хилийн тусгай анги" гэж эрэмбэ заасан заалттай байсан, хэрэглэдэггүй байсан, зөвлөхөөр хэрэглэхдээ үндсэн үүрэг гүйцэтгэж буй болон түүнд үйлчилдэг ангиуд нэг зиндаанд тавьсан. Үндсэн үүрэг гүйцэтгэж байгаа, үйлчлэх ангитай ижил болгосноор хангалтын ангиуд очих сонирхолгүй командын мэргэжилтнүүд очих болсон. Үр дагавар нь хангалтын ангийн шинж өөрчлөгдсөн.

Ж нь: Холбооны ангид бие бүрэлдэхүүний 70 орчим хувь холбооны биш байгаагаас холбоочны байр суурь доошилж, улмаар холбооны чадавхи буурсан гэж үздэг. Үндсэн ангиас, түүнд үйлчилдэг анги зиндаа эрэмбээр шат доогуур байх ёстой.

б/. Одоогийн хуулиар хилийн тусгай анги гэдэг болсон байсан хилийн анги буюу отряд "тусгай анги" биш бол бригад, дивизтэй дүйцүүлэн эрэмбэлэгддэггүй. Гамшгийн тухай хуульд салбар, отряд, анги гэж бүтцээ эрэмбэлэн хуульчилсан. Одоо ангиа бригад болгон өргөжүүлсэн. Тэгэхээр манай "анги буюу отряд" аль нэгжтэй дүйцэх вэ?. Хуульчилсан нэршил нэг л агуулгаар хэрэглэдэг, хэрэгждэг. Онцгой байдлын албаны отряд, хилийн отряд нэг утгаар ойлгогдоно. Тэгэхлээр отряд-батальоны зиндаагаар салбарын дээр ангийн /бригадын/ доор хуульчлагдсан болохоор хилийн ангиуд маань тусгай хороо биш батальон л болж байна. Хилийн тусгай ангийг хилийн анги болгосноор улам баталгаажуулж байх шиг. Би буруу ойлгож байж болзошгүй. Учир холбогдолыг сайтар ухаарч, тусгах ёстой. Өөрийгөө хэт дөвийлгөсөн /амбиц/ байдал хүнд байдалд оруулна шүү. Санаатай биш дутмагшилын үр дүн адилхан тусна. Цагдаа, Хил хамгаалах алба гэдэг зиндаа, эрэмбийг хэт доошлуулсан, цагдаагийн хэрэг бүртгэлийн албатай жишсэн этгээд зүйлчлэл болж байна. Хэрэг бүртгэх алба ХЦ-т байж бидэнд тусалж үйлчилж байсан шүү.

А. Та байлдааны бэлтгэл, оператив хэлтэст ажиллаж, удирдаж байсан, ХЦДС-д багш, сургалтын албаны дарга, захирал байсан, цэргийн сургалтын талаар туршлага бүхий оператив-тактикийн түвшингийн бэлтгэгдсэн мэргэжилтэн төдийгүй судлаач, Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтэн мэргэжилтний зөвлөлд багтаж байсны хувьд хилчдээ сургах талаарх таны бодол?

Х. Тархи толгойд үргэлж уяатай, санаа зовж байдаг асуудлын нэг. Ер нь бэлэн байдал, сургалт хоёр урагш байх ёстой.Түүнд цэргээ сургаж байж, хилийн халдашгүй, хязгаарын аюулгүй байдлыг хангана. Хэрэв урьдчилан харж, түүнд бэлтгэгдээгүй бол ялангуяа сургасан гэх аргалсан, дарга нараа хуурсан үйлэл байсаар. Би сургах боломж нөхцөл, хандлага зэргийг маш товч хэллээ. Одоо байнга хэрэглэдэг боловч хөгжүүлдэг уламжлалт шавьлан суралцах аргын тухай ярилцья.

А. Манайд дээр үед лам хуврагийн шугамаар л байсан гэж ойлгодог. Цэрэгт хэрэглэж байсан гэж үү?

Х. Ийм сургалт байсан. Ламаар хязгаарлахгүй мэргэжил эзэмших

сургалтанд байсан, дагалдан жолооч, хүн, малын санитар, слесарь, сантехник зэрэг Монголд байгаагүй техник мэргэжлийн чиглэлээр өргөн хэрэглэж байсан. Ёслож шавь ороогүй 3 оны цэрэг 2, 2 оны цэрэг шинэ цэргээ сурган хүмүүжүүлдэг, хил дээрх амьдралыг гэтлэн давах аргыг эзэмшүүлж байсан "бичигдээгүй сургалт" байсан, байгаа, байх ч болно. Хамт олон албан ёсны / тасаг,застав/ -т хуваагдана, албан бус байдлаар суралцах, ойлгох, гүйцэтгэх, зөв буруу хандлагаар хуваагдан, хүлээн зөвшөөрөгдсөн зонхилогчийн нэгийг аялдан дагадаг. Мөн "Сайныг дагавал" гэдэг зүйр үг дагалдан суралцахын тухай байдаг.

Онцлоход, харуулд үүрэг гүйцэтгэж буй бүлэг, байнгын хамт олон болох тасагтай хольж хутгаж ойлгож болохгүй. "Нэг дор үхэж ,сэхэх" гэсэн тодотгол бие биенээ бүрэн мэдэрсэн байнга зэрэгцэн байх тухайн цэрэгт нэн чухал эвлэл, нэгдлийн талаарх яриа болно. Монгол дэлхийд мөнхөрсөн аравтыг бий болгосон. Москва дах Арбат, "Дети Арбата" ном, есаул буюу есөн айл ахалсан аравтын ахлагч зэрэг баримт бий. Харин бид л мартсан, Манж болон гадыхан ч сайн мартуулсан. Мөн сотник, темник, хүрээ буюу округ, караул-харуул, крым-хэрэм, курил-хүрэл гэх мэт. Халх голын тулалдаанд бид ялсан ч газар нутгаа алдсан, тэр гал зогсоосон шугамаар хил тогтоосон. Үүрэг гүйцэтгэл маргаангүй байх, сэтгэл зүйн бэлтгэлгүй байх, үүргээ ухамсарлах чадвар мөхөс байхын түүхэн баримт. Хил дээрх шугам, зурвас амины үнэтэй гэдэг энэ. Монгол Улсын орших, эс оршихын эш үндэс, хилчид амьнаас үнэтэй хүчин зүйлийг ойлгодог, хариуцлагаа ухамсарладаг, ямагт сэргэг, нөхцөл байдлыг мэдэрч байх эх оронч үзлээ уламжлуулдаг эрмэлзлэлийн үндэс суурь энэ. Бусад цэргээс ялгардаг имиж, эе эвийн эрхэмлэдэг үзлийн эх булаг энэ. Сургалт үүн дээр суурилдаг. Цэргийн сургалт хүсэл сонирхол дээр бус хил дээр шаардлагатай бүхэнд сургах зарчмаар явагддаг. Учир нь, цэргийн амь насыг хайрласны дээр амьнаас үнэтэй төрөлх нутгийн төө газрын тогтвортой байдлыг хангуулах ур чадварыг эзэмшүүлэх ёстой учраас.

Би 3-ын тогтолцоо, цэрэг сургах боломж олгох талаар өгүүлсэн. Одоо сургалт явуулах талаар ярья. Сургалтыг бүсчилсэн байдлаар явуулбал үр дүнтэй. Уулын бэлтгэл говьд, говь цөлийн бэлтгэл ууланд тохиромжгүй. Бүсчилсэн хамгаалалтын гол зорилт үүнийг харгалзсан үйлдэл хийхэд байгаа. Сургалт хоёр талын зохицлоор үр дүнд хүрнэ. Багш оюутанг юунд сургаж байгааг, сурагч юуг,хир хугацаанд сурахыг ойлгосон, ойлгуулсан байх ёстой. Ойлгосон хүн эрмэлздэг, үл ойлгогч дөлдөг жамтай, нэг нь хичээгээд, нөгөө нь дүр үзүүлээд байвал, цаг зараад ч нэмэргүй. Дүр эсгэх үйлдэл хил дээр байх ёсгүй үйлдэл. 10.100.1000-т нь хэдэн зуун дамжаад хэрэглэгдэж байгаа нь эвсэг хамт олныг бүрдүүлсэн, аливаад шавилан суралцаж харилцан ойлгох, ажиллах, дайчин барилдалгааг үүсгэн бэхжүүлсэнд гэж би ойлгодог. Одоо шавь сургалтыг явуулахын тулд эхлээд сурагчтай байх, үүний тулд харуулын дарга, манааны алагч нарыг хос мэргэжилтэн

болгохоос эхэлж бэлдэнэ. Ж нь: Харуулын дарга-мөр судлаач, харуулын дарга-мэргэн буудагч,х аруулын дарга-нохой хөтлөгч, харуулын дарга-морь сургагч зэрэг албан тушаалыг бий болгоод, заавал гүйцэтгэх үүрэг болгон чадваржуулмагц албанд, харуулд цуг гаргангаа болон түүнд сонирхогч нарт зааж ойлгуулах, давтуулан дадалагажуулах зэргээр явагдана. Албаны дүн гаргахад нэг чухал үзүүлэлт болгон дүгнэж, ур чадварын үнэлэмж болгох зэргээр ач холбогдлын хөшүүргийг буй болгосноор хэрэгжинэ. Хилийн хэлтэст ажиллах үедээ хилийн манааны чадамжийг дээшлүүлэхийн тулд "хилийн манааны ахлагч" тэмдгийг гаргаад, дараа нь зүүлт нэмж хэдэн удаа зөрчил гаргуулалгүй манаа сайн ахалсаныг сайшаахаас эхлэн 10 хоногийн орон нутгийн чөлөө олготол шагнах журам Х ба ДЦУЕГ-ын даргын тушаал гарган мөрдсөн нь ХЦАХ-д хариуцлагыг нь ойлгуулах, идвэхийг нь өрнүүлэхэд бодит хөшүүрэг болж байсныг сайтар мэдэрсэн билээ. Мөн байлдааны бэлтгэл хэлтэст байхдаа: онц буудагч, тэргүүний тамирчин тэмдэг бий болгон шагнаж байсан нь цэргүүдийн урмыг дэмжиж, ур чадварыг нэмэгдүүлэн, өөртөө итгэх итгэл, бие бялдраа бие аан хөгжүүлэх зэрэгт ихээхэн нэмэр болж байсныг дурсахад таатай байна. Дайнд орж болзошгүй үе байсныг цэрэг бүр битүүдээ мэдэрч хичээж байсан.

Би ярилцлагаа үүгээр дуусгах бодолтой байна. Хөгширхөөр үг олширдог. Сургаал айлдаж байгаа боловч сул, эмзэг юмны талаар юу хөөрснийг мэдэх үүрэгтэй. Сүүлийн 15 жилд тэтгэвэрт байгаа минь сонор соргог сэрэмжтэй байх хариуцлагын чадварыг минь сулруулсан байж болзошгүй тул уучлал хүсье.Та бүгдэд амжилт хүсэн хийморьлог соргог, сэргэг, жудагтай байхын ерөөлийг дэвшүүлье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД АСАН П.ЖАСРАЙН ШАДАР ХАМГААЛАГЧИЙН ДУРСАМЖ...

Өвлдийн Ноён Цорос овогт дэд хурандаа
Хайдав овогтой Энхсайхан.
(1992-1998 онд шадар хамгаалагч)



Миний бие Ховд аймгийн Жаргалант суманд Харагчин туулай жил буюу 1963 онд төрсөн, эцэг эхээсээ ах дүү 9-үүлээ мэндэлсэн. 1981-1982 онуудад Дорнод аймаг дахь ХЦ-ийн 0131 дугаар ангид хилчин, байлдагч. 1982-1987 онуудад Москва хотод ХЦКД төгсөөд, Ховд аймгийн Булган суман дахь ХЦ-ийн 0130-р анги, 1989-1990 онуудад Баян Өлгий аймаг дахь ХЦ-ийн 0165-р ангид тагнуулын ажилтан, 1990-1992 оны 7-р сар хүртэл УАБХЕГ-т (Одоогийн ТЕГ) хил хариуцсан ажилтнаар ажиллаж байлаа.

1992 оны УИХ-ын сонгууль болоод удаагүй байлаа. Гэтэл нэг өдөр газрын дарга хошууч генерал Ж. Баатар дуудаж байна гэхлээр нь явж очоод ирснээ илтгэлээ. Генерал маань мэндийн зөрүүгүй (х/г Ж.Баатар харьцаа муутай хүн байлаа), “Чи өнөөдрөөс эхлэн ерөнхий сайд П.Жасрайн бие хамгаалагчаар ажиллана, би тушаал дээр гарын үсэг зурсан” гэлээ. Би хариуд нь генералаа санал асууж болоогүй юм уу гэтэл Чи битгий олон юм яриад бай гээд утсаар ярьснаа Чи ороод ир гэж байна. Удсан ч үгүй хамгаалалтын албаны дарга хошууч Базарсад орж ирлээ. Генерал Базарсадад хандаж ч Чи энэ Энхсайханыг ерөнхий сайдад танилцуул гэлээ. /Энэ үед би хил хариуцсан ажилтан тул ХЦ-ийн форм өмсдөг ахлах дэслэгч цолтой байлаа/. Генералын өрөөнөөс гараад, өрөөнд ороод бичиг баримтаа цэгцлээд Базарсад даргатай төрийн ордон, орж ерөнхий сайд дээр орлоо. Базарсад дарга ерөнхий сайдад миний товч анкет танилцуулаад, өнөөдрөөс эхлэн таны комиссараар ажиллана гэлээ. Дарга хариуд нь, энэ хүн чинь тэгээд цэрэг хувцсаа тайлна биз дээ гээд инээгээд за тэгвэл зүтгээд байж дээ гэлээ. (ий нуугүй ярихад энэ үед би ганц костюмтай, зангиа зангидаж мэддэггүй байлаа)

Энэ өдөр бол 1992 оны 07 сарын 26-ны өдрөөс 1998 оны 3 сарын 4-ныг хүртэл миний бие өвгөн даргын шадар хамгаалагчаар ажилласан юм. Дарга маань их энгийн яриатай, юм ярихдаа инээж ярьдаг хүн байлаа. Энэ үед лангуун дээр давс, гоймон л байлаа. Хамгаалалтын алба маань төвдөө 5 хүрэхгүй хүнтэй, ерөнхий сайд тогоочгүй байлаа. Засгийн газрын хуралдаан шөнийн 03 цаг хүртэл

хуралдана, Дууяа эгч гадагшаа явсан үед Их тэнгэрт өглөө 04 цагт очоод хувцсаа солиод гал зууханд орж хоол хийнэ, зарим үед дарга маань би гурил зуурах уу гэж асуудагсан хөөрхий... Дарга маань гурилтай хоолонд дуртай хоол идэхдээ 1 ширхэг хальсалсан сармис барьж иддэгсэн. Даргад маань нэг цайвар өнгийн костюм байдаг байлаа олон жил өмсөөд өмдний дотор тал нь доогууpаа цоорсон хумсны толин чинээ нөхөөстэй тэр костюмдаа их хайртай юм л бол нөгөөдөхөө өмсөнө, нэг удаа тэсэлгүй хэллээ даргаа та энэ костюмыг дандаа өмсөх юм ерөнхий сайд нөхөөстэй костюм өмссөн байна гэх вий гэсэн чинь инээгээд Ээ золигоо Би энэ костюмыг чехээс авсан юм биеэнд эвтэйхэн байдаг юм шкафанд байхаар өмсөөд байх юм чи далд хийчихээрэй гэж билээ. Хөдөө ажлаар явах үед Дууяа эгч Энхсайхан явж байгаа юм чинь даргадаа юу авч явахаа мэднээ гэдэг байлаа. Хөдөө ажлаар яваад ирэхэд доод тал нь 30 гаруй мөнгөн аяга цугладаг байлаа тэр аяганаас та алыг нь авах вэ гэхэд хэрэггүй чи наадахаа тоо ёсоор фондонд өг гэдэг байлаа. Их хурлын гишүүн болсны дараа төрийн ёслолын фондын ажилтантай ордон дотор таарлаа, тэгсэн тэгж байна танай даргыг гадаад явахад нь бэлэглэсэн заан, торго, даавуу байх юм. Чи түүнийг аваад даргадаа өг, одоо сүүлийн үеийн дарга нар хөдөө яваад ирэхдээ та нар шиг бэлгийн юмаа өгөхөө больсон гэж хэлэв. Ингээд хурлын завсарлагаанаар нөгөө юмнуудаа аваад өрөөнд нь тавчихаад даргад үзүүлэхэд, за за чи авсан бол Дууяад өгчих заан нь их хөөрхөн юм байна гэж байлаа. Дарга зааны цуглуулгатай байсан юм.

1993 оны 2 сард Баянхонгор, Өвөрхангай аймгаар явлаа. Энэ үед ах Дандиа /Намсрайжав/ нь өвчтэй байлаа. Биднийг Өвөрхангайд байхад өглөө 06 цагийн үед Дэлгэрмаа эгч утсаар ярьж Дандиа муудаад байна та ухаантай байгаа дээр нь ирэх хэрэгтэй гэлээ. Бид шадар сайд Пүрэвдорж гуайтай утсаар ярьж нисдэг тэрэг дуудах асуудал ярихад, дарга маань зөвшөөрөөгүй тул УАЗ-469 машинаар явсаар ирэхэд ах нь өөд болсон байлаа. Энэ үед нисдэг тэрэг дуудаад ирэх байсан ч, дарга маань даруу хүн учир зөвшөөрөөгүй юм даа. 1993 оны 6 сарын 14-нд Бээжингээр дамжин АНУ-д 14 хоног ажлын айлчлал хийлээ. Бидний Монголд оруулж ирсэн зүйл маань Бойнг онгоц /Солонгосын түрээсийн 2 онгоц/ уул уурхайн хүнд машин механизм, моторола станц, кока кола ундаа зэрэг юм. Энэ үед ард түмний амьдрал хүнд байсан үе. Амралтын өдөр гэж амраад байх зав зай маш муу байлаа. Амралтын өдөр байсан ч, гэртээ ажлын өрөөндөө байнга сууж ажлаа хийдэг. Салхинд гарахдаа Их тэнгэрийн их байр хүртэл алхана. Энэ үед дарга маань надаас их зүйл асууна. Ялангуяа хилийн асуудал асууна. Би өөрөө хилийн сургууль төгсөж, хил хариуцаж байсан учир, би хилийн асуудлаар мэдээлэл сайтай байлаа. Энэ үед хилчид цалингаа авч чадахгүй, винтов, СГС буу зарж цалин тавьж байгаа асуудлыг даргад ярихад үнэхээр хүнд байгаа байхаа гэнэ. Нэг өдөр ордон дотор явж байтал хошууч генерал Базарсадтай тааралдав. (Сад генерал энэ үед Их хурлын гишүүн

байлаа). Завтай бол хоёулаа манай өрөөнд оръё гэж байна орлоо. Сад генерал ярьж байна, Энхсайхан цаад хилчид чинь цалингаа авч чадахгүй байна, би удахгүй Их хурлаар Хилчдийн нийгмийн асуудлын талаар асуудал оруулах гэж байна, Чи мэргэжлийн хүн амьдрал мэдэх учираас Ерөнхий сайдад ойлгуулах хэрэгтэй байна гэлээ. Ингээд би Сад генералын асуудлыг даргад ярихад, дарга хилчдээ харалгүй яахав гэж байсан. Одоо хилчдийн хоол хүнсний нэмэгдэл, хил дээр ажилласны нэмэгдлийг өвгөн даргын засгийн үед бүгдийг нь ийнхүү өөрчлөн шинэчлэсэн юм. 1995 оны үеэр Дэлгэрмаа эгч өвдөөд Ихтэнгэрт байрладаг байлаа. Дээгий эгч Ариунаа, Болдоо гээд Аюуш ах хөдөө ажлаар явна. Нэг өдөр нэгэн тэмдэглэлт үйл явдал боллоо. Би ажилтай байлаа, Дээгий эгч намайг дуудлаа яваад орлоо.

Дарга, Аюуш ах, Жамсран, Жанцан гээд байж байна. Надад хундагатай архи өглөө, нөгөөдөхийг амслаа, тэгсэн Дээгий эгч аав танай энэ коммиссар чинь Ховдын өөлд Аюушийн хамаатан юм байлаа гээд тас тас хөхөрч надыг Аюуш ах болон гэр бүлийн хүмүүсдээ танилцуулж билээ. Ингээд 1995 оны хавар Дээгий эгчийн бие нь өвдөөд сайд нарын 2 эмнэлэгт хэвтэж байлаа. Дарга ОХУ-д айлчилж ерөнхий сайд Черномырдантай их өрийн асуудлаар орчуулагчгүй 1 цаг гаруй ярилцсан, энэ үеэр Дээгий эгчийн өвчтэй байгааг сонсоод Черномырдан дарга Москвад аваал ир, би эмчилгээний асуудлыг даая гэж байлаа. Москвагаас ирсний дараа даргатай энэ асуудлыг ярихад "Харин ээ гэснээ Аюушийг худалдааны төлөөлөгчийн газар ажлуулахаар явуулахаас, тэгэхгүй бол ирэх жил сонгууль болно Жасрай төсвийн мөнгөөр охиноо эмчүүллээ гэх байх гэж байсан нь хичнээн зарчимч шудрага хүн болох нь надад танигдсан. Ингээд Аюуш ахынх Москва гэр бүлээрээ явж билээ. 1996 он гарлаа. Сонгуулийн жил ажил их байлаа. Хавар 4 сарын үед МАХН-ын байранд хурал болж, сонгуульд оролцох гишүүдээ гаргах гээд хурал шөнө 03 хүртэл хуралдлаа. Маргааш нь 10 цагт дахин хуралдахаар боллоо.

Би өглөө ажил дээрээ очоод, байж байтал дотуур утас дуугарлаа. Утсаа автал, даргын туслах Хаадгар гуай ярьж байна. "Энхсайхаан даргыг битгий сэрээ, Москвагаас Аюуш сая ярилаа. Дэлгэрмаа өнгөрсөн гэнэ. Би Санжаа эмчийг сая дуудсан гэлээ, ингээд утсаа тавьтал гадуур утас дуугар ч холын дуудлага орж ирлээ. Утсаа автал Энхсайхан уу гэж байна тиймээ гэтэл Аюуш ах нь байнаа. Эгч нь өнгөрлөө, аавтай ярьж зөвлөлгөө авах ажил гараад байна гэлээ, би ч сандараад за гэж хэлээд дотуур, утсаар Хаадгар гуайтай ярив. Аюуш ах ярьж байна, би даргыг дуудлаа та эмч гээд утсаа таслав. Дээшээ гарч дуудахын өмнө тогооч Болдоо / улсын начин/ үйлчлэгч эмэгтэй 2-т дуулгалаа. Тогооч Болдоог чи энд утсан дээр байж бай, би даргыг дуудлаа гээд дээшээ гараад чимээ чагнасан дарга хурхираад унтаж байна. Өрөөний үүдэнд очоод хаалга зөөлөн нүдээд даргаа гэлээ, сэрсэнгүй дахиад нүдтэл сэрлээ яасан бэ? Энхсайхан надаас асуув, Москвагаас Аюуш гэх гэлээ цаашаа ярих гэтэл

хоолой зангирлаа. Тэгсэн дарга хувцсаа өмсөнгөө нөгөө Дээгий золиг муудаж байгаа юм байх даа гэж байна. Ингээд доошоо буугаад утсаар яриад уйллаа. Гараараа нулимсаа арчиж байна, энэ үед нөгөө өрөөнд миний костюмны кармаанаас нусны алчуур аваад ир гээд тогооч Болдоод хэллээ. Дарга ч утсаа тавилаа. Даргаа тайван байгаарай гэж хэллээ. Ингээд тогооч Болдоо бид хоёр даргыгаа түшээд дээшээ шат өөд өгсөөд амралтын өрөөнд оруулаа. Болдоо ч гараад хаалга хаалаа. Даргаа тайван байгаарай цай уухуу, гэтэл дарга маань нулимсаа арчингаа сервант руу зааж байна, хартал хугас шилтэй архи харагдаж байна, түүнээс стаканд ахиухан хийгээд татуулчихаад, гал зууханд орж цай авч ирж өглөө. Энэ асуудлыг хийхгүй байсан бол дарга маань харвах байсан байх гэж боддог. Ингээд даргын хажууд сууж байтал Санжаа эмч сувилагчтай орж ирж билээ.

1996 оны сонгууль болж МАХН ялагдлаа. Дарга их хурлын гишүүн боллоо. Тунсаг, Батмөнх, Одхүү жолооч бид 4 дарга дээр үлдлээ. Ингээд бид хүүхдийн зуугийн урьд талын даргын байранд нүүж ирлээ. Дарга маань өглөө ажилдаа ирэхдээ алхана, буцахдаа ч бас алхана. Амралтын өдрүүдэд Хустайн нуруунд Ёндонжамц ахынд очиж амардаг байлаа. Манай жолооч Одхүү бид хоёр анд дуртай, даргын 60 насны ойгоор Хилийн цэргээс урт винтов, Цагдаагийн газраас чех калибр буу бэлэглэсэн юм. Чех калибр гаднаас харахад автомат шиг хэлбэртэй, энэ буугаар Одхүү бид хоёр Хустайн нуруунд Ёндонжамц ахынд очихдоо туулай, ятуу бууддаг байлаа. Хөдөө явахын урьд өдөр даргад буугаа авч явахыг хэлнэ. Тэр буугаар ан хийлгэхийг Дууяа эгч зөвшөөрдөггүй байлаа, дарга Дууяа эгчээс нууж надад өгдөг байлаа. Даргыг та өөрөө буугаараа бай буудахуу гэхэд буудахгүй, Дарга нэгэн түүх ярьдаг байлаа. Тэр нь дарга улс төрийн товчоонд байхдаа ажлаар баруун аймаг явсан юм гэлээ. Тэр үед хавар цаг байсан усны шувууд ирсэн байж. Хамт явсан нөхөд даргаар нэг шувуу буудуулсан оножээ. Тэгээд оройн хоолон дээр нөгөө шувууны махыг өндөгтэй хамт чанаад өгсөн гэнэ. Юун өндөг вэ гэтэл таны буудсан шувуу өндөгтэй байжээ гэсэн гэнэ түүнээс хойш буу шагайдаггүй гэж ярьдаг байлаа.

1997 оны зун нөхөн сонгуулийн ажлаар Завхан явлаа. МАХН-аас Н. Энхбаяр өрсөлдсөн. Бидэнтэй хамт Ж.Жанцан өөрийн фургон машинаар гал тогооны хэрэслэлтэй явсан юм. Бид Завханд ажиллаад буцахдаа Идэрийн гол дээр хонож загас барих төлөвлөгөөтэй байлаа. Завханаас гарах үед аймгийн МАХН-ын нөхөд гаргаж өгөөд хагас, шил виски өгөөд замдаа хэрэглэ гэлээ. Идэрийн гол дээр ирлээ. Хар морь унасан залуу үхрээ хураагаад явж байна. Би машинаас бууж уулзаад загас бариад хоночих газар байна уу гэлээ, тэгсэн нөгөө залуу надыг дагаад яв гэлээ. Ингээд голын хөвөөнд нэг сайхан зүлэгтэй газар ирлээ, бүгд машинаас буулаа дарга нөгөө залуутай зүлгэн дээр замилан сууж нутаг усны талаар юм ярьж сууна, тэгсэн дарга надыг дуудаад нөгөө виски байна уу гэж байна, би машинаас нөгөө виски

аягатай авч ирж өглөө. Би чихэр гаргаад тавих, хооронд дарга нөгөө вискинээс ахиухан хийж нөгөө залууд өгсөнд нөгөө залуу бүгдийг уучихаад амаа арчингаа, Та чинь ямар кинонд тоглолоо гэж байна тэгэхлээр нь би хажуунаас нь наад хүн чинь ардын жүжигчин Жасрай гэдэг хүн дээ гэсэнд, нөгөө залуу архинд халсан нь илт дарга руу том харснаа Яанаа та чинь ерөнхий сайд байна шүү дээ гэж хэлээд мориндоо морьдоод гэрийн зүг давхиж даргыг аваад ирнэ гэлээ. /Учир нь даргатай хоёулхнаа байхдаа нөгөө асуудлаа ярих гэж/. Ингээд даргаа өглөө гэрээс аваад хоёулаа алхлаа. Төв шуудангийн зүүн талаар гараад, Сүхбаатарын талбайд хөл тавих үедээ хэлнэ дээ гэж тооцоолов. Ингээд даргадаа хэллээ, надыг ТЕГ-аас хуучин дарга маань ир гээд байна, би яахав даргаа гэлээ, Тэгсэн дарга маань инээгээд за Энхсайхаан чи миний хажууд олон жил боллоо, Тагнуулын



Ингээд миний бие ажлаа хийж байтал, 1998 оны цагаан сарын дараахан ТЕГ-ын хэлтсийн дарга хурандаа Г.Жаргалсайхан нэг өдөр утсаар ярьж Чи одоо эргэж ирж ажлаа хий, мэрэгжлийн хүн байхгүй байна гэлээ. Би балмагдлаа. Би эхлээд даргадаа дуулгая тэгээд хариу хэлье гэлээ. Даргадаа яаж хэлэх талаар бодлоо, ингээд нэг өдөр хамт хамгаалагчаар ажиллаж байгаа Зоригтыг чи маргааш ордон дээр өрөөндөө байж бай, би байгууллага мэрэгжлийн хүн байхгүй байгаа нь аргагүй, чи яв даа одоо 2000 он гараад миний хамгаалалт бууна. Чи залуу хүн мэрэгжлийн ажлаа хий, би тагнуулын дарга нарт хэлэх үү гэснээ, Чи надтай хамт 6 жил ажиллалаа, ажиллах үед миний амьдралын баяр баясгалан зовлон жаргалын хүнд үеийгч хуваалцсан шүү гэж билээ. Ингээд миний тушаал 1998 оны 3 сарын 4-нд гарлаа. Тагнуулын ерөнхий газар ажиллаж байхдаа даргатай очиж

уулзахад ном бичиж, оюутануудад лекц уншиж байгаагаа ярина. Мөн нано технлогийн талаар ярьж манай мал аж ахуйд нэвтрүүлвэл их зүгээр юм гэж ярьдаг байлаа.



Ингээд миний бие 2003-2004 онуудад Москвад тагнуулын академийн дээд курст /ФСБ/ сурлаа. Энэ үеэр Аюуш ахтай холбоотой байлаа. Энэ үед дарга маань их өрийн асуудлаар Н.Энхбаярын хамт ирээд өрийн асуудлыг шийдэж билээ. Энэ үед би даргатай Элчин сайдын байранд уулзахад, дарга инээгээд за Энхсайхан сурлага өндөр үү? гээд нөгөө 1995 онд Черномырдантай ярьсан асуудлаа, одоо л нэг дуусгалаа даа гэж байлаа. Энэ дашрамд өгүүлэхэд даргыг маань өөд болсны дараа, энэ өрийн асуудлыг МАХН-ын хэсэг нөхөд өөрсдөө хийсэн болгож, ард түмний тархийг яаж угааваа, хамт явж байсан, одоо энэ намд том алга хашиж байгаа нөхөр улайм цайм худлаа ярихыг сонсоод Хятадын агуу удирдагч Ден-ся-пины "Ард түмэн бол цагаан цаас, түүн дээр юу ч бичиж болно" гэсэн үг санаанд орж билээ.

Тагнуулын академи төгсөөд миний бие 2004-2010 оны хооронд Баян-Өлгий аймгийн тагнуулын даргаар ажиллаа. Энэ үед би даргатай утсаар ярина, Жанцан та хоёр ажлаа зохицуулаад 7, 8 сарын үеэр нэг ирээч бүгдээрээ Алтай 5 Богдод очоод нэг сайхан амраад яваач гэдэг байлаа. Дарга маань хариуд нь зав гаргаад очино оо гэдэг байлаа зайлуул. Эцэст хэлэхэд: Миний бие Жасрай гэж энэ агуу хүний хажууд 6 жил ажиллахад минь их урам хайрласан хүн дээ. Дарга маань их энгийн яриатай, хүнтэй юм ярихдаа инээж ярина, Монгол орны маань хөгжил цэцэглэлтийн тал дээр бүхэл бүтэн амьдралаа зориулсан хүн дээ. Миний бие даргатайгаа хамт ажиллах хугацаандаа энэ айлын гэр бүлийн нэг гишүүн нь болж үр хүүхэд, найз нөхөд, хамаатан садангийн хүмүүстэй нь ах дүү шиг сайхан цаг үеээ өнгөрөөдөг байлаа. 2013 оны 11 сарын 26 даргын маань 80 насны ойн арга хэмжээнд оролцлоо. Хүлээн авалтан дээр хамтран ажиллаж байсан сайд дарга нар болон үр хүүхэд, ач, зээ, хамаатан садангийн хүмүүстэй ярьж хөөрч нилээд суулаа. Энэ үед энэхүү дурсамж бичих зөвлөмж Батаа ахаас авч билээ.

Ингээд эцэст нь энэхүү дурсамжаар дамжуулан даргатай хамт ажиллаж байсан нөхөд болон гэр бүл, үр хүүхэд, ач, зээ хамаатан садангийн хүмүүст эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хувиасаа болон гэр бүлийнхээ өмнөөс хүсэж байна.

Та бүхнийг маань Мөнх хөх тэнгэр ивээх болтугай.

ТӨРД ОРХИГДСОН Ч ЭХ ОРНЫХОО ТӨЛӨӨ ЗҮТГЭСЭЭР...

Түүхийн жимээр нэвтрүүлгийн санаачлагч, жолооч, найруулагч М.Жавзансүрэн (Ph. D)

Намрын шаргал наран ээсэн баруун хилээс эхэлж, дайны сорви арилаагүй Халхын гол, Ялалтын хөшөө, Баянцагааны өндөрлөг, Ханан хөшөө, Бурхант, Баянхошуу, Буйр нуур, Мэнэнгээр түүчээлсэн их аяны харгуй МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙГ 4 тойрсоны дайтай 30 мянган км яваад Хилийн 0277-р ангиас дөрөө мулталлаа.

Он цагийг түүчээлсэн их аяны харгуйн зорилго нь юусан билээ хэмээн асуух хүн бүрт нэг л хариулт өгсөн нь МОНГОЛ улсын ХИЛИЙН түүхийг үлдээх, ХИЛИЙН хариуцсан хэсэгт байх түүх, соёлын дурсгалуудыг тойрох байлаа.

Дархан хилийн түүхийг өртөөлөн явахдаа МОНГОЛ улсын ХИЛ тайван байх хэдий ч, ХИЛЧДИЙН хэзээ ямагт байгаагаараа байдаг зан он цагийн саалтанд үл хувиран, улам ихээр хүмүүсийн хайрыг татаж байгаа боловч, хилд зорьсон үй олон сэтгүүлчид ХИЛЧДИЙН сайн, сайхан занг мэдэрч, зочломтгой, дайламтгай хэмээн магтахаас бус хичнээн хүн амьдрал руу нь өнгийсөн бол гэж асууя.

Он цагийн саалтанд үл бүдгэрэх түүхийн жим улам тодорч байгаа нь орчин цагийн нээлттэй ил тод байдал, хилийн түүхийг сонирхогч хүмүүсийн буян байж болох ч нийгмийн хүрээнд ХИЛЧДИЙН талаарх ойлголт ямар вэ?

Сошиалд эрх чөлөө нэвт ханхалж, юу бичих, эс бичих нь сайн дурын хэрэг боловч, хилчдийн талаарх ойлголт төдийлөн сайн биш, нэр бүхий албан тушаалтнууд ч, ихэд ухаантай байж болох хэд, хэдэн хүн ХИЛИЙГ сумын ард иргэд манадаг мэтээр "хийрхэж" байхыг харлаа.

Басхүү Сулинхээрийн асуудалтай холбоотой элдэв янзын үзэл, ойлголт ард түмний дунд байж, тэр хэмжээгээрээ нийгэмд отрядыг нааш нь татсантай холбоо бүхий ХИЛ дотогшоо нүүлээ хэмээн хардагсад ч олон байна. Монгол Улсын ХИЛИЙН тухай хуулийн

4 дүгээр зүйл. Монгол Улсын хил, 4.2. Улсын хил халдашгүй дархан байна.

6 дугаар зүйл. Улсын хилийн шугамын асуудлыг шийдвэрлэх

6.1. Улсын хилийн шугамыг тодорхойлох, тогтоох, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Их Хурал / цаашид "Улсын Их Хурал" гэх/, улсын хилийг хамтран шалгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ хэмээн заасныг үл мэдэгчид ХИЛИЙН тухай асуудлыг хэсэг бүлэг хүмүүс шийддэг мэт санаан зоргоор бичихийг харахаар урам хугарах юм.

Сулинхээрийн отрядын хамгийн гол шийдсэн асуудал нь ХИЛЧДИЙН нийгмийн баталгааг хангахад чиглэгдэж байгааг өөрийн нүдээр харсаны хувьд баттай хэлэх байна.

Үүнтэй холбоотой ХИЛЧДИЙН нийгмийн баталгааг ТӨР хангаж чадаж байгаа юу? Хэмээн ТӨРӨӨС асууя. Тийм болохоор энэхүү нийтлэлээ "ОРХИГДОГСОД" хэмээн нэрлэе.

Тэртээ хол, шувуу л хараяа нисэхээс

өөр амьд амьтны бараа үл харагдах хилийн торгон шугаман дээр дөрвөн цагийн эргэлтэнд манаанд ХИЛЧИД зогсож байна. Тэрхүү буйдхан застав, хилийн ангиудад эх орныхоо төлөө тангараг өргөсөн хилийн цэргүүд манаанд гарсаар байна. Гуравхан жилийн дараагаар түүхт 90 жилийн ойгоо тэмдэглэх гэж буй ХИЛ хамгаалах байгууллагын түүхэн замнал баян. Зах зээлийн ороо бусгаа цагт ч ХИЛЭЭ орхиогүй хүмүүс ХИЛЧИД л байлаа.

Гэсэн ч...

Хэзгүй гүдэсхэн хилчид минь хэдхэн үг, даргын тушаалаар хэрээс хэтэрсэн зүйлийг ч болгож яваг та мэдэх үү?

ХИЛЧИН хүний цалин хангамжийг аваад үзье. Хилчдийн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаа хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу бодож олгох аж. Дундаж цалинг бодоод үзэхээр бага юм. Энэ мөнгөөр амь амьдралаа авч яваа хилчин өр, зээлгүй байж чадах болов уу. Бүгд өр, зээлтэй. Газар бүрт томилогдож, ХИЛ дагаж явсаар амь амьдрал, биегүй болсон хүмүүс.

Цэргийн албаа хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 7.1.19. цэргийн албаа хаагч ээлжийн амралтаар өөрийн төрсөн нутагтаа очих, буцаж ирэх замын зардлыг хоёр жилд нэг удаа цэргийн анги, байгууллага олгох гэж хуулиар заажээ. Заалтын дагуу гэр бүлээ дагуулан нутагтаа амрахаар явах замын зардал хэд гарахыг эрүүл ухаанаар тооцож үзсэн хүн бий болов уу?

Хаа байгаа Баян-Өлгий аймгийн хилийн дугаар ангид ажиллаж буй ХИЛЧИН эхнэр, хүүхдүүдээ дагуулан, зүүн хязгаарт байх Дорнод аймагт амьдран суугаа эцэг, эхдээ 2 жилд 1 удаа очиход өгч буй замын зардал дунджаар 200 мянган төгрөг аж. Хаа хүрэх мөнгө юм бол...

Цэргийн албаа хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 7.1.9 дүгээр зүйлд "Офицер, ахлагч, цэргийн гэрээт албаа хаагч нь ажлын нөхцөл, албан тушаал, мэргэжил, мэргэжлийн зэрэг, цэргийн цол, албаа хаасан хугацаа зэргийг үндэслэж тогтоосон дүрэмт хувцасны болон мөнгөн хангамжтай байхаас гадна байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх, харуул, манаанд гарах, хээрийн сургууль, дадлага хийх үедээ хүнсний болон эдийн хангамж, түүнчлэн нийслэлээс бусад сум, суурин газарт байрлаж байгаа цэргийн анги, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт албаа хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг үл харгалзан хүнсээр хангагдах", ХХЕГ-ын даргын А/151 дүгээр тушаалаар "Хүнсний хангалтын заавар"-ыг баталжээ.

Энэхүү тушаалыг харангуут "төрийн" хувцас өмсөж, хүнсээ бэлдүүлчихээд, цалингаа авчихаад, ажлаа хийж байж, юундаа ялархдаг юм тэр хилчдийн юун нь мундаг гэж үхэн хатан тэдний төлөө яваад байгаа юм бэ, тэд цалин авч байгаа ажлаа л хийж байна, энэ тэдний сонголт хэмээн ад үзэх хүмүүсийг нэвтрүүлэг хийх явцдаа өчнөөн харлаа. Уучлаарай, жилийн

4 улиралд хил дээр зогсож байгаа хилчний хувьд хангалтгүй хангамж. Хилээр явж үзэхээр амь амьдралаа эх орондоо зориулсан хилчин хүнийг бусад төрийн албан хаагчидтай харьцуулашгүй гэдгийг мэдэх болов уу?

Баян-Өлгий аймагт байх хилийн ангиар явж байлаа. Цагдаагийн ажилтнуудын байр хэдэн давхар орон сууц байхыг хараад атаархам. Харин миний явсан хилийн ангиудын хилчдийн байр гэж 70,80 аад онд баригдаад, аль хэдийн чанарын шаардлага хангахаа байсан ч өнгөн хэсгийг нь додомдож засаж амьдарсаар байгаа дан ганц орон сууцнууд. Яаж болгож байдаг юм бол хэмээн өрөвдөн харж, хилээр тойрч үзээч гэж зарим нэгэнд хэлчихмээр...

Хамаг сайхан залуу насыг нь ЭХ ОРОН хэмээн зүтгүүлчихээд, яг ид хийж бүтээх 40 насан дээр нь, за одоо боллоо, та тэтгэвэртээ гарч болно гэдэг. 40 насандаа тэтгэвэрт гарч байгаа ХИЛЧНИЙ тэтгэвэрт суусны дараах амьдралын баталгаа юу билээ.

Нэгэн жишээ хэлье. Тэр хол байх хилийн ангиас тэтгэвэртээ гарч байгаа ахлагчтай таарч билээ. Жижигхэн гэрээ портер дээр ачаад их хотын зүг зориглон хөдөлж буй нь тэр. Хил дамжиж ажилласаар тавилга гэх юмгүй, хэдэн хүүхдүүд нь сургууль сольсоор сурлагагүй, гэргий нь үндсэн ажилгүй, бие гэж авах юмгүй 43 настай залуугаас хотод очоод хаана байх уу? хэмээн асуухад, таньдаг айлынхаа хашаанд буух санаатай гэсэн юм. 36 сартай тэнцэх хэмжээний тэтгэмжээрээ хашаа байшин авч чадах болов уу? заставын бор хүү нь оюутан болж байдаг, тэр хүүгээ дуртай сургуульд нь оруулмаар, төлбөрийг нь хүчрэхгүй болохоор үе удам дамжсан хилчин л болгох байх даа гэх. Шүүрс алдмаар.

Хилчний амь нас үнэгүй...

39.2. Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно гэжээ. Дунджаар 30 сая орчим төгрөгний үнэтэй амьтай аж. Хилчний амь үнэгүй байсаар ирсэн гэвэл үнэн. Учир нь Овоотын цэнхэр хязгаараас нэвтрүүлгээ хийж явахдаа 8 "баатрын" (үнэндээ 11 хилчин) хөшөөнд хүндэтгэл үзүүлсэн юм. Түүхийг сөхөж үзвээс....

1938 оны 12 дугаар сарын 31-ний өдөр тус отрядын Хөх усны заставын тасгийн дарга Содном ахлагчтай гурван хилчин Атасын хар амны постон дүүрэг гүйцэтгэж байхад Халхын баруун өмнөд овоогоор хил зөрчин орж ирсэн хасгийн 500 орчим дээрэмчидтэй хүч тэнцвэргүй тулаанд орж амь хайрлалгүй тулалдаж хилчин Дүрсээ амь эрсдэж, Халтархүү хүнд шархдан ухаан алдаж, тасгийн дарга Содном эцсээ хүртэл тулалдсан хэдий ч аргагүйн эрхээр дээрэмчдийн гарт оржээ. Дээрэмчид Содномыг хэрцгийгээр тамлав ч Содном эх орныхоо өмнө өргөсөн тангарагтаа үнэнч байж ямар ч зүйлийг өчсөнгүй. Дайснууд үүнд нь хорсож манай зоригт хилчнийг толгойгоор нь галд шарж алсан байдаг. Үдэш Халтархүү ухаан орж нөхдөө харахад бүгд алагдсан байсан тул хүнд шархтай

Халтархүү дан ногоон цамцтай хөл нүцгэн мөлхсөөр 30 гаруй километр явж заставтаа хэл хүргэсэн байна. Заставын дарга Хандын Жүрмэд цагийн байдлын талаар сумангийн дарга Бавууд мэдэгдээд өөрөө 6 хүнтэй групп авч тулгаралт болсон Атасын хар аманд 1939 оны 01 дүгээр сарын 02 нд ирж дээрэмчидтэй олон цаг тулалдсаны эцэст хүчээр илүү дайсны гарт арга буюу автжээ. Ийнхүү Атасын хар аманд манай эрэлхэг найман хилчин нэн харамсалтайгаар амиа алдсан билээ.

Дээрэмчид заставын дарга Жүрмэдийн чих, хамрыг огтолж цээжин дээр нь таван хошуу сийлэн, хөлийн шөрмөсийг сугалж, тасгийн дарга Самбуугийн хуруунуудыг нугалан үе мөчөөр нь жиргэн зүрхийг нь сугалж алсан бөгөөд бусад хилчдийг бутанд шатааж шарж алсан байдаг. Дайснууд манай хилчдэд ихэд хорсон тэднийг дэндүү хэрцгийгээр алсан байхыг бодоход тэдэнд багагүй хохирол учруулжээ. Эх орон ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнч байж эр цэргийн ёсоор алтан амиа өргөсөн эдгээр хилчдээрээ бахархмаар ч цэл залуу хорин насандаа амь үрэгдэж, алдар нь мартагдах шахсан аавын хөвгүүдээ бодохоор харамсмаар.

Заставын дарга Хандын Жүрмэдийг Монгол улсын баатраар нэхэн шагнах сайн цагийг хилчид хүлээж байна. Гэвч ХИЛЧИН хүний амь үнэгүй учир төрийн сонорт хүрэхгүй 82 жил улиран оджээ.

39.3. Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна хэмээжээ. 20 наснаас 40 нас хүртэлх залуу насаа ХИЛД хатаасан хилчинд өгч буй тэтгэмж нь хэдхэн халтар төгрөгөөр үнэлэгдээд насан туршдаа хилд ажиллаж байсан бахархалаас өөр юмгүй үлдэж буйн жишээ энэ.

39.4. Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно хэмээжээ. Энэ заалт хүчингүй заалт гэж би хардаг.

Хилчний гэргий гэж хэн бэ? Оюутан байхдаа "Амьдрал хайр дээр тогтдог" хэмээн ирээдүйн офицертэй хайр сэтгэлээр гагнагдаж хөтлөлцөн гүйсээр төгсөнгүүт нь гэр орон, аав, ээжээсээ зөрөн байж, ганц чемодантай өмссөн хувцастай залууг даган заставаар эхэлсэн амьдрал. Их, дээд сургууль төгссөн ч, мэргэжлээрээ ажиллаж үзээгүй гэргий нь ажил олдох юм бол угаагч, буудлын үйлчлэгч, холбоочин хийнэ, ажил бас тэр бүр олдохгүй. Үе, үеийн хилчдийн дүр төрх ийм л байсан. Харин одоо цагт өнгө мөнгөн дээр тогтож байгаа энэ үед хилчин залууг дагаж, амьдрал хайр дээр тогтдог хэмээн хил рүү зүтгэх бүсгүй хэд болсон бол. Миний ажигласнаар яг одоогийн хилчин залуусын гэр бүлийн асуудал орхигдсон. Өнөөгийн бүсгүйчүүд өөр зүйл хүсэж, өөр зүйлийг мөрөөддөг, өөр амьдралаар амьдрахыг

хүсдэг болсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл цаг үе өөр болсон. Өнөө цагийн хилчин залуучуудад минь хамгийн гол зүйл гэр бүл. Гэр бүлдээ санаа үл зовох аваас ХИЛЭЭ сайн манана. Гэхдээ гэрт ямар ч асуудал байсан ХИЛЭЭ манасаар ирсэн, манах ч болно. Гэхдээ хэдий болтол тушаалаар явах вэ? Хилчдийн дүр төрх ӨӨР байгаасай, шинэ байгаасай гэж би хүсэж байна. Өөрөөр хэлбэл ХИЛД ажиллах тушаал авсан өдрөөс эхлэн чиний гэр орон, цалин хангамж, амьдралын баталгаа бусад улс орнуудын жишиг биш юм аа гэхэд өнөөдрийн байгаагаас хавьгүй илүү бүүр 100 хувь өөрчлөгдөөсэй гэж хүсэж байна.

Хил дагасан заставын бүсгүй нөхөрийгөө тэтгэвэрт гарахад нь 40 насандаа бас л гэртээ сууна. Түүнд цалин орлого ч байхгүй, бас тэтгэвэр ч байхгүй. Харин тэтгэвэрийн доод хэмжээгээр тогтоож өгөх юм бол хэдэн бор хүүхдүүдийнхээ сургууль соёлын мөр хөөхөд нь хоосон хонуулахгүй, хоёр идүүлэхгүй байж байх. Хилчин хүнийг баян гэж сонссон хүн бий болов уу. Хилийн хурандаа нарыг бусад төрийн албан хаагч нар, өөр салбарын хурандаа нар шиг мөнгөтэй, эрх мэдэлтэй баян гэж дуулсан болов уу. Өнөө л тавилга гэх юмгүй гэртээ "БИ ХИЛЧИН" гэсэн ганцхан бахархалтайгаар амьдарч явна.

Хилийн заставын хүүхдүүд...

Хил дагасан аав, ээжийнхээ гараас хөтлөн, жижүүр, машин гэж хэлд орж, сургуульд ортолоо хамт амьдарч байгаад, сургуульд оронгуут, аав, ээж, ах дүү нар, дотуур байр хэсэн аав, ээжийгээ харуулдсаар өссөн. Олон газар төрсөн, олон сургууль сольсон, тогтсон ангигүй, сурлага сайнгүй заставаар өссөн хэдэн бор хүүхдийн ирээдүй бүрхэг. Тэр бас л хилчин болно. Заставын амьдралыг мэдэрч өссөн бяцхан хүүгийн мөрөөдөлд хилчин болно гэсэн мөрөөдөл байж болох ч хурааж хуримтлуулсан юмгүй хүүгээ ТӨЛБӨРТЭЙ сургуульд тэр бүр оруулж чадахгүй. Бас нөгөө талаараа яс маханд нь заставын хүүхдүүдэд ХИЛЧИН болно гэсэн мөрөөдөл байдаг учирт сэтгэлийн дуудлагаараа ч Хилийн сургуульд ордог. Гэвч амьтан ах дүүгийнхээр голдуу өссөн хүүхдүүдийн ирээдүй бүрхэг. Тэдний өссөн орчин, цэцэрлэг сургууль жирийн бидний хүүхдүүдээс тэс өөр. Тэд нар минь бас л орхигдсон. Нэгэн жишээ татья.

"Сайн байна уу? Та хилээр их явах юм. Их сайхан байна. Миний аав, ээж хилчин байсан юм. Сургуулиас хол учир аавын ах дүү нараар би дүү нартайгаа амьдарч өссөн. Аав, ээж хоёр минь хил дамжин, жилдээ ганц нэг л уулзалдах тэр үед аавынхаа ах дүү нарт ад үзэгдэж, айлаас айл дамжин өссөн болохоор би хилчин болохыг хүсдэггүй, харин миний мөрөөдөл элэг бүтэн амьдрал, хүүхдүүдээ өөрөө өсгөж, өөрөө сургуульд нь хүргэж өгөх, та минь болж өгвөл энэ талаар хилчдийнхээ дуу хоолой болоорой" гэжээ. Харуусал төрөх.

Тэтгэвэрт гараад, 36 сартай тэнцэх хэмжээний мөнгөө гар дээрээ авч байх үед анх заставд ажиллаж байхад нь төрсөн хүү, охин нь их сургуульд орох болсон байна. Өнөө жаахан мөнгө сургалтын төлбөрт таарна. Эсвэл өр зээлэнд таарах. Хот ороод амьдарнаа,

хүүхдүүдээ бодоод гэсэн зориг байх боловч тэр мөнгөнөөс хашаа байшин ч авах мөнгө үлдэхгүй нь ҮНЭН.

Хилээр дамжсаар байгаад тавилга гэх юмгүй, гэр орон гээд байх юмгүй, буйдхан заставаар явсаар эх орныхоо торгон хил дээр зогссоор, халуунд халж, хүйтэнд хөрч явсаар БИЕГҮЙ болдог тэд хэдэн бор хүүхдүүдээ намар болохоор хаана суулгах вэ? хэмээн шаналдаг. Аав, ээж нь байгаа бол, аль аймагт байсан ч тэдэндээ аваачиж өгнө. Аймаг ойрхон бол аймагт, суманд суулгана. Ихэнх ангиуд хол. Тийм ч учраас Сулинхээрийн асуудал хамгийн зөв шийдэл байсан. Тэр шийдвэр хилчдийн нийгмийн асуудлыг шийдсэн чухал шийдвэр болсон ч ганцхан анги л энэ шийдвэрт хамрагдсан. Бусад ангиуд Сулинхээр шиг орон сууцтай, сургуультай, цэцэрлэгтэй болоход лавтай 100 жил болно.

Хаана хүүхдээ суулгах, хэнийд байлгах вэ? гээд бөөн асуудал байх атал, нэг л өдөр тушаал гарч өнөө муу хүүхдүүдээ дагуулан, эхнэрээ дагуулан бас л нэгэн шинэ газар луу явцгаана. Үр хүүхдүүд нь ч эхнэр ч хамтдаа хил манасан учир, тэдэнд маань ч адилхан хангалт, тэтгэмж байх ёстой. Застав бүрт туслах багшийн орон тоог, анги бүрт цэцэрлэгийн бага, дунд, ахлах бүлгийн асуудлыг шийдэж, зөвхөн хилчдийн хүүхдүүдийг хамруулдаг цэцэрлэгийг анги бүр дээр байгуулж, хилчин хүн ар гэртээ санаа зовохгүй байх ёстой. Тэгвэл Монгол Улсын ХИЛ амгалан байх болно.

Хилийн застав дээр 2 настай хүүгээ, охиноо гэртээ түгжиж байхаар застав дээр байх туслах багшийн гар дээр хүлээлгэн өгөөд ажлаа хийх сайн цагийг би мөрөөднө. Мөрөөдөл нэг их хол биш гэж найдна. Ихэнх ангиуд сумаас хол бас арай ойрхон нь зайтай. Шороо тоос орсон, хүйтэн пургонд сууж сургууль руугаа хүргүүлэх бяцхан хүүхдүүдэд улс төрчдийн ЖДҮ-ээс иддэг, зувчуулдаг мөнгөнөөс автобус аваад өгөх юмсан. Тойрог бүрт хилийн анги байгаа, тэр ангид ганц автобус аваад өгсөн гишүүнийг сонссон хүн бий болов уу. Үгүй. Угаасаа хилчид юу хэцүү байсан ч, яаж амьдарч байсан ч, ямар үе байсан ч гоншигнох эрхгүй хүмүүс. Учир нь тушаал гүйцэтгэ. Гүйцээ...

Ахмад ХИЛЧИН...

Түүхийн жимээр хэмээх нэвтрүүлгийг санаачилж, жолооч, хөтлөгч, найруулагчаа хийн 110 мянган км явсанаас 30 мянган км-ийг хилд зүтгэлээ. Монгол улсын ХИЛИЙГ бүтэн 4 тойрсоны дайтай явж ирээд дөнгөж дөрөө мултлаад сууж байна. Анги бүрт очих бүртээ ахмад хилчидтэйгээ уулздаг юм. Хил рүү явах зөвшөөрлөө аваад ахмад хилчдийнхээ хамт Түүхийн жимээр бэдрэхдээ гэрийнх нь гаднаас хичнээн ахмад хилчдийг авч явж, хичнээн удаа харуусан нулимс мэлмэрсэнийг тоолж чадамгүй.

Холын хол байх хилийн ангид машинаа барин очиж, зам зуурtаа элдэв саад бэрхшээлийг даван туулж эх орныхоо төлөө зүтгэх бүсгүй миний сэтгэлийн утасыг хөндөх ахмад хилчдийн амьдрал эгэлээс эгэл. Хүүхэд байхад 4 айлын орон сууц, 8 айлын орон сууц гээд 70,80 аад онд баригдсан хэдэн навтгар байшингууд сумын

төвдөө л гоё байшингууд харагддаг байсан бол одоо цагт тэр байшингууд хүний нүдэнд торохооргүй жижигхэн бас өнгө муутай. Тэрхүү байшингуудад ажиллаж байгаа офицерүүд нь амьдрах хэдий ч тэтгэвэрт гарсан ахмад хилчид минь хаа газрынх байсан ч тэтгэвэрт гарсан ангиа бараадаж, нэг их том хашаанд байх хаяа хатгасан хэдэн бор гэртээ амьдарна. Тэр гэрүүдийн гадаа очиж, хичнээн олон ахмад хилчидтай дөрөө нийлэн хилээр явлаа даа. ДааНч өрөвдмөөр. Тэртээх 20 жилийн өмнө ажиллаж байсан заставаа харан нулимс нь мэлмэрэх ахмад хилчдийнхээ хамт явж, тэднийхээ хайраар хичнээн олон нэвтрүүлгүүдийн ард гарснаа би мартахгүй ч, тэр ангийн хажууд байх гэр хорооллын гаднаас даллан, даллан үдэх ахмад хилчдийнхээ сүү шиг сэтгэлд дэм болох юу ч хийж чадахгүй эрх мэдэлгүй нэгэн жирийн бүсгүй гэдэгтээ гунигладаг юм.

ХИЛЧИД минь 40 насан дээрээ тэтгэвэртээ гарсан өвөө, эмээ нар болж, цээжин дотороо БИ ТОРГОН ХИЛДЭЭ зогссон ХИЛЧИН хүн гэсэн ОМОГШИЛ БАХАРХАЛААС өөр юмгүй үлджээ. Цастайд ч, шуургатайд ч, бороотойд ч, хүйтэнд ч, халуунд ч ямар ч цаг үед бидний ЭНХ АМГАЛАНГИЙН манаанд зогсож байгаа ХИЛЧДЭЭ анхаараач. Тэд минь ОРХИГДЖЭЭ...

Хилчин хүний цорын ганц эрх бас үүрэг...

Хилийн тухай хуулийн 39.1. Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэн нь төрийн төлөөлөгч байж, улсын эрх ашгийн үүднээс иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих, түүний биелэлтийг хангуулах эрхтэй гэжээ. Үүнээс өөр эрх, үүрэг байхгүй. Тушаал, Гүйцэтгэ, Мэдлээ.

Учир нь чи МОНГОЛ улсынхаа төлөө зүтгэнэ гэж тангараг өргөсөн учирт...

Гэсэн ч... Бүх зүйлийг тушаалын дагуу болгох гэж зүтгэсэн ХИЛЧИД, бүх зүйлийг тушаалын дор хийлгэж гэж зүтгэсэн үе, үеийн дарга нар нэг л өдөр мухардалд орно. Үндсээр нь нэг амьсгаагаар өөрчилж, цалин хангамжийг нь нэмэгдүүлж, ХҮНЭЭ бодсон ХИЛЧНЭЭ бодсон ТӨР улс байж чадахгүй аваас МОНГОЛ улсын дархан ХИЛИЙН манаанд зогсох ХИЛЧДИЙН минь сэтгэл амар амгалан байж чадах уу.

Харагдах гоё сайхан байдалд нь баярлахаас илүүтэй, нүд рүү хараад, амьдрал руу нь өнгийцгөө... ТӨР хилчдээ аль хэдийн хаясан... ТЭД ОРХИГДОГСОД болжээ... Бодоход зүрх шимширнэ...

ХИЛЧИН-УРАН БҮТЭЭЛ

“ЭВ МОД” НААДМЫН СҮЛД ДУУ

Орхон Сэлэнгийн усаар ундаалсан
Орос Монгол хоёр улсын
Дархан хилийн дагшин овоо нь
Даяар олны түүхийг дархалсан юм

Мөнх найрамдлын шимээр амилсан
Монгол Оросын торгон хилд
Энх мэндийн ерөөл дэвшүүлж
Эв модны наадмаа эхэлцгээе
Хурай Хурай Хурай Хурай

Удамт дээдсээс өртөөлж ирсэн
Ухааны цартай энэ наадмыг
Төрийн сүлдэс нь дээрээс ивээж
Түмэн олон нь баясан дээдэлдэг юм

Мөнх найрамдлын шимээр амилсан
Монгол Оросын торгон хилд
Энх мэндийн ерөөл дэвшүүлж
Эв модоо эвсэн нийлүүлцгээе
Хурай Хурай Хурай Хурай

Буурал өтгөсийн сүлдээр амилсан
Буяны даллагатай энэ наадмыг
Хоёргүй сэтгэлийн билигдэл болгож
Хотол олон нь хамтдаа цэнгэдэг юм

Мөнх найрамдлын шимээр амилсан
Монгол Оросын торгон хилд
Энх мэндийн шерөөл дэвшүүлж
Эв модоо эвсэн нийлүүлцгээе
Хурай Хурай Хурай Хурай

Ө.Бавуу

ХИЛЧНИЙ ШИРЭЭНИЙ НОМ




Таныг хүндэтгэсэн:
НҮБ-ын Нийгэм Эдийн Засгийн зөвлөлд зөвлөх эрхтэй, Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академийн академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, дэслэгч генерал, Боржигон овгийн Ишцогийн Эрэнцэнгийн хүү

Шавийн Арвай

НҮБ-ын Нийгэм Эдийн Засгийн зөвлөлд зөвлөх эрхтэй, Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академийн академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал Боржигон овгийн Ишцогийн Эрэнцэнгийн хүү, Шавийн Арвай агсны туурвисан "Дурдатгал ба Хүүрнэл" бүтээл хилчин бидэнд оюуны томоохон хөрөнгө оруулалт, мөн энэ эрхэм хүмүүний хилчин бидэндээ, хойч үедээ захисан гэрээслэл, захиас, даалгавар болон очиж байна.

Манай гарагийн хүн төрөлхтний хөгжлийн хоёр ба гурав дахь мянганы зааг дээр улсын хилийн баталгаатай шийдвэрлэлт, түүний найдвартай хамгаалалт, мөн Монгол Улсын онц чухал объектуудын аюулгүй нөхцөл байдал, урлагийн тухай энгийн маш ойлгомжтой өгүүлэхийн зэрэгцээ бичлэгийн онцлог нь асуудлыг сэдэж, шийдэл рүү хөтөлсөн өвөрмөц хэлбэрээр бичигдсэнд оршино.


Шалгагчийн гарын авлага



Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимээс санаачлан боловсруулж, Хилийн албаны сургуулийн нийт сонсогч, суралцагчид, хилийн шалган нэвтрүүлэх албанд ажиллаж байгаа офицер, ахлагч нарын албаны онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, бие даан хөгжих, суралцах боломжийг олгох зорилгоор боловсруулагдсан. Агуулгын хувьд хилийн боомтын тухай ерөнхий ойлголтыг өгөх, шалган нэвтрүүлэх албаны түүхэн хөгжлийн талаарх баримтууд, хил нэвтрэх эрхийн баримт бичиг, түүний онцлог,

нууцлалуудын талаар, МУ-ын виз, адилтгал хийх арга зүй зэрэг олон сэдвийн хүрээнд боловсруулагдаж, хэвлэгдэн гарч байна.


Хилийн шалган нэвтрүүлэх албанд холбогдолтой хууль тогтоомжууд



МУ-ын хилийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, үүний дагуу хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд мөрдөх хэм хэмжээний актууд шинэчлэгдэн гарсантай холбогдуулан "Шалган нэвтрүүлэх алба-эрх зүй" бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийн агуулгын дагуу сонсогч, суралцагчдад сургалтыг зохион байгуулахад шаардлагатай сургалтын гарын авлага эмхтгэлийг боловсруулав.

Бүтцийн хувьд МУ-ын олон улсын гэрээ, хэлэлцээр, МУ-ын хуулиуд, МУ-ын засгийн газрын тогтоол, яам агентлагаас гарган мөрдөж буй тушаал гэсэн дарааллаар эмхэтгэгдсэн.


"Цэргийн байр зүй" сурах бичиг




Энэхүү бүтээл нь, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын офицер, ахлагч, тэдгээрийн харьяа сургуулиудын сонсогч нарт зориулсан бүтээл бөгөөд цэргийн байр зүйн сургалтад өргөн хэрэглэгддэг ойлголтуудыг товч, тодорхой илэрхийлсэн, сорил бодлого, зураг, бүдүүвч, хүснэгтийг оруулсан.

Суралцагчид байлдааны ажилла-гааны үед болон цэргийн хээрийн сургууль, команд-штабын сургууль ба газар орон дээр албан үүрэг гүйцэтгэхдээ байр зүйн зургийг ашиглаж чаддаг, орчин үеийн техник хэрэгслийн тусламжтайгаар газар орон дээр баримжаалах чадвар эзэмшсэн офицеруудыг бэлтгэхэд оршино.

Галт зэвсэгтэй адилтгах үхэлд үл хүргэх зэвсэг



Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн эрхлэгч, хурандаа Г.Мөнх-Ертөнц, ахлах багш, дэд хурандаа М.Баттулга нарын боловсруулсан гарын авлага. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын офицер, ахлагч, тэдгээрийн харьяа сургуулиудын сонсогч нарт зориулсан гарын авлага бөгөөд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед, зорчигч, тээврийн хэрэгслийн барьцаалсан этгээдийг саатуулах, гэмт үйлдлийг таслан зогсоох, барьцаалагчдыг чөлөөлөх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед дэг журам сахиулах, таслан зогсоох, хилийн хяналтын байгууллагын алба хаагчид болон зорчигчдод учирч болох болзошгүй аюулаас урьдчилах сэргийлэх зорилгоор галт зэвсэгтэй адилтгах үхэлд үл хүргэх зэвсэг, галт хэрэглэлийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд оршино.



Ар тал, эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Ц.Одонгэрэл, багш, дэслэгч Б.Юмаажав нарын боловсруулсан энэхүү сурах бичиг нь тэнхимийн хэрэгжүүлж буй "Эдийн засаг" хөтөлбөрийн ерөнхий суурь, заавал судлах "Нягтлан бодох бүртгэлийн үндэс" хичээлийн үндсэн сурах бичиг болно.

"Эдийн засаг" сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хичээл зааж буй багшийн сургах арга барил болон суралцагчийн бие даан сурах арга зүйд нийцсэн, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг бүрэн багтаасан, өргөн хүрээний мэдлэг олгохуйц түвшинд боловсруулагдахад оршино.

Бие хүний сэтгэл зүйн онцлогийг судлах судалгааны арга, аргачлал



Сэтгэл судлалын судлагдахуун нь хүний нүдэнд ил харагддаггүй хийсвэр үзэгдлийг судалдаг нарийн төвөгтэй шинжлэх ухаан юм. Тийм учир судалж буй үзэгдлийнхээ агуулга мөн чанарыг бусдад илэрхийлэн, ойлгуулсны үндсэн дээр судалгааг хийх тул сэтгэл судлалын мэдлэгтэй байх нь зохистой.

Мэргэжлийн зарчим, ёс зүйн дагуу туршигч нь судалгаа, оношлогоо явуулах болон түүний үр дүнг боловсруулах журам зааврыг сайтар судалж, мэдсэний үндсэн дээр мэргэжлийн туршилт, судалгааг хийх хэрэгтэй гэж үздэг. Энэхүү судалгаа оношлогооны материал нь сэтгэл судлалын мэргэжлээр суралцдаг сонсогч, оюутнууд нэн тэргүүнд эзэмших, бие даан ажиллах мэргэжлийн арга, аргачлалыг нэг доор эмхэтгэсэн боловсруулах зорилготой юм.

Өөрийгөө таниад бусдыг шинжихүй




Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь хүнийг “Сэтгэл зүйн давтагдашгүй өвөрмөц онцлогтой, хүрээлэн буй орчинтойгоо харьцах харилцаагаа ухамсарласан, үйл ажиллагааны тодорхой хэлбэрийг эзэмшсэн нийгэм, хамт олны төлөөлөгч тодорхой хүнийг бие хүн” гэж үздэг. Өөрөөр хэлбэл байгаль хүнийг бий болгож, нийгэм хүнийг төлөвшүүлж байдаг.

Хүн өөрийгөө таньж мэдэж, зөв буруугаа тунгааж үзэх нь хамгийн чухал. Эртний сэтгэгч Хилон “Өөрийгөө таньж ав, тэгсэн цагт та хорвоо ертөнц, бурхдыг таних болно”.

Оросын гүн ухаантан Н.Г.Чернышевский “Өөрийгөө судалж чаддаггүй хүн, хүнийг хэзээ ч бүрэн сайн мэдэж чадахгүй” гэжээ. Тухайн хүнийг бүрэн таньж мэдсэнээр тэр хүнтэй яаж харилцах, ямар ажил хөдөлмөр эрхлэх боломжтойг мэдэрч хамтарч ажиллахад

туйлын хялбар болно.

Хүнтэй ажиллах арга барил харилцааны соёл, хүнийг таньж мэдэх энгийн ойлголтыг энэхүү гарын авлагад оруулсан болно.




“Хаант Орос-Манж Чин улсын хилийн харилцааны түүхэн тойм (1689-1911 он)” нэг сэдэвт бүтээлийг орос, хятад хэл дээрх нийтийн хүртээл болоогүй гадаад эх сурвалжуудыг ашиглан туурвисан бөгөөд Нэрчүгийн, Буурын, Хиагтын, Тарвагатайн, Цицикарын гээд тэр үед байгуулсан бүх хилийн гэрээнүүдийн эртний орос, латин, манж, уйгаржан монгол хэл дээрх эх болон орчин үеийн орос, монгол хэл дээрх орчуулгыг хавсаргасан болно. 30 хэвлэлийн хуудастай.

XXI зууны Монголын түүх судлалд Монголын гадаад харилцааны түүх, тэр тусмаа хилийн харилцааны түүхийн судалгаа томоохон байр суурь эзэлдэг.

Улсын хил үүсэн бий болох нь урт удаан хугацааны үйл явц бөгөөд улс төр, эдийн засаг, угсаатны зүй, түүхийн, цэргийн, хил залгаа улсын гээд олон хүчин зүйлүүдээс хамаардаг.

Монгол Улсын улсын хил бүрэлдэн бий болж тогтсон үе урт удаан хугацааны тасралтгүй үргэлжилсэн үйл явц бөгөөд дээрх хүчин зүйлүүдийн үр дүнд Хаант Орос, Манж Чин хоёр гүрний нутаг дэвсгэр зах нийлэх болсон үеэс нутаг дэвсгэрээ зааглах, хил тогтоох, тэмдэглэх, хилийн харилцаа, хилийн худалдааг хөгжүүлэх асуудал ихээхэн чухал болж иржээ.

Хаант Орос-Манж Чин улсын хоорондын гадаад харилцааны түүхийн гол цөмийг хилийн харилцааны асуудал эзэлдэг бөгөөд хилийн харилцааны түүхийг тодруулахад гол анхаарлаа хандуулан судалгаа хийсэн болно.



Өвөр Монголын Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын цэрэг ангийн командлагчийн сургуульд хэрэглэх нэгдэлтэй найруулсан заах материал **“Хилийн хамааралтын ухаан”** номыг 2012 онд Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос дотоодод, албан хэрэгцээнд зориулан гаргасан.

Энэ ном нь БНХАУ-ын хил хамгаалалтын байдал, хил судлалын ухааны хөгжил, Хятадын төрийн хилийн бодлогын агуулга, арга зүй, түүнийг боловсруулахдаа 18 улстай хиллэдэг учраас улс тус бүртэй харилцдаг хилийн харилцааны онцлог, хил тогтоож байсан түүхийн асуудал зэргийг нягт уялдуулсан, хилийн төлөөлөгчийн ажиллагаа явуулах болон аливаа хилийн зөрчил, асуудлыг шийдвэрлэх арга тактик зэргийг тусгасан, манайхаар бол "Хилчний сурах бичиг", "Хил хамгаалалтын дүрэм", "Хилийн төлөөлөгчийн ажиллагааны заавар"-тай зарим агуулгаараа дүйцэхүйц, бидний тэр бүр мэддэггүй, олддоггүй мэдээллийг агуулсан, хил залгаа БНХАУ, эсрэг талынхаа хил хамгаалалтын арга тактиктай танилцан хил хамгаалалтад бүтээлчээр ашиглахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулах, албан хэрэгцээнд ашиглах ном болно.

"Хилийн хамааралтын ухаан" номыг уйгаржин монголоос крилл бичигт буулгахдаа өвөрлөгч дуудлага, өгүүлбэрийн бүтэц, үгсийн санг өөрчлөөгүй аль болох дүйх үгийг олж тохируулахыг чармайв.

Хилийн уулзалтууд ихэвчлэн өвөр монгол орчуулагчтайгаар явагддаг учраас хил хамгаалалтын зарим нэр томьёо, хэллэгийн учрыг олоход танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой гэж үзэв.

Хурандаа Ц.Ганболд, Хилийн...р ангийн Их Жаргалант, Ганц модны заставт 1975-1978 онд алба хаасан ахмад хилчин, Ноён Цорос Х.Баярсайхан бид чадан ядан бичлэг, дуудлагаар нь бүрэн эхээр нь буулгасан ч хятад нэр, зарим "хятаджсан" өвөр монгол үгийг манай утга дүйх үгээр оноон тохируулан, тохоон найруулахад хүндрэлтэй байсныг нуух юун. Жишээ нь: Оумен-Макао, Сияанганг-Сингапур, Жиеэнг Жиеве Ши-Чан Хай Ши гэж нэрийдэж байгааг нь бид өөрөөр дуудаж хэвшжээ.

Голдлоготой хүн-энэ нь Хятадын дотоодын хамгаалахын нэр томъёо бөгөөд "сэжигтэй, хяналтад байгаа этгээд"-ийг нэрлэдэг байна.

Дүйшээн-судлагдахуун, хорт эдхар тамхи, дагуул од-хиймэл дагуул, түргэн халигч-дуунаас хурдан онгоц, доошлуулах-шатлах зэрэг өвөрмөц хэллэгүүд олонтоо байгааг тухай бүр хаалтанд зүүлт хэлбэрээр оруулж өгсөн болно.